



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

СОЦИОЛОГИ

Гарын авлага

Зөвлөх:

Доктор, проф. О.Мөнхбат

Боловсруулсан:

Д.Мөнхтөр (МА)

М.Батбаатар (МА)

Г.Түмэннаст (МА)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот
2012 он

DDC
306.345
С-61

Дэлхийн банкны «Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах» төсөл

СОЦИОЛОГИ
ГАРЫН АВЛАГА

Зөвлөх: Доктор, проф. О.Мөнхбат

Боловсруулсан: Д.Мөнхтөр (МА)
М.Батбаатар (МА)
Г.Түмэннаст (МА)

Хэвлэлийн хуудас: 16.4
Цаасны хэмжээ: В5
Хэвлэсэн тоо: 1200
Хэвлэсэн газар: «СОДПРЕСС» Хэвлэлийн компани

ISBN 978-99962-54-46-8



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ, ОЮУТАН НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн «Шүүх, эрх зүйн шинэчлэлт» төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, «Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт»-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн «Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах» төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн зохицуулагч
Большорлоогийн Сарантуяа*

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг.

Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг.

1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны «Хууль зүйн үйлчилгээг сайжруулах» төслийн «Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих» дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- ❖ Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- ❖ Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- ❖ Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх
Ухнаагийн Туяа (Ph.D)*



Оролмаагийн МӨНХБАТ

Социологийн ухааны доктор, профессор, МУИС-ийн НШУС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, Азийн философийн холбооны дэд ерөнхийлөгч, «Транспаренси Интернэйшнл» Монголын Удирдах зөвлөлийн гишүүн. Монголын Социологчдын холбооны гишүүн, Монголын нийгмийн ажлын холбооны гишүүн.

Тэрээр 9 гарын авлага, нэгэн сэдэвт бүтээл, 40 орчим эрдэм шинжилгээ, судалгаа, танин мэдэхүйн өгүүлэл гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүл, сонинд хэвлэн нийтлүүлсэн. Нийт 50 орчим үндэсний хийгээд олон улсын судалгааны төсөлд гүйцэтгэгч, төслийн удирдагчаар ажилласан.



Дашзэвэгийн МӨНХТӨР

Социологийн ухааны магистр, докторант. МУИС-ийн НШУС-ийн Социологи-Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш. МУИС-ийн Хамт олны зөвлөлийн тэргүүн. Монголын социологичдын холбоо, МЗЭ-ийн гишүүн.

Тэрээр Социологийн гарын авлага, эрдэм шинжилгээний олон тооны өгүүлэл, судалгааны тайлан хэвлүүлсэн. А.Гиддэнсийн «Социологи» (2006) сурах бичгийн орчуулагчийн нэг бөгөөд мэргэжлийн олон өгүүлэл орчуулж сэтгүүлд хэвлүүлжээ. Үндэсний болон олон улсын 30 орчим судалгааны төсөлд зөвлөх, төслийн удирдагч, судлаачаар оролцсон.



Монхооройн БАТБААТАР

Социологийн ухааны магистр, докторант. МУИС-ийн НШУС-ийн Социологи-Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш.

Тэрээр үндэсний хэмжээний 30 гаруй судалгааны ажлыг удирдах буюу хамтран гүйцэтгэж, мэргэжлийн олон тооны ном сурах бичгийг хамтран орчуулж, мэргэжлийн сэтгүүлүүдэд 10 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлжээ.



Гэлэнхүүгийн ТҮМЭННАСТ

Социологийн ухааны магистр, докторант. МУИС-ийн НШУС-ийн Социологи-Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, Нийгмийн ажлын багш сургагчдын холбооны тэргүүн, Монголын социологичдын холбооны гишүүн.

Тэрээр «Нийгмийн ажлын түүх» ном, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, хамтын бүтээл хэвлүүлсэн.



АГУУЛГА

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ	
«СОЦИОЛОГИ» ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	6
ХОЁРДУГААР ХЭСЭГ	
СОЦИОЛОГИ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	9
БҮЛЭГ-I. Удиртгал.....	9
БҮЛЭГ-II. Социологийн онолын хөгжил.....	20
БҮЛЭГ-III. Нийгэм, түүний ангиллууд	29
БҮЛЭГ-IV. Соёл ба нийгэмшил	34
БҮЛЭГ-V. Бодгаль ба бүлэг.....	52
БҮЛЭГ-VI. Нийгмийн ялгарал, давхраажил	60
БҮЛЭГ-VII. Нийгмийн институтууд	69
БҮЛЭГ-VIII. Социаль дэг ёс хийгээд гаж үзэгдэл.....	121
БҮЛЭГ-IX. Социологийн судалгаа: Хөтөлбөр ба аргууд	143

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

«СОЦИОЛОГИ» ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр:	<i>Социологи</i>
Индекс:	<i>Soc</i>
Кредит цаг:	<i>2 кр</i>
Нийт цаг:	<i>48 (лекц-32, семинар-16)</i>
Семестр:	<i>1-р курсын хаврын улиралд</i>
Хичээлийн залгамж холбоо:	<i>Эрхзүйн социологи</i>

1.2 Социологийн хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн хүрээнд социологийн шинжлэх ухааныг судлах нь ардчилал хөгжиж, ардчиллын соёл шинээр төлөвшиж, нийгмийн өөрчлөлт шинэчлэл асар хурдацтай явагдаж буй Монголын нийгмийн хувьд нэн чухал юм. Аль ч тоталитар нийгэмд социологийн шинжлэх ухаан бүрэн утгаараа хөгжиж, тархаж байгаагүй. Учир нь социологи тодорхой нийгмийн талаарх хийсвэр бус, бодит баримт сэлт хийгээд шүүмжлэлт шинжилгээнд тулгуурлаж байдаг.

Хуульч мэргэжил нь нийгмийн олон талт харилцаа, уялдаа холбооны төвд оршиж буй хүнтэй нүүр тулж, түүний зан үйл, үйлдэлд нөлөөлж, учир шалтгаанжуулж байгаа социаль хүчин зүйлсийг ойлгон мэддэг байхыг шаардана. Үүнд социологийн боловсрол, соёл чухал нөлөөтэй юм. Хүмүүсийн хамтын амьдралыг боломжтой болгож, социаль орчны хэвийн оршин тогтнох нөхцөлийг хангахад чиглэсэн эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалт нь чухамхүү иргэдийн үнэлэмж, итгэл үнэмшил, соёлоос ихээхэн хамаардаг бөгөөд тийм ч учраас социологийг хуулийн салбарын оюутнууд, зөвхөн мэдлэгийн академик салбар ухаан гэдэг үүднээс төдийгүй мөн нийгэм дэх сэтгэлгээ, итгэл үнэмшил, зан хандлагын олон талт соёлд сургах нэгэн хэрэгсэл гэдэг талаас судлах нь чухал юм.

Санал болгож байгаа хичээлийн хэрэгцээ шаардлага нь дээрх хүчин зүйлсээр тайлбарлагдана.

1.3 Хичээлийн зорилго, зорилт

А. Мэдлэгийн хувьд

- ❖ Социологийн сэтгэлгээний үүсэл, хөгжлийн үндсэн үе шат, онолын үзэл баримтлалтай танилцах
- ❖ Социологийн шинжлэх ухааны суурь ойлголтууд, нийгмийн үндсэн бүрдүүлбэрүүдийн талаар мэдлэг эзэмших



Б.Чадварын хувьд

- ❖ Нийгмийн үзэгдлүүдийг оюутан өөрийнхөө хувийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан авч үзэхийн зэрэгцээгээр, социологийн үзэл ойлголт, ухагдахууны түвшинд ойлгож, тайлбарлал хийж сурах

В. Хандлагын хувьд

- ❖ Нийгмийн болон эрх зүйн үзэгдэл үйл явцыг нийгэм соёлын эх орчинд нь тогтолцооны үүднээс задлан шинжлэх, тайлбарлах хандлага төлөвших
- ❖ Хувь хүнийхээ хувьд оюутан хүн, нийгмийн үзэгдлүүд, хүмүүсийн социаль амьдралын олон талт байдлын уг чанарын талаар зохих төсөөлөлтэй болж, соёлын үл тэвчих болон ялгаварлах үзлүүдээс ангид, хүлээц зөвшилцөөнийг эрхэмлэсэн зан хандлагыг эзэмших

1.4 «Социологи» хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

№	Хичээлийн агуулга	Сэдвийн нэрс	Цаг	Хичээлийн хэлбэр
1	Удиртгал	Социологийн шинжлэх ухааны үүсэл, судлах зүйл. Нийгмийн бусад шинжлэх ухаан, ялангуяа эрх зүйн шинжлэх ухаантай холбогдох нь	2	Лекц
		Социологийн шинжилгээ, түүний онцлог (Э.Дюркхаймын «амиа хорлолт»-ын шинжилгээний жишээн дээр)	2	Семинар
2	Социологийн онолын хөгжил	Сонгодог хийгээд орчин үеийн социологийн онолын хөгжлийн үе шат, парадигм	4	Лекц
3	Нийгэм, түүний ангиллууд	Нийгмийн хэв маягийн ангиллууд	2	Лекц
4	Соёл ба нийгэмшил	Соёлын тухай ойлголт, Соёлын хэлбэрүүд, нийгмийн хэв маягууд дахь соёлын хэлбэрүүд	2	Лекц
		Гэмт хэргийн үнэлэмж соёлын ялгаанаас хамааран өөрчлөгдөх нь (Н.Смелзер)	2	Семинар
		Нийгэмшил, түүний үндсэн үе шатууд: Фройд, Ж.Г.Миид, Ж.Пиаже, М.Доналдсон	2	Лекц
		Бие хүний социаль шинж: амьдралын зорилго, үнэт зүйл, статус, үүрэг	2	Семинар

5	Бодгаль ба бүлэг	Бодгаль хүн ба бүлгийн тухай суурь ойлголтууд Хүний тухай үзэл, онолууд	2	Лекц
		Эрх зүйн орчин дахь бие хүн ба бүлгийн харилцаа, түүний онцлог	2	Семинар
6	Нийгмийн ялгарал, давхраажил	Давхраажлын тогтолцоо, орчин үеийн давхраажлын онолууд: К.Маркс, М.Вебер, В.Парьето, Т.Парсонс, П.Сорокин, Э.О.Райт, Ф.Паркин Давхраажлын шалгуур үзүүлэлтүүд	2	Лекц
		Социаль мобиль хөдөлгөөн, Тэгш бус байдал ба ядуурал	2	Семинар
7	Нийгмийн институтууд	Гэр бүл ба боловсролын тогтолцоо	4	Лекц
		Монголын гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтүүд, эрх зүйн зохицуулалт	2	Семинар
		Засаглал улс төрийн тогтолцоо, эдийн засаг, шашны институт	4	Лекц
		Засаглал, эрх мэдлийн хэв маягууд, (М.Веберийн социологийн шинжилгээнд тулгуурлан хэлэлцэх)	2	Семинар
8	Социаль дэг ёс хийгээд гаж үзэгдэл	Нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйл, нийгмийн гаж үзэгдэл, түүний хэлбэрүүд	2	Лекц
		Гэмт хэрэг ба ял шийтгэл, гавьяа ба шагнал (П.Сорокины социологийн шинжилгээн дээр хэлэлцэх)	2	Семинар
9	Судалгааны аргууд	Социологийн судалгааны хөтөлбөр	2	Лекц
		Тоон судалгааны аргууд	2	Лекц
		Чанарын судалгааны аргууд	2	Лекц
	Бүгд	Лекц-32, Семинар-16	48	



ХОЁРДУГААР ХЭСЭГ.

СОЦИОЛОГИ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА (ЛЕКЦ-32 цаг, СЕМИНАР-16 цаг)

БҮЛЭГ-I. Удиртгал

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Удиртгал	Социологийн шинжлэх ухааны үүсэл, судлах зүйл. Нийгмийн бусад шинжлэх ухаан, ялангуяа эрх зүйн шинжлэх ухаантай холбогдох нь	2	Лекц
	Социологийн шинжилгээ, түүний онцлог (Э.Дюркхаймын «амиа хорлолт»-ын шинжилгээний жишээн дээр)	2	Семинар

Сэдэв - 1: Социологийн шинжлэх ухааны үүсэл, судлах зүйл. Нийгмийн бусад шинжлэх ухаан, ялангуяа эрх зүйн шинжлэх ухаантай холбогдох нь (лекц-2 цаг)

Хичээлийн зорилго: Социологийн шинжлэх ухааныг үүсэхэд хүргэсэн нөлөөллүүд, нийгмийг судлах социологийн хандлагын онцлог, социологийн мэдлэгийг эзэмшихийн танин мэдэхүйн ба практик өгөөж, мөн нийгмийн бусад шинжлэх ухаантай холбогдох байдал зэргийн талаар анхны суурь ойлголттой болно.

Гол ойлголтууд:

- ❖ Социаль физик
- ❖ Социологи
- ❖ Позитивизм
- ❖ «Социал» хэмээх нэр томъёо
- ❖ Социал баримт сэлт (fact)
- ❖ Макро ба микро социологи
- ❖ Бүтэц ба үйлдэл

Сэдвийн агуулга:

- ❖ Социологи үүсэхэд нөлөөлсөн нийгэм, улс төр, танин мэдэхүйн нөхцөлүүд
- ❖ О.Конт ба «социологи»-ийн үүсэл. Социологи ба байгалийн шинжлэх ухааны арга
- ❖ Социологийн судлах зүйл ба «Социал баримт сэлт»-ийн социологийн тайлбарлал

- ❖ Социологийн шинжилгээний түвшин: макро ба микро социологийн судлах зүйл
- ❖ Социологи нийгмийн бусад шинжлэх ухаануудтай (түүх, социал антропологи, улс төр судлал, сэтгэлзүй, эдийн засаг, эрх зүй) холбогдох нь
- ❖ Эрхзүй норматив (хэм хэмжээт), харин социологи норматив бус шинжлэх ухаан болох нь

Социологи үүсэхэд нөлөөлсөн нийгэм, улс төр, танин мэдэхүйн нөхцөлүүд

Социологийн шинжлэх ухааны үүслийг XVIII зууны хоёр дахь хагасаас Баруун Европт эхэлсэн үйл явц болох орчин үеийн нийгэмтэй салшгүй холбоотой хэмээн олон судлаачид үздэг. (Ritzer, 1996: 6) Социологи үүсэхэд нөлөөлсөн гэгддэг үндсэн хүчин зүйлсийг дараах байдлаар тоймлон харуулж болно.

• *Нийгмийн үндсэн хүчин зүйл: Аж үйлдвэрийн хувьсгал*

Аж үйлдвэржилт, хотжилт, түшмэл ёсны хөгжил зэргийг сүүлийн 400 гаруй жилийн туршид дэлхий ертөнцийг хувьсган өөрчлөхөд онцгой нөлөө үзүүлсэн үйл явцууд хэмээн барууны нийгэм судлаачид үндсэндээ санал нэгтэй тэмдэглэсэн байдаг. (Stein, 1978: 445)

Үүнээс аж үйлдвэрийн хувьсгал нь социологи үүсэхэд хүргэсэн гол хүчин зүйлийн нэгээр ямагт тооцогддог. Хөдөлмөрийн бүтээмжийн огцом, онцгой өсөлт хэмээн товчхон илэрхийлж болох аж үйлдвэрийн хувьсгалын нөлөөгөөр өрнөдийн нийгэмд хотжилт урьд өмнө байгаагүйгээр чанарын өөр өнгө төрхтэй болсон. Хүн амын нягтрал ихсэж, соёлын маш олон төрлийн элемент нэг дор зэрэгцэн орших нь нийгмийн хэвийн нөхцөлд тооцогдохоос өөр аргагүй нийгмийн тийм шинэ төлөв байдал үүсэж эхэлсэн байна.

Үүнийг социологийн хэлээр илэрхийлбэл, нийгэм нэг төрөлт байдлаас олон төрөлт байдал руу шилжин оржээ.

• *Улс төрийн үндсэн хүчин зүйл: Францын хөрөнгөтний хувьсгал*

Энэ хувьсгалын гол үр дүн нь засаглалын монарх ёсыг халж бүгд найрамдах засаглалын эхийг тавьсан явдал юм. Эрх чөлөө, тэгш эрх, шударга ёс хэмээх уриаг тунхагласан чухам энэ хувьсгалын чөлөөлөх үзэл санааны нөлөөгөөр нийгмийн оюун санаа илүү иргэнлэгжиж, шинжлэх ухааны сэтгэлгээнд ч шинийг эрэлхийлэх илүү таатай нөхцөл бий болсон байна.

• *Оюун санаа, танин мэдэхүйн хүчин зүйл: байгаль шинжлэл дэх ололтууд, позитивизм ба нийгмийг хийсвэр бус тодорхой байдлаар судлах хэрэгцээ цэцэсэн явдал*

Дээр өгүүлсэн нийгэм, улс төрийн өөрчлөлтүүдийн дүнд нийгмийн бодит байдал ихээхэн өөрчлөгдөж, урьд өмнөх (уламжлалт) нийгэмтэй



харьцуулахын аргагүй болсон төдийгүй нийгмийн судалгааны хуучин арга барил ч шинэ нөхцөлд хангалттай бус болох нь илт мэдрэгдэх болжээ. Нийгмийг дан ганц философийн хийсвэр ойлголтуудаар болон шашны номлолоор судалж, тайлбарлахыг оролдож асан шинжлэх ухааны хуучин хандлагыг халах ёстой хэмээн социологийн үндэслэгчдийн нэг О.Конт үзэж байв. Үүнд байгалийн шинжлэлийн аргууд, позитивизмийн зарчмууд чухал үүрэгтэй байлаа.

О.Конт ба «социологи»-ийн үүсэл

• *Конт ба социологи*

Социологийн шинжлэх ухааны нэрийдсэн эцэг хэмээн дийлэнхдээ хүлээн зөвшөөрөгддөг Францын сэтгэгч Огюст Конт (1798-1857)-ын анхаарлын төвд нийгмийг хэрхэн засаж сайжруулах тухай асуудал байжээ. Хэрвээ нийгмээ урагш ахиулъя гэвээс социал зан үйлийг шинжлэх ухаанчаар судлах ёстой гэж үзэж байсан бөгөөд анх удаа тэрээр «sociology» хэмээх латин, грек үгсийн нийлбэр нэр томъёог өөрийн үүсгэхээр оролдож буй нийгмийг судлах шинэ шинжлэх ухааны нэр болгон хэрэглэсэн байна. Түүний 1838 онд хэвлүүлсэн Позитив философийн курс хэмээх бүтээлд энэ тухай анх тодорхойлогдсон байдаг ч 1820-иод онуудад нэгэн нөхөртөө бичсэн захидалдаа энэ нэр томъёог хэрэглэж байсан нь харагддаг. О.Конт энэхүү шинжлэх ухаанаа эхлээд социал физик хэмээн нэрийдэж байсан ч түүнийг өмнө нь Бельгийн нэгэн нийгмийн статистикч хэрэглэснийг мэдээд больсон байна. (Coser, 1971: 3) Түүнийхээр социологи нь нийгмийн өөрчлөлтийн явцад хүний оюун санаа, зан суртахуун хэрхэн өөрчлөгдөхийг судалдаг шинжлэх ухаан юм.

• *Конт ба позитивизм*

«Тэрээр социал зан үйлийг судлахад шинжлэх ухааны ажиглалтыг хэрэглэхийг хүсэж байсан бөгөөд үүнийгээ позитивизм хэмээн нэрлэжээ. Конт нь социологи бол бидний «позитив» гэж нэрлэж болох тэрхүү мэдлэгт тулгуурласан шинжлэх ухаан байх ёстой гэж үзэж байлаа.» (Shepard and Greene, 2001:14)

• *Конт ба социологийн аргууд*

Энэхүү шинэ шинжлэх ухааныхаа нийгмийг судлах аргуудыг мөн гаргаж ирсэн байна. Үүнд: ажиглалт, туршилт, харьцуулалт ба түүхэн хандлага
Үүнээс эхний хоёр нь байгалийн шинжлэх ухааны аргууд бөгөөд сүүлийн хоёрыг нь өөрөө гаргаж тавьсан байна.

• *Конт ба социал статик, социал динамик*

О. Конт нь, нийгмийн тогтвортой байдал ба эмх журмын судалгаа болох социал статик болон нийгмийн өөрчлөлтийн судалгаа болох социал динамик хоёрыг зааглан ялгаж өгчээ. Нийгмийн тогтворт байдал хийгээд нийгмийн өөрчлөлт хувирлын хоорондох энэхүү зааг ялгааны асуудал нь орчин үеийн социологийн анхаарлын төвд ч байсаар байна.

Социологийн судлах зүйл ба «Социал баримт сэлт»-ийн социологийн тайлбарлал

• *Социологийн судлах зүйл*

Социологийн судлах зүйлийг тогтсон ганцхан өгүүлбэрээр илэрхийлэх боломжгүй юм. Энэ нь социологийн шинжлэх ухааны туулж өнгөрүүлсэн түүх хийгээд онол, парадигмын ялгаа, түүнчлэн улс орон, бүс нутгийн ялгаанаас ч хүртэл хамааран янз бүрээр тодорхойлогдсон байх нь элбэг. Сурах бичгүүдэд нийгмийг бүхэлд нь судалдаг шинжлэх ухаан гэхээс авахуулаад хүмүүсийн өдөр тутмын амьдралыг судална гэх хүртэл олон талтайгаар тодорхойлсон байдаг. Түүнээс гадна, нийгмийн шинжлэх ухаануудыг судлах зүйлээр нь гэхээсээ илүүтэй нийгмийг судлах арга хандлагаар нь ялгах нь зүйтэй гэсэн үзэл ч яригддаг. (Bilton, 1986: 1)

Гэсэн хэдий ч социологи бол эцэстээ социал бүтцийг судалдаг шинжлэх ухаан юм гэж тоймлон үзэж болно. (Shepard and Greene, 2001: 6)

Социал бүтэц: нийгмийн харилцаанд орж буй хүмүүсийн хоорондын загварчлагдсан харилцан үйлчлэл.

• *Социал баримт сэлт ба социологийн шинжилгээний онцлог*

Социологийн шинжилгээний онцлог хийгээд бие даасан академик салбар шинжлэх ухаан болон хөгжсөн түүх нь францын социологич Э. Дюркхаймын нэртэй салшгүй холбоотой юм. Эхэн үеийн социологичид социологийг шинжлэх ухаанч байлгах тал дээр их анхаарал тавьж байсан ч хэрэг дээрээ Э.Дюркхайм тэргүүтэй хожмын социологичид энэ ажлыг гүйцэлдүүлсэн байна. Энэ нь хий төсөөллийг ажиглалтаар орлуулах болон өгөгдөл цуглуулах, ангилах, түүнчлэн нийгмийн онолуудыг шалгахад өгөгдлийг ашиглах зэрэг аргуудыг боловсруулсантай холбоотой юм. Э.Дюркхайм энэхүү социологичдын хамгийн гол төлөөлөгч байсан бөгөөд тэрээр статистик техникүүдийн хэрэглээг анх удаа амиа хорлолтын талаарх өөрийн суурь судалгаандаа нэвтрүүлсэн хүн юм.

Тэрээр амиа хорлолт нь дан ганц хувь үйлдлээс илүү зүйлсийг өөртөө агуулж байдаг бөгөөд амиа хорлолтын түвшин нь бүлгийн шинжүүдээс хамааран хэлбэлзэж байдгийг судалгаагаараа нотлон харуулжээ. (Bilton, 1986: 610) Э.Дюркхайм хүний социал зан үйл нь сэтгэлзүйн хүчин зүйлээс илүүтэй социал хүчин зүйлээр тайлбарлагдах ёстой гэдгийг үзүүлсэн. Социал баримт сэлт бол хувь бодгиалиас ангид оршиж, түүнийг хязгаарлаж, эргээд түүнд шахалт үзүүлж байдаг шинжүүдийг өөртөө агуулах бөгөөд нэг социал баримт сэлт нь өөр нэг социал баримт сэлтээр тайлбарлагдах ёстой гэдэг нь социологийн шинжилгээний талаар баримталж асан түүний үндсэн баримтлал байсан байна.

Эцэст нь тэмдэглэхэд, социологийн шинжилгээний төв нь хувь хүний түвшинд бус харин ямагт бүлгийн түвшинд байдаг онцлогтой. (Shepard and Greene, 2001: 6)



Социологийн шинжилгээний түвшин: макро ба микро социологийн судлах зүйл

• *Макро ба микро социологи*

Макро социологи нь томоохон бүтцүүд, хоорондоо холбоо бүхий социал институтууд, нийгмийн амьдралын өргөн цар хүрээтэй болоод түүхэн үйл явцуудыг судалдаг бол микро социологи нь үйлдэл, харилцан үйлчлэл болон утга учрын ертөнцийн бүрэлдэлтийг илүү сонирхдог. Голчлон бэлгэдлийн харилцан үйлчлэлийн онол, солилцооны онол ба этнометодологи зэрэг нь микро социологийн жишээнд дурьдагддаг бол марксизм, функционализм, системийн онолуудыг макро социологид хамруулдаг байна. (Marshall, 1998: 466)

Тэмдэглэх зүйл гэвэл, дээрх ялгаа нь заримдаа техник шинжтэй бөгөөд үүнийг хэт туйлшруулан, бүгдэд хамруулан хэрэглэхийг оролдох нь тийм ч өгөөжтэй бус гэдгийг анхаарахад илүүдэхгүй.

• *Социологи нийгмийн бусад шинжлэх ухаантай холбогдох нь. Эрхзүй норматив (хэм хэмжээт), харин социологи норматив бус шинжлэх ухаан болох нь*

Нийгмийн шинжлэх ухаанууд нь хэдийгээр өөр өөрийн түүхтэй, судлах зүйл, арга барилын ялгаатай салбарууд ч гэсэн бүгд хүний нийгэм хэмээх нэг талбарт ажилладаг учраас хоорондоо салшгүй холбоотой нь тодорхой. Энэхүү холбоо болоод ялгааг «Гэр бүл»-ийн сэдвээр жишээлэн дараах хүснэгтээс харж болно.

№	Нийгмийн шинжлэх ухаан	Судлах зүйлсийн жишээ
1	Социологи	Гэр бүлийн гишүүдийн тоо хэмжээ болоод эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт хоёрын хоорондын хамаарал
2	Антропологи	Бичиг үсэггүй нийгэм дэх гэр бүлийн хэв шинж
3	Сэтгэл судлал	Сэтгэл санааны байдалд төрөлтийн үйл явцын үзүүлэх нөлөөлөл
4	Эдийн засаг	Монгол гэр бүлийн жилийн орлогын түвшин
5	Улс төр судлал	Тухайн гэр бүлийн нийгмийн анги давхаргын харьяалал ба сонгуульд санал өгөх байдал
6	Түүх	Колоничлогдсон нийгэм дэх гэр бүлийн хэв шинж

Социологи норматив бус шинжлэх ухаан бол эрх зүй нь норматив шинжлэх ухаан юм. Энэ байдал нь тус шинжлэх ухаануудын төвлөрөн судалдаг нийгмийн амьдралын тэрхүү үзэгдлүүдийнх нь онцлогоос хамаарч байгаа болно.



Хяналтын асуултууд:

1. Социологийн үүслийг чухам яагаад О.Конттой холбон үздэг вэ?
2. О.Конт социологийн судлах зүйл, онцлогийн талаар юу гэж үзэж байсан бэ?
3. Социологийн анхны онолуудын нийгмийг судлах арга загвар нь яагаад философи зэрэг хүмүүнлэгийн ухааныхтай бус харин байгалийн шинжлэх ухааныхтай илүү ойр байсан бэ?
4. Аж үйлдвэрийн хувьсгалыг социологи үүсэхэд нөлөөлсөн нийгмийн шалтгааны нэгэнд тооцдгийн учир?
5. Э.Дюркхайм «социал баримт сэлтийг эд зүйл мэт авч үзэж, судлах ёстой» гэсний учрыг социологийн онцлогтой холбон тайлбарлана уу?
6. Социологийн шинжилгээний үндсэн онцлогийг эрхзүйн шинжлэх ухаантай харьцуулан тайлбарлана уу
7. Социологи ба эрхзүйн шинжлэх ухааны хоорондын үндсэн ялгаа юунд орших вэ?



Эх сурвалж:

1. Ritzer, G. (1996) *Sociological Theory*. New York: The McGraw-Hill Companies, Inc.
2. Stein, M. (1978) «*The Value of Community Studies*» in *Modern Sociology Introductory*. Reading. (Ed) Peter Worsley. Penguin Books
3. Coser, L.A. (1971) *Masters of Sociological Thought*. New York: Harcourt Brace Jovanovich, Inc.
4. Bilton, T. (1986) *Introductory Sociology*. London: Macmillan.
5. Shepard, J.M., Greene, R.W. (2001) *Sociology and You*. Illinois: NTC.
6. Marshall, G. A (1998) *Dictionary of Sociology*. Oxford University Press



Унших материал:

1. Гидденс, А. (2006) *Социологи*. УБ.
2. Смелзер, Н. (2001) *Социологи*. УБ.
3. Мөнхбат, О. (2008) *Социологийн онол*. УБ. Адмон
4. Глазырин, В.А. (Ред.) (2003). *Хууль зүйн социологи*. УБ.
5. Социологи сэтгүүл. №1-6, МУИС, Социологийн тэнхим. 2001-2005
6. Schaefer, R. T. (1989) *Sociology*. New York: McGraw-Hill, Inc.



Сэдэв - 2: Социологийн шинжилгээ, түүний онцлог (Э.Дюркхаймын «Амиа хорлолт»-ын шинжилгээний жишээн дээр ярилцах)

Хичээлийн зорилго: Амиа хорлох үзэгдэлд нэрт социологич Э.Дюркхаймын хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан хэлэлцэж, нийгмийн олон янзын үзэгдлийг авч үзэх социологийн арга, хандлагын уг чанар, онцлогийг тодруулан ойлгох, мөн нийгмийн тодорхой баримт сэлтийг социологийн онолын үүднээс хэрхэн тайлбарласныг жишээн дээр харуулах

Жич: (Хичээлийн эхэнд оюутнууд, хүмүүсийг амиа хорлоход хүргэдэг гэж бодож буй шалтгаануудыг дэвтэртээ бичиж, энэ талаар нь товчхон хэлэлцүүлэг өрнүүлж болно)

Гол ойлголтууд:

- ❖ Гаж үзэгдэл
- ❖ Нийгмийн аноми байдал
- ❖ Амиа хорлохуй
- ❖ Эгоист амиа хорлолт
- ❖ Альтруист амиа хорлолт
- ❖ Аноми амиа хорлолт
- ❖ Эв нэгдэл
- ❖ Социал баримт сэлт

Сэдвийн агуулга:

- ❖ Амиа хорлох үзэгдлийг психологийн үүднээс тайлбарлаж байсан нь
- ❖ Амиа хорлолтын төрлүүд: Эгоист, альтруист, аноми амиа хорлолтын шалтгаан ба онцлог
- ❖ Э. Дюркхайм амиа хорлох үзэгдлийн төрлүүдийг нийгмийн социал эв нэгдэл ба бүтцийн онцлогтой холбон тайлбарласан нь
- ❖ Бүлгийн социал эв нэгдэл хэт их ба хэтэрхий сул байх үед амиа хорлолт ихэсдэг болох нь
- ❖ Э. Дюркхайм амиа хорлохуйг тухайн хувь хүний сэтгэлзүйн онцлог юм уу аль эсхүл тодорхой нэг агшны сэтгэлийн байдлаар бус харин нас, хүйс, ажил, мэргэжил, итгэл үнэмшил, гэрлэлт, орлого гэх зэрэг өргөн хүрээтэй нийгмийн хүчин зүйлсийн дэвсгэр дээр тайлбарлагдах ёстой социал үзэгдэл гэж авч үзсэн нь социологийн шинжилгээний сонгомол нэг жишээ болох нь

Санал болгож байгаа арга:

1. Мэтгэлцээн
2. Бүлгээр ажиллуулах

Амиа хорлох үзэгдлийн социологийн шинжилгээ (Э.Дюркхайм)

• *Амиа хорлох үзэгдлийг психологийн үнднээс тайлбарлаж байсан нь*

ХИХ зууны сүүл үе нь өрнө дахины нийгмийн шинжилгээнд, тэр дундаа эдийн засгийн шинжилгээнд хүртэл сэтгэл зүйн хүчин зүйлсийн нөлөө ихээхэн моодонд орж байсан цаг үе байлаа. Чухам ийм цаг үед Дюркхайм «Амиа хорлохуй» хэмээх алдарт бүтээлээ бичиж хэвлүүлсэн бөгөөд энэ сэдэв нь магадгүй сэтгэл зүйн хүчин зүйлсээр тайлбарлагдахад хамгийн илүү дөхөмтэй үзэгдэл байсан юм.

Хүмүүс амиа хорлолтын шалтгааныг ихэвчлэн тухайн хувь хүмүүсийн сэтгэлийн хэт их гутралтай холбон үзэж, харин тухайн хүмүүсийн бүлэгтэйгээ холбогдсон холбоог нь анзаардаггүй нь харагддаг. Жишээ нь, хэн нэг эмэгтэй өөрийн хүүхдээ осолд орж нас барсныг сонсоод амиа хорлож, нэг хүн бизнес нь дампуурсны дараагаар амиа хорлож, залуу хүү найз охиндоо хаягдаад амиа хорлож...гм. Энэ мэт хувь хүний түвшний болон сэтгэл санааны нөхцөлүүд хүмүүсийн амиа хорлох сэдлийг төрүүлэхэд ихээхэн үүрэгтэй нь үнэн ч, энэхүү сэтгэл санааны байдлын өөрчлөлтүүд нь чухам амиа хорлох үзэгдлийн ар дахь зарим үнэнийг тайлахад хангалттай байж чаддаггүй нь судалгаагаар нэгэнт нотлогджээ. (Cole, 1980: 14)

Амиа хорлолтын хувь

Хэрвээ та амиа хорлолтын хувийг (тодорхой нэг ангилалд хамаарагдах 100 000 хүн тутмаас амиа хорлосон тохиолдлын тоо) судалж үзвэл амиа хорлох хандлага хүн бүрт адил биш байдгийг харж болно. Жишээ нь, эрчүүдийн амиа хорлох магадлал эмэгтэйчүүдийнхээс, протестант шашинтнуудынх католикуудынхаас, ганц бие эрчүүдийнх гэр бүлтэй эрчүүдийнхээс, илүү өндөр боловсролтой хүмүүсийнх доогуур боловсролтой хүмүүсийнхээс, цэрэг армийнхных энгийн иргэдийнхнээс илүү өндөр байдаг байна. Яагаад тэр вэ?

Таны бодлоор бол эрчүүд эмэгтэйчүүдээс илүү их сэтгэлээр унаж явдаг уу. Өндөр боловсролтой хүмүүс бага боловсролтой хүмүүсээс илүү сэтгэлээр унадаг байх нь уу? Үүнд шууд л тийм гэсэн хариулт өгөх аргагүй. Харин ч жишээ нь, боловсрол өндөртэй хүмүүс, бага боловсролтой хүмүүстэй харьцуулахад илүү сэтгэл өег явдаг байна.

Э.Дюркхайм амиа хорлох үзэгдлийг социологийн үнднээс тайлбарласан нь

«Амиа хорлохуй» хэмээх бүтээлдээ Э.Дюркхайм янз бүрийн бүлгүүдийн хоорондох амиа хорлолтын хувь өөр, өөр байдгийн учрыг тайлахыг оролдсон байна. Амиа хорлолтын талаарх Дюркхаймын онол нь социологийн үзэл хандлагыг тодорхой судалгаанд хэрэглэсний хамгийн шилдэг жишээний нэг гэгддэг. Дюркхайм социал бүлгүүд дэх амиа хорлолтын хувь нь бодгалийн зөвхөн сэтгэл санааны гутралаар тайлбарлагдах зүйл биш юм гэдгийг харуулахыг зорьсон. (Cole, 1980: 14)



Дюркхайм судалгаагаараа, эдийн засгийн уналтын үед хүмүүсийн амиа хорлох магадлал ихэсдгийг илрүүлсэн нь дээр дурьдагдсан сэтгэл санааны гутралын тайлбарыг зөвтгөж байгаа мэт харагдаж магад. Үнэхээр ч хүмүүс санхүүгийн хувьд гачигдалд орсон бол сэтгэлээр унаж таараа, үүнээс үүдээд амиа хорлох явдал ч ихсэх боломжтой. Гэтэл Дюркхайм, үүний сацуу эдийн засгийн цэцэглэлтийн үед ч амиа хорлолтын хувь өндөрсөж байсныг олж харжээ. Ийм нөхцөлд сэтгэл санааны гутралын онол үүнийг хэрхэн тайлбарлахсан билээ?

- *Амиа хорлолтын төрлүүд: эгоист, альтруист, аномн амиа хорлолтын шалтгаан ба онцлог*

Амиа хорлолтын талаар ихээхэн хэмжээний материал судалсныхаа дараагаар Дюркхайм хэд хэдэн төрлийн амиа хорлолт байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. (Bilton, 1996: 613-615)

Эгоист амиа хорлолт

Эхний хоёр төрөл болох эгоист ба альтруист амиа хорлолт нь тухайн бодгалийн хувьд учир холбогдол бүхий, хэлхээ холбоонд оршдог тэрхүү бүлэгтэйгээ хэр зэрэг зохицолтой байдгаас нь хамаармал шинжтэй.

Хэрвээ бодгаль тэрхүү учир холбогдол бүхий бүлэгтээ дасан зохицож чадаагүй бол тухайн хүн эрэгтэй ч байсан эмэгтэй ч байсан хамаагүй, зорилго нь сарниж, стресст орсон үедээ дэмжлэг авч чаддаггүй байна. Ийнхүү өөрсдийгөө нийгмээс эсвэл бүлгээсээ тусгаарлагдсан хэмээн үзснээсээ болж амиа хорлосон хүмүүсийн амиа хорлолт нь эгоист амиа хорлолт гэж нэрлэгддэг.

Альтруист амиа хорлолт

Нөгөө талаас бүлэгтээ хэтэрхий ихээр холбогдон дасах явдал ч байна. Бүлэг хичнээн их чухал болох тусам бодгалийн амьдрал төдий чинээ үнэ цэн багатай болдог. Хувь амьдралаа (бүлэгтэйгээ харьцуулахад) чухал гэж тооцдоггүйгээсээ болж амиа хорлогсдыг Дюркхайм альтруист амиа хорлолт хэмээн нэрлэжээ.

Өөрөөр хэлбэл, хэтэрхий их хэмжээний юмуу эсвэл хэт бага түвшний социал дасан зохицол нь амиа хорлолтод хүргэх нөхцөлийг бий болгодог аж.

Аномик амиа хорлолт

Амиа хорлолтын өөр нэг төрөл нь аномик амиа хорлолт юм. Дюркхаймын үүзэж байснаар хувь хүмүүсийн өдөр тутмын зан үйлүүд утга учир бүхий зорилго чиглэлтэй байх аваас, мөн тодорхой дүрэм журам хийгээд хэм хэмжээнд захирагдаж байх аваас тэд өөрийн амьдралдаа сэтгэл хангалуун байх аж. Хэрвээ тэрхүү зорилго нь утга учраа алдах юм бол тухайн хүн учраа олохоо больж, амьдрал нь утгагүй болж үүний улмаас амиа хорлох магадлал ихэсдэг. Дюркхайм, нэг бол нийгэм дэх огцом өөрчлөлт эсвэл хувь хүний социал амьдрал дахь огцом өөрчлөлт нь аномн байдал буюу ямар ч эмх журамгүй мэт байдлыг үүсгэж амиа хорлох магадлалыг ихэсгэдгийг тогтоожээ.

Аномик амиа хорлолтын онол нь эдийн засгийн донсолгоонт үеүдийн туршид (энэ нь огцом өсөлтийн үе ч байсан, эс бөгөөс огцом уналтын үе ч байсан ялгаагүй) ихсэх амиа хорлолтын учир холбогдлыг тайлбарлах боломжтой.

Энэ онол, өөрсдийнх нь социал нөхцөлүүд гэнэт орвонгоороо эргэсэн хүмүүсийн бүлэг дотор ихэсдэг амиа хорлолтын хувийг тайлбарлахад бас ашиглагдаж болно.

Фаталист амиа хорлолт

Дюркхаймын ангилсан амиа хорлолтын төрлүүдээс харьцангуй бага дурьдагддаг нь фаталист амиа хорлолт юм. Аномик амиа хорлолт нь зохицуулалт хэтэрхий сул байх үед тохиолддог бол харин зохицуулалт хэтэрхий их үед фаталист амиа хорлолт гарах магадлал ихэсдэг байна. Дюркхайм, «дарангуй дэг журмын улмаас ирээдүй нь ямар ч өршөөлгүйгээр хаагдаж, хүсэл эрмэлзэл нь балмадаар боймлогдсон хүмүүсийн» хувьд фаталист амиа хорлолт ихэсдгийг илрүүлжээ. (Ritzer, 1996: 91) Үйлдэл болгоныг нь дарангуйлан журамладгаас болоод итгэл найдвар алдсаны улмаас амиа хорлосон боолын жишээг энд эш татаж болох юм.

- *Э.Дюркхайм амиа хорлох үзэгдлийн төрлүүдийг нийгмийн социал эв нэгдэл ба бүтцийн онцлогтой холбон тайлбарласан нь*

Социологичийнхоо хувьд Дюркхайм амиа хорлосон бодгалийн хувь үйлдэл дээр голлон анхаараагүй байна. Энэ нь сэтгэл зүйчдэд орхих ажил юм. Харин тэрээр амиа хорлолтын хувь дахь хэлбэлзлүүдийг тайлбарлахыг илүү сонирхож, амиа хорлолтын хувь яагаад аль нэг бүлгийн дунд нөгөө бүлэгт байдгаасаа их байдгийг тайлбарлахыг чухалчилсан байдаг. Үүнийгээ тэрээр өөрийн судалгааны суурь үзэл баримтлалын нэг болох нийгмийн эв нэгдлийн онолтой холбон тайлбарласан байна.

Амиа хорлолтын төрлүүдийг социал шалтгаацлын байдлаар нь багцлан үзүүлбэл:

Нягтрал	Бага →	Эгоист амиа хорлолт
	Өндөр →	Альтруист амиа хорлолт
Зохицуулалт	Бага →	Аномик амиа хорлолт
	Өндөр →	Фаталист амиа хорлолт

Э.Дюркхайм амиа хорлохуйг, тухайн хувь хүний сэтгэлзүйн онцлог юм уу аль эсхүл тодорхой нэг агшны сэтгэл санааны байдлаар бус харин нас, хүйс, ажил, мэргэжил, итгэл үнэмшил, гэрлэлт, орлого гэх зэрэг өргөн хүрээтэй нийгмийн хүчин зүйлсийн дэвсгэр дээр, аль ч цаг үеэс үл хамааран бүлгээс бүлэгт тогтмол шинжтэйгээр тайлбарлагдах ёстой социал үзэгдэл гэж авч үзсэн нь социологийн шинжилгээний сонгомол нэг жишээ болсон юм.



Хяналтын асуултууд:

1. Гаж үзэгдэл гэж юу вэ тодорхойлно уу.
2. Гаж үзэгдэл, гэмт хэрэг хоёр давхцах ойлголт мөн үү?
3. Э. Дюркхайм ямар баримт болоод үндэслэлүүдэд тулгуурлан амиа хорлох үзэгдлийг зөвхөн психологийн бус харин социологийн үүднээс тайлбарлагдах ёстой үзэгдэл гэж үзсэн бэ?
4. Амиа хорлохуйг социал баримт сэлт болгож буй гол үзүүлэлтүүдийг хэлнэ үү.
5. Эрт үед Монголд өндөр настай хүмүүстэй холбоо бүхий «ам барих» заншил байсныг гэмт хэрэг юм уу, амиа хорлолттой холбон үзэж болох уу? Болох бол яагаад, үгүй бол яагаад?
6. 1990-ээд оноос өмнөх ба хойших тодорхой нэгж хугацаан дахь амиа хорлолтын статистикийг харьцуулан үзээд мэтгэлцээн өрнүүлнэ үү?



Эх сурвалж:

1. Cole, S. (1980) The Sociological Method: An Introduction to the Science of Sociology. Chicago: McNally Publishing Company
2. Bilton, T. (1986) Introductory Sociology. London: Macmillan.
3. Ritzer, G. (1996) Sociological Theory. New York: The McGraw-Hill Companies, Inc.



Унших материал:

1. Оюунханд, Ш. (2005) Нийгмийн девиаци ба амиа хорлохуй. УБ.
2. Смелзер, Н. (2001) Социологи. УБ.
3. Глазырин, В.А. (2003) Хууль зүйн социологи. УБ.
4. Сайнхишиг, Г. (2006) Социологийг үндэслэгч суутнууд. УБ.
5. Социологи сэтгүүл - 4. МУИС. 2003,
6. Schaefer, R. T. (1989) Sociology. New York: McGraw-Hill, Inc.

БҮЛЭГ-II. Социологийн онолын хөгжил

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Социологийн онолын хөгжил	Сонгодог хийгээд орчин үеийн социологийн онол: Үе шат, парадигмууд	4	Лекц

Хичээлийн зорилго: Социологийн хөгжлийн явцад бий болсон онол үзэл баримтлалыг судалж, нийгмийн амьдралын үйл явц, үзэгдэл юмсыг тайлбарлахдаа хэрэглэх ур чадварыг эзэмшиж, Мэдлэг-Хэрэглээ-Ур чадвар гэсэн схемээр оюутныг ажиллаж сургахад энэхүү хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Позитивизм
- ❖ Ойлгож буй социологи
- ❖ Парадигм
- ❖ Нийгмийн баримт сэлтийн парадигм
- ❖ Дефиницийн парадигм
- ❖ Нийгмийн зан үйлийн парадигм

Сэдвийн агуулга:

- ❖ Нийгмийн онолын тодорхойлолт
- ❖ Социологийн онолын хөгжилд нөлөөлсөн хүчин зүйлс
- ❖ Орчин үеийн социологийн онолууд
- ❖ Парадигмын тухай

Санал болгож буй арга:

Энэхүү сэдвийг заахдаа Бүлгээр ажиллах аргыг ашиглах нь тохиромжтой. Ингэхдээ оюутнуудыг 5-6 хүнтэй бүлэгт хуваан тодорхой сэдвүүдийг сонгуулан, сонгосон сэдвээ социологийн онол, парадигмын хүрээнд тайлбарлуулна.

Эрх зүйн социологийн хүрээнд онолыг ойлгох ойлголт нь ерөнхий социологийн хийгээд бусад нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны ойлголттой нэгэн ижил боловч практик хэрэглээ тал дээр голлон анхаарсан прагматик шинжтэй, хүн судлагдахуун бүхий салбарын хувьд хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хуулийн засаглалыг эрхэмлэсэн онцлогтой аж.

Нийгмийн онолыг янз бүрээр тодорхойлох нь байдаг бөгөөд тухайлбал:

1. Аливаа юм үзэгдлийг тайлбарласан тайлбар,
2. Юмс үзэгдэл, зан үйлийг системтэй авч спекулатив байдлаар тайлбарласан тайлбар,



3. Юмс үзэгдлийн хэв шинж болон бодит байдлыг урьдчилан таах юм уу тайлбарлахад чиглэсэн логик нотолгоо бүхий өгүүлэмжийн цогц,
4. Зан үйл, үзэгдэл юмс, нөхцөл байдлын уялдаа холбоо болон тэдгээр нь яагаад өрнөн бий болж байгаа талаарх системтэй тайлбарыг агуулсан цогц хувьсагч,
5. Онол гэдэг нь эмпирик ертөнцийг (хүний мэдрэхүйд шууд болон шууд бус байдлаар мэдэгдэж буй) тайлбарлахаар зорьсон (яагаад гэсэн асуултад хариулсан хариулт) харьцангуй хийсвэр, ерөнхий өгүүлэмжийн цогц гэх мэтчилэн олон жишээ татаж болох юм.

Дээрх тодорхойлолтуудын нийтлэг шинж нь тайлбарлал гэсэн ойлголтоор илэрч байгаа бөгөөд онолын тусламжтайгаар бид нийгмийн үзэгдэл юмсыг тайлбарлаж, тэдгээрийг шийдвэрлэх шийдлийн хувилбар, нийгмийн технологийг бий болгож байдаг билээ. Энэ утгаараа онол гэдэг нь юмс үзэгдлийн шалтгаан-өрнөл-үр дагаврыг тайлбарлаж, шийдлийн загвар, хувилбарыг санал болгож байдаг шинжлэх ухааны хэрэглэгдхүүн юм.

Олон тооны социаль онол үзэл баримтлалууд нийгэм-хүмүүнлэгийн ухаанаас ангид хол хүмүүс төдийгүй энэ чиглэлийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг хүртэл чиг баримжаа алдахад хүргэх нь бий. Харин нийгмийн шинжлэх ухааны эдгээр онол үзэл баримтлалыг цэгцлэн эмхэлсэн ангилал тэдгээр онолыг ойлгож, ашиглаж, хэрэглэж сурахад бидэнд тусладаг аргазүй болж өгдгөөрөө чухал ач холбогдолтой юм.

Социологийн онолын хөгжлийн явцад гарсан хэд, хэдэн томоохон онцлогуудыг нэрлэж болно. Социологийн онол бүрдэх үйл явцад шийдвэрлэх нөлөө үзүүлсэн чиглэл бол байгалийн шинжлэх ухааны онол арга зүйн нөлөөн дор бий болсон позитивизм юм. О.Конт, Г.Спенсер зэрэг позитивизмын эхэн үеийн төлөөлөгчид социологийн судлах зүйлийг тодорхойлохдоо өөрсдийн үзснээр нийгмийн амьдралд хамгийн чухал үүрэгтэй гэсэн социаль хууль зүй тогтлыг сонгон авч, тэдгээрийнхээ тусламжтайгаар социологийн судлагдхууны хүрээг тодотгон, товч томруун байдлаар томъёолохыг хүсч байлаа. Энэ үеийн төлөөлөгчид тэр үед хүчийг олж, танин мэдэхүйн үйл явцдаа ихээхэн амжилтад хүрсэн байгалийн ухааны хүчтэй нөлөөн дор оршиж байв.

Эдгээр сэтгэгчид социологийн судлах зүйлийг «нийгмийн статик болон динамик хууль зүй тогтол», «хувьслын хууль зүй тогтол» гэх зэргээр тодорхойлон тэдгээрийг байгалийн объектив хууль зүй тогтолтой адилтган үзэж байлаа. Контын позитив сургаалийн нөлөөн дор оршиж асан хожуу үеийн төлөөлөгчид ч гэсэн мөн л байгалийн үзэгдэл юмстай ижил объектив шинжтэй социаль үзэгдэл юмсийг социологи судлах ёстой гэсэн байр суурьтай байв (Walsh; 2006, Спенсер; 1998). О.Конт «Байгалийн бодит байдлын нөлөөн доор хүний оюун санаа, ёс суртахуун хэрхэн өөрчлөгдөх хууль зүй тогтол», Ф.Теннис «Нийгмийн гишүүдийн объектив харилцаа, уялдаа холбооны хууль, зүй тогтол» бол социологийн судлагдхуун юм хэмээн үзэж байлаа.

Түүнчлэн О.Конт, Г.Спенсер нар өөрсдийн үзэл баримтлалыг «Нийгмийн физик» хэмээн нэрлэн О.Конт оюун санааны хөгжлийн гурван шатны хууль, Г.Спенсер «Түгээмэл хувьслын хууль, Ф.Теннис «Бүх нийтийн тэгш бус байдлын доторх тэгш байдлын тухай хууль» гэх зэргээр байгалийн хуулиудын адил нийгмийн хуулиудыг бий болгох гэсэн хандлага хүчтэй байсны бас нэгэн жишээ юм.

Байгалийн ухааны онол, арга зүйг анх О.Конт социологид илүүтэйгээр хэрэглэсэн юм. Үүнтэй холбогдуулан Английн социологич Спенсер «Байгалийн тухай шинжлэх ухааныг нийгмийн тухай шинжлэх ухаантай холбож өгсөн явдал нь О.Контын гол гавьяа» гэж хэлсэн бий.

Эмпирик судалгааны аргын хувьд ч мөн ялгаагүй байгалийн шинжлэх ухааны парадигм ноёрхож байлаа. О.Конт социологийн үндсэн 4 аргыг тодорхойлохдоо «Туршилт ажиглалт, харьцуулалт»-ын арга нь надаас өмнө байгалийн ухаанд ашиглагдан үр дүнтэй нь нотлогдсон юм гэж хүлээн зөвшөөрчээ. Ф.Теннис «Цэвэр социологи»-ийнхоо эмпирик түвшин болох «Социографик»-ын үндсэн аргыг ажиглалт, харьцуулалт гэж үзэж байв.

Позитивизмын дараах үеийн сэтгэгч Э.Дюркхайм социологийн онолын объектив шинжийг улам бүр онцлон социологийн онол нь «Хүний сэтгэхүйн гадна оршиж, хүнд албадлагын нөлөө үзүүлдэг социаль баримт сэлт»-ийг судална гэж тодорхойлж байв.

Э.Дюркхайм социологийн арга зүйн хувьд мөн л байгал шинжлэлийн объектив судалгааны аргуудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байсан агаад «сорилын аргыг судлаачдын субъектив нөлөөн дор явагддаг болохоор социологид өргөнөөр ашиглах боломжгүй» гэж үзэж байснаараа багахан ялгагддаг. Ийнхүү байгалийн ухааны нөлөөлөл социологийн онол, судалгааны аргыг тодорхойлоход давамгайлдаг асан эл хандлага хорьдугаар зууны эхэн үе хүртэл үргэлжилсэн билээ.

Харин Г.Зиммел, М.Вебер зэрэг сэтгэгчид социологийн онолын сэтгэлгээний тавцанд гарч ирснээр судлах зүйлийн талаарх уламжлалт хандлагыг өөрчилж, байгалийн ухааны нөлөөллөөс социологийг чөлөөлөх үйл явц эхэлсэн билээ.

Эдгээр эрдэмтэд позитивист онолын дүрслэн зураглах дескриптив хандлагыг үгүйсгэн тайлбарлах, ойлгох гэсэн интерпретив зарчмыг илүүд үзснээр социологийн онолын хөгжилд «Ойлгож буй социологи» гэсэн шинэ чиглэлийг бий болгосон нь улмаар орчин үеийн социологид ихээхэн нөлөө үзүүлсэн парадигмын эхлэл суурь болсон юм.

Г.Зиммел бээр социологийг тодорхой нэг үзэгдэл юмсыг судалдаг ухаан хэмээн үзэхээсээ илүүтэйгүүр нийгмийн шинжлэх ухааны өвөрмөц арга зүй мөн гээд энэ утгаараа нийгмийн бусад шинжлэх ухааны түгээмэл арга зүй байж чадна гэж үзжээ. Тэрээр социологи нь аливаа шинжлэх ухааны мөр гараагүй тийм атар онгон асуудлыг хайх шаардлагагүй агаад хүний нийгэмд ийм үзэгдэл юмс, асуудлыг олно гэдэг бол хий дэмий хүч цаг барах явдал гэж байлаа. Г.Зиммел бичихдээ «Социологи нь хүнийг нийгмийн амьтан, нийгмийг бүхий л түүхэн үйл явцыг тээгч хэмээн үзэж



судалдаг хийгээд өөр бусад нийгмийн ухааны хөндөж судалдаггүй тийм салбарыг нээж олоогүй хэдий ч энэ бүх ухааны хувьд шинэ зам болох шинжлэх ухааны аргыг нээснээрээ, энэ арга нь бүхий л асуудлыг судлахад хэрэглэж болдгоороо онцлог» гэжээ (Осипов; 1991).

М.Вебер позитивистуудын байгалийн ухааныг хуулбарлах гэсэн туйлширсан хандлагыг үгүйсгэн нийгэм, түүхийг шинжлэх ухаанчаар судалж чадахуйц түүхийн социологи гэсэн шинэ салбарыг үүсгэсэн гэж судлаачид үздэг аж (Ritzer; 1996). М.Вебер социологийн судлах зүйлийг асуудлыг нэгэн мөр болгон хайрцаглахаас татгалзаж, харин түүний мөн чанарыг тодотгохыг эрмэлзэж байсан нь юмс үзэгдлийн утга учрыг ойлгомжтойгоор тайлбарлаж танин мэдэхэд чиглэсэн «ойлгож буй социологи» хэмээн нэрийдсэн түүний үзэл баримтлалд тусгалаа олжээ. Түүнчлэн тэрээр социологийг нийгмийн бусад шинжлэх ухаантай хэрхэн бүтээлчээр хамтран ажиллаж болох тухай асуудлыг хөндсөн нь эл ухааныг бусад ухаанаас ялгаатай болохыг нотлохыг эрмэлзэж асан өмнөх үеийн сэтгэгчдээс өвөрмөц байж чаджээ.

Эмпирик үйл явцын нэгтгэгдсэн нэгэн төрөл байдал болон ерөнхий төсөөллүүдийг хэв шинжид оруулан хэлбэржүүлэхийг эрмэлздэг социологи, соёлын ач холбогдол бүхий индивидуаль үйлдэл, бүтцийг тайлбарлан, тэдгээрийн учир шалтгааныг задлан шинжилдэг түүх нь нэг нэгэндээ хэрэгцээтэй үйлчилгээг үзүүлж чадна хэмээн М.Вебер тооцож байлаа.

Социологи нь өөрийн бүтээсэн түгээмэл ертөнц буюу «идеаль хэв шинж»-ийн тусламжтайгаар эмпирик ертөнцийг судлах агаад хэдийгээр эдгээр хэв шинж эмпирик бодит байдлыг бүрэн дүүрэн илэрхийлэн хамарч эс чадах авч түүнийг илүү сайн ойлгох боломж олгодог байна. Түүх бол эмпирик түвшинд ерөнхийлөн нэгтгэх боломжгүй эмпирик үйл явцуудаас бүрддэг тул социологийн боловсруулсан дээрх түгээмэл ертөнцийн тусламжтайгаар түүхийн тэдгээрх үзэгдэл, үйл явцын учир шалтгааныг тайлбарлан таньж болох аж.

Веберийн үзсэнчлэн ойлгомжтойгоор тайлбарлагдаж чадахуйц утга учрыг агуулсан хүний зан үйл, үйлдлийг судалдаг социологи нь байгалийн ухаанаас ялгагдахуйц социаль парадигмтай байх ёстой гэж үзэж байсан нь дараа дараагийн сэтгэгчдийн үзэл бодолд хүчтэй нөлөө үзүүлж, улмаар социологийн судлах зүйлд хандах хандлагад чухал өөрчлөлт хийж чадсан билээ.

Ийнхүү шинээр бүрэлдэн үүсэж байсан социологийн сонгодог төлөөлөгчид, тэдгээрийн онол, үзэл баримтлалуудад эл ухааны судлагдхуун, судалгааны аргын талаар байгалийн ухааны нөлөөллийг дэмжсэн хийгээд үгүйсгэсэн зөрчил бүхий хоёр хандлага зонхилж байсан нь ХХ зууны социологийн хөгжилд голлох нөлөө үзүүлсэн билээ.

Хорьдугаар зуун бол социологийн онолын хувьд ийнхүү позитивизм хийгээд ойлгож буй социологийн хоорондын өрсөлдөөнөөр тодорхойлогдож ирсэн бөгөөд энэ зууны төгсгөл, ХХI дүгээр зууны эхлэл үе гэхэд онолын сэтгэлгээнд томоохон парадигмууд үүсч хөгжсөн онцлог шинжээр тодорхойлогдож байна.

Орчин үеийн социологийн онолын ангиллын дотор тэдгээр онол үзэл баримтлалуудыг ижил төсөөтэй шинжээр нь төрөлжүүлэн бүлэглэсэн ангилал болон тэдгээрийг эсрэг тэсрэг шинжээр нь бүлэглэн ангилсан ангиллууд зонхилдог байна.

Нэгдэх ангилал болох социологийн онол, үзэл баримтлалуудыг эсрэг тэсрэг шинжээр буюу юмс үзэгдлийг тайлбарлахдаа зарчмын өөр өөр байр сууринаас хандаж байгаа байдлаар нь нэгэн бүлэг төрөлд харьцуулан хуваах нь нэлээд хожуу бий болсон хандлага юм. Энэ хандлагын хамгийн тод жишээ бол Английн социологич Э.Гиддэнсын «онолын дилемм» хэмээх нэрлэсэн ангилал юм.

Тэрээр орчин үеийн социологийн онолын хөгжилд функционализм, структурализм болон символик интеракционизм хийгээд марксизм гэсэн дөрвөн онолын хандлагыг хамгийн чухал ач холбогдолтойд тооцоод тэдгээрийг хэд хэдэн дилеммэд хуваажээ. Ингэхдээ нийгмийн бүтэц хийгээд хүний үйл ажиллагаа мөн нийгэм дэх зөрчилдөөн хийгээд зөвшил зэрэг социологийн үндсэн ойлголтуудыг хэрхэн тайлбарлаж байгаагаар нь социологийн үзэл баримтлалуудыг онолын эдгээр дилеммэд хуваасан байна.

Дилемм бүр өөртөө харьцангуй эсрэг тэсрэг байр суурь бүхий социологийн онолуудыг багтааж байгаа юм. Тухайлбал, онолын нэгдүгээр дилеммыг Э.Гиддэнс:

«Нэгдүгээрх нь нийгмийн бүтэц хийгээд хүний үйл ажиллагааны асуудалтай холбоотой. Эл асуудал нь ямар хэмжээнд бид өөрийн амьдралынхаа нөхцөл байдалд идэвхтэйгээр нөлөөлж буй бүтээлч эхлэлийг тээгчид вэ хэмээсэн асуултад оршино. Магадгүй үйлдлийн ихэнх хэсэг маань бидний хяналтаас ангид оршиж байгаа нийгмийн суурь хүчнүүдийн нөлөөллийн үр дүн байж болох билээ. Үүнд хэрхэн хандаж буйгаараа социологичид хуваагдсаар ирсэн бөгөөд хуваагдсаар байна. Символик интеракционизм хүний зан үйлийг бүрдүүлж буй идэвхтэй бүтээлч шинжийг онцолдог бол бусад гурван хандлага (марксизмын зарим хувилбарыг эс тооцвоос) нь нийгмийн инстиутаас бидний үйл ажиллагаанд үзүүлж байгаа албадлагын нөлөөлөлд гол анхаарлаа хандуулдаг» гэж тодорхойлсон байна (Гиддэнс; 1999).

Хоёрдахь ангилал буюу социаль онол сургаалийг ойлголт ухагдхууны аппарат, даган мөрдөж байгаа үндсэн зарчмууд хийгээд тайлбарлалын хэв загварын ижил төсөөтэй шинжээр бүлэглэсэн ангиллын тоонд позитивист чиглэл, функциональ сургууль, Чикагогын сургууль гэх мэт онолын чиглэл, сургуулиудаар нь хуваасан ангилал орно. Энэ ангилал нь харьцангуй уламжлалт шинжтэй бөгөөд баруун, зүүн Европ ба хойд Америкийн социологийн аль алинд нь бий.

Мөн эл ангилалд социологийн онолуудыг судлагдхууны түвшнээр нь буюу макросоциологи ба микросоциологи гэж ангилсан болон ерөнхий, тусгай буюу салбар онолууд гэсэн хэв шинжийн ангилал мөн харьяалагдана. Гэхдээ хэрэв түвшнээр ангилсан нь өрнө, дорнын социологид нийтлэг



тохиолддог бол хэв шинжийн ангилал хуучин зөвлөлтийн одоогийн Оросын социологид түгээмэл ажиглагддаг.

Дээр дурдсаны зэрэгцээ хоёрдахь ангиллын хувьд хамгийн чухал ач холбогдолтой бөгөөд цаг хугацааны хувьд ч ихээхэн залуу нэгэн ангилал байдаг нь парадигмын баримтлал юм. Парадигм бол дан ганц социологийн төдийгүй бүхий л нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны хувьд тун чухал ойлголт билээ. Эдүгээ цагт социологийн ухаанд парадигмыг дараах хэдэн үндсэн функцээр авч хэрэглэж байна. Үүнд:

- ❖ Орчин цагийн социологийн онол үзэл баримтлалуудыг ангилан бүлэглэх аргазүй болгон хэрэглэдэг,
- ❖ Социологийн шинжлэх ухааны бүхий л хөгжил түүний дотор онолын сэтгэлгээний хөгжлийн өрнөх арга зам, хэлбэрийг тайлбарлах арга зүй,
- ❖ Баялаг агуулгатай, нарийн түвэгтэй, олон талт байдал бүхий судлагдхуунтай социологийн шинжлэх ухааны статус, түүнийг олон парадигмт ухаан болохыг нотлох зэрэг функцүүд орно.

Үүнээс үзэх ахул парадигм бол маш өргөн утгатай, чухал ач холбогдол бүхий ойлголт болох нь харагдаж байгаа агаад энэ хэсэгтээ бид парадигмыг социологийн онолыг ангилах арга зүй болох талаас нь авч үзнэ.

Парадигмын тусламжтайгаар социологийн онол үзэл баримтлалыг ангилсан ангилал цөөнгүй бий. Тухайлбал, Америкийн социологич Роберт Фридэрх нийгмийн интеграци, зөвшлийг онцолсон системийн парадигм болон эмх цэгцгүй, зөрчилдөөн хямралд анхаарал хандуулдаг зөрчилдөөний парадигм гэсэн ангиллыг санал болгосон нь бий. Эл ангилал нь Томас Куны «Шинжлэх ухааны хувьсгалуудын бүтэц» бүтээлийг хэвлэгдсэн даруйд парадигмын баримтлалыг ашиглан хийсэн хамгийн анхны ангилал юм.

Түүнчлэн АНУ-ын социологич Ж.Рицэр мөн парадигмын тусламжтайгаар орчин үеийн социологийн онол үзэл баримтлалуудыг ангилсан бөгөөд ингэхдээ эдгээр онолын 1. Онолын эх сурвалж, 2. Социологийн судлах зүйлд хандах хандлага, төсөөлөл, 3. Судалгааны аргууд болон 4. Тулгуур онолуудын ижил төсөөтэй байдал гэсэн үзүүлэлтийг ашигласан байна (Мөнхбат; 2008). Ингээд Рицэр

1. Социаль баримт сэлтийн парадигм,
2. Социаль дефиницийн болон
3. Социаль зан үйлийн парадигм гурван үндсэн парадигмыг тодорхойлжээ.

Ж. Рицэрын (1996) үзснээр социологийн ухааны эрдэмтдийн нийгэмлэг өөрсдийн үнэт зүйлс, үзэл бодол, итгэл үнэмшилд суурилсан онол арга зүйн баримжааллын дагуу дээрх гурван парадигмд хуваагдаж, танин мэдэхүйн хүрээнд өрнөж буй мэдлэгийн өрсөлдөөнд оролцдог байна.

Дээрх парадигм бүр орчин үеийн нийгмийн онол үзэл баримтлалууд дээр суурилж, тэдний тусламжтайгаар социологийн ухааны онол хийгээд эмпирик эрэл хайгуул, судалгаа шинжилгээг удирдан явуулах арга зүйн үндэс нь болдог байна. Одоо эдгээр парадигмыг эх сурвалж, судлагдхуун,

судалгааны арга болон тулгуур онолууд гэсэн шалгуур тус бүрээр нь нягтлан авч үзье.

Рицэрийн үзснээр Социаль баримт сэлтийн парадигмын хувьд:

1. Сонгодог төлөөлөгч нь Францын социологич Э.Дюркхайм бөгөөд түүний «Социологийн аргын дүрмүүд» болон «Амиа хорлохуй» бүтээл эл парадигмын танин мэдэхүйн эх сурвалж болдог байна.
2. Энэ парадигмын гол төвлөрөл (focus) нь нийгмийн баримт бэлт буюу нийгмийн томоохон социаль институт, социаль бүтцүүд бөгөөд эдгээр баримт сэлт хүмүүсийн амьдрал хийгээд үзэл бодол, үйлдэлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэж үзнэ.
3. Эл парадигмын хүрээнд ярилцлага-анкетын асуулга болон түүхэн харьцуулалтын аргууд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд юмс үзэгдлийг бидний ажиглалтад өртөж байгаа гадаад шинж тэмдэг дээр нь тулгуурлан дүрслэн зураглах нь түлхүү байна.
4. Бүтэц-функционализм болон зөрчилдөөний онол нь энэхүү парадигмын тулгуур онолуудыг бүрдүүлнэ. Түүнчлэн системийн үзэл баримтлал мөн харьяалагдана.

Энэхүү парадигмын тулгуур онолуудын үүднээс гэмт хэргийн өсөлтийн шалтгааныг макро түвшний буюу тухайлбал, ажилгүйдэл, ядуурал, засаглал, статус өөрчлөхийн төлөө зөрчил тэмцэл зэрэг системийн шинжтэй хүчин зүйлсээс хамаарна хэмээн үзэж, улмаар үр дагаврын хувьд нийгмийн системийн тогтвортой байдал, зөвшлийг алдагдуулан улмаар хямрал сүйрэлд хүргэх аюултай хэмээн үздэг байна.

Орчин үеийн социологийн хоёрдогч томоохон парадигм болох дефиницийн парадигмын хувьд:

1. Германы социологич М.Вебер бол энэхүү парадигмын сонгодог төлөөлөгч нь бөгөөд түүний «Ойлгож буй социологи» болон «Нийгмийн үйлдлийн тухай» бүтээлүүд нь мэдлэгийн эх сурвалж нь болно.
2. Социологийн судлагдхуун бол хүмүүсийн үйлдэл, харилцан үйлдэлд төвлөрөх ёстой бөгөөд тэдгээр агуулагдаж буй субъектив утга учир бол танин мэдэхүйн үндсэн асуудал юм гэсэн байр сууриас эл парадигм хандана.
3. Ярилцлага, анкет асуулгын зэрэгцээ ажиглалтын арга тус парадигмын судалгааны аргын үндсэн яс модыг бүрдүүлнэ.
4. Тулгуур онолын хувьд феноменологи социологи, символик интеракционизм болон этнометодологи хамаарна.

Нийгмийн дефиницын парадигмын тулгуур онолын хүрээнд гэмт хэргийг тайлбарлахдаа бидний өдөр тутмын амьдралын туршлагаас үүдэн тайлбарлахыг эрмэлздэг бөгөөд бие хүний субъектив дотоод ертөнцийг нээн илрүүлэх, хүмүүс хоорондын үйлдэлд агуулагдаж байгаа утга учир (ач холбогдол)-ыг ойлгох замаар тайлбарлана. Бид нэг л үйлдлийг олон янзаар ойлгон хүлээж авч байдаг бөгөөд жишээ нь, улаан гэрлээр уулзвар нэвтэрч байгаа машиныг харсан хүн уг үйлдлийг дүрэм зөрчиж, улмаар



осол аваарт хүргэх аюултай хэмээн үздэг атлаа хэрэв тухайн машин нь тусгай дохиололтой, түүнээ асаасан бол хэвийн байх ёстой зүйл мэтээр хүлээж авдагтай ижил.

Социологийн гуравдах үндсэн парадигм бол социаль зан үйлийн парадигм агаад үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу авч үзвэл:

1. Сонгодог төлөөлөгч, эх сурвалжийн хувьд Б. Скиннэр болон түүний бихевиорист чиглэлээр туурвисан бүтээлүүд орно.
2. Социологи нь хүний зан үйлд анхаарлаа хандуулах ёстой хэмээн үздэг бөгөөд урамшуулал хийгээд шийтгэл нь хүний аливаа зан үйл үйлдлийг урьдчилан нөхцөлдүүлдэг гэж үзнэ.
3. Эл парадигмын судалгааны үндсэн арга бол туршилтын арга бөгөөд
4. Тулгуур онолуудын хувьд бихевиорист социологи, солилцооны онол, рационал сонголт болон сүлжээний үзэл баримтлалууд орно.

Бихевиорист социологийн үүднээс гэмт хэргийг тайлбарлахдаа үйлдэгч этгээдийн зан үйл, түүнийг бүрэлдэн тогтоход нөлөөлсөн гэр бүлийн орчин, нийгэмшлийн онцлог зэрэг социаль хүчин зүйлтэй холбон тайлбарладаг байна. Сүүл үеийн бихевиорист чиглэлийн үзэл баримтлалын дотор гэмт хэргийг рациональ сонголтын онол үүднээс буюу гэмт хэрэг үйлдэж олж авч болох ашиг хонжоо, олз омог зэргийг урьдчилсан тооцсон, ухамсартай үйлдэл хэмээн үзэх хандлага давамгайлах болж байна (Deflem; 2009). Жишээлбэл, авлига авч байгаа албан тушаалтан гэмт хэрэг үйлдэж буйгаа сайтар ухамсарлаж байдаг бөгөөд хууль бусаар баяжих гэсэн эрмэлзэлдээ хөтлөгдөн эл үйлдлийг хийж, улмаар зохих шийтгэлээс зайлсхийх үүднээс баримт бичгийг хуурамчаар үйлдэх зэргээр дахин гэмт хэрэг үйлдэж байдаг байна.



Хяналтын асуултууд:

1. Онол болон түүний хэрэглээ гэж юу болохыг тайлбарлана уу?
2. Эхэн үеийн социологийн онолын сэтгэлгээнд байгалийн ухааны онол арга зүйн үзүүлсэн нөлөө, шалтгаан, онцлогыг тайлбарлана уу?
3. Позитивизм гэж юу болох түүний социологийн онолын сэтгэлгээнд эзлэх байр суурийг тайлбарлана уу?
4. Хүний нийгэм, байгаль хоёрыг ялгаатай хэмээн үзсэн М.Вебер, Г.Зиммел нарын үзэл баримтлалын онцлогыг позитивизмтэй харьцуулах замаар тодорхойлно уу?
5. Парадигм гэж юу болохыг тайлбарлана уу?
6. Социологийн үндсэн парадигм, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг тайлбарлана уу?



Эх сурвалж:

1. Мөнхбат О (2008) Социологийн онол. УБ., УВ принтинг
2. Deiflem M (2009) Sociology of Law: Visions of a Scholarly Tradition. Cambridge University Press.
3. Ritzer G. (1996) Sociological theory. The McGraw- Hill Companies, Inc. pp111
4. Walsh.J (2006) Theories for direct social work practice. Second Edition. WADSWORTH Cengage Learning
5. Chafetz, J.S (1987) The role of theory in sociology. In R.L.Curtis, Jr (Ed.) Sociology: Persons and Process in social context (pp. 24-38). Dubuque, IA:Kendall\ Hunt.
6. Спенсер.Г (1998) Опыты научные, политические и философские. Пер с англ. Мн:Современный литератор.
7. Осипов Г.В. (1998) История социологии в Западной Европе и США. Учебник для вузов. М:Изд группа Норма-Инфра



Унших материал:

1. Мөнхбат О (2008) Социологийн онол. УБ., УВ принтинг
2. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон



БҮЛЭГ-III. Нийгэм, түүний ангиллууд

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Удиртгал	Нийгмийн хэв маягийн ангиллууд	2	Лекц

Сэдэв - 1: Нийгмийн хэв маягийн ангиллууд

Хичээлийн зорилго: Социологийн шинжлэх ухаан дахь нийгэм, соёлын хэв маягийн зарим үндсэн ангиллын талаар мэдлэг олгох ба үүндээ тулгуурлан нийгмийн тодорхой үзэгдлүүдийг тухайн нийгмийнх нь болоод цаг үе, дэвсгэр соёлынх нь онцлогтой зөв уялдуулан шинжлэх чадвар суулгах

Гол ойлголтууд:

- ❖ Нийгэм
- ❖ Нийгмийн хэв маяг
- ❖ Орчин үеийн өмнөх нийгэм (Premodern)
- ❖ Орчин үеийн нийгэм (Modern)
- ❖ Орчин үеийн дараах нийгэм (Postmodern)
- ❖ Хотжилт
- ❖ Рационализм
- ❖ Мэдээллийн нийгэм
- ❖ Хэрэглээний нийгэм
- ❖ Даяаршил

Сэдвийн агуулга:

- ❖ Нийгмийн хэв маягийн ангиллууд нь нийгмийн үзэгдлүүдийг хийсвэр бус тодорхой байдлаар шинжлэхийн үндэс болох нь
- ❖ Нийгмийн хэв маягийн ангиллын жишээнүүд. А. Гидденс: Орчин үеийн өмнөх, Орчин үеийн, Орчин үеийн дараах нийгэм
- ❖ Даяаршил өнөөгийн дэлхий дахины онцлох шинэ нөхцөл байдал болох нь

Нийгмийн хэв маягийн ангиллууд нь нийгмийн үзэгдлүүдийг хийсвэр бус тодорхой байдлаар шинжлэхийн үндэс болох нь

Социологийн шинжлэх ухаан нь үзэгдлүүдийг ерөнхий бус тодорхой байдлаар судлахыг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн аливаа үзэгдлийг тодорхой түүхэн цаг хугацаа, соёлын орон зайд авч үзэх хэрэгтэй гэсэн үг. Үүний учир, хүн төрөлхтний туулж ирсэн нийгмүүдийг аль болох дотроо бүрэн агуулсан тийм нийгмийн хэв маягийн ерөнхий ангилалтай танилцсан

байх нь наад зах нь өөрсдийн амьдарч буй цаг үе, нийгмээ зөв ойлгож ухаарахад, цаашилбал үзэгдэл, үйл явцад социологийн үүднээс үнэн зөв дүн шинжилгээ хийж сурахад шаардлагатай юм. Жишээ нь, эртний Монголд байсан, өндөр настай хүмүүстэй холбоо бүхий «ам барих» заншлыг тэр үеийнх нь нийгэм-соёл, учир холбогдлын хүрээнд тайлбарлаж байж л сая утга учир нь ойлгогдоно.

Зарим социологичид хүний нийгмийг орчин үеийн өмнөх, орчин үеийн, орчин үеийн дараах гэсэн нэлээн ерөнхий ангиллаар тоймлон үзэж болно гэсэн санал дэвшүүлжээ.

Хүний нийгэм үүссэнээс хойш наад зах нь хэдэн арван мянгаар тоологдох хугацаа өнгөрсөн авч өнөөгийн дэлхий ертөнцийг тодорхойлж буй орчин үеийн хэв маягийн нийгэм бол дэргэд нь ердөө л өчигдрийн гэмээр шинэхэн явдал юм.

Шигтгээ. Хүмүүн төрөлтөн дэлхий ертөнцөд хагас сая шахам жил оршиж байна. Суурин амьдралын оршин тогтнох зайлшгүй үндэс болсон газар тариалан дөнгөж арван хоёр мянга орчим жил. Иргэншлийн үүсэл зургаан мянга орчим жилээс цаашгүй. Хэрэв бид хүний оршихуйн энэ бүх хугацааг нэг хоног буюу 24 цаг гэж төсөөлж бодвол газар тариалан 23 цаг 56 минутад, иргэншил 23 цаг 57 минутад үүсжээ. Харин орчин үеийн нийгмийн хөгжил дөнгөж 23 цаг 59 минут 30 секундэд гарч ирсэн байна! Гэтэл энэхүү хоногийн 24 цагийн үлдсэн 30-хан секундэд «хүн төрөлхтний бүтэн өдөртэй» тэнцэхгүйц хэмжээний өөрчлөлт гарчээ. (Гидденс, 2006: 530)

Нийгмийн хэв маягийн ангиллын жишээ. Орчин үеийн өмнөх, Орчин үеийн, Орчин үеийн дараах нийгэм

- **Орчин үеийн өмнөх нийгэм**

Гидденс энэ хэв маягийн нийгмийг дараах гурван төрөлд ангилан үзжээ.

- Ан агнах ба ургамал жимс түүх үйл ажиллагаанд суурилсан ан агнуурын ба ургамал жимс түүгчдийн нийгэм
- Мал аж ахуй ба суурьшсан газар тариалан хөгжсөн мал аж ахуйн ба газар тариалангийн нийгэм
- Азтек, эртний Мисир, Грек, Римчүүд гэх мэт аж үйлдвэрийн бус иргэншлүүд

- **Орчин үеийн нийгэм**

Энэ хэв маягийн нийгэм нь XVIII зууны сүүл үе болоод XIX зуунд хөгжиж эхэлсэн гэж үздэг. Ли ба Ньюбай (Holbom M. and Langley P. 2002: 2) нар энэ нийгмийн гол шинж гэж дараах дөрвөн зүйлийг тэмдэглэжээ.

Аж үйлдвэржилт: Аж үйлдвэрийн хувьсгал нь XVIII зууны хоёр дахь хагсаас эхэлсэн бөгөөд хүний үйлдвэрлэн бүтээх хүчийг асар ихээр нэмэгдүүлж, хүний нийгмийн байгалиас хамаармал байдлыг эрс багасгажээ.



Капитализм: Энэ нь товчхондоо хөлсний хөдөлмөрт тулгуурласан ажил эрхлэлт хийгээд ашиг олоход суурилсан бизнесийг өөртөө агуулж байгаа болно.

Хотжилт: Шинэ түвшний хотжилтын нөлөөгөөр хүн ам хот суурин газруудад тасралтгүй төвлөрөх болсон.

Либерал ардчилал: Хэмжээгүй эрхт засаглалыг нийгмээ хэрхэн авч явахыг иргэд нь мэдэлцдэг засаглалаар нэгмөсөн халжээ.

Дээрх өөрчлөлтүүд нь мөн үүний зэрэгцээгээр шинжлэх ухаан ба технологийг ашиглан хөгжлийг төлөвлөж, дэвшилд хүрч, асуудлуудыг шийдэж чадна гэсэн итгэлийг өөртөө агуулсан орчин үеийг бүтээн бий болгосон хэмээн тооцогдож байна.

Зарим судлаачид социологи бол энэхүү орчин үетэй салшгүй холбоо бүхий шинжлэх ухаан гэж үздэг.

• **Орчин үеийн дараах үе**

Зарим социологичид орчин үеийг халж орчин үеийн дараах үе гарч ирж байна гэж үзэх болжээ.

- Энэ үзэл санааны нэг гол хандлага нь гэвэл, дан ганц шинжлэх ухаан ба рационал чанарын тусламжтайгаар дэвшилд хүрч чадна гэсэн итгэл суларч, илүү сайн ирээдүйг бүтээх чадвартай гэж амласан онолуудын талаарх эргэлзээ нэмэгдсэн явдал юм.
- Зарим постмодернистуудын үзлээр бол энэ өөрчлөлтүүд нь аж үйлдвэржилтийн дараах (үйлчилгээ - эсвэл мэдээллийн технологид суурилсан) эдийн засагтай холбоотой аж.

Постмодернистууд нийгмийн талаарх өмнөх онолууд хоцрогдсон гэж үздэг бол зарим социологичид постмодернжилтын талаарх онолуудын үндэслэлтэй эсэхэд эргэлзэж байна. Тухайлбал, Английн социологич Антони Гидденс өнөөгийн орчин үеийн нийгэм орчин үежилтийн өндөр дээд шатанд л гарч байгаа болохоос орчин үеийн дараах үе шатанд орсон хэрэг биш гэж үзжээ. Түүнийхээр бол даяаршил зэрэг анхаарахгүй байхын аргагүй чухал өөрчлөлтүүд гарч байгаа нь үнэн хэдий ч орчин үеийн нийгмийн гол шинжүүд хадгалагдсаар байгаа ажээ. (Holborn and Langley, 2002: 189)

Даяаршил өнөөгийн дэлхий дахины онцлох шинэ нөхцөл байдал болох нь

Дараах тодорхойлолтыг даяаршлын талаарх нэлээн товч бөгөөд оносон тодорхойлолт гэж үзэж болох юм хэмээн «Социологийн толь»-доо Маршалл (1998: 449) тэмдэглэжээ. Даяаршил бол нийгэм ба соёлын зохион байгуулалтад газарзүйн хүчин зүйлийн тулгасан хязгаарлалтууд багассаны зэрэгцээгээр хүмүүс ч энэхүү багасалтыг цаг ирэх тусам улам ихээр анзаарч мэдэрч эхэлснийг илтгэж буй нийгмийн үйл явц юм.

Дээрх тодорхойлолтод илэрхийлэгдсэн газарзүйн хязгаарлалт багасахад нөлөөлсөн буюу өөрөөр хэлбэл, даяаршлын үйл явцыг хүчээ авахад нөлөөлсөн үндсэн хүчин зүйл бол ямар ч эргэлзээгүй технологийн дэвшил юм.

Даяаршлын судалгаа нь дэлхий дахиныг хамарсан соёлын систем бий болсныг судалдаг бөгөөд дэлхий дахиныг хамарсан соёлыг бий болгосон олон талт нийгмийн ба соёлын хөгжил өөрчлөлтүүдийг дараах байдлаар дурьджээ. Үүнд: дэлхийг хамарсан хиймэл дагуулын мэдээллийн систем бий болсон, дэлхий нийтийг хамарсан хэрэглээ ба хэрэглээний загварууд бий болсон, амьдралын универсал хэв маяг дэлгэрсэн, Олимпийн наадам, хөл бөмбөгийн дэлхийн цом, олон улсын теннисийн шигшээ тоглолт зэрэг дэлхийн хэмжээний спортын төрлүүдийн хөгжил, үндэсний төр улсын ноёрхол суларсан, дэлхийн хэмжээний цэрэг армийн систем бүрэлдсэн, ДОХ мэтийн бүхнийг хамарсан аюулт өвчинтэй тулгарсан, НҮБ зэрэг дэлхийн хэмжээний улс төрийн тогтолцоо бий болсон, Марксизм зэрэг дэлхий нийтийг хамарсан улс төрийн хөдөлгөөн дэлгэрсэн, хүний эрхийн ойлголтын цар хүрээ өргөсөж, дэлхийн шашин хоорондын харилцаа нарийссан зэрэг үйл явдлуудыг нэрлэсэн байна.

Энд түүнээс ч илүүтэй, дэлхий дахиныг нэг газар орон хэмээн ойлгосон шинэ төрлийн ухамсрыг даяаршлын үзэл баримтлал өөртөө агуулж байгаа бөгөөд даяаршил энэ утгаараа «нэгэн цул бүтэн болохынхоо хувьд дэлхий дахин жинхэнээрээ зохион байгуулагдаж буй үйл явц» гэсэн байдлаар тодорхойлогджээ.

Үүний сацуу, мөн хурцаар яригдах болсон, зөвхөн яригдаад зогсохгүй хөдөлгөөн хүртэл болж илрэх болсон нэг зүйл гэвэл соёлын ийм шинэ нөхцөл байдалд үндэстнүүд өөрсдийн соёлын онцлогийг хэрхэн хадгалан авч үлдэх тухай асуудал юм.

Даяаршлын нөлөөгөөр гарсан дэвшлийн зэрэгцээгээр шинэ, шинэ асуудлууд ч урган гарсаар байна. Зөвхөн тусгай нэг үндэсний төр улсын (nation-state) хүрээнд шийдвэрлэх аргагүй асуудлууд ихэссэн, мөн интернет, гар утас гэх мэт харилцаа холбооны шинэ технологиуд нь тухайлбал, улс дамжсан гэмт хэргийн сүлжээ үүсэх, зохион байгуулалт нарийсах зэргээр эрхзүйн орчинд ч төвөгтэй шинэ нөхцөлүүдийг үүсгэж байгааг судалгаа харуулдаг.



Хяналтын асуултауд:

1. Социологи болон нийгмийн бусад шинжлэх ухаан дахь нийгмийн хэв маягийн ангиллуудтай танилцах нь ямар ач холбогдолтой вэ?
2. Орчин үеийн ба орчин үеийн өмнөх (уламжлалт) нийгмүүдийн хоорондын үндсэн ялгааг нэрлэж тайлбар өгнө үү?
3. Аж үйлдвэрийн хувьсгалыг яагаад орчин үеийн нийгмийг өмнөх нийгмүүдээс ялгаж өгсөн гол үйл явц гэж үздгийг тайлбарлан мэтгэлцэнэ үү?
4. Монголд модернжилт явагдсан уу? Тийм бол хэзээнээс ямар онцлогтойгоор?



5. Аж үйлдвэрийн дараах нийгэм, мэдээллийн нийгэм, хэрэглээний нийгэм, пост модерн нийгэм гэх зэрэг нэр томъёог агуулгын хувьд адил төстэй гэж үзэж болох уу? Болох бол яагаад, болохгүй бол яагаад? Задлан тайлбарлана уу?
6. Нийгмийн хэв маягийн онцлогоос хамааран гаж үзэгдэл, гэмт хэргийн нөхцөл байдал, төрөл хэлбэр өөрчлөгддөг үү? Өөрчлөгддөг бол хэрхэн?
7. Даяаршлын нөхцөл байдалтай холбоотойгоор нийгэмд гарч буй өөрчлөлтүүдийн (тухайлбал, эрхзүйн хүрээнд) эерэг болон сөрөг үр дүн, нөлөөллүүдийг жишээ баримтад тулгуурлан тайлбарлана уу.



Эх сурвалж:

1. Гидденс А. (2006) Социологи. УБ: Адмон
2. Holborn M. and Langlely P. (2002) Sociology: Themes and Perspectives. London: HCP Ltd
3. Marshall, Gordon, (1998) A Dictionary of Sociology, Oxford University Press.



Унших материал:

1. Lenski A. and Lenski G. Human Society: Introduction to Macrosociology.
2. Смелзер Н. (2001) Социологи. УБ.
3. Гидденс А. (2006) Социологи. УБ: Адмон

БҮЛЭГ-IV. Соёл ба нийгэмшил

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Соёл ба нийгэмшил	Соёлын тухай ойлголт, үндсэн бүрэлдэхүүн	2	Лекц
	Гэмт хэргийн үнэлэмж соёлын ялгаанаас хамааран өөрчлөгдөх нь (Э.Дюркхайм, П.Сорокин, Н.Смелзер)	2	Семинар
	Нийгэмшил, түүний үндсэн үе шатууд: Фройд, Ж.Г.Миид, Ж.Пиаже, Л.Колберг	2	Лекц
	Бие хүний бүтэц, тогтолцоо	2	Семинар

Сэдэв - 1. Соёлын тухай ойлголт, үндсэн бүрэлдэхүүн

- ❖ Соёлын тухай ойлголт, тодорхойлолт
- ❖ Соёлын мөн чанар, үүрэг, бүрэлдэхүүн хэсгүүд

Хичээлийн зорилго: Соёлын тухай ойлголт, соёлын мөн чанар, хэлбэр, үүргийн талаарх социологийн тайлбарлалуудтай танилцаж, соёлын олон талт байдлыг ойлгох чадварыг эзэмшинэ.

Гол ойлголт:

- ❖ Соёл
- ❖ Үнэт зүйл
- ❖ Хэм хэмжээ
- ❖ Оюуны зүйлс
- ❖ Материаллаг эд зүйлс
- ❖ Соёлын түгээмэл (универсал) шинж
- ❖ Өвөрмөц (суб) соёл
- ❖ Арга хэмжээ/Санкци

Сэдвийн агуулга:

- ❖ Соёлын тухай ойлголт, тодорхойлолт
- ❖ Соёлын мөн чанар, үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд
- ❖ Соёл ба нийгэм, соёлын хэлбэрүүд
- ❖ Соёлыг эзэмших үйл явц болох нийгэмшлийн тухай

Соёлын тухай ойлголт

Culture (соёл) гэдэг үг colere гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд соёлоуулан боловсруулах, хөрс боловсруулах гэсэн утгатай. Дундад зууны үед энэ үгээр үр тарианы ургамлыг боловсруулах дэвшилтэт аргыг тэмдэглэж байжээ. Гэтэл XVIII-XIX зууны үеэс хэрэв хүн тансаг



төрхтэй, ном их уншсан байвал «соёлтой хүн» хэмээх болсон. Тухайн үед жирийн ард олноос язгууртныг ялгахад ихэвчлэн хэрэглэж байжээ. Харин өнөөгийн амьдралд «соёл» гэсэн үг нь дуурийн театр, шилдэг уран зохиол, сайн хүмүүжил зэрэг ойлголттой дүйх болсон (Смелзер, 2000, 34) байна. Соёлыг тодорхойлсон орчин үеийн шинжлэх ухааны тодорхойлолтууд өмнө дурдсан язгууртны өнгө аясаа нэгэнт орхижээ.

Тодорхойлолт

Соёлын талаар олон зуун (300 гаруй) тодорхойлолт байдаг бөгөөд хамгийн нийтлэг байдлаар «соёл бол хүний оюун санаа, ухамсар шингэсэн биет хийгээд биет бус зүйл» хэмээн тодорхойлох нь бий. Товчоор хэлбэл, соёл нь хүний амьдралыг зохион байгуулдаг (Смелзер, 2001, 35) бөгөөд ахмад үе нь хойч үедээ залгамжлуулсан буюу эсвэл өөр бүлгээс олж авсан «зан төлөв» юм.

Соёлын мөн чанар, үндсэн бүрэлдэхүүнүүд

Нэрт социологич А.Гидденсийн соёлын талаарх үзлийг энд авч үзье. Хүмүүсийн өдөр тутмын харилцаанд «соёл» гэдэг нэр томъёог бид хэрэглэхдээ соёлыг «оюун ухааны дээд бүтээл», урлаг, уран зохиол, хөгжим, уран зураг гэх мэтээр л ойлгодог. Социологи дахь соёл гэсэн ойлголт нь бүтээлч үйл ажиллагааны дээрх төрлүүдийг төдийгүй өөр олон зүйлийг агуулдаг. Соёлд нийгмийн гишүүдийн амьдралын бүхий л хэв маяг ордог. Үүнд хувцаслах, гэр бүлийн амьдрал ба гэрлэх ёслол, хөдөлмөрийн үйл ажиллагаа, шашны ёс заншил, чөлөөт цагаа өнгөрүүлэх зэрэг бүгд орно. Түүнчлэн хүмүүсийн хийсэн ба тэдэнд үнэ цэнтэй зүйлс, тухайлбал, нум сум, анжис, үйлдвэр, машин, компьютер, ном, орон сууц зэрэг бас багтана. «Соёл»-д тухайн нийгмийн гишүүдийн *амьдралын хэв маягт* хамаарах дадал зан заншил, түүнчлэн тэдний үйлдвэрлэсэн материаллаг баялаг орно. «Нийгэм» гэдэг нь нийтлэг соёлд хамаарагдаж буй хувь хүмүүсийг холбогч *харилцамжийн систем* юм. Нийгэмгүйгээр ямар ч соёл байхгүйн адил соёлгүйгээр ямар ч нийгэм оршин тогтнож чадахгүй. Соёлгүйгээр бид энэхүү нэр томъёонд ямагт оруулдаг бүрэн утгыг агуулсан «хүн» биш байхсан. Бид өөрсдийгөө илэрхийлэх хэлгүй байсансан бол өөрийгөө ухамсарлаж чадахгүйгээр барахгүй бодох, тунгаах бидний чадвар нэн хязгаарлагдмал байх байсан нь хэнд ч ойлгомжтой (Гидденс, 2006, 21). Нийгэм судлаач Уорд Гуденау соёлын үндсэн бүрэлдэхүүн хэсгийг судлаад соёл бол үндсэн дөрвөн элементээс бүрдэл болдог (Смелзер, 2000, 41-43) гэжээ. Эдгээрийг багцлан дараах байдлаар харуулж болно.

Үндсэн элементүүд	Агуулга
Төсөөлөл, ойлголтууд	Хүн төрөлхтөн хүрээлэн буй юмсын хэлбэр, өнгө, амтыг нэгэн ижил мэдэрдэг боловч, өөрсдийн соёлын ертөнцөд эдгээрийг өөр өөр нэр томъёогоор тэмдэглэдэг. Хэлний онцлогтой холбоотойгоор тухайлбал, Монгол хэлэнд хашгирах, уйлах, буйлах гм олон үгийг англи хэлэнд «сгу» гэсэн ганц үгээр тэмдэглэх жишээтэй.
Холбогдол	Соёл тус бүр бодит байдлын хүрээ болон харилцаа холбооны тодорхой төсөөллийг бий болгодог. Олон соёл нь ертөнцийн аль нэг хэсгийг харилцан адилгүй тайлбарлаж, ойлгож, мөн үндэслэж байдаг. Орчин үеийн соёлд «нар хиртэх үзэгдэл»-ийг физик утгаар нь тайлбарлахад төвөггүй байх болно. Харин эл үзэгдлийг саяхныг хүртэл зарим улс орнууд «Рах хэмээх том амьтан нарыг залгилаа» хэмээн үзэж, дом хийх явдал элбэг байлаа.
Үнэлэмж	Энэ нь хүмүүсийн нийтээр хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшил юм. Товчхондоо үнэлэмж бол зан суртахууны зарчмуудын үндэс бөгөөд нийгмийн байгуулал тус бүр юу үнэ цэнтэй, юу үнэ цэнтэй биш гэдгийг тогтоодог. Ихэнх нийгэмд «өөрийн эцэг, эхийг хүндэл», «хүний эрхийг дээдлэх», «эрдэм боловсролтой байх» гм өөр өөрийн үнэт зүйлтэй.
Дүрэм, хэм хэмжээ	Хэм хэмжээ нь тодорхой соёлын үнэлэмжийн дагуу хүмүүсийн зан төлвийг зохицуулна. Жишээ нь, гэмт хэрэг, хулгай, болон бусдын эд хөрөнгийн завших, өмчийг сүйтгэх зэргийг хориглосон олон хуулиуд бий.

Соёлын эдгээр үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд хоорондоо нягт холбоотой. Гуденау эдгээр үндсэн элементүүдийг дараах байдлаар нэгтгэсэн байдаг.

Үүнд:

Соёлын элементүүд	Нэгтгэл, тайлбар
Хүрээлэн буй ертөнцийн тухай төсөөлөл, ойлголтууд	Юу байгааг?
Харилцан холбоо	Юу байж болохыг?
Үнэт зүйлс	Хэрхэн хандахыг?
Дүрэм (хэм хэмжээ)	Хэрхэн үйлдэхийг?

Соёл ба нийгэм, соёлын зарим хэлбэрүүд

«Соёл» гэдэг ойлголт нь «нийгэм» гэсэн ойлголттой адил социологийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг ухагдахуун юм. Соёл нь өөртөө



тодорхой бүлгийн гишүүдэд байдаг **үнэт зүйлсийг**, тэдгээрийн дагаж мөрддөг **хэм хэмжээ** болон *материаллаг эд баялгийг* багтаадаг. (Гидденс, 2006, 20).

Үнэт зүйлс нь хийсвэр эрхэмлэл болж байдаг бол хэм хэмжээ нь хүмүүсийн заавал дагаж мөрдөх ёстой тодорхой зарчим, дүрэм журам юм. Нийгмийн амьдралд «болно» эсвэл «болохгүй» гэдгийг хэм хэмжээ тодорхойлж байдаг. Тухайлбал «моногами» буюу гэрлэлтийн нөгөө хосдоо үнэнч байх явдал нь ихэнх нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрсөн «үнэт зүйлс» болдог. Гэтэл өөр олон соёлын хүрээнд нэг хүн хэд, хэдэн эхнэр эсвэл нөхөртэй байхыг зөвшөөрдөг ажээ. Энэ нь нийгэм бүр соёлын өөрийн гэсэн сонголтыг хийдэг болохыг харуулж байна. Түүнчлэн зарим хүмүүс өөрсдийн амьдралын маягийг «соёлтой, зөв» өөрсдийн бусыг хачин эсвэл бүдүүлэг хэмээн хандах нь буй. Өөрийн соёлын давуу талын байр сууринаас бусдын соёлын тухай шүүн хэлэлцдэг энэхүү хандлагыг угсаатан төвт үзэл буюу этноцентризм гэж нэрлэдэг.

Соёлыг ерөнхийд нь биет ба биет бус хэмээн ангилж болно. (Кравченко, 2000, 20-55) Нийгмийн зан төлвөөс хамааран соёлын эдгээр хэлбэрүүд нь харилцан адилгүй үнэлэмжтэй байна. Нэгэн соёлд материаллаг, үнэтэй зүйлсийг үнэлэх төдий байхад нөгөөд тэдгээр нь хүмүүсийн зан төлөвт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байж болно. Товчлон өгүүлэхэд олон соёлын хооронд асар олон тооны ялгаа бий. Эдгээр ялгааг танин мэдэх үүднээс соёлын өөрийн нь үнэт зүйлс, утгыг задлан шинжлэх үндсэн дээр ойлгохыг соёлын релятивизм гэнэ. Ойролцоо соёлын ялгааг ойлгоход энэ үзэл баримтлал тус болох юм.

XX зууны эхээр Европын ихэнх нийгэмд соёлын хоёр хэлбэр бүрэлдэн тогтсон нь тансаг урлаг, сонгодог хөгжим, утга зохиолыг төлөөлөх дээдсийн эрхэм соёл, үлгэр, билиг зүй, дуу, домгийг багтаасан ядуусын ардын соёл юм. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гарч ирснээр эдгээр соёлын ялгаа арилсан байна.

Үүний зэрэгцээ соёлыг нийгмийн бүлгүүдэд хэрхэн хэрэглэгдэж буй байдлаар нь ангилж болно. Бүх соёлд зуршмал байдаг соёлын түгээмэл (универсал) шинж гэж бий. Тухайлбал, судлаач Жорж Мердок онцлон авч үзээд 60 гаруй соёлын түгээмэл шинжийг онцолсон (Смелзер, 2001, 38) нь бий. Энд спорт, биеийн чимэглэл, хамтын хөдөлмөр, бүжиг, боловсрол, оршуулгын ёс, бэлэг бэлэглэх заншил, хооллох, тоглоом, хууль ёс, анагаах ухаан, тоо, хүний нэр, өмчлөх эрх, шашин, зочлох зан, цус холилдох хориг, шог яриа, шашны зан үйл гм-ийг соёлын түгээмэл хэлбэрүүдийн жишээ болгон дурдаж болно. (Schaefer, 1994, 64).


Нөгөө талаар соёл нь нийгмийн гишүүдийн харилцааг бэхжүүлж бие хүмүүсийг тодорхой бүлэгт харьяалагдах мэдрэмжийг төлөвшүүлж байдаг. Соёлын нэг бүлэгт хамаарагдаж буй гишүүд бие биеэ илүү ойлгож, итгэж, талархаж байдаг. Тэдний нийтлэг мэдрэмж нь өвөрмөц хэллэг, этгээд хэл, дуртай хоол, хувцасны загвар зэрэг соёлын хэлбэрүүдээр илэрч байдаг. Бүлгүүдийн хоорондын зөрөлдөөний шалтгаан болж буй соёлыг дэд соёл

(суб) буюу өвөрмөц соёл гэж нэрлэдэг. Зарим тохиолдолд зонхилж буй соёлын үндсэн хэсгүүдэд зөрчилдсөн хэм хэмжээ, үнэт зүйлсийн үндсэнд сөрөг соёл төлөвшиж болох ажээ.

Соёлыг эзэмших үйл явц болох нийгэмшлийн тухай

Нийгэм судлаач Клайд Клакхон соёлыг нийгмийн онцлог шинжээр нь тодорхойлжээ. Тэрбээр «...бүхэл бүлэг буюу нийгэм тодорхой юмыг нэг маягаар үйлдэж сурах буюу онцлогийг нь эзэмшсэн, ахмад үе нь хойч үедээ залгамжлуулсан, эсвэл өөр бүлгээс олж авсан зан төлвийг соёл гэнэ» (Смелзер, 2000, 35) гэжээ. Түүний томъёолсноор соёлыг бий болгодог, түүнчлэн соёлд суралцдаг болохыг онцолж үзсэн байна. Хүн сургалтаар соёлыг эзэмших ба соёлд суралцах үйл явц нь нийгэмшлийн үндсэн дээр явагдаж байдаг аж. Чухамдаа үнэлэмж, шүтлэг, хэм хэмжээ, дүрэм зэргийг өөрчилсний дүнд бие хүний шинжүүд бүрэлдэж, түүний зан төлөв зохицуулагдаж байдаг.

Соёл нь нийгмийн гишүүдэд бие хүний шинж чанарыг төлөвшүүлэхийн хэрээр зан төлвийг зохицуулах хяналтын үүрэг гүйцэтгэнэ. Нийгэм судлаач Клиффорд Гиртц соёл бол «зан төлвийг удирдахад үйлчилдэг төлөвлөгөө жор, дүрэм, загварыг багтаасан зохицуулагч тогтолцоо мөн» гээд соёлгүй бол хүмүүс чиг баримжаагүй болно (Смелзер, 2000, 44) гэжээ. Соёл нь хүний сэдлийг, тухайлан сексийн болон түрэмгий сэдлийг дарах нөхцөлийг тодорхойлж байдаг. Өөрөөр хэлбэл, тэрхүү сэдэл хэрэгцээг хангах зохих цаг, орон, аргыг тодорхой дүрэм, хэм хэмжээгээр тогтоож, хуульчилж өгдөг. Энэхүү хэм хэмжээг сахихад санкци буюу арга хэмжээ онцгой нөлөө үзүүлнэ.



Эх сурвалж: (Смелзер, 2000, 44)

Соёлын элемент болох хэм хэмжээ нь албан (хууль, дүрэм, журам гм) ба албан бус (тогтсон ёс жаяг, уламжлалт дэг сахих гм) байхын дээр зөрчигдсэн тохиолдолд мөн өвөрмөц хориг арга хэмжээг агуулж байдаг болохыг социологич Шифр (Scheafer, 1994, 75) дараах байдлаар үзүүлжээ.



Хэм хэмжээ ба хориг арга хэмжээ

Хэм хэмжээний төрөл	Хориг арга хэмжээ	
	Эерэг	Сөрөг
Албан хэм хэмжээ	Цалин нэмэх, шагнаж урамшуулах	Сануулах, тушаал буулгах, ажлаас халах
Албан бус хэм хэмжээ	Инээх, найр тавих, хүндэтгэл үзүүлэх	Дургүйцэх, доромжлох, гадуурхах



Хяналтын асуултууд:

1. Соёл ба нийгэмшил хэмээх ойлголтуудын харьцаа, эдгээр ойлголтуудыг судлах социологийн хандлагын онцлог юу вэ?
2. Дараах үзэгдлүүд материаллаг болон оюуны соёлын алинд нь орохыг тогтоо. (ирүүл тулаан, медаль, жүнз, дуу бүжиг, мэтгэлцээн, багт наадам, сургууль, цүнх, гал гм)
3. Соёлын ялгааг арилгахад нийгэм дэх ямар институт чухал үүрэг гүйцэтгэсэн бэ?
4. Соёл нь нийгэмшилд эерэг, сөрөг аль үүргийг илүүтэй гүйцэтгэх вэ, яагаад гэдгийг эргэцүүлээрэй.
5. Та бүхний хичээлээ бичиж буй дэвтэр үнэт зүйл, эсвэл соёлын бүрэлдэхүүний алинд нь орох вэ, яагаад?
6. Монгол улсын хувьд 01 сарын 13, 07 сарын 11-ний өдрүүд яагаад тэмдэглэлт чухал өдрүүд вэ?
7. Өвөрмөц (суб) соёл хэмээх ойлголтыг тайлбарла, тухайн соёлд хамаарах 5 хүртэлх жишээг дурдана уу?



Эх сурвалж:

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Смелзер Н (2001) Социологи. УБ
3. Ионин Л.Г (1998) Социология культуры. М., Логос
4. Karp D.A (1993) Sociology in everyday life, FE Peacock publishers
5. Schaefer Richard.T, Lamm Robert.P. (1994) Sociology. New York; McGraw-Hill, Inc



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Кравченко А.И(2000), Социологийн удиртгал, УБ

Сэдэв - 2: Гэмт хэргийн үнэлэмж соёлын ялгаанаас хамааран өөрчлөгдөх нь

Хичээлийн зорилго: Соёлын олон янз хэв маяг, соёлын нийгмийн үндэс, гэмт хэргийн талаарх нийгмийн бүлгүүд болон олон нийтийн үнэлэмж, гэмт хэргийн хэлбэрүүдийг соёлын онцлогтой холбон тайлбарлах, тэдгээрийн мөн чанарыг танин мэдэх, зөв ухаарч сурахад хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Нийтийн соёл
- ❖ Соёлын алдагдал
- ❖ Аноми байдал
- ❖ Нийгмийн хяналт
- ❖ Бүлгийн хэм хэмжээ
- ❖ Гэмт хэргийн хохирогч
- ❖ Гэмт хэрэг
- ❖ Гэмт үйлдэл

Сэдвийн агуулга:

- ❖ Хөгжиж байгаа болон хөгжингүй нийгэм дэх гэмт хэргүүд (Н.Смелзер)

Санал болгож байгаа арга:

1. Асуулт тавих
2. Бүлгээр ажиллах
3. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах

ЖИШЭЭ?	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
... XIX зуун хүртэл гэмт хэргийн шийтгэлийн үндсэн хэлбэр нь дөнгө, занчих, улайссан төмрөөр тамгалах буюу дүүжлэх зэрэг байв. Үйлдвэржихээс өмнөх Европод хамгийн ноцтой, хамгийн хатуу цээрлэл хүлээдэг нь шашны гэмт хэрэг, эсвэл өмчтөн болон язгууртнуудын өмчийн эрх мэдлийн эсрэг гэмт хэрэг болдог байв. Өнөөдөр иймэрхүү зөрчлийг эсвэл огтоос гэмт хэрэг гэж үзэхгүй, эсвэл хуулийг бага зэрэг зөрчсөн гэж л үзнэ.	<i>Гэмт үйлдэл, гэмт хэргийн ялгаа юу вэ? Шийтгэлийн тухай ярилцах</i>
...Энэтхэгт өнөөг хүртэл «нэр хүндийн аллага» байсаар байна. Үхрийн мах идэх, гэр бүлийн хэн нэг нь доод кастын хүмүүстэй гэрлэхээр завдсан тохиолдлоос үүдэн мянга мянган хүмүүс амь насаараа хохирдог.	<i>Үйлдлийг зөв, буруу гэж үзэх нь юунаас ихэвчлэн хамаарах вэ? тухайн жишээ аноми байдалтай холбоотой юу?</i>



...Нэгэн төрийн албан хаагч албан тушаалаа ашиглан 100 сая төгрөгийн авлига авсан гэж буруутгагджээ. Тухайн албан тушаалтан өмнө нь ийм байдлаар албан тушаал буурч байсан билээ. Энэ хүн тэнсэн харгалзах ял авч, хохирлын зарим хэсгийг барагдуулах болжээ. Яг энэ өдөр шүүх өмнө нь хулгай хийсэн гэж буруутгагдсан боловч гэм буруугүй нь нотлогдсон, одоо ажилгүй залууг 100 мянган төгрөгийн утас хулгай хийсэн гэж ялласан байна. Түүнд 3 жилийн хорих ял өгчээ.

Энэ нь социологийн хүрээнд авч үзвэл ямар гэмт хэрэг вэ? бид юунд шүүмжлэлтэй хандах ёстой вэ?



Хяналтын асуултууд:

1. Аноми гэж юу гэсэн утгатай вэ?
2. Репрессив ба реститутив санкц хэмээх ойлголтууд ямар ялгаатай вэ?
3. Гэмт хэргийн нийтлэг ямар төрлүүд байдаг вэ? Хот хөдөөд зонхилж буй гэмт хэргийн статистик тоо баримтыг харьцуул.
4. Нийгэм дэх мэргэжлийн бүлгүүд ёс зүйгээ сахин мөрдөх нь ямар үүрэгтэй вэ?
5. Гэмт хэргийн виктим шинж гэж юу вэ?
6. Нийгмийн хэм хэмжээ, аноми байдал, мэргэжлийн бүлгийн ёс зүйн хэм хэмжээ, гэмт хэрэгтэн зэргийн харилцаа холбоог тодорхойл.
7. Органик ба механик эв нэгдэл, репрессив ба реститутив хориг арга хэмжээ зэргийн уялдаа холбоог тайлбарла.



Эх сурвалж:

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Смелзер Н (2000) Социологи. УБ
3. John Scott, Gordon Marshall (2004) Oxford. Dictionary of Sociology., Oxford University press
4. Schaefer R.T, Lamm R.P (1994) Sociology. New York, McGraw Hill
5. Дюркхайм Э (1990) Самоубийство. М:Мысль
6. Сорокин П.А(1990) Система социологии. Том 1, 2., М:Наука



Унших материал:

1. Смелзер.Н (2001), Социологи, УБ
2. Гидденс.Э, (2006), Социологи, УБ, Адмон

Сэдэв - 3: Нийгэмшил, түүний үндсэн үе шатууд

Хичээлийн зорилго: Хүний нийгэмшлийн үндсэн үе шатууд, нийгэмшлийн агентууд болон бие хүний бүтэц, хөгжлийг тайлбарлаж сурна.

Гол ойлголтууд:

- ❖ Нийгэмшил
- ❖ Танин мэдэхүй ба дасан зохицохуй
- ❖ Дүр ба үүрэг
- ❖ Сөрөг нийгэмшил
- ❖ Дахин нийгэмшил
- ❖ Нийгэмшлийн агент

Сэдвийн агуулга:

- ❖ Нийгэмшлийн үндсэн үе шатууд
- ❖ Нийгэмшлийн агентууд: гэр бүл, үе тэнгийнхэн, сургууль, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл

Санал болгож байгаа арга:

1. Уншиж ярилцах
2. Асуулт хариулт

Нийгэмшлийн тухай

«Хүмүүс өөрсдөө нийгэмд хүлээсэн зохих дүр, үүрэгтэйгээ уялдуулан, тогтсон хандлага, туршлага, ухаан суух үйл явц бол нийгэмшил юм» гэдэгтэй олонх социологичид санал нэгддэг. Оксфордын социологийн толь бичигт «Нийгэмшил гэдэг нь нийгмийн дүрүүдийг гүйцэтгэхэд суралцах үүднээс нийгмийн үнэт зүйл болоод хэм хэмжээг эзэмших болон нийгмийн гишүүн болон төлөвших үйл явц мөн» хэмээжээ. (Scott, J. Marshall G, 2005, 621)

Нийгэмшил нь хүмүүсийг тодорхой дүр, үүрэгт тоглоход хүртэл сургадаг байна. Нийгэмшил бол хүмүүс эзэмшиж авсан нийгмийн дүр, үүргээ ашиглан хоорондоо харьцах боломж олгох төдийгүй нийгмийг хадгалан үлдээх үүрэгтэй юм. Нөгөөтэйгүүр нийгэмшил бол нийгмийн шинж чанаруудыг хүн эзэмших үйл явц бөгөөд чухамдаа нийгэмшсэн хүн сая бие хүн болж төлөвшдөг. Энд нийгэмшлийн хэд хэдэн жишээг авч үзье.

Унших материал 1.

«... Цэргийн дарга эрхэмсэг эр» хэмээх 1982 онд нэрд гарсан кинонд Ричард Гир, нисгэгч болохыг хүссэн увайгүй, ёс суртахууны зарчимгүй Мэйо гэдэг залуугийн дүрд тоглодог билээ. Тэрбээр тэнгисийн цэргийн нисэхийн сургууль төгсөхдөө цэргийн дарга, эрхэмсэг эр болдог. Мэйогийн хувьд цэргийн сургуульд элсэн орохоос өмнө өөрийн замд тохиолдсон бүхнийг хэнэггүй хохироодог байв. Гэвч цэргийн сургуульд элссэнээр дураараа унтах нь бүү хэл нийтийн жишгийг үг дуугүй дагах болдог.



Нэг удаа Мэйюг хэмжээгүй эрх эдэлдэг жагсаалын бэлтгэл хариуцдаг ахлагч шүдний сойзоор шат цэвэрлэхийг тушааж, гүйцэтгүүлнэ. Мэйю цэргийн сургуулийн дадлага хийх явцдаа офицер болов. Ингэснээр түүний шинэхэн цэрэг байхдаа үсээ хусуулан, эрчимтэй жагсаал, марш, дэглэлт, доромжлол дуусгавар болсон. Мэйю офицер цол хүртсэн ч түүнтэй хамт сурч байсан, ялангуяа жагсаалын бэлтгэл хариуцаж байсан ахлагч цол ахисангүй. Тэнгисийн цэргийн дүрмийн шаардлага нь тушаалыг цаг хугацаанд биелүүлдэг, хэлбэрэлтгүй, шаргуу хүмүүсийг албанд тэнцүүлж, тушаал ахиулдаг ажээ. Цэргийн албан хаагчийн нийгэмшил нь ердийн иргэнийг бодвол илүү их туршлага шаарддаг бөлгөө.

Унших материал 2.

...Энэ бол Элен Келлэрт тохиолдсон явдал юм. Өвчний улмаас хараа, сонсголгүй болсон тэр охиныг эцэг, эх нь нийгэмшүүлэх гэж оролдсоор байтал бяцхан охин зан байдлын ихээхэн өөрчлөлттэй болжээ. Хооллох үедээ тэрбээр бусдын аяганаас хоолыг нь булаана. Биеэ угаах, хувцас өмсөх үед бөөн хэрэг мандаана. Нэг удаа өлгийтэй дүүгээ унагааж бараг л егүүтгэх дөхжээ. Элен хүмүүстэй харилцаж огт сураагүй байлаа. Гэтэл түүнд Энни Салливан хэмээх багш эмэгтэй олдож, хараагүй хүмүүсийн бичиг, үсэг зааж, ярьж, сонсох боломж олгосноор сая орчин ахуйтайгаа харилцах болжээ. Ингэснээр тэрбээр эцэг, эхийгээ хүндэлж, өөрийн дүүгээ хайрлаж, хувцсаа өмсөх болон бусад зүйлсийг бие даан хийдэг болсон байна.

Унших материал 3.

...Анна бутач хүүхэд байсан учир эх нь түүнийг гэртээ байнга түгжиж орхидог байжээ. Эх нь Аннаг хооллодог байсан хэдий ч усанд ховор оруулдаг, тэвэрдэг хийгээд энхрийлдэггүй, түүнтэй бараг ярилцдаггүй байв. Аннаг 6 настай байхад гадны хүмүүс илрүүлэхэд тэр охин явж сураагүй байжээ. Аннаг хүүхдийн халамжийн төвд өгч улмаар тусгай сургуульд оруулжээ. Энэ үед тэр охин бөмбөгөөр тоглодог, өөрөө хувцаслаж, энгийн хялбар үйлдэл хийж, хоолоо зөвхөн халбагаар идэж сурсан боловч үг яриа нь 2 настай хүүхдийн түвшинд байсан байна.

Унших материал 4.

...Женни төрөлхийн түнхний мултралтай учраас хэвийн явж сураагүй. Эцэг нь түүнийг байнга зоддог байв. Охин нь нэг нас хүрэхэд эцэг нь түүнийг оюун ухааны хомсдолтой гэж үзээд тусгай өрөөнд хорьжээ. Ихэнхдээ цоожтой, хөшиг нь хаалттай, ийм л өрөөнд 11 жилийг өнгөрөөсөн Женни гэр бүлийн гишүүдээ өөрийг нь хооллохоор ирэх үед хардаг. Эцэг нь охинтойгоо ярилцдаггүй, хэрэв бухимдуулвал огцом, тодорхой бус авиагаар ханддаг, дуу чимээ гарган анхаарал татвал зоддог байв.

Эцсийн бүлэгт ээж нь охиноо дагуулан гэрээсээ зугтсан байна. Охины байдал нийгмийн ажилтны анхаарал татсан тул түүнийг хүүхдийн эмнэлэгт, нөхөн сэргээх тасагт хэвтүүлсэн юм. Тухайн үед охин цэх шулуун явж, гүйж, харайж чадахгүйгээр үл барам инээх нь хүртэл бодитой бус байжээ. Түүний үг яриа 3-4 настай хүүхдийн түвшинд байсан ба сэтгэл зүйч охиныг «нийгмийн амьдралд дасан зохицоогүй, хүнтэй адилгүй бүдүүлэг амьтан» хэмээн тодорхойлжээ.

Нийгэмшлийн үндсэн үе шатууд

Нийгэмшил бол тасралтгүй үйл явц юм. Нийгэмшил нь бага болон өсвөр насанд эрчимтэй явагддаг боловч бие хүний хөгжлийн дунд болон хижээл насанд ч үргэлжилсээр байдаг. Судлаач Орвиль Г.Брим нийгэмшил бол бүх насанд явагддаг хэмээх санааг анх түрүүнд дэвшүүлсэн юм. Тэрбээр хүүхдүүд болон насанд хүрэгчдийн хооронд нийгэмшлийн дараах ялгаа байдгийг тэмдэглэжээ. (Смелзер, 2001)

<i>Шигтгээ.</i>	<i>1. Насанд хүрэгчдийн нийгэмшил нь ихэнхдээ тэдгээрийн гадаад зан төлвийн өөрчлөлтөөр илэрхийлэгддэг бол</i>
<i>Хүчхэд ба насанд хүрэгчдийн нийгэмшлийн онцлог</i>	<i>хүчхэдийн нийгэмшил нь суурь үнэлэмж баримжаалалд нөлөөлдөг.</i>
	<i>2. Насанд хүрэгчид хэм хэмжээг үнэлэх чадвартай бол хүчхэцүд түүнийг зөвхөн эзэмшиж чадна.</i>
	<i>3. Ихэнх тохиолдолд насанд хүрэгчдийн нийгэмшил нь хар, цагаан хоёрын дундах олон янзын «саарал» өнгө байдаг гэсэн ухаарал болно.</i>
	<i>4. Насанд хүрэгчдийн нийгэмшил нь хүнд тодорхой туршлага, арга барил эзэмшихэд, хүчхэдийн хувьд энэ нь ихэнхдээ тэдний зан төлвийн сэдлийг төлөвшүцүлэхэд чиглэж байдаг.</i>

Үүнийг хамт нийгэмшлийн үе шатны талаар харилцан адилгүй үзэл баримтлалууд байдаг. Социологич Брингерхофф: Нийгэмшлийг «хүүхэд насны буюу анхдагч нийгэмшил, бусдыг даган дуурайж, дүрд суралцах буюу хоёрдогч нийгэмшил, нэгэнт тогтсон үнэт зүйлс, амьдралын замналаа бүхэлд нь өөрчлөх буюу дахин нийгэмшил» гэсэн хэсгүүдэд (Brinkerhoff, 1988, 147-148) хуваан үзжээ.

Оросын социологич Г.В.Осипов нийгэмшил бол нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйл, соёлын элементүүдийг эзэмших замаар хувь хүн нийгэмд нэгдэх үйл явц хэмээгээд 1.Дасан зохицох, 2.Харилцан уусах үе гэсэн хоёр үндсэн шатанд хуваан үзжээ (Осипов, 1990, 158). Тухайлбал, хүмүүс нийгэмшихдээ эхлээд дасан зохицож нийгмийн шинжүүдийг эзэмших бөгөөд үүнийхээ дараагаар өөрийн дүрд тохирсон үйлдлийг гүйцэтгэдэг болохыг энд онцолжээ.

Социологичдын хувьд «Нийгэмшил бол хүмүүсийн бага балчраас эхлээд өтлөх хүртэл социаль хэм хэмжээ ба дүрийг эзэмших үйл явц» (Кравченко, 2000, 62) гэдэгтэй санал нийлдэг.

Нийгэмшлийн агентууд

Хүний нийгэмшилд нөлөөлдөг байгууллага, бүлэг болон бие хүмүүсийг нийгэмшилтийн агент хэмээх ойлголтоор тэмдэглэдэг. Аливаа соёлд **гэр бүл** нь хүүхдийг нийгэмшүүлэгч үндсэн агент болдог юм. Гэвч түүнээс хойших амьдралын үе шатанд нийгэмшлийн олон олон агентууд үйлчилж



эхэлдэг. Хүний амьдралын тодорхой үе шатанд үйлчилдэг зарим агентуудыг (Schaefer, 1994, 107) энд авч үзлээ.

Гэр бүл	<p>Орчин үеийн нийгэм дэх анхдагч нийгэмшил нь гэр бүлийн явцуу жижиг хүрээнд явагддаг. Өрнөдийн ихэнх хүүхдүүд хүүхэд ахуй насаа ээж, аав болон нэг хоёрхон хүүхэдтэй гэр бүлд өнгөрүүлж байна. Үүний эсрэгээр бусад олон соёлд авга ах, эгч, нагац ах, эгч, өвөө, эмээ нар нь гэр бүлийн нэг хэсэг болох ба нэг гэрт хамтдаа амьдарч, бүгдээрээ бага насны хүүхдийг хүмүүжүүлдэг.</p>
	<p>Зарим хүүхдийг нэг л эцэг, эх хүмүүжүүлдэг бол зарим нь хошоод аав, ээж («салсан» болон «хойд» эцэг, эхчүүд)-ийн гар дамжин хүмүүждэг. Ийм олон янз байдалтай хэдий ч гэр бүл нь хүүхдийн нялх үеэс өсвөр нас хүртэлх нийгэмших явцад, түүнээс цаашлаад үе үеийн хүмүүсийн холбоо хөгжихөд чухал агент хэвээрээ байсаар байна.</p>
Үе тэнгийнхэн	<p>Нийгэмшлийн өөр нэг чухал агент бол үе тэнгийнхэн, нас чацуутнуудын нэгдэл юм. Зарим соёлд, ялангуяа уламжлалт нийгэмд нас чацуу хүмүүсийн бүлэг насны үечлэлээр бий болдог. Нэг үеийн хүмүүс тодорхой эрх, үүрэгтэй байдаг бөгөөд нас ахихын хэрээр эдгээр нь өөрчлөгдөж байдаг.</p> <p>Орчин үед олонх эмэгтэйчүүд ажил эрхэлж, хүүхдүүд нь цэцэрлэгт явдаг болсноор үе тэнгийнхний харилцаа өмнөх үеэс илүү ач холбогдолтой болжээ. «Үе тэнгийнхэн» гэдэг үг нь нас «адил тэгш» гэсэн утгатай бөгөөд хүүхдийн хооронд үүссэн нөхөрсөг харилцаа, үнэхээр аядуу эгалитаризм юм.</p> <p>Үе тэнгийнхний харилцаа хүний бүхий л амьдралд ач холбогдлоо алдахгүй.</p>
Сургууль	<p>Сургуулийн боловсрол нь тодорхой тогтоосон хичээлийг судлахыг тодорхойлж буй албан ёсны үйл явц юм. Гэвч сургууль нь арай өөр харьцаагаар нийгэмшлийн агент болж байдаг. Хүүхдүүдээс анги танхимдаа чимээгүй сууж хичээллэх, хичээл дээр нягт нямбай байх, сургуулийн дэг журмыг мөрдөх зэргийг шаарддаг. Сургуульд суралцсанаар хүүхдүүд төрж өссөн нийгмийн орчны хязгаарлалтыг даван туулж чаддаг гэж үздэг. Боловсрол бүх хүмүүст нээлттэй төдийгүй заавал эзэмших ёстой тул ядуу зүдүү давхаргын хүүхдүүд хэрэв амжилттай сайн суралцвал нийгэм эдийн засгийн шатаар өгсөх боломжтой.</p>
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	<p>Дэлхийн түүхийг сөхөн үзвэл саяхнаас хэвлэлийн материалууд дэлхийн сая сая хүний үзэл бодол, хандлагыг тодорхойлох тэдний амьдралын өдөр тутмын хэсэг болжээ. Судалгаанаас үзэхэд хүүхдүүд нэг жилд бараг зуун хичээлийн өдөртэй тэнцэх хугацаанд зурагт үздэг байна. Насанд хүрэгчид ч бас мөн ийм цагийг зурагт үзэн өнгөрүүлдэг. Судалгаанаас үзэхэд үйл явдлыг телевиз, сонин хоёр ялгаатай мэдээлсэн тохиолдолд бараг хоёр дахин олон хүн сонинхоос илүү телевизийн мэдээнд итгэдэг ажээ. Ийнхүү олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл ба тэдний тогтсон хандлагад гүнзгий нөлөөлдөг байна.</p>

Бусад агентууд	Дээрх агентуудын зэрэгцээ ажил хөдөлмөр, сайн дурын нийгэмлэг, клуб, сүм хийд, оршин суугчид гм олон олон агентууд хүний нийгэмшил, төлөвшилд зохих үүрэг гүйцэтгэсээр байгаа болно.
-----------------------	--

Эдгээр агентуудын зэрэгцээ хүний сөрөг ба дахин нийгэмшилтэй холбоотой агентууд бий. Энд дахин нийгэмшүүлэх зорилго бүхий зарим институт, тухайлбал шоронг авч үзье.

Зарим нөхцөл байдалд насанд хүрсэн хүмүүс дахин нийгэмшилд орж болно. Өөрөөр хэлбэл, урьд өмнө тогтсон үнэт зүйлс, бие хүний зан үйлийн загвараа өөрчилж, өмнөхөөс эрс ялгаатай үнэт зүйлсийг эзэмших нь буй. Тийм нөхцөлийн нэг бол гадаад ертөнцөөс тусгаарлагдсан, цоо шинэ хатуу ширүүн дэг, шаардлага бүхий сэтгэл мэдрэлийн эмнэлэг, шорон, хуаран зэрэг цагдах байгууллагууд юм. Энд Германы бөөнөөр хорих газарт хүмүүс хэрхэн дахин нийгэмшиж байсан тухай сэтгэл засалч Беттельгеймийн дурдатгалыг сонирхоё. ...Тухайн үед харгис хатуугаараа нэрд гарсан Бухенвальд болон Дахаугийн шоронд ажиллах үед эрүү шүүлт, байнгын доромжлол, өлсгөлөнт нөхцөлд хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, зан үйл үндсээрээ өөрчлөгдөж буйг тэрбээр ажиглажээ. «...Би хорих газар дахь хүмүүсийн зан үйл төдийгүй бие хүний шинжид гарч буй түргэн өөрчлөлтийг ажигласан юм. Хоригдож буй эхэн үедээ тэд гэр бүл, найз нөхдийн хүрэнээсээ салж, дарамтаас болж сэтгэцийн сааталд ордог. Шинэ хоригдлуудын ихэнх нь хорих газрын хүнд нөхцөлийг эсэргүүцэж, үйлдлээ өмнөх амьдралын туршлага үнэт зүйлтэйгээ нийцүүлэхийг эрмэлзэнэ. Гэвч айдас, зовлон, тодорхойгүй байдал нь бие хүнийг цөхрөлд оруулах ба удалгүй «явдаг үхдэл» болж хувирна. Өөрийнхөө хувь тавиланд ямар ч сонирхолгүй, идэвх санаачилгагүй болсон ийм хүмүүс тун удалгүй үхдэг. Үлдсэн хэсгийн хувьд зан үйл хүүхдийнхтэй адилхан болж, цаг хугацааг мэдрэх, урьд өмнөхөө санах чадвараа алдаж, сэтгэл санааны хувьд хүчтэй өөрчлөлтөд ордог. Тухайн газарт жилээс илүү байсан «хуучин хоригдлууд» шоронгийн амьдралын харгис, хэрцгий явдалтай аажмаар эвлэрч, дахин нийгэмшиж эхэлдэг байна. Тэд урьдах амьдралаа санахаа больж, бие хүний шинж нь хоригдлуудтай жигшүүртэй байдлаар харилцдаг шоронгийн харгалзагчийн зан үйл, арга, үзэл санааг дуурайх замаар хөгждөг байна» (Гидденс, 2006, 59)



Эх сурвалж:

1. Батбаатар М (2007) Социологийн онол, түүх УБ., Сорхон цагаан хэвлэл.
2. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
3. Смелзер Н (2001) Социологи. УБ
4. Осипов Г.В. (1990) Социология и социализм М, Наука
5. Schaefer R.T, Lamm R.P (1994) Sociology, New York, Mc Graw Hill
6. David B.Brikerhoff, Lynn K.White (1988) Sociology, West Publishing company
7. Scott J. Marshall G (2005) Oxford Dictionary of Sociology. Oxford University press



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон

Сэдэв - 4: Бие хүний бүтэц, тогтолцоо

Хичээлийн зорилго: Нийгмийн шинж чанаруудыг эзэмшсэн хүн болох бие хүний бүтэц, тогтолцоо, хүний хөгжлийн онол, үзэл баримтлалуудтай танилцана.

Гол ойлголтууд:

- ❖ Итгэл үнэмшил
- ❖ Үнэт зүйл ба хэм хэмжээ
- ❖ Хэрэгцээ ба сонирхол
- ❖ Хүний статус ба үүрэг

Сэдвийн агуулга:


- ❖ Бие хүний бүтэц, тогтолцооны үндсэн хэсгүүд
- ❖ Бие хүний хөгжлийн онол, үзэл баримтлал

Санал болгож байгаа арга:

1. Уншиж ярилцах
2. Асуулт хариулт

Бие хүний бүтцийн талаар олон хандлага, үзэл баримтлалууд байдаг. Энэ талаарх суурь үзэл баримтлалын нэг бол бие хүний нийгмийн тогтолцооны шинж чанарууд, тэдгээрийн харилцааг илэрхийлсэн социологич Левадагийн үзэл (Осипов, 1990, 156) юм.

Схем 1. Бие хүний бүтэц.





Дээрх зүйлс нь бие хүний социаль системийн үндсэн компонентууд болж байдаг. Ой тогтоолт нь хүн орчин тойрноо тусган авах, ухамсарлах түүний тодорхой шинж чанарыг төлөөлөн мэдлэг бүрэлдэх чиг үүргийг гүйцэтгэдэг. Харин үйл ажиллагааны тал нь хүн орчин тойрондоо хандах хариу үйлчлэлийн нөхцөлийг хангадаг. Бие хүний үйлдэхүй, эс үйлдэхүй, үйл ажиллагаа зэрэг орчиндоо хандах хэлбэр түвшингүүд нь хүн бол «үйлдэгч» амьтан гэдэг онцлог шинжийг агуулдаг. Соёлын үндсэн компонент нь бие хүнээс орчин тойрон түүний аливаа юмс үзэгдлийн талаар тодорхой үнэ цэн үнэлгээнүүд эрэмбэлэгдсэн төлөөллүүдийг (сайн, муу, сайхан, муухай гэх мэт) бүрэлдүүлэх чиг үүрэгтэй. Өрнөдийн системийн онолд хүний социаль тал өөрөө системлэг шинжтэй, хүн бусад хүмүүстэй харилцах явцад энэ систем нь хөгжиж өөрчлөгдөж байдаг тухай онцолжээ.

Ихэнх судлаачид бие хүний бүтцийн үндсэн шинжүүдэд дараах зүйлсийг орно гэж үздэг. Үүнд:

- ❖ Бие хүний нийгмийн статус, түүний үүрэг, дүрүүд
- ❖ Бие хүний өөрийн ухамсар, түүний ертөнцийг үзэх үзэл хийгээд үнэт зүйлийн баримжаалал
- ❖ Бие хүний оюун санааны ертөнц
- ❖ Өөрийгөө илэрхийлэх бүх төрлийн үйл ажиллагаа, хөдөлмөр гэх мэт.

Үүнээс гадна зарим судлаач тухайлбал, И.Каган «бие хүнийг үйл ажиллагааны гол субъект болгон авч үзээд бие хүний бүтцийг бүрдүүлэгч гол зүйлс бол танин мэдэхүйн, үнэт зүйлийн, уран бүтээлийн, харилцааны, уран сайхны шинжүүд болно» (Осипов, 1990, 156) гэжээ.

Бие хүний хөгжлийн тухай

Бие хүний нийгмийн шинж нь хүмүүс хоорондоо харилцах явцад бүрэлдэн тогтдог. Бие хүн хөгжих, нийгмийн шинжийг олж авах, төлөвших, төгөлдөржих үйл явцад олон хүчин зүйл нөлөөлнө.

Хүний хөгжилд нөлөөлөх зүйлс	Жишээ
Нас, хүйс, оюуны түвшин, биеийн жин зэрэг хүчин зүйлс онцгой нөлөөтэй.	...Зарим нийгэм гоолиг биетэй хүнийг илүү үнэлдэг, иймд ихэнх хүмүүс биеэ гоолиг болгохын тулд анхаарч эхлэх нь хөгжлийн нэг үндэс болно.
Хүрээлэн буй орчноос хамааралтай.	...Өлөн зэлмүүн байдалд өссөн хүүхэд үеийнхнээсээ биеийн болон оюуны хувьд хоцрогддог.

Өөрийн хувийн туршлага нөлөө үзүүлнэ.	...Эцэг эхийн аль нэгийг алдсан хүн дахин хэн нэгнийг алдахаас эмээж, хүмүүсийг хайрлах зан байдлын хувьд өөрчлөлт орж болно.
Хувь хүний хөгжил, төлөвшилд соёл чухал үүрэгтэй.	...Нийгэмд бүрэлдэн тогтсон соёл хүн алхам тутамдаа суралцах хэрэгтэй болдог.

Хүний хөгжилд нөлөөлдөг эдгээр зүйлсийг бие хүний онолууд шүүн тунгаажээ. Бие хүний онолуудын гол үзэл санааг дараах хүснэгтэд тоймлон үзүүллээ.

Бие хүний онолууд

Онол	Онолчид	Үндсэн үзэл санаа
Бие хүний хөгжлийн онол	Чарльз Хортон Кули	Бусад хүмүүс тэднийг хэрхэн үнэлж буйн «Толины тусгалын» үр дүн гэж үзнэ.
	Жорж Херберт Мид	Бие хүний хөгжлийн үндсэн шат бол өөртөө бусдын үүргийг хүлээн авч «БИ» болон «НАМАЙГ» хэмээх төлөвшилтэй уялддаг.
Психоаналитик онол	Зигмунд Фрейд	Бие хүн хөгжих нь хэд хэдэн дараалсан үе шатаар явагдах ба бэлгийн гүйцэд хөгжлөөр төгс болно. Үе шат бүхэнд «ИД» болон «ГОЦ БИ»-ийн хооронд зөрчил үүснэ.
	Эрик Эриксон	Бие хүн өөрийнхөө амьдралд хямралыг гэтлэн давах хөгжлийн үе шатыг туулна.
Танин мэдэхүйн хөгжлийн онол	Жан Пол Пиаже	Дараалсан үе шатыг дамжих бүрт сэтгэх чадвар нэмэгдэхийн хамт, үе шат бүхэн нь шинэ мэдлэг эзэмших аргад сургана.
Зан суртахууны хөгжлийн онол	Лоренс Колберг	Бие хүний зан суртахууны хөгжил нь дараалсан хэд хэдэн үе шатаас бүрдэнэ. Тэдгээр нь суралцах чадварыг хөгжүүлэх, бусдын сэтгэхүйг ойлгоход чиглэсэн байна.



Хяналтын асуултууд:

1. Нийгэмшил хэмээх ойлголтын соёл хэмээх ойлголттой холбогдох сэжиг юу вэ?
2. Нийгэмшил нь эерэг сөрөг аль үүргийг илүүтэй гүйцэтгэх вэ, яагаад?
3. Сөрөг ба дахин нийгэмшил хэмээх ойлголтуудад ялгаа бий юу?
4. Нийгэмшлийн талаарх З.Фрейд, Ж.Г.Мид, Ж.Пиаже, Л.Колберг нарын үзлийн гол утга санааг тайлбарла?
5. Бие хүний нийгмийн шинж чанаруудаас нэн тэргүүнд алиныг нь эзэмшдэг вэ?
6. Сөрөг нийгэмшлийн жишээ гаргана уу.



Эх сурвалж:

1. Батбаатар М (2007) Социологийн онол, түүх УБ., Сорхон цагаан хэвлэл.
2. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
3. Смелзер Н (2001) Социологи. УБ
4. Осипов Г.В. (1990) Социология и социализм М, Наука
5. Schaefer R.T, Lamm R.P (1994) Sociology, New York, Mc Graw Hill
6. Scott J. Marshall G (2005) Oxford Dictionary of Sociology. Oxford University press



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон

БҮЛЭГ-V. Бодгаль ба бүлэг

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Соёл ба нийгэмшил	Хүн ба бүлгийн тухай суурь ойлголтууд Хүний тухай үзэл, онолууд	2	Лекц
	Эрх зүйн орчин дахь бие хүн ба бүлгийн харилцаа, түүний онцлог	2	Семинар

2.5. Бодгаль ба бүлэг

Сэдэв - 1: Хүн ба бүлгийн тухай суурь ойлголтууд Хүний тухай үзэл, онолууд

Хичээлийн зорилго: Бодгаль хүн ба бүлгийн амьдралын нийгмийн үндэс, хүний бүлгийн зан үйл, нийгэм дэх бүлгийн хэлбэрүүдийг тайлбарлаж сурна.

Гол ойлголтууд:

- ❖ Бодгаль хүн
- ❖ Хувь хүн
- ❖ Бие хүн
- ❖ Символизм
- ❖ Пессимизм
- ❖ Диспозиц
- ❖ Хүний зан үйл
- ❖ Өдөр тутмын харилцаа
- ❖ Социаль бүлэг
- ❖ Анхдагч бүлэг
- ❖ Хоёрдогч бүлэг
- ❖ Бүлгийн зан хандлага

Сэдвийн агуулга:

- ❖ Хүний тухай ойлголт, тодорхойлолт
- ❖ Хүний тухай социологийн үзэл онолууд
- ❖ Бүлгийн тодорхойлолт
- ❖ Нийгмийн бүлгийн ангилал, онцлог

Санал болгож байгаа арга:

- ❖ Асуулт тавих
- ❖ Бүлгээр ажиллах



- *Хүний тухай ойлголт, тодорхойлолт*

Шинжлэх ухаан үүсэх үеэсээ хүнийг сонирхон судалж байсны хувьд хүн бол шинжлэх ухааны судалгааны хосгүй объект юм. Хүнийг биологийн, сэтгэлзүйн, угсаа гарвал зүйн, нийгмийн, соёлын, газарзүйн тэр ч бүү хэл цаг агаарын гм олон хандлага, чиглэлээр мөн чанарыг нь тодорхойлж, хувьсал өөрчлөлтийг авч үзэж тайлбарлах нь бий. Энд жишээ болгон дараах хандлагуудыг дурдаж болох юм.

- **Биологийн хандлага.** Хүний нийгмийн үзэгдэл үйл явцыг хүний биологи шинжид тулгуурлан тайлбарладаг. Жишээ нь, хүний нүүр царай, төрөлх араншин, инстинкт, биеийн тогтоц, төрх, цусны болон хромсомын онцлог шинж, тулах болон хөдлөх эрхтэн гэх мэт олон шинжүүдээр хүнийг тойрсон асуудлыг тайлбарладаг. Энэ хандлагад Дарвин, Ломброзо, Шелдон, Кричмер гэх мэт олон салбарын эрдэмтэд багтдаг. Хүний нийгэмшлийн хөгжил, орчинд хандах хандлага нь биологийн шинжид илүүтэй тулгуурладаг гэж үздэг.
- **Сэтгэлзүйн хандлага.** Хүнийг сэтгэцийн болон сэтгэлзүйн амьтан гэж үздэг. «Сэтгэц гэдэг үзэгдэл нь энэ ертөнц дээр байгаа үзэгдэл юмсын аймгийн нэгэн бүрэлдэхүүн болж эргээд тэрхүү ертөнцөд бидний төсөөлөөгүй ихээр нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй» гэж Ницше хэлсэн нь бий. Хүн бол сэтгэгч амьтан гэдэг нь шинэ дүгнэлт биш бөгөөд эртний сонгодгуудаас эхлээд хүний үл үзэгдэх шинж чанарын тухай, тухайлбал сүнс хүн бүрт байдаг дотоод энерги импульсийн тухай сургаж байсан байна. Гэвч орчин үеийн шинжлэх ухаанд хүний сэтгэлзүйн амьдралыг тайлбарлах, сэтгэц гэж юу болох, түүний өөрийн цэвэр шинжийг био-физиологийн нөхцөлөөс нь ангид авч үзэж байна. Тухайлбал уураг тархи, түүнд багтсан мэдрэлийн үй түмэн эсүүд, хүний мэдрэлийн тогтолцоо зэрэг нь хэдийгээр сэтгэх үндэс мөн боловч сэтгэлзүйн амьдрал бол мэдрэхүйгээс давсан өөр ертөнц мөн гэж үзсэн.
- **Антропологийн хандлага** бол хүн түүний үүсэл хөгжил, язгуур шинж түүнд нөлөөлсөн байгаль нийгэм, соёлын хүчин зүйлсийг авч үздэг. Антропологид хүн хүний хамтын амьдрал үүсч бий болоход нийгэм соёлын нөлөөллийг авч үзэх ба хүний дээд өвөг, эх соёлуудыг тайлбарласан байдаг.
- **Соёлын хандлага.** Шинжлэх ухааны харьцангуй сүүл үеийн хандлага бөгөөд хүн бол нийгмийн амьтан тэр дундаа нийгмээс дээгүүрх үзэгдэл болсон соёлын амьтан мөн гэж үздэг. Эл хандлага ёсоор «Хүн бол дээд үнэт зүйл, өөрийн амьдралдаа үнэт зүйлс, үнэлэмж, үнэ цэн, хорио цээр гэх мэт соёлын олон хүчин зүйлийг бий болгож, нэгтгэж, хадгалж байдаг» гэжээ. Энэ утгаар нь хүний өөрийн үнэлэмж үнэт зүйлсийн баримжаалал түүнийг танин мэдэх бололцоотой гэж үздэг.
- **Нийгмийн хандлага.** Социологи, философи, эдийн засаг, эрх зүйн гэх мэт олон шинжлэх ухаануудын уулзвар зааг дээр судлагддаг.

Хүнийг тойрсон асуудлууд нь бусадтайгаа байгаа цагт үүсдэг. Хүн бусадгүйгээр оршдоггүй гэж үздэг. *Социаль генетик хандлага* ба хүний нийгмийн шинж чанарыг хэрхэн тодорхойлох вэ гэдэг асуудал байнга тавигддаг. Өөрөөр хэлбэл, биологийн шинжийг бодвол нийгмийн шинж нь хийсвэр ойлголт, түүнд гарт баригдах барин тавин хэмжүүр тогтоох бололцоо хомс гэж үздэг. Тиймээс энэ шинжийг хүн бусадтайгаа байх тэр орон зайд нарийвчлан тодорхойлох хэрэгтэй юм.

- **Социологийн хандлага** нь хүний нийгмийн зан үйл бол нийгэм орчиндоо хариу үйлдэл үзүүлж байгаа хэлбэр, нөгөө талаас бусдын зан үйлийг тайлбарлаж түүнд дасан зохицож байгаа арга хэлбэрийг судалдаг. Иймд социологи бол хүний зан үйлийн тухай шинжлэх ухаан гэж ихэнх эрдэмтэд санал нэгтэй хүлээн зөвшөөрөх нь бий. Хүний тухай социологийн ойлголт, тайлбар энгийн. Хүнийг бүлгийн харилцааны үүднээс, нэг бол бүлгээс ангид авч үздэггүйд социологийн хандлагын гол онцлог оршино. Хүнгүй бүлэг оршдоггүйн адил хүний шинжийг бүлэггүйгээр олж авах талаар төсөөлөх аргагүй. Чухамдаа хүнийг хүн болгож буй гол чанар, үндсэн шинж бол нийгэм дэх бичил орчин болох бүлэг мөн. Хүнийг мөн чанарын хувьд биологи, сэтгэл зүй, нийгэм, соёлын уг чанартай гэж үздэг. Энэ талаарх социологийн тайлбар үзэл урсгалуудыг багцлан дараах хүснэгтэд дурдав (Батбаатар, 2007, 63).

- *Хүний тухай үзэл онолууд*

1.Символизмын чиглэл: Энэ чиглэлийн гол төлөөлөгч нь Эрнст Каспер юм. Хүн бол ерөөс символ (билэг тэмдгийн) амьтан. Хэл, үлгэр домог, шашин гэх мэт соёлын элементүүдийг онцлон авч үздэг. Өөрөөр хэлбэл, хүн нь символыг түгээх шинж чанараараа амьтдаас ялгаатай. Соёлын билэг тэмдгийг ойлгох чадвар зөвхөн хүнд байдаг гэж үздэг.

2.Пессимист үзэл: Гол төлөөлөгч нь Макс Шеллер. Өөдрөг бус урсгал чиглэл гэж үзэж болно. Гол агуулга нь хүн бүрэн гүйцэд боловсорсон амьтан биш юм гэж үздэг. Ийм учраас хүнийг дахин шинээр боловсруулах хэрэгтэй. Ийнхүү боловсруулах гол субъект бол хүн өөрөө юм. Хүн биологийн организмын хувьд хагас дутуу боловсрогдсон амьтан гэж үздэг. Жишээ нь, адгуус хурдан, харах, үнэртэх зэрэг өөрийн тодорхой шинжээрээ хүнээс харьцангуй давуу гэж үздэг. Энэ үзлээр байгалиас хэдий чинээ тусгаар байна, тэр хэмжээгээр хүн өөрийгөө хөгжүүлэх боломж бололцоог олж авдаг. Үүнийг зөвхөн хүн өөрөө бий болгож чадна. Хүний өөрчлөгдөх, хөгжих үйл явц нь ямар нэг хэв загвараар явагддаггүй гэж үзжээ.



3. Философийн антропологийн үзэл: Гол төлөөлөгч нь Эрих Фромм. Позитивист уламжлалтай. Э.Фроммын үзэл онолын гол санаа нь М.Шеллерийн «хүн бол төгс боловсорсон амьтан биш» гэдэгтэй холбогдоно. Хүн мөн чанарынхаа хувьд дараах зөрчилтэй.

1-рт Хүн үргэлж нийгэм рүүгээ тэмүүлдэг.

2-рт Хүн үргэлж нийгмээс зугатааж байдаг.

Түүнийхээр хүний бүх үйл ажиллагаа хоёр үндсэн хэрэгцээгээр тодорхойлогддог. Эхний хэрэгцээ нь бусад зүйлтэй холбоотой байхад оршино. Хоёрдах нь бусад зүйлээс хараат бус байх хэрэгцээ. Чухамхүү хүний нийгмийн мөн чанарыг эдгээр хоёр хэрэгцээ тодорхойлдог гэж үздэг. Жишээ нь, амьдралын зорилго, үнэт зүйлс гэх мэт шинжүүд үүнд хамаарна. Нөгөө талаар хүн бол хамгийн их айдастай байдаг амьтан. Хүн аливаа зүйлд ухамсартай хандах тусам илүү их айдастай байдаг гэж үзсэн. Ийм учраас айдас нь сэтгэлгээтэй нягт холбоотой байдаг бөгөөд хүний мөн чанарын бас нэг тал мөн.

• *Бие хүний онолууд*

1. Дүрүүдийн онол

Бие хүний дүрүүдийн онол нь хүнийг судлах социологи ба сэтгэл зүйн нэгдлийг өөртөө агуулж байдаг. Бие хүний дүрүүдийн онолын үндэс нь нийгмийн сэтгэлзүйч Ж.Х.Мид, социологи дахь социаль антропологич Р.Линтон нарын бүтээлд тусгалаа олсон. Ж.Х.Мид гол анхаарлаа дүрүүдийг сургахад буюу өөрөөр хэлбэл «бие хүмүүс хоорондоо харилцан үйлдэлцэх явцдаа дүрүүдийг эзэмших, хувь хүн харилцаанд орохдоо өдөөсөн харилцан үйлдлийн үүргийн хүлээлтийг тэмдэглэх» зэрэг болно. Харин Р.Линтон бие хүний социаль байр суурьтай холбоотой дүрүүдийн нийгэм соёлын мөн чанар, нийгэм ба бүлгийн хориг арга хэмжээ болон дүрүүдийн хэрэгцээний тогтолцоог авч үзсэн байна. Бие хүний дүрүүдийн онолын хүрээнд «дүрүүдийн зөрчилдөөн» болох дараах өвөрмөц үзэгдлийг илрүүлсэн байна. Нийгмийн янз бүрийн социаль нийтлэгүүдээс тухайн гишүүндээ «дүрүүдийн зөрчилдөөнт» байдал оруулах буюу харилцан адилгүй хандах нь субъектийг хямралын нөхцөл байдал оруулдаг ажээ.

2. Бие хүний марксист онол

Нийгэм дэх үүрэгт ангийн ухамсарыг гол болгодог. Бие хүнийг нийгмийн харилцааны бүтээгдэхүүн болгон авч үздэг.

3. Бие хүний диспозиц онол

Бие хүн социаль зан үйлийн хувьд өөрийгөө зохицуулдаг хэмээх онол. Диспозиц гэдэг нь бие хүний үйл ажиллагааны тодорхой нөхцөлд түүний зан үйл, үйлдэл авч үзэгдэх явдал мөн. (Л.Хьелл, Д.Зиглер, 2000, 270) Диспозиц нь дараах зүйлсийг агуулна.

- Амьдралын зорилго ба үнэт зүйлийн баримжаалал
- Социаль хэв шинжийн объект ба нөхцөл байдал ерөнхийлөн дүгнэгдсэн социаль баримжаалал

4. Социометрийн чиглэл

Бүлгийн дотоод харилцааг судласны дараагаар бүлэг дэх хүний үйл ажиллагааг тайлбарлахыг гол болгодог.

5. Сэтгэц-задлал шинжлэлийн онол

З.Фройдийн үзэлд тусгагдсан. Бие хүний хамгаалалтын механизм ба сэдэлд анхаарлаа хандуулдаг. Энэ үзэл нь бүлгийн онолууд өөрчлөгдөх гол үндэс нь болж өгсөн.

Хүнийг мөн чанарын хувьд бодгаль хүн, хувь хүн, бие хүн хэмээн ялган үзэх нь буй. (Радугин, 2003, 69) Эдгээр ойлголтыг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Бодгаль хүн хэмээх ойлголтоор дахин давтагдашгүй биологийн болоод хувийн шинж чанарыг,

Хувь хүн хэмээх ойлголтоор нийгмийн харилцаамжийн хувьд нэг тухайлсан онцлог шинжээр нь,

Бие хүнийг нийгмийн харилцааны объект хийгээд субъект болох хувьд нь тус тус авч үздэг.

- *Бүлгийг тодорхойлох нь*

Аливаа нийгмийн бүлэг нь: Нэгдмэл нэг зорилготой, хэрэгцээ сонирхол эрх ашгийн хувьд адил буюу ойролцоо, тодорхой бүтэц зохион байгуулалтай хоёр ба түүнээс олон хүмүүсийн нэгдэл мөн. (Сорокин)

- *Бүлгийн ангилал, онцлог*

XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн социологчид (Э.Дюркхайм, Г.Зиммел, Ч.Кули, Ж.Морено болон бусад) социологи дахь бүлгийн онолыг дэвшүүлсэн байна. Хагас зууны туршид бүлгийг судлах явцад бичил бүлгийг судлах гурван үндсэн гол чиглэл тодрон гарсан. Тэдгээр нь бүлгийн өөрчлөлтийг судлах чиглэл, зан үйлийн хандлага болон социометрийн чиглэл ажээ.

Хүн төрөхөөс авахуулаад насан эцэслэх хүртлээ нийгмийн ямар нэг тодорхой бүлэгтэй холбоотой амьдардаг. Хүний хамгийн анхны бүлэг бол гэр бүл юм. Энэ утгаар нь гэр бүлийг нийгмийн анхдагч бүлэг гэж үздэг. Цэцэрлэг сургууль, цэргийн болон хөдөлмөрийн хамт олон гм нь бүгд нийгмийн тодорхой бүлгүүд юм. Бүлгийг судлаачид албан ёсны ба албан ёсны бус, анхдагч, хоёрдогч, гэнэтийн, зайлшгүй, чөлөөт гэх мэт олон янзаар ангилж үздэг. Бүлэг бол өөрийн дотоод бүтэцтэй, ёс суртахууны болон эрхзүйн хэм хэмжээтэй, дотооддоо хяналт тавих арга механизмтай, бас өөртөө тодорхой зөрчлийг агуулж өөрчлөгдөн хөгжиж байдаг «амьд» нэгдэл байдаг.

Бүлэг бүхэнд нийгмийн тодорхой үүрэг байна. Нийгэмд гүйцэтгэх үүргийнх нь онцлогоос хамаарч бүлгийг гүйцэтгэгч, илэрхийлэгч, дэмжигч бүлэг гэж ангилах нь бий. Гэхдээ бүлгийн ямар ч ангилал нэлээд



харьцангуй шинжтэй байдаг. Бүлэг бол бие хүнийг хүрээлж буй нийгмийн шууд орчин мөн. Ийм болохоор аливаа бүлэг нь хувь хүнийг нийгэмтэй холбох нэг ёсны гүүр болж байдаг.



Хяналтын асуултууд:

1. Бие хүн ба бодгаль хүн хэмээх ойлголтууд ямар ялгаатай вэ?
2. Хүний тухай социологийн онолуудын ижил төсөөтэй ба ялгаатай талуудыг харьцуулж тодорхойл?
3. Анхдагч ба хоёрдогч бүлгийн ялгааг тодорхойлно уу.
4. Социаль бүлгийн үндсэн шинжүүд юу вэ?
5. Бие хүн ба бүлгийн зан хандлагын аль нь давамгайлалч шинжтэй вэ?
6. Хүн насны онцлогоос хамааран нийгмийн ямар бүлэгт илүүтэй хамрагддаг вэ? насны үе шат бүрт зонхилон хамрагддаг бүлгүүдийг дурдана уу.
7. Гэмт бүлэглэлүүдийн хэлбэрүүдийг судалж, гэмт үйлдэл, гэмт явдал, гэмт хэрэг зэргийг жишээн дээр тайлбарлах.



Эх сурвалж:

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Батбаатар М (2007) Социологийн онол, түүх УБ., Сорхон цагаан хэвлэл
3. Громов И, Мацкевич.А, Семенов.В (1997) Западная социология. М:Ольга
4. Дюркхайм Э (1990) Самоубиство., М:Мысль
5. Сорокин П.А (1995) Система социологии. том 1,2. М., Астрель
6. Радугин А.А(2003) Социологи, УБ., Адмон
7. Руденко Р.И. (2006) Социологийн ажилбар. /Орч.ред. Н.Болормаа/ УБ., PRO-LINE
8. Смелзер Н (2001) Социологи. УБ.,ШУА
9. Хьелл Л, Зиглер Д (2000) Теории личности. Санкт-петербург, Питер
10. Schaefer R.T, Lamm. R.P (1994) Sociology., New York, McGraw Hill



Унших материал:

Смелзер.Н (2001), Социологи, УБ, ШУА
Гидденс.Э (2006), Социологи, УБ, Адмон
Батбаатар.М(2007), Социологийн онол, түүх УБ.,

Сэдэв - 2: Эрх зүйн орчин дахь бие хүн ба бүлгийн харилцаа, түүний онцлог

Хичээлийн зорилго: Эрх зүйн орчин дахь бие хүн ба бүлгийн амьдралын нийгмийн үндэс, хүний бүлгийн зан хандлага, нийгэм дэх бүлэг, гэмт бүлэглэлүүдийн хэлбэрүүдийг харьцуулан тайлбарлах, гэмт хэрэгтэн бие хүний онолуудыг өөр хооронд нь харьцуулж, онцлог ялгааг тайлбарлаж сурах болно.

Гол ойлголтууд:

- ❖ Эрх зүйн субъект
- ❖ Гэмт хэрэгтний зан үйл
- ❖ Девиант бүлгүүд
- ❖ Гэмт хэргийн бүлэг
- ❖ Гэмт хэргийн бүлэглэл
- ❖ Гэмт хэргийн бүлгийн зан хандлага

Сэдвийн агуулга:

- ❖ Эрх зүйн орчин дахь хүн ба бүлгийн тухай суурь ойлголтууд
- ❖ Гэмт хэрэгтний зан үйлийн тухай үзэл, онолууд
- ❖ Гэмт хэрэгтэн ба гэмт хэргийн бүлэглэл, тэдгээрийн онцлог
- ❖ Гэмт бүлгийн зан хандлага, түүний онцлог

Санал болгож байгаа арга:

- ❖ Мэтгэлцэх

Мэтгэлцэхэд анхаарах гол зүйл нь тухайн сэдэв ямар нэг хэлбэрээр нотлогдох болон няцаагдах төлөвт байх ёстой. Мэтгэлцэх дараах сэдвүүд байж болох юм.

НОТОЛГОО	НЯЦААЛТ
Улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд бол гэмт бүлэглэл-мафи мөн.	Улс төр, эдийн засгийн бүлэглэл нийгмийн хөгжилд үр ашигтай, эдгээр нь цөөн тохиолдолд л шаардлагатай гэмт үйлдэл хийхэд хүрдэг.
Гэмт хэрэг болгон санаатай бөгөөд ёс зүйгүй байдаг.	Гэмт хэрэг болгон санаатай үйлдэгдэх албагүй, зарим гэмт хэрэг ёс зүйтэй байж болно.
Аливаа бүлгээр үйлдэгдсэн гэмт хэрэгт учруулсан хохирлоос хамаарч бүгдэд нь ял төлөвлөх нь зөв.	Аливаа бүлгээр үйлдэгдсэн гэмт хэрэг бүрт ял төлөвлөхдөө сэдэл үүсгэсэн ба үйлдсэнийг нь яллах ёстой.



Аливаа гэмт хэрэг орчноос хамааран, бүлгийн нөлөөгөөр үйлдэгддэг.	Аливаа гэмт хэргийг хувийн дотоод сэдэл, шалтгаантай үйлддэг.
Монголд гэмт хэрэг их байна, учир нь?	Монголд гэмт хэрэг бага байна, учир нь?

? **Хяналтын асуултууд:**

1. Нийгэм, хүн ам зүйн онцлогоос хамааран бие хүн гэмт хэрэгт холбогдох явдал байдаг уу, яагаад?
2. Хүүхдийн бүлэгт ихэвчлэн үйлдэгддэг гэмт хэргүүдийг тодорхойл?
3. Бие хүний гэмт хэрэг үйлдэх потенциалт байдал гэж юу вэ?
4. Асуудалтай, эрсдэлтэй, девиант бүлгүүдийн ялгааг дурдана уу?
5. Гэмт хэрэгтний зан үйлийн тухай социологийн болон эрх зүйн онолуудын ижил төсөөтэй ба ялгаатай талуудыг харьцуулж тодорхойл?
6. Гэмт хэргийн бүлэглэлүүдийн социаль шинжийг тодорхойл.
7. Гэмт хэрэгтэн бие хүн ба гэмт хэргийн бүлгийн зан хандлагыг харьцуулан ярилц.

📖 **Эх сурвалж:**

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Батбаатар М (2007) Социологийн онол, түүх УБ., Сорхон цагаан хэвлэл
3. Громов И, Мацкевич.А, Семенов.В (1997) Западная социология. М:Ольга
4. Дюркхайм Э (1990) Самоубиство., М:Мысль

📖 **Унших материал:**

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Оюунханд Ш (2005) Нийгмийн девиаци ба амиа хорлохуй УБ., Адмон

БҮЛЭГ-VI. Нийгмийн ялгарал, давхраажил

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Нийгмийн ялгарал, давхраажил	Давхраажлын тогтолцоо, орчин үеийн давхраажлын онолууд: К.Маркс, М.Вебер, В.Парьето, Т.Парсонс, П.Сорокин Давхраажлын шалгуур үзүүлэлтүүд	2	Лекц
	Социаль мобиль хөдөлгөөн Тэгш бус байдал ба ядуурал	2	Семинар

Сэдэв - 1: Давхраажлын тогтолцоо, давхраажлын онолууд Давхраажлын шалгуур үзүүлэлтүүд

Хичээлийн зорилго: Социаль ялгарал, давхраажил, орчин үеийн нийгмийн давхраажлын онолууд, жендэр ба давхраажил, мобиль хөдөлгөөн, ядуурал, тэгш бус байдлын талаар ерөнхий мэдлэгтэй болно. Тэгш бус байдалд ялгаварлах үзлээр үл хандахын зэрэгцээгээр тэгш бус байдал, нийгмийн ялгарлын талаар өөрийн хандлагатай болж, түүнд хүргэж буй нийгмийн хүчин зүйлсийг шүүмжлэлт байдлаар задлан шинжлэх арга чадварт суралцана.

Гол ойлголтууд:

- ❖ Нийгмийн ялгарал
- ❖ Нийгмийн давхраажил
- ❖ Боолчлол
- ❖ Каст
- ❖ Язгуур, зиндаа
- ❖ Эрх мэдэл ба хөнгөлөлт
- ❖ Засаглал ба нэр хүнд
- ❖ Нийгмийн баялаг ба хангамж
- ❖ Анги (дээд, дунд, доод, ажилчин, малчин, сэхээтэн)
- ❖ Мобиль хөдөлгөөн
- ❖ Тэгш бус байдал ба ядуурал

Сэдвийн агуулга:

- ❖ Давхраажлын тогтолцоо, тэгш бус байдлын тухай
- ❖ Орчин үеийн давхраажлын онолууд
- ❖ Давхраажлын шалгуур үзүүлэлтүүд
- ❖ Социаль мобил хөдөлгөөн
- ❖ Тэгш бус байдал ба ядуурал

Санал болгож байгаа арга:

- ❖ Уншиж, ярилцах
- ❖ Асуулт тавих



- *Давхраажил, тэгш бус байдлын тухай*

Давхраажил гэсэн нэр томъёо нь үе, давхраа, давхраажил, үелэл гэсэн утга бүхий *strata* гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд социологийн ухаанд нийгмийн шатлан захирах тогтолцоонд эд баялаг, нэр хүндийг хүртэх боломжоороо ялгардаг бүлгүүдийн зэрэг шатлалыг тэмдэглэдэг.

Товчхондоо нийгмийн давхраажил бол нийгэм үе буюу давхаргад хуваагдахыг илэрхийлсэн ойлголт юм. Нийгмийн давхраажлын тогтолцоог боол эзэмшлийн, кастын, язгуур зиндааны ба ангийн гэсэн дөрвөн хэсэгт ялган үздэг. Давхраажлыг авч үзэхийн тулд нийгэм дэх хүмүүсийн тэгш бус байдалд анхаарлаа хандуулна.

Тэгш бус байдал нь нэр хүнд, засаглал, мөнгө гэх мэт нийгмийн баялгаас хүмүүс харилцан адилгүй хүртэж буй нөхцөл юм.

Давхраажил бол тэгш бус байдал үе дамжин уламжлагдаж, үүний үр дүнд нийгэмд янз бүрийн анги давхраа үүсэх үйл явц юм.

Анги бол адил бус нэр хүнд, засаглал, эдийн засгийн чадавхи, баялаг бүхий нийгэмд ондоо ондоо байр эзэлж буй нийгмийн бүлгээр нөхцөлдөнө.

Эдгээр тодорхойлолтыг ойлгох дараах хялбарчилсан жишээг авъя.

ТЭГШ БУС БАЙДАЛ, ДАВХРАА, АНГИ


Тэгш бус байдал. Фермер эрхэлдэг хүн аж ахуйгаа улам өргөжүүлэх боломжтой. Арвин мал аж ахуй эрхэлж байх үед тариачин хүний тарьж байсан газар хатаж ихээхэн алдагдалд орлоо гэж үзье. Үүний үр дүнд тэр хоёр хүн материаллаг хангамжийн хувьд ялгаатай болно.

Давхраажил. Фермер эрхлэгч аж ахуйгаа улам хөгжүүлж, нас эцэслэсний дараа бүх хүүхдүүдэд нь зохих хувь ноогдоно. Харин тариачныг нас барахад хүүхдүүд нь юу ч өвлөсөнгүй. Ийм байдал бусад фермер, тариачдад нэгэн адил давтагдана.

Анги. Цаг хугацаа өнгөрөх тусам нийтлэг сонирхол болон тариачдаас дээгүүр гэх мэдрэмжээрээ фермер эрхлэгчид нэг бүлэг болон нэгдэхийн зэрэгцээ тариачид ч өөрсдөд тулгарч буй асуудлаараа нэгэн бүлэгт нэгдэж эхэлдэг.

Нийгмийн давхраажил, анги зэрэг нь нийгмийн бүтцийг бүрдүүлэгчид бөгөөд эл бүтцийг социологичид харилцан адилгүй авч үзэж, «зүсэлт» хийжээ. (Руденко, 2006, 282)

Нийгмийн бүтцийн үндсэн зүсэлтүүд



• *Орчин үеийн давхраажлын онолууд*

Социологичид нийгэмд тэгш бус байдал их тархсаныг хүлээн зөвшөөрдөг боловч түүний мөн чанар, шалтгааныг янз бүрээр тайлбарладаг.

Онолууд	Гол төлөөлөгчид	Үзэл баримтлал
Функционалист онол	Э.Дюрхайм	Цэцэглэн хөгжиж буй нийгэмд хамгийн авьяаслаг хүн, хамгийн чухал ажил үүргийг гүйцэтгэх ёстой. Шилдэг бөгөөд авьяас чадвартай хүнийг татахын тулд нийгэм эдгээр хүмүүсийн гавьяаг үнэлж, шагнаж урамшуулж байх ёстой.
	К.Дэвис, У.Мур	Хамгийн чухал ажил хөдөлмөрийг ухаантай хүмүүс гүйцэтгэх нөхцөлийг нийгэм хангаж өгснөөр тэгш бус байдал ач холбогдолтой. Ердийн нийгэмд дайчид ба анагаагчид өндөр статустай байдаг бол хөгжингүй нийгэмд эмч, инженерүүд өндөр үнэлэгддэг гэжээ.



Мөргөлдөөний онол	К.Маркс	Эдийн засгийн байгууллын аль ч хэлбэрт үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшсэн ноёлогч анги байдаг бөгөөд тэд үйлдвэрлэлийн хяналтыг хэрэгжүүлдэг гэж үзжээ.
	Р.Михельс	Эрх мэдэл төвлөрөх хандлага нь байгууллагын бүтэцтэй голлон холбоотой. Байгууллагад ажиллагсдын тоо тодорхой хэмжээнд хүртэл өссөн ямар ч тохиолдолд цөөнхийн эзэрхийлэл ямагт тогтоно гэжээ.
	Р.Дарендорф	Ангийн тэмцлийн шинж чанар эрх мэдлийн шинж чанараар тодорхойлогдоно гэж үзээд мөргөлдөөн дарга цэргийн хоорондын харилцаагаар биш эрх мэдэл хэн нэгэнд нь их байгаатай голлон холбогдоно гэж үзсэн.
Веберийн онол	М.Вебер	Тэрбээр давхраажлын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд бол хөрөнгийн тэгш бус байдал, алдар нэр, эрх мэдэл гэжээ.
	Ф.Паркин	Түүнийхээр өмч нь нийгмийн цөөнх хэсэг монопольчилж, эрх мэдэлд хүрэхдээ ашигладаг социаль саад бөгөөд бүлгүүд нөөц баялгийг зөвхөн өөрөө хянах, бусдын боломжийг хязгаарлахыг оролдож байдаг гэж үзсэн.
Элитийн онол	В.Парьето	Дээд анги шинэчлэгдэх үйл явц бол элитийн мөчлөгтэй холбоотой гээд элитийг хүмүүсийн элит ба энгийн олонх гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваан үзсэн.
Шилжинги чанарын онол	П.Сорокин	Нийгмийн давхраажил гэдэг бол хүмүүсийн үйл ажиллагаа ба нийгмийн үүргээс үүдсэн тэгш бус ялгарал бөгөөд энэ нь бүлэг хооронд төдийгүй бүлгийн доторх статусын ялгаанаас үүдэн бий болдог гэж үзсэн байна.
Уорнерийн онол	Л.Уорнер	Хүмүүсийн ангийн хамаарлыг бусад хүмүүсийн үнэлгээгээр буюу нэр алдраар тогтоодог. Уорнер давхраажлыг 6 ангилжээ.
Трейманы онол	Д.Ж.Трейман	Давхраажлыг хүмүүс хоорондын харилцаанаас бус харин тодорхой мэргэжилтэй уялдуулан тайлбарласан. Тэрбээр хөдөлмөрийн хуваарь, засаглал, эрх ямба, мэргэшил зэрэгтэй уялдуулж үзжээ.
Ангийн онол	Э.О.Райт	Капиталист үйлдвэрлэлд буй үндсэн ангиудыг эдийн засгийн нөөц баялгийг хянаж буй байдлаар нь тодорхойлж болно. Эдгээр хяналтууд нь хөрөнгө санхүү, үйлдвэрлэлийн хэрэгсэл, засаглал зэрэг болно гэжээ.

• *Давхраажлын шалгуур үзүүлэлтүүд*

Давхраажлын шалгуур үзүүлэлтийг социологичид харилцан адилгүй, өөр өөрөөр боловсруулж, авч үзсэн байдаг. Эдгээрийг дараах байдлаар багцлан нэгтгэж болно.

Эрдэмтэд, судлаачид	Давхраажлын шалгуур үзүүлэлтүүд
К.Маркс	Үйлдвэрлэлийн хэрэгсэл, өмч хөрөнгө, эрх мэдэл
М.Вебер	Засаглал, үнэ хүнд, эд баялаг
П.Сорокин	Эрх ба хөнгөлөлт, үүрэг ба хариуцлага, нийгмийн баялаг ба хангамж, засаглал ба нэр нөлөө
Монгол эрдэмтэд (Х.Гүндсамбуу, О.Мөнхбат нар)	Хөрөнгө бэл бэнчин, боловсрол, угсаа гарвал, орлого, эрх мэдэл

Орчин үеийн өрнөдийн нийгмийн давхраажлыг тодорхойлж буй үзүүлэлтүүдийг жагсаан үзвэл, 1.Мэргэжлийн нэр хүнд, 2.Эрх мэдэл, засаглалын түвшин, 3.Орлого, эд баялаг, 4.Боловсрол, мэдлэг, 5.Уламжлал, дэг жаяг хадгалах байдал, 6.Угсаа гарвал зэрэг болно (Руденко, 2006, 284).



Хяналтын асуултууд:

1. Давхраажлын эртний хэлбэрүүдийг дурдана уу?
2. Нийгмийн ялгарал хийгээд давхраажил хэмээх ойлголтуудын ижил төсөөтэй ба ялгаатай талуудыг дурдана уу?
3. Нийгмийн давхраажлын онолуудыг харьцуулан онцлог, ялгааг тайлбарлана уу?
4. П.Сорокины үзэлд тусгагдсан анги ба давхаргын тодорхойлолтын утгыг хэлнэ үү. Ямар ялгаатай вэ?
5. Хөгжингүй нийгэмд нийгмийн ямар давхарга зонхилдог вэ?
6. АНУ дахь нийгмийн бүтцийг ямар давхаргад хуваан үзсэн байдаг вэ?
7. Хэвтээ ба босоо чиглэлийн мобиль хөдөлгөөнүүд ямар ялгаатай вэ?
8. Монгол дахь ядуурлын үндсэн шалтгаануудыг энэ чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүнд тулгуурлан дурдана уу.



Эх сурвалж:

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Гүндсамбуу Х (2005) ХХ зууны Монголын нийгмийн давхраажил: төлөв байдал, хандлага., УБ
3. Мөнхбат О (2000) Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ.,
4. Руденко Р.И (2006) Социологийн ажилбар., УБ. PRO LINE
5. Сорокин П.А (1995) Система социологии. том 1,2. М., Астрель
6. Смелзер Н (2001) Социологи.УБ



Унших материал:

1. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
2. Смелзер Н (2001), Социологи, УБ
3. Гүндсамбуу Х (2005) ХХ зууны Монголын нийгмийн давхраажил: төлөв байдал, хандлага., УБ
4. Мөнхбат О (2000) Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ.,

Сэдэв - 2. Нийгмийн шилжинги хөдөлгөөн, тэгш бус байдал ба ядуурал

Хичээлийн зорилго: Нийгмийн тэгш бус байдал хийгээд ялгарал, давхраажил, нийгмийн шилжинги (социаль мобильност) хөдөлгөөний хэлбэрүүд, түүний шалгуур үзүүлэлтүүдийг ялган тайлбарлаж сурна. Мөн Монголын нийгэм дэх давхраажил, өнөөгийн нийгмийн тэгш бус байдалд шударга ёс, хүний эрхийн үзэл санааны үүднээс шинжилгээ хийж, үзэл бодлоо дэвшүүлэн тавих суурь мэдлэгтэй болно.

Гол ойлголтууд:

- ❖ Тэгш бус байдал ба ялгарал
- ❖ Нийгмийн ахиц дэвшил ба лугшилт
- ❖ Нийгмийн шилжинги хөдөлгөөн
- ❖ Хэвтээ чиглэлийн шилжинги хөдөлгөөн
- ❖ Босоо чиглэлийн шилжинги хөдөлгөөн
- ❖ Эрх мэдэл ба хөнгөлөлт
- ❖ Үүрэг ба хариуцлага
- ❖ Нийгмийн баялаг ба хангамж
- ❖ Засаглал ба нэр хүнд

Сэдвийн агуулга:

- ❖ Нийгэм дэх шилжинги хөдөлгөөний шалтгаан, үр дагавар
- ❖ Нийгмийн шилжинги хөдөлгөөн, түүний онцлог, хэлбэрүүд
- ❖ Босоо чиглэлийн шилжинги хөдөлгөөн-зиндаачлал
- ❖ Хэвтээ чиглэлийн шилжинги хөдөлгөөн

Санал болгож байгаа арга:

- ❖ Тохиолдол шинжлэх, дасгал ажиллах

Шилжинги (мобил) хөдөлгөөн гэж юу вэ?

Орчин үед, нийгэм хөгжихийн хэрээр шилжинги хөдөлгөөн нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, нэг давхраанаас нөгөө давхраанд шилжих, давхраа хооронд бие хүн статусаа солих шилжилт идэвхжиж байна. Нийгэм бүрт давхраажлын тодорхой бүтэц, тогтолцоо байх бөгөөд шилжинги хөдөлгөөний боломжоос хамааран хэлбэрийн хувьд хаалттай болон нээлттэй хэмээн хуваах нь бий.

Хаалттай давхраажлын хувьд давхраа хооронд маш чанд, хатуу зааг, хил хязгаартай, нэг давхраанаас нөгөө рүү шилжихийг хориглосон байдаг. Ийм давхраажлын жишээ болгож кастын байгуулал бүхий орнуудыг (Энэтхэг, гм) дурдаж болох юм. Харин нээлттэй давхраажил бүхий тогтолцооны хувьд нэг давхраанаас нөгөө рүү шилжихэд албан ба албан бус хязгаарлалт тавьдаггүй байна,

Шилжинги хөдөлгөөнийг шилжих хөдөлгөөнөөс ялгаатай ойлгох ёстой болохыг доорх хүснэгтэд тусгав.



Нийгмийн шилжинги хөдөлгөөн гэдэг нь тухайн хүн юм уу, бүлгийн нийгэм эдийн засгийн байр суурь өөрчлөгдөхийг илэрхийлсэн нэр томъёо юм.

Босоо шилжинги хөдөлгөөн нь нийгэм эдийн засгийн хэмжүүрээр байр суурь дээш буюу доош шилжих хөдөлгөөнийг хэлнэ.

Хэвтээ шилжих хөдөлгөөн гэж мужаас мужид, хөдөөнөөс хотод гэх мэт газарзүйн хувьд шилжих үйл явц юм.

Нэг үеийн доторх зиндаачлалыг интрагенераци, янз бүрийн үеийнхнийг хамарсан зиндаачлалыг интергенераци буюу үе дамжсан зиндаачлал гэж нэрлэнэ.

Дасгал 1. Тохирох хэсгүүдийг холбож, яагаад гэдгийг тайлбарла?

Тэгш бус байдал бол...	...нийгэм үе давхаргад хуваагдах явдал мөн
Бат хотод ажилд орохоор шилжиж ирсэн...	...интрагенераци зиндаачлал юм
Нийгмийн давхраажил бол...	...нийгмийн баялгаас адилгүй хүртэх
Хөдөлмөрлөх явцад тухайн хүн албан тушаал ахиж байвал...	...хэвтээ чиглэлийн шилжинги хөдөлгөөн
Нийгмийн байр суурь, хүндлэл бол...	...босоо чиглэлийн шилжинги хөдөлгөөн
Орлого, нэр хүнд, эрх мэдэл өсөж байвал...	...статус мөн.

Дасгал 2. Дээд, дунд, доод ангийн тухай дүрсэлж ярилцах: үүнд баян чинээлэг ба ядуу хүмүүс цөөн бөгөөд дунд анги голлосон ромбо маягийн, баян хүмүүс цөөн, ядуу хүмүүс ихтэй, дунд анги бүрэлдээгүй гурвалжин маягийн гм нийгмийн анги, бүтэц, давхрааны онцлогоор тэмдэглэл хийлгэж тайлбарлуулж, харилцан ярилцах.

Дасгал 3. Босоо чиглэлийн шилжинги хөдөлгөөний нийгэмд үзүүлэх эрх зүйн нөлөөллийг хэлэлц. Үүнд авлига, амиа хорлолт, залилан гм гэмт хэрэгт хэрхэн нөлөөлж болох талаар шүүн ярилцах.

Социологид нийгмийн шилжинги хөдөлгөөний мөн чанар, зүй тогтлыг тайлбарлах арга зүйн дараах хандлагууд бий. Эдгээрийг дурдвал,

Нийгмийн давхраажлыг шинжлэх арга зүйн хандлагууд

Бүтэц үүргийн хандлага	Зөрчилдөөний хандлага	Хувьслын хандлага
Нийгмийн шилжинги хөдөлгөөн нь жам ёсны, зайлшгүй, гарцаагүй шинжтэй. Учир нь энэхүү үйл явц нь нийгмийн хэрэгцээ шаардлагаар тодорхойлогдож байдаг.	Шилжинги хөдөлгөөн нь зайлшгүй биш ч гарцаагүй шинжтэй бөгөөд нийгмийн бүлгүүдийн өрсөлдөөн, зөрчилдөөнөөс улбаатай явагдана.	Шилжинги хөдөлгөөн нь зайлшгүй шинжтэй бус, мөн жам ёсны хэрэгцээнээс үүсдэггүй гэж үздэг.

Нийгмийн хэрэгцээ болон үүргийн дагуу бий болж буй үйл явц тул энэ нь шударга шинжтэй.	Эд хөрөнгө, нэр хүнд, эрх мэдэл эзэмшигчид давхраажлыг тодорхойлдог тул шударга биш.	Давхраажил нь шударга ба шударга бус алин нь ч байж болно. Тухайн тохиолдлыг онцолж үзэх хэрэгтэй.
Давхраажил нь нийгэм зүй зохистойгоор оршин тогтнох нөхцөлийг хангадаг.	Давхраажлын үйл явц нь нийгэм хэвийн оршин тогтнох үйл явцад саад болдог.	Давхраажил нь нийгмийн хөгжилд түлхэц үзүүлэх, эсвэл саад болж болох юм.



Хяналтын асуултууд:

1. Нийгмийн хөдөлгөөн, шилжих хөдөлгөөн ба мобил хөдөлгөөний ялгааг тайлбарлан ярилц?
2. Нийгмийн тэгш бус байдал хийгээд ялгарал, давхраажил хэмээх ойлголтуудын ижил төсөөтэй ба ялгаатай талуудыг дурдана уу?
3. Тэгш бус байдал ба шударга ёс, тэгш эрх зэрэг ойлголтуудын агуулгыг шүүмжлэн ярилц.
4. Хэвтээ ба босоо чиглэлийн мобил хөдөлгөөнүүдэд ямар хүчин зүйлс голлох нөлөө үзүүлдэг вэ?
5. Давхраажлын зарим элементүүдийг гэмт хэргийн зарим хэлбэрүүдтэй холбон ярилцана уу? (жишээ нь, авлига, эрх мэдэл ба хөнгөлөлт гм ойлголтууд холбоотой эсэх?)



Эх сурвалж:

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Гүндсамбуу Х (2005) ХХ зууны Монголын нийгмийн ялгарал давхраажил: төлөв байдал, хандлага. УБ.,
3. Мөнхбат О (2000) Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ
4. Парсонс Т (2000) О структуре социального действия М.,Наука
5. Сорокин П.А (1990) Система социологии. том 1,2 М.,
6. Смелзер Н (2001) Социологи. УБ



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Мөнхбат О (2000) Нийгмийн социаль бүтцийн социологи. УБ
4. Гүндсамбуу Х (2005) ХХ зууны Монголын нийгмийн давхраажил: төлөв байдал, хандлага., УБ



БҮЛЭГ-ҮИИ. Нийгмийн институтууд

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Нийгмийн ялгарал, давхраажил	Гэр бүлийн болон боловсролын институт	4	Лекц
	Монголын гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтүүд	2	Лекц
	Эдийн засгийн болон шашны институт	2	Семинар
	Засаглал ба улс төрийн институт	2	Лекц
	Засаглал, эрх мэдлийн (authority) хэв маягууд М.Веберийн социологийн шинжилгээнд тулгуурлан хэлэлцэх	2	Семинар

Сэдэв - 1: **Нийгмийн институтууд:** **Гэр бүлийн болон боловсролын институт**

Хичээлийн зорилго: Гэр бүл ба боловсролыг нийгмийн институт болгох үүднээс нь авч үзэх, тэдгээр институтийн бүтэц, бүрэлдэхүүн, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар суурь мэдлэг хийгээд социологийн институциональ хандлагын үүднээс тайлбарлах аргазүйг эзэмшүүлэхэд энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Нийгмийн институт
- ❖ Инститүцжих үйл явц
- ❖ Гэр бүл ба гэр бүлийн хувьсал өөрчлөлт
- ❖ Гэр бүлийн хэлбэр, хэв маяг
- ❖ Гэр бүлийн чиг үүрэг
- ❖ Боловсрол ба боловсролын хэв маягууд
- ❖ Боловсролын чиг үүрэг

Сэдвийн агуулга

- ❖ Нийгмийн институт гэж юу вэ? институтийг тодорхойлох шинж чанарууд: Гэр бүл болон гэр бүлийн институтийн онцлог, хэлбэр, хэв маяг, гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг,
- ❖ Боловсрол институт болох нь, боловсролын институтийн онцлог ба боловсролын хэв маягууд, боловсролын нийгэмд гүйцэтгэх үүрэг,

• *Нийгмийн институтц гэж юу вэ?*

Энэ болон дараагийн бүлэгт (VIII) нийгмийн суурь институтүүдийн талаар (гэр бүл, боловсрол, шашин, төр болон эдийн засгийн институтүүд) социологит хэрхэн авч үздэг талаар авч үзэх болно. Тиймээс тэдгээрийн талаар эргэцүүлэхийн өмнө ерөөс нийгмийн институт (social institution) гэж юу болох талаар товч тайлбарлах хэрэгтэй болж байна.

-
- | | |
|--|--|
| <i>Шигтгээ.</i> | 1. <i>Социаль институтцүүд нь нийгмийн амьдралыг сууриар нь бэхэлж өгдөг. (Гидденс, 2006, 314)</i> |
| <i>Нийгмийн институтцийн талаарх тодорхойлолтууд</i> | 2. <i>Институтц гэдэг нь нийгмийн тогтвортой хэрэгцээг хангахад чиглэсэн цэрэг, статусын цогц байдал юм. Нийгмийн хэрэгцээтэй нийцэж байх нь институтцийн чухал шинжийн нэг мөн. (Смелзер, 2001, 68)</i> |
| | 3. <i>Нийгмийн институтцүүд нь нийгмийн суурь хэрэгцээг хангахад чиглэсэн итгэл үнэмшил хийгээд зан үйлийн зохион байгуулагдсан хэв загвар мөн. (Sheafer, 1995)</i> |
-

Хэрэв бид нийгмийг байшинтай зүйрлэвэл институтц нь түүний бүхэлдээ оршин тогтнох үндэс буюу «яс мод» нь болж байдгийг дээрх тодорхойлолтууд онцолж байна. Мөн нийгэмд оршин буй тогтвортой хэрэгцээг хангахын тулд буюу ийм хэрэгцээнд нийцүүлэн хүмүүс тодорхой үүрэг болоод статусын хүрээнд байнгын үйл ажиллагааг явуулж байх бөгөөд түүний үр дүнд институтц бүрэлдэн тогтдог болох нь харагдаж байна. Улмаар хүмүүсийн үүрэг, статусын нэгдэл болсон байгууллага, бүлгүүд нь нийгмийн хөгжлийн явцад соёлын (итгэл үнэмшил, зан үйлийн) тодорхой хэв загварыг бүтээх ба бүрэлдэн бий болсон эл хэв загвар нь хүмүүсийн хооронд цаашид өрнөх харилцаа, харилцан үйлдлийг зохицуулж байдгийг илэрхийлжээ. Нийгмийн суурь хэрэгцээг хангагч үндсэн институтүүдийн хувьд бол юуны өмнө гэр бүл, боловсрол, шашин, төр засаг, эдийн засаг, урлаг, шүүх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл зэргийг дурдаж болох юм. Социологич Р. Миллс орчин үеийн нийгэмд *суурь институциональ эмх журмыг* буй болгож буй үндсэн таван институтц байгааг: 1) Эдийн засгийн институтүүд-аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах; 2) Улс төрийн институтүүд – засаглал; 3) Гэр бүлийн институтүүд-бэлгийн харилцаа, төрөлт, хүүхдийн нийгэмшлийг зохицуулах; 4) Цэрэг, дайны институтүүд – хууль ёсны залгамжийг хэрэгжүүлэх; 5) Шашны институтүүд – бурхны хамтын гэрээ, сургаалийг зохион байгуулах гэжээ. (Добреньков В.И., Кравченко А.И, 2002, 58)



- *Нийгмийн институтууд бүтцийн ямар элементүүдийг агуулдаг вэ? (Дж. Бернард и Л. Томпсон)*

Нийгмийн чиг үүрэгтэй нь холбогдсон зорилго, зорилттой

Зан үйлийн хэв загвар ба дүрэм горимтой

Бэлэгдэл, бэлгэ тэмдгийн тусгаар системтэй

Өвөрмөц, хэрэглээний зүйлстэй

Аман болон бичмэл уламжлалтай

Социологийн шинжлэх ухаан үүссэн цагаас хойш түүний судлах асуудлын хүрээнд социаль институтүүдийн оршин тогтнол хийгээд чиг үүрэг онцгой байртай байж ирсэн билээ. Тухайлбал, уг шинжлэх ухааныг үүсгэн байгуулагч О.Конт нийгмийн тогтвортой байдалд гэр бүл, шашин, төр засаг гэсэн гурван институт чухал үүрэгтэйг заагаад тэдгээрийн нийгмийн зөвшил, интеграцчилалд тус тусын оруулж буй хувь нэмрийг заасан байдаг. (Мөнхбат О, 2009)

- *Гэр бүлийн институт ба гэр бүлийн хувьсал*

Гэр бүл бол нийгмийн хамгийн анхдагч, урт удаан оршин тогтносон, басхүү хамрах хүрээ хамгийн өргөнтэй институт болох нь тодорхой юм. Энэ талаар Британий социологич А.Гидденс «Ямар ч төрлийн нийгэмд гишүүд нь гэр бүлд хүмүүждэг бөгөөд аль ч нийгэмд насанд хүрэгчдийн дийлэнх нь гэрлэсэн эсвэл гэрлэж байсан байх юм. Гэрлэлт маш өргөн тархсан социаль институт болдог хэдий ч, янз бүрийн соёлтой улс орнуудад нийгмийн амьдралын бусад харилцааны адил гэрлэлт, гэр бүлийн хэлбэрүүд нь хоорондоо үлэмж ялгаатай байдаг» хэмээн онцолсон байдаг. (Гидденс, 2006, 315) Гэр бүл үүсгэх, гэрлэх харилцаа нь улс орнуудын соёлын онцлогоос хамааран ихээхэн өөрчлөгдөж байдаг бол басхүү нийгмийн хөгжлийн түүхэн үе шатуудад гэр бүлийн амьдрал ихээхэн хувьсаж ирсэн байх юм. Түүхч Лоуренс Стоун дундад зууны гэр бүлийн амьдралын хэв маяг орчин үеийнхээр солигдоход хүргэсэн өөрчлөлтийн бүдүүвчийг гаргажээ. Тэрээр XVI-XIX зуун хүртэлх европын гэр бүлийн хувьслыг гурван үе шатанд авч үзсэн байна. (Гидденс, 2006, 319-320) Гэр бүл хэмээх ойлголтын талаар барууны социологичдын тодорхойлолтуудаас сонирхое. *Гэр бүл гэж садан төрлийн холбоогоор холбогдсон насанд хүрэгчид нь хцүхдүцдүйнхээ өмнө хариуцлага хүлээсэн бүлэг хүмүүсийг хэлнэ (Гидденс, 2006, 315), цусан төрлийн холбоо, гэрлэлт болон үрчлэлтэд дулдүйдсан, аж амьдралаараа холбогдож, үр хцүхдийн хүмүүжилд харилцан хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдэл (Смелзер, 2001, 68), гэр бүл гэдэг нь цусан төрөл, гэрлэлт (гишүүд нь энэхү*

харилцааг хүлээн зөвшөөрсөн), үрчлэлээр холбогдсон, гишүүдийнхээ нөхөн үйлдвэрлэл болон асран халамжлахад анхдагч үүрэг хариуцлагаа хуваалцаж буй хүмүүсийн бүрдэл (Sheafer, 1995, 361). Гэр бүл гэх ойлголтын доор цусан болон садан төрлийн хэлхээгээр, мөн үрчлэлээр холбогдсон, харилцан үүрэг хариуцлага хүлээсэн хүмүүсийн бүлэг гэж тодорхойлох нь социологийн шинжлэх ухааны төдийгүй, нийгмийн шинжлэх ухааны бусад салбаруудад ч нийтлэг тааралддаг зүйл гэж хэлж болно. Түүнчлэн улс орнуудын эрхзүйн актуудад, тухайлбал гэр бүлийн хуульд ч энэхүү агуулгаар тодорхойлсон байх нь нийтлэг зүйл юм.

- *Гэр бүлийн түүхэн хувьсал*

Нээлттэй овгийн гэр бүл. Аж үйлдвэрийн хувьсгалаас өмнө олонх гэр бүл газар хагалж, гар урлал хийдэг үйлдвэрлэлийн нэгж байлаа. Ханиа сонгох нь хайр сэтгэл, дэврүүн эрмэлзэл бус, харин бусдыгаа халамжлах, гэр бүлийн үйлдвэрлэлийг тасралтгүй явуулах шаардлага. Ханиа сонгох хувийн эрх чөлөө нь эцэг эх, төрөл төрөгсөд, нийтлэгийн ашиг сонирхолд захирагдаж байв. Дэврүүн хайрыг язгууртнуудаас гадна, шашныхан дур гутам зүйл гэж үздэг байв. Бэлгийн харилцааг дур ханамжийн эх булаг гэхээс илүү үр удмаа үлдээх шаардлага гэж үздэг байжээ.



Тусгаар эцгийн эрхт гэр бүл. XVI зууны эхэн үеэс эхлэн гол төлөв нийгмийн дээд давхаргынхны гэр бүлийн амьдрал өмнөх хэлбэрээс тусгаар эцгийн эрхт гэр бүл өөд шилжих шилжилтийн байдалтайгаар зуу орчим жилийг туулжээ. Удтал хугацааг завсрын шатанд өнгөрөөсөн ч, энэхүү хэлбэр гарч ирэн цаашид түгэн тархсан нь гэр бүлийн хувьсалд ихээхэн ач холбогдолтой байжээ. Дан гэр бүл улам бүр тусгаарлагдан бие дааж, төрөл садан, орон нутгийн нийтлэгтэй нь холбоо нь суларсан байна. Гэр бүлийн хувьслын энэ шат нь эцгийн дарангуй эрх мэдлийг дагалдуулж байсан ч, энэ нь эцэг, эхийн хайр халамж өссөнтэй холбоотой байлаа.



Гэрсэг, хаалттай дан гэр бүл. Гэр бүлийн гишүүдийн сэтгэл санааны итгэлээр холбогдсон, гэр бүлийн бие даасан чанар өндөрссөн, хүүхдийн хүмүүжилд илүү анхаарал тавьдаг. Гэрсэг, хаалттай дан гэр бүл бий болсон нь сэтгэл хөдлөлийн хувь шинж өсч, өөр өөр мэдрэмж, ариун хайрын хэм хэмжээг тодорхойлдог хувийн сонголтоороо гэрлэх явдал өссөнөөс үүдсэн мэдрэмжийн хайр, гэрлэлтээс гадуурх харилцаанд төдийгүй гэрлэлтэд зохих ёсны байр сууриа эзлэх болов. Ханиа сонгох нь хайр дурлал дээр тулгуурлан харилцаагаа үргэлжүүлэх хүслээс хамаарч эхлэв. Хүн амын чинээлэг давхрааныхны дунд үүссэн гэр бүлийн энэхүү хэлбэр аж үйлдвэржилт эхлэхэд (XVIII зууны сүүлээс) барууны ихэнх улс орнуудад зонхилох болжээ. Харин XX зуун хүртэл хадгалагджээ. Ийнхүү гэр бүл өнөөг болтол хадгалагдсан тэр төрхөндөө оржээ.



• *Гэр бүлийн хэлбэр ба хэв маягууд*

Дан (nuclear) болон **өргөжсөн** (extended) гэр бүлийн талаар социологичдын бүтээлд дурдсан байх нь нийтлэг. Ийм ангилал нь гэр бүлийн бүтцээс үүдэлтэй байдаг. Олонх америкчууд эцэг эх болон тэдний хүүхдүүдээс (төрүүлсэн болон өргөж авсан) тогтож байгаа гэр бүлийг зүй ёсны хэмээн үздэг байна. Түүний зэрэгцээ өргөжсөн гэр бүл байх ба энэ нь дан гэр бүлийн гишүүдийн дээр эмэг, өвөг, нагац, авга, ач зээ, үеэл хамтран аж төрөхийг хэлнэ. Ихэнх нийгэмд дан гэр бүлийг нийгмийн үндсэн нэгдэл хэмээн чухалд үздэг боловч, нийгмийн харилцааны хөгжил, харилцан туслалцаа, дэмжлэгийн баталгаа болох өргөжсөн гэр бүлийн үүргийг үнэлэх явдал ч өөрчлөгдөж байна. (Смелзер, 2001, 369) Түүнээс гадна **моногами** гэр бүл нь нэг эмэгтэй зөвхөн нэг эрэгтэйтэй л өөр хоорондоо гэрлэх явдлыг ойлгодог. Үүний зэрэгцээ бас гэрлэлтийн өөр хэлбэрүүд байх ба нэг хүн хэд, хэдэн хүнтэй гэрлэхийг **полигами** гэр бүл гэнэ. Олон эхнэртэйг **полигини**, олон нөхөртэйг **полиандр** гэнэ. (Sheafeg, 1995, 362, 363) Барууны орнуудад гэрлэлт болон гэр бүлийг моногамитай адилтгадаг. Өөрөөр хэлбэл, нэгээс илүү эмэгтэйтэй, юм уу эсвэл эрэгтэйтэй нэгэн зэрэг гэрлэснийг хууль бус хэмээн үздэг байна. Гэвч судлаачдын явуулсан судалгаагаар гэр бүлийн моногами хэлбэр нь хамгийн өргөн дэлгэрсэн туршлага биш ажээ. Жорж Мердок 565 нийгмийн байгуулалд харьцуулсан судалгаа хийж үүний 80 хувьд нь полигами хэлбэр байгааг тогтоожээ. Түүний судалсан нийгмийн байгууллын дөнгөж дөрөвд нь буюу нэгээс бага хувьд нь полиандр хэлбэр тохиолджээ. Тэгэхээр дэлхийн улс орнуудад нэг нөхөр олон эхнэртэй гэр бүлийн хэлбэр зонхилдог гэсэн үг юм. (Гидденс, 2006, 317)

Социологийн шинжлэх ухааны хүрээнд **уламжлалт** болон **орчин үеийн** гэр бүлийн хэв маягуудын талаар судлан эргэцүүлэх нь бий. Уламжлалт болон орчин үеийн гэр бүлийн амьдрал үйл ажиллагааны хэм хэмжээг харьцуулсан хүснэгтээс харж болно.

Уламжлалт болон орчин үеийн гэр бүлийн нийтлэг хэм хэмжээ

Гэр бүлийн үйл ажиллагааны хүрээ	Уламжлалт гэр бүлийн хэвийн хэм хэмжээ	Орчин үеийн гэр бүлийн ердийн хэм хэмжээ
Үйлдвэрлэлийн	Хөрөнгөтэй чинээлэг давхрааны гэр бүлийн эхнэр ажиллах ёсгүй. Хөрөнгөгүй гэр бүлийн эхнэр эдийн засгийн шаардлагын улмаас ажил эрхэлдэг.	Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд ажил хийх, мэргэжлээрээ өсөх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох тэгш эрх олгогдсон байна.
Нөхөн үржихүйн	Гэр бүл нь олон хүүхэдтэй байх ёстой. Олон хүүхэдтэй байх тусам сайн хэмээдэг.	Гэр бүлийн хосуудын үзэл бодол, амьдралын хэм маягаар төлөвлөгдөн төрөлт хязгаарлагдаж байдаг.

Хүмүүжлийн	Хүүхдүүдийг маш хатуу дэгээр хүмүүжүүлэх ба хүмүүжлийн шинж чанарыг эцэг тодорхойлж эх нь гүйцэтгэдэг.	Хүүхдийг хүмүүжүүлэхдээ түүний ашиг сонирхол, санал бодлыг харгалзан үлгэр дууриал, итгэл үнэмшил дээр тулгуурладаг. Хүүхдийг эцэг, эх хоёр тэгш оролцоотойгоор хүмүүжүүлнэ.
Аж ахуйн	Гэрийн аж ахуйг эмэгтэйчүүд хөтлөх ба чинээлэг гэр бүлд эрэгтэйчүүд гэрийн ажлаас бүрэн чөлөөлөгддөг. Харин хөрөнгөгүй гэр бүлд тэд биеийн хүчний хүнд ажил хийдэг.	Эхнэр, нөхөр хоорондоо тохиролцон авьяас чадвар боломжоо харгалзан үүргээ уян хатан хуваарилна.
Эдийн засгийн	Гэр бүлийн тэжээгч нь нөхөр бөгөөд түүний олсон мөнгийг эхнэр захиран зарцуулна.	Гэр бүлийн материаллаг аж байдлыг дээшлүүлэхэд мэргэжил эзэмшилт болон нэмэлт орлого олох боломжоосоо хамааран эхнэр, нөхөр хоёулаа адил оролцоно.
Чөлөөт цагийн	Найз нөхөдтэй харьцах, зугаа цэнгэлд явах, дуртай зүйлээ хийхэд гэр бүлийн хосууд хамтдаа эсвэл нөхөр нь тодорхой хэмжээгээр илүү эрхтэй байв.	Эхнэр, нөхөр хоёулаа гэр орноосоо гадуур болон нэг нэгнээсээ тусдаа чөлөөт цагаа өнгөрүүлэх тэгш эрхтэй.
Оюун санааны харилцааны хүрээ	Хосууд хоорондоо зөвхөн гэр бүлийн асуудал, гэрийн аж ахуй, хүүхдүүд болон төрөл төрөгсдийн тухай ярилцдаг.	Хосуудын харилцаа нь нөхөрсөг, гэр бүлийн асуудлаас гадна ажил мэргэжил сонирхлын тухай ярилцдаг.
Найз нөхөд, төрөл садантайгаа харьцах харилцаа	Бүхий л төрөл садантайгаа заавал байнгын харилцаа холбоотой байх, хөршүүдтэйгээ найз нөхдийн харилцаатай байх, нөхрүүд нь л дотно найз нөхөдтэй байна.	Сонирхол дээр тулгуурлан найз нөхдийн харилцааг тогтоох, төрөл садан болон хөршүүдтэйгээ байнгын харилцаанд байх албагүй.
Эрх мэдэл, тэргүүлэгчийн хүрээ	Нөхөр нь өрхийн тэргүүн бөгөөд бүхий л асуудалд шийдвэр гаргадаг.	Хосууд хамтдаа ярилцаж байгаад шийдвэр гаргадаг. Эрх мэдлээ хуваалцдаг байна
Нийгмийн анхдагч хяналтын хүрээ	Эмэгтэйчүүдийн зан үйлд гэр бүлийн зүгээс хатуу хяналт тавих боловч эрэгтэйчүүдэд харьцангуй зөөлөн хандана.	Эрэгтэй ба эмэгтэйн зан үйлд гэр бүлийн зүгээс адил тэгш хяналт тавьдаг.



Сэтгэл санааны харилцааны хүрээ	Зөвхөн эмэгтэйчүүд хайр энхрийлэл сэтгэл санааны дэмжлэгийг үзүүлдэг.	Гэр бүлийн хосууд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн зан авирын онцлогийг харгалзан харилцан сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэг.
Нийгмийн нэр хүндийн хүрээ	Гэрлэлтийг харьцангуй хязгаарлагдмал, нийгмийн нэгэн төрөл хүрээнд хийдэг. Гэрлэлтийн тусламжтай нийгмийн нэр хүндээ дээшлүүлэхийг эрмэлздэг.	Хувь хүний нийгмийн нэр хүндийн байдал бус харин хувийн шинж чанар гэрлэлтэд чухал ач холбогдолтой байдаг.
Бэлгийн харилцааны хүрээ	Бэлгийн харилцаа нь зөвхөн хүүхэд төрүүлэх зорилготой дагавар шинжийг агуулдаг. Эмэгтэйчүүдийг гэрлэхээс өмнө бэлгийн харилцаанд орохыг хориглодог, эрчүүдийг энэ асуудлаар шүүмжилдэггүй. Хөрөнгөтэй давхрааны эрчүүдийн гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаанд хориг тавьдаггүй.	Бэлгийн харилцаа нь нөхөн үржихүйн үүргээс улам бүр тусгаарлагдаж байна. Эмэгтэйчүүд бэлгийн амьдралд маш хариуцлагатай хандаж, өндөр шаардлагыг тавьдаг. Хайртай бол гэрлэхээс өмнө бэлгийн харилцаанд орохыг хүлээн зөвшөөрдөг. Гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаанд орсон аль нэгийг ялгалгүй зэмлэн шүүмжилдэг.

Эх сурвалж: Бүрэнжаргал Т. Гэр бүлийн социологи. 2005 он. 113

Уламжлалт гэр бүлээс орчин үеийн гэр бүлийн хэв маяг бүрэлдэн бий болсон нь гэр бүлийн өөрчлөлтийн түүхэн үйл явцтай холбоотой юм. Гэр бүлийн социаль өөрчлөлтийн үйл явц нь европын хамжлагын систем халагдаж хотруу нүүдэл нэмэгдсэн XVI зууны эхэн үеэс, мөн XVIII зууны сүүл хагасаас эхэлсэн аж үйлдвэржилтийн хувьсгалаас улбаатай гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Анхлан Европт тэр дундаа Англид XVIII зууны сүүл хагасаас, дараа нь Францад, арай хожуухан Германд улмаар бусад орнуудад хүчээ авсан аж үйлдвэрийн хувьсгал нь нөхөр өрхөө тэжээгч, (breadwinner) эхнэр нь ар гэрээ авч явагч (housekeeper) дүрийг бүтээж, гэрийн эзэгтэйн (housewife) сонгодог хэв маягийг бүтээсэн байна. Харин түүхийн явцад гэр бүлийн энэхүү хэлбэрүүд нь орчин үеийн гэр бүлийн хэв маягруу гулсан орсон байна. Гэр бүлийн эдүүгээжлийн үйл явц бол XX зуунд хамаарах үйл явдал билээ. Социологич А.Гидденс дэлхий дахины гэр бүлийн амьдралд гарч буй өөрчлөлтийн гол чиглэлүүдэд а) гэр бүлд омгийн болон ураг төрлийн бусад нэгдмэл бүлгүүдийн нөлөө буурсан, б) ханиа чөлөөтэй сонгох хандлага ажиглагдаж, дурлал, ариун хайрыг чухалчлах явдал түгээмэл болов, в) эмэгтэйчүүд ханиа сонгох болон гэр бүлийн дотоод асуудалд шийдвэр гаргах эрхтэйг хүлээн зөвшөөрсөн, г) хүмүүс ураг төрлийн харилцаагаар тогтоогдсон тодорхой хүрээнээс гэр бүл

болох явдал халагдав, д) бэлгийн харилцааны эрх чөлөө бий болж, хавьгүй чөлөөтэй болсон, е) хүүхдийн эрх өргөжих ерөнхий хандлага ажиглагдсан зэргийг авч үзжээ. (Гидденс, 2006, 322) Гэр бүл ийнхүү *уламжлалт хэв маягаас орчин үеийн хэв маягт* шилжихэд аж үйлдвэрийн хувьсгал суурь дэвсгэр болсон боловч, эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх хөдөлгөөн, бүх нийтийн боловсролын системийн үүсэл, хөгжил, олон түмний үйлдвэрлэл ба хэрэглээ, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, залуучуудын хөдөлгөөн (1960-аад оны хиппи, 70-аад оны рокууд, 80-аад оны панк, 90-ээд оны эгосентрик) гээд өнгөрсөн зуу гаруй жилийг дамнасан социаль өөрчлөлтийн үр нөлөө юм.

• *Гэр бүлийн өөрчлөлтүүд ба гэр бүлийн бодлого*

Америкийн социологич Смелзерийн хэлсэнчлэн бидний зүгээс нэгэнт мэдэх болсон гэр бүл болон гэр бүлийн амьдралд гарч байгаа өөрчлөлтүүдийг олонх судлаач нийгмийн (төрийн) зүгээс анхаарах ёстой асуудлууд хэмээн үзэж байгаа юм. Үүнд, эн тэргүүнээ:

- ❖ Гэрлэлтийн түвшин буурах явдал
- ❖ Салалт болон гэр бүлийн тусдаа амьдрагч гишүүдийн тоон өсөлт
- ❖ Гэрлэлгүйгээр ханилагч хосуудын тоо хэмжээний өсөлт
- ❖ Гэрлэлтээс гадуур төрсөн хүүхдүүд нэмэгдэж байгаа байдал
- ❖ Өрөөсгөл гэр бүлийн тоон өсөлт
- ❖ Гэр бүлийн хэмжээ хийгээд төрөлтийн түвшин буурч байгаа байдал
- ❖ Хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн өсөлтөөс хамаарч гэр бүлийн үүргийн болон хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо өөрчлөгдөж буй байдал зэрэг асуудлыг оруулж болох юм. (Смелзер, 2001, 392)

Нийгмийн хамгааллын чиглэлийн хууль тогтоомжууд нь төр болон гэр бүлийн өргөн цараатай харилцааны хүрээг илэрхийлж байдаг билээ. Нийгмийн энэ үндсэн институтийн өөрчлөлтийг баримжаалж эх, хүүхэд, гэр бүлд чиглэсэн төрийн санаачлагууд болох гэр бүлийн асуудлаар дагнан хариуцсан төв байгууллага (гэр бүлийн яамтай улс орнууд европт хэд хэд бий), зөвлөл, хороо байгуулж, нийгмийн хамгааллын шинжтэй хууль тогтоомжуудийг баталж, боловсронгуй болгож ирсэн нь барууны орнуудад түгээмэл практик болж ирснийг ХХ зууны түүхээс харж болдог. Улс орнуудын төрийн бодлогын түүхэн туршлагуудаас харж байхад төр болон гэр бүлийн харилцаа сонирхолтой байдлаар явж ирсэн байдаг. Нийгмийн баримжаатай ардчилсан дэглэм (social democratism) хүчтэй хөгжсөн зарим улс оронд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг (энэ утгаараа орчин үеийн гэр бүлийг) идэвхтэй дэмжиж ирсэн байхад, нөгөө хэсэгт нь консерватив нийгмийн бодлогоор дамжуулан уламжлалт гэр бүлийн хэв маягийг хадгалж үлдэх гэсэн эрмэлзэл илүүтэй байсаар ирсэн юм.



Шигтгээ. *Умардын буюу скандинавын орнуудад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хүчтэй дэмжиж ирсэн бол харин эх газрын баруун европын орнуудад харьцангуйгээр уламжлалт гэр бүлийг хадгалахыг эрмэлзэж ирсэн ба эмэгтэйчүүдийг гэртээ цр хүүхдээ авч явах байдлыг нь төрөөс бодлогоор дэмждэг байв. Эхний бцлэг оронд (Швед, Финлянд, Дани г.м) эмэгтэй хүн гэрээс гадуур хөдөлмөрлөх нөхцөлийг хангахын тулд цэцэрлэг, өдөр өнжцүлэх, асрах төвцүдийг олноор байгуулж байхад, харин уламжлалыг хадгалагч хоёр дахь бцлэг оронд (Герман, Франц, Белги, Австри г.м) эхцүд хүүхдээ гэртээ өсгөх нөхцөлийг хангах үүднээс гэр бүлийн, хүүхдийн, эхийн мөнгөн тэтгэмжүүдийг бий болгож иржээ.*

Эх сурвалж: Family life and family policies in Europe. Volume 2. Problems and issues in comparative perspective. Oxford university press. 2002,213

Сүүлийн зуу гаруй жилийн хугацаанд гэр бүлийн харилцаа ихээхэн өөрчлөгдөж, улмаар гэр бүлийн амьдрал бүхэлдээ эдүүгээжиж ирснээс үүдэн улс орнуудын эрхзүйн тогтолцооны хөгжил нь нийгмийн гишүүдийн зан үйлийг зохицуулах шинэ тутам сорилтуудтай тулгарсаар ирсэн билээ. Улс орнуудын улс төрийн бодлогын ялгаатай хөгжил, соёлын онцлог, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран гэр бүлийн харилцааг хуульчлах талаар өөр өөрсдийн туршлагыг бий болгож ирсэн нь тодорхой боловч гэр бүлийн хүрээний өөрчлөлтөөс үүдэлтэй тулгамдаж буй асуудлуудыг зохицуулах хууль тогтоомжийн их давалгаа өнгөрсөн зуу гаруй жилийг өртөөчлөн хийгдсэнийг доорх хүснэгтээс харж болно.

Шигтгээ. *Жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгслийн хууль тогтоомжуудыг батлан мөрдцүлсэн огноо*

Гэр бүлийн харилцаанд хамаарах эрх зүйн зохицуулалтын хөгжил

АНУ 1873, Канад 1882, Швед 1910, Дани 1913, 1937, Франц 1920, Белги 1923, Итали 1926, Япон 1931, Ирланд 1935, Герман 1941, Испани 1941, Их Британи 1930, Швед 1938

Үр хөндөлтийн тухай хууль тогтоомжуудыг батлан мөрдцүлсэн огноо

Нидерланд 1861, Швед 1921, 1938 Дани 1937, Франц 1920, Белги 1867, Их Британи 1893, 1938, Португал 1886, Итали 1926, Япон 1940, Ирланд 1861, Герман 1926, Испани 1941, Швейцар 1937

Эх сурвалж: Anne Helene Gauthier. The State and Family. A comparative Analysis of Family Policies in Industrialized Countries. Clarendon press Oxford. 1998, 31-33

Эдүүгээжих үйл явцын гэр бүлийн харилцаанд гаргасан өөрчлөлтийн асуудлаар эрхзүйн зохицуулалтын хүрээнд дэлхийн улс орнуудад соёлын түгээмлүүд (cultural universal) ажиглагдах боллоо. Үүний нэг томоохон

жишээ нь жирэмслэлтээс сэргийлэх эм, бэлдмэл, хэрэгслийг чөлөөтэй хэрэглэх, үр хөндүүлэх зэрэг харилцааг улс орнууд эрхзүйн хүрээнд зөвшөөрөх буюу хүлцэж хандах нь (tolerance) улам бүр нийтлэг болж байна гэсэн үг.

Шигтгээ. Европ дахь үр хөндөлтийн хууль	<i>Хугацааны загвар (12 хүртэлх долоо хоногт зөвшөөрнө)</i>	Институциональ загвар Хууль бус	
	<i>Австри, Белги, Болгар, Чех, Словак, Дани, Герман, Грек, Нидерланд, Норвеги, Швед (18 хүртэлх долоо хоногт)</i>	Чөлөөтэй	Хязгаарлагдмал боломжтой
		Их Британи, Финлянд, Франц, Унгар, Итали, Швейцар	Польш, Португал Ирланд

Эх сурвалж: Family life and family policies in Europe. Volume 2. Problems and issues in comparative perspective. Oxford university press. 2002, 233

Үр хөндөлтийн хүн ам зүйд үзүүлсэн нөлөө нь социологичдын анхаарлын төвд байдаг асуудал бөгөөд түүнийг хуулиар зөвшөөрснөөр барууны хөгжилтэй орнуудын хүн амын өөрчлөлтөд үзүүлсэн нөлөө тийм ч их байгаагүй билээ. Харин жирэмсний эсрэг эм, бэлдмэл, хэрэгслийг хуулиар зөвшөөрсөн нь үр хөндөлтөөс илүү хүчтэй нөлөө үзүүлжээ. Нөгөө талаас үр хөндөлт болон жирэмснээс сэргийлэх хоёр нь төрөлтөд нөлөөлөх хувьдаа харилцан нэгнээсээ хамаарах явдал байсныг ч тусгасан байдаг. Тухайлбал, зүүн европын орнуудад жирэмснээс хамгаалах эм, бэлдмэл, хэрэгслийн илт дутагдалтай байдал нь тэнд үр хөндөлтийн түвшин өндөр байхад нөлөөлсөн бөгөөд энэ нь төрөлтөд үзүүлэх үр хөндөлтийн нөлөө өндөр байсныг илэрхийлж болох талтай.

Гэр бүл салалт

Өрнөдөд олон зуун жилийн турш гэрлэлтийг бараг цуцалдаггүй байжээ. Онцгой тохиолдолд, тухайлбал гэрлэлтийн хэвийн харилцаа байх боломжгүй үед салалтыг хүлээн зөвшөөрдөг байв. Зарим улс оронд жишээ нь, Испанид гэрлэлтээ цуцлуулах эрхийг хүлээн зөвшөөрдөггүй аж. Түүнээс гадна Ирландад 1986 онд бүх нийтийн санал асуулгийн үр дүнд олонх нь гэр бүл салалтыг хуулиар зөвшөөрөхийн эсрэг санал өгчээ. Гэхдээ салалтыг хориглох нь нэлээд ховор зүйл болжээ. Бараг ихэнх үйлдвэржсэн орнуудад салалтыг хүлээн зөвшөөрсөн, нэг ёсондоо салалтаар уралдах «уралдааны систем»-ийг тогтоосон билээ. Гэр бүл салалт нь антропологич Паул Боханнаны тодорхойлсноор нэгэн зэрэг зургаан үйл явцыг агуулдаг гэжээ. Түүнийхээр сэтгэлзүйн салалт, хууль ёсны салалт, эдийн засгийн салалт, эцэг, эх байхын салалт, бүл, олон нийтийн салалт (найз нөхөд, хөрш, хамт олон өөрчлөгдөх), бодит салалт (бие даах, өөрийгөө хүндлэхийг



хичээх) зэрэг давхацсан үйл явцуудыг багтаасан нарийн төвөгтэй үйл явц юм. (Sheafer, 1995, 377) Гэр бүл салалтын асуудлыг шүүхээр шийдвэрлээд л асуудлыг нэг мөр шийдсэн гэж үзэж болохгүй бөгөөд энэ нь удтал үргэлжлэх нийгэм, сэтгэлзүй, эдийн засгийн үргэжлэл, үр дагаврыг буй болгодог. Тухайлбал, гэр бүл салалт хүүхдэд ихээхэн хэмжээний хөнөөлтэй зүйл бөгөөд зарим судлаачдын үзсэнчлэн сэтгэлзүй, нийгэмшлийн хувьд хөвгүүдэд охидуудаас хүнд тусдаг ажээ. (Sheafer, 1995,378) Түүнчлэн шүүхийн шийдвэрээр ихэнхдээ хүүхэд эх дээрээ үлддэг бөгөөд эндээс салсан өрх толгойлсон эмэгтэйчүүдэд гэр бүлээ тэжээх, хүүхдээ өсгөхөд санхүүгийн бэрхшээл нүүрлэдэг билээ. Шүүхээр хүүхдийн тэтгэвэр тогтоосон боловч эрчүүд түүнийгээ барагдуулахгүй байдлаас өрх толгойлсон эхчүүдийн амьдрал ядууралд орох, эх хүүхдэд учрах эрсдлийг бууруулах үүднээс умард европын зарим орнуудад хамгааллын өвөрмөц арга хэмжээг өнгөрсөн зуунд анхлан авч эхэлсэн байдаг.

Шигтгээ. *Хууль ёсны асран халамжлагчийн цэргээ орхисон эцэг, эхчүүдээс тэдний хүүхдэд чиглэсэн мөнгөн дэмжлэгийг гаргуулан авах сонгодог арга замыг Шведчүүд болон бусд скандинавын орнуудад буй болгожээ. Гэрлэлтээ цуцлуулж хүүхэдтэйгээ үлдсэн эхчүүдэд хүүхдээ өсгөхөд нь чиглэсэн мөнгөн тэтгэмжийг (хүүхдийн тэтгэвэртэй тэнцэх) олгох ба үүнийг заримдаа халамжлагч төрийн арга хэмжээ гэсэн буруу төсөөллүүд байдаг. Энэ бол гэр бүлийн уналтаас сэргийлэх, буцаан гаргуулах хангамж бөгөөд төрсөн болон өргөж авсан хүүхдүүдийнхээ өмнө хүлээх эцэг, эхийн эдийн засгийн цэрэгт тулгуурласан зүйл юм. Эцэг шүүхээр тогтоосон хүүхдийн тэтгэвэрээ төлж чадахгүй байгаа тохиолдолд төр урьдчилан олгон, харин эцгээс эргүүлэн гаргуулж авах бодлогын арга хэмжээ билээ.*

Эх сурвалж: Family life and family policies in Europe. Volume 2. Problems and issues in comparative perspective. Oxford university press. 2002, 198-200

Гэр бүлийн институт ямар цэрэг гүйцэтгэдэг вэ?

Гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх чиг үүргийн талаарх мэдлэг бусад чиглэлийг бодвол илүү ихээр бүрэлдэн бий болсон гэж үзэж болно. Ерөнхийд нь нөхөн үржихүйн, нийгэмшил, хүмүүжлийн, үнэт зүйлсийг дамжуулах гэх мэтээр түүний нийтлэг үүргүүдийг дурдаж байх нь олонтаа. Харин доорх хүснэгтээс нэлээд нарийвчлалтайгаар хувь хүний болон нийгмийн түвшинд ялгаж харах боломж бүрдэж байна.

<i>Шигтгээ.</i>	Гэр бүлийн үүргүүд	Нийгмийн үүрэг	Хувь хүний үүрэг
<i>Гэр бүлийн инститүцийн социаль чиг цүрэг</i>	1 Нөхөн үржихүйн	Хүн амыг биологийн хувьд нөхөн үйлдвэрлэх	Үр хүүхэдтэй болох хэрэгцээгээ хангах
	2 Хүмүүжлийн	Өсвөр залуу үеийг нийгэмшүүлэх, соёлын үл тасалдах чанарыг дэмжих	Эцэг, эх болж, үр хүүхэдтэйгээ харилцаа холбоотой байж, хүмүүжүүлэх
	3 Аж ахуйн	Нийгмийн гишүүдийг эрүүл бие бялдартай байлгах, хүүхдийг асран тэтгэх	Гэр бүлийн гишүүд харилцан нэг нэгэндээ ахуйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх
	4 Эдийн засгийн	Хөдөлмөрийн чадвартай болон насанд хүрээгүй нийгмийн гишүүдийг дэмжин тэтгэх	Гэр бүлийн гишүүд нэг нэгэндээ материаллаг дэмжлэг тусламж үзүүлэх
	5 Нийгмийн анхдагч хяналтын	Гэр бүлийн гишүүдийн нийгэмд биеэ авч явах зан үйл болон эхнэр, нөхөр, эцэг, эх, үр хүүхдийн ахмад настай хүмүүсийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, ёс суртахууны хэм хэмжээг тогтоох	Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааны эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг бүрэлдүүлэн дэмжих
	6 Оюун санааны харилцаа холбоо	Гэр бүлийн гишүүдийг бие хүн болгон төлөвшүүлэх	Гэр бүлийн гишүүдийн оюун санааны хөгжлийг дэмжих, гэр бүлийн эв нэгдлийн үндсийг бэхжүүлэх
	7 Нийгэм-нэр хүндийн	Гэр бүлийн гишүүдэд нийгмийн нэр хүндээ өвлүүлэх, нийгмийн бүтцийг нөхөн үйлдвэрлэх	Нийгэмд эзлэх байр сууриа дээшлүүлэн өсөн дэвших хэрэгцээг хангах
	8 Чөлөөт цагаа өнгөрүүлэх	Чөлөөт цагийг зүй зохистой өнгөрөөх, үүнд нийгмийн хяналт тавих	Гэр бүлийн гишүүд хамтдаа чөлөөт цагаа өнгөрүүлэх хэрэгцээг хангах, сонирхлыг нь баяжуулах
	9 Сэтгэл санааны харилцаа	Бие хүний сэтгэл хөдлөлийг тогтворжуулах, сэтгэл зүйн засал хийх	Гэр бүлд бие хүн сэтгэл зүйн хамгаалалт болон дэмжлэх авах
	10 Бэлгийн харилцааны	Бэлгийн харилцаанд хяналт тавих	Бэлгийн харилцааны хэрэгцээг хангах

Эх сурвалж. Бүрэнжаргал Т. Гэр бүлийн социологи. УБ, 2005 он, 171



- **Боловсролын институц ба боловсролын хэлбэрцүд**

Сургууль гэдэг үг грек үгнээс гаралтай ба «чөлөөт цаг, амралт» гэсэн утгатай ажээ. Учир нь аж үйлдвэржилтийн эринээс өмнөх нийгэмд хөрөнгө мөнгөтэй, цаг завтай хүмүүс л сургуульд суралцах боломжтой байсан. Шашны зүтгэлтнүүд, лам нар бичиг үсэг тайлагдсан цорын ганц социаль бүлэг байсан гэж хэлж болох юм. Ихэнх хүмүүсийн хувьд нас ахина гэдэг нь ахмад үеэсээ социаль туршлага, мэргэжлийн ур чадварыг өвлөн эзэмших явдал байлаа. Бидний дээр дурдсанчлан хүүхэд наснаасаа эхлэн гэрийн ажилд оролцох, тариан талбайг боловсруулах, аж ахуйн бусад ажилд туслах нь хэвийн зүйл байсан. Тэр үед унших бичих нь өдөр тутмын амьдралд тийм ч их хэрэгцээтэй, ашигтай зүйл байгаагүй. (Гидденс, 2006,343)

Нийтээр бичиг үсэг мэдэхгүй байсны өөр нэг шалтгаан бол номын бүх эх бичвэрийг гараар хичээнгүйлэн хуулбарлан бичдэг байсан явдал бөгөөд энэ нь өртөг ихтэй төдийгүй өргөн дэлгэрээгүй байсан юм. Энэ байдлыг Хятадаас Европт орж ирсэн ном хэвлэх (барлах) арга өөрчилсөн билээ. Өрнөдөд 1454 онд Йоханн Гутенберг гэгч анх хэвлэлийн машин зохион бүтээжээ. Ном хэвлэх энэхүү арга нь эх бичвэр, ном товхимол төдийгүй нийгэмд хэрэгцээтэй мэдээ агуулсан материал сэлтийг олон нийтийн хүртээл болгожээ. Улмаар нийгмийн амьдралын бүх хүрээнд хэвлэмэл материалуудыг ашиглах болсон нь бичиг үсэгт тайлагдах, суурь түвшинд уншиж, бичих чадварыг өндөр түвшинд хүргэсэн байна. Аажмаар тусгайлан барьсан сургуулийн байранд суралцах, орчин үеийн хэлбэр бүхий боловсрол үүсэж, төлөвшиж эхэлжээ. Европын орнуудад, Америкт анхан шатны боловсрол олгох сургуулийн систем байгуулагдаж эхэлсэн үе буюу XIX зууны эхний хагас хүртэл үндсэндээ хүн амын дийлэнх нь сургуулийн боловсролгүй байжээ. Аж үйлдвэржилтийн үйл явц, хотжилт нь тусгайлан сургуулиуд байгуулах хэрэгцээг өдөөсөн юм. (Гидденс, 2006,343) Ерөнхийдөө **боловсролын институцийн хөгжилд** хүчтэй нөлөө үзүүлж, түүний тархалтыг хурдасгасан хоёр томоохон үйл явдал бол *нэгдүгээрт*, ардчилсан хувьсгал (Францын хувьсгал), *хоёрдугаарт*, аж үйдвэрийн хувсгал (Англи түүчээ болсон) хэмээн үздэг. Эл хоёр үйл явдал нь цаг хугацааны хувьд хоёул XVIII зууны сүүл хагаст хамрах билээ.

Өнөө цагт хүмүүс үйл ажиллагааны олон салбарт ажиллаж байгаа ба мэргэжлийн ур чадварыг эцэг эхээс хүүхдүүдэд өвлүүлэх бололцоогүй болсон бөгөөд мэдлэг эзэмших үйл явц нь ихэнхдээ өвөрмөц ур чадвар, дадлыг практик байдлаар өвлүүлэх бус, харин хийсвэр шинжлэх ухаануудын мэдлэгт (математик, байгаль судлал, түүх, уран зохиол) суурилах болжээ.

Орчин үеийн **боловсролын институцийн нэг онцлог** шинж нь хүмүүс эрт, орой ямар ч болов бага сургуульд заавал бөгөөд үнэ төлбөргүй суралцах явдлаар илэрхийлэгдэх учиртай. Ийм хандлага эхлээд Германд бий болж бусад улс оронд дэлгэрчээ. (Смелзер, 2001, 407) Улс орнуудад иргэд нь ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхийг үндсэн хуулиар тунхаглах байдал нь нийтлэг зүйл болсон бөгөөд ядуу буурай

болон хөгжиж байгаа орнуудын ерөнхий боловсролд бүрэн хамран сургах чиглэлд дэлхийн хэмжээний байгууллага, хөгжилтэй орнууд анхааран дэмжих болсон байна. Энэ утгаараа боловсролын институт нь А.Гидденсийн гэр бүлийн институтийн мөн чанарын талаар онцлож байсан лугаа **нийгэмд хамгийн өргөн тархсан** зүйл мөн ажээ. Өнөөгийн нийгэмд боловсролын институтцаар дамжаагүй хүмүүс өчүүхэн бага хувийг эзлэх бөгөөд боловсролын гадна үлдэж байгаа хүмүүсийг албан бус болон зайны хэлбэрээр ч болов шинжлэх ухааны сургалтад хамруулахыг хичээдэг. Америкийн социологич Свелзер дэлхийн улс орнуудад боловсролын хэд, хэдэн хэв маягууд оршин байгаа талаар дурдсан нь бий. Тэрээр бүх нийтийн болон шилмэл боловсрол, төвлөрсөн болон төвлөрөлгүй боловсрол, техникийн болон ерөнхий боловсрол зэргийг ялгаатай болохыг заажээ. (Свелзер, 2001, 417)

• **Бүх нийтийн болон шилмэл боловсрол**

Боловсролын институт үүсч бий болохоосоо эхлэн цаашдын хөгжлийнхөө явцад удтал нийгмийн дээд давхаргынханд хамаарах зүйл хэвээр үлдсэн билээ. XX зуунд боловсрол бүх нийтийн үйл хэрэг болж, шилмэл боловсролын тогтолцоо задрах үйл өрнөхөөс өмнө боловсрол, ялангуяа дээд боловсролын тогтолцоо шилмэл хэсгийнхний зүйл байсан тул шилмэл боловсрол үүсч хөгжих, хадгалагдах үндэс болсон байна. Учир нь хэдийгээр бүх нийтийн боловсрол бүрэлдсэн ч шилмэл боловсрол олгох, эзэмших хандлага Европын орнуудад өнгөрсөн зуунд ч хадгалагдсаар байсан бөгөөд өнөө хир нь оршоор буй.

<i>Шигтгээ.</i>	<i>Дундад цөийн европ дахь дээд боловсролын бүхий л тогтолцоог шилмэл боловсрол хэмээн нэрлэж болох бөгөөд учир нь хүн амын өчцүхэн хэсэг (1-5%) болох нийгмийн дээд давхаргын төлөөлөгчдөд хүртээлтэй байв. Оксфорд, Кембридж, Эдинбург, Сэнт-Эндрю зэрэг Их Британий ууган дээд сургуулиуд голлож «боловсон хүн»-д нийцэх, хүмүүнлэгийн болон тусгай мэдлэгийг заадаг байв.</i>
<i>Шилмэл боловсролын үүсэл, хөгжил</i>	

XX зуунд шилмэл боловсролын тогтолцоо задарч, доод болон цөөнхийн бүлгийн төлөөлөгчдөд боловсрол эзэмших тэгш бололцоо олгох шаардлагын улмаас дээд боловсрол өргөн тархсан юм. Ерөнхийдөө Америк, Канад, хуучнаар ЗХУ, Япон зэрэг улс оронд анх бүх нийтийн боловсролын хөгжил хурдасч, харин европт энэ үйл явц эдгээр орныг бодвол алгуур явагдсан байна.

• **Төвлөрсөн болон төвлөрөлгүй боловсрол**

Боловсролын институтийн төвлөрөл болон төвлөрсөн бус байдлын талаар социологичдын өгүүлсэн зүйлсийг авч үзье. Тэдний судалснаар боловсролын системийн зарим хэв маяг нь хэт төвлөрсөн шинжтэй байсан



аж. Тухайлбал, Франц улсад бүх оюутнууд үндэстний нэгдсэн хөтөлбөрийн дагуу суралцдаг, мөн нэгдсэн шалгалтыг өгдөг. Харин Америкийн систем нь аж үйлдвэрийн хөгжингүй улс орнуудтай харьцуулахад төвлөрөл арай багатай. Орон нутгийн удирдлагууд сургуульд зориулан ихээхэн хөрөнгө, хэрэгсэл гаргаж шаардлагатай санхүүжилтийн 40 хувийг хангаж өгдөг бол холбооны засгийн газар 10 хувийг нь л гаргаж өгдөг байна. Бусад хөрөнгө нь орон нутгийн татварын орлогоос бүрддэг. (Гидденс, 2006,345) Сургалтыг гэр бүл, сургууль болон бусад бүлэг төдийгүй нийгэм хэрэгжүүлнэ. Боловсрол, нийгмийн нэгдмэл байдалд амин чухал учраас төрийн засаглалын хяналт буюу нөлөөнд ямагт байж иржээ. Төр ба боловсролын харилцан үйлчлэл нь боловсролын хяналтын төвлөрлөөр тодорхойлогдоно. ЗХУ-д боловсрол хатуу чанд төвлөрсөн байв. Гэгээрлийн яам, Дээд, тусгай дунд боловсролын яам гэсэн коммунист нам, Сайд нарын зөвлөлд захирагддаг хоёр байгууллага бүх түвшний сургалтыг хариуцаж, төсвийг хянах бөгөөд тус улсын боловсролын институтийн зорилго нь үр ашигтай эдийн засгийг буй болгох, коммунист нийгмийг байгуулах зорилго бүхий төрийн хэрэгцээг гүйцэлдүүлэхэд оршиж байв. БНХАУ-д боловсролыг мөнхүү төвлөрүүлсэн ажээ. Бүх нийтийн боловсролын аугаа зорилтыг хэрэгжүүлэх, бүх нийтийн бичиг үсэг тайлагдалтыг бий болгох, сургалтыг сургууль, үйлдвэр, хамтрал, нэгдлээр зохион байгуулах нүсэр кампанит ажлыг төр удирдан хэрэгжүүлдэг байжээ. (Смелзер, 2001, 413)

Дээрх бичлэгүүдээс харахад боловсролыг төвлөрсөн болон эс төвлөрсөн гэх ангилалд багтаах нь төр ба боловсролын харилцан хамаарал, боловсролын удирдлага, санхүүжилтэд төв болон орон нутаг ямар харьцаатай оролцдог, сургалт явуулах, суралцагчдын амжилтыг дүгнэх ажлыг хэрхэн зохион байгуулдаг, тухайн нийгмийн зорилготой боловсролын институтийн хэрхэн уялдаж байгаа зэрэг асуудлуудаас хамаардаг байна.

- *Техникийн болон ерөнхий боловсрол*

Дээр дурдсанчлан боловсролын институтийн зорилго нь улс төр, нийгмийн хэрэгцээг хангахад чиглэхээс гадна эдийн засгийн хэрэгцээг хангахад байнга үйлчилдэг. Ардчилсан улс орнуудад боловсролын улс төрийн бус эдийн засгийн чиг үүрэг нь илүү чухалд тавигддаг байж болох юм гэсэн таамаглал нь тийм ч оновчтой зүйл биш билээ. Америкт өргөн дэлгэрсэн хүмүүнлэгийн боловсрол нь хуучны ЗХУ-ынхаас эрс ялгарч байжээ. Учир нь хуучны ЗХУ болон Хятад дахь боловсролын систем нь голлож аж үйлдвэрт шаардагдах дадал чадвар олгох чигийг баримжаалж байсан тул мэргэжлийн болон техник, эрдэм шинжилгээний тусгай бэлтгэлд илүү анхаардаг байжээ. Харин америк маягийн хүмүүнлэгийн боловсролыг чухалд үздэг нь ардчилсан нийгэм өөрөө оршин тогтнохын тулд иргэний боловсрол түүний дархлааг бэхжүүлэхэд таатай хөрс суурь болох бизээ. Гэвч орчин үеийн улс орнуудад хүмүүнлэгийн болон техникийн боловсрол нь зэрэгцэн оршиж байдаг боловсролын институтийн өргөн тархсан хоёр хэлбэр билээ.

• *Боловсролын институц ямар цэрэг гүйцэтгэдэг вэ?*

Боловсролын институтийн зүгээс нийгэмд гүйцэтгэх үндсэн чиг үүргүүдийг социологи дахь функциональ үзэл баримтлалын талынхан онцлон авч үздэг байна. Э.Дюркхайм боловсрол нь тухайн нийгэмд ноёрхогч соёлын үнэт зүйлсийг дамжуулах чиг үүрэгтэйг тэмдэглэсэн байдаг. Гэвч соёлын үнэт зүйлс бие биенээсээ үлэмж ялгаатай байдгийн хувьд боловсролын агуулгад ч ийм гүнзгий ялгаа бий болж байдаг гэсэн үг. Түүхэн цаг үеүдэд соёлын онцлогоосоо хамаараад боловсролын зорилго өөр өөр байсан бол өдгөө дэлхийн янз бүрийн соёлуудад үнэт зүйлсээс хамаараад боловсролын агуулгад ялгаа байгаа нь дамжиггүй. Хүн төрөхтөний хүмүүнлэгийн үнэт зүйлсийн дунд зөвшил бий болж, шинжлэх ухаануудын мэдлэг түгээмэл зүйл болохын хирээр боловсролын агуулга улам бүр нэгдэж байгаа ч түүх, уран зохиол, иргэний боловсрол, нийгэм, хүмүүнлэгийн тухай мэдлэгийг ерөнхий боловсролын хүрээнд дамжуулахдаа ялгаатай хандлагуудыг барих явдал одоо ч байсаар байна.

Юутай ч боловсролын институт нь сургалтын агуулга, арга барил, технологийн түвшингээс харьцангуй үл хамааран нийгэмд үндсэн чиг үүргүүдээ гүйцэтгэсээр байгаа билээ.

Боловсролын институтийн үндсэн чиг үүргүүд

Үндсэн үүргүүд	Боловсролын институц
Хяналтын үүрэг	Сургуулиуд нийгэмд ноёрхогч үнэт зүйлсийг хүүхдэд олгохын зэрэгцээ нийгмийн хяналтын хэрэгсэл болдог байна... Хүүхдүүдийн зан үйлийг өдрийн турш гол төлөв багш нар болон сургуулийн захиргааны бусад төлөөлөгчид хянадаг болно. Сурагчдын олонх нь сургуулиас тогтоосон дэг журмыг зөв гэж үзэж, удирдлагад нь захирагдаж, сургуульд олж эзэмшсэн итгэл үнэшил, дадал дүй болон гаргасан амжилтаа өндрөөр үнэлдэг юм. Боловсрол нь гэр бүл, шашин болон хуулийн тогтолцооны нэгэн адил нийгмийн тогтворт байдлыг тэтгэн дэмжихэд чиглэсэн институт болно.
Шүүлтүүрийн үүрэг	Коллеж төгсөгчдөөс таксиний жолооч, барменаар ажиллах явдал гардаг бол боловсролын түвшин багатай хүмүүс спорт, урлагийн болон бизнесийн зарим салбарт оргил амжилтад хүрсэн нь цөөнгүй байдаг. Гэсэн хэдий ч сургууль, коллеж нь ирээдүйд ямар ажил эрхлэх вэ? гэдгийг нь тодорхойлох нэгэн шүүлтүүр болдог юм... Боловсрол бол хүмүүсийг чанар чансааных нь байдлаар хуваарилах ухаалаг арга хэмээн үздэг.
Хүний капиталын үүрэг	Боловсрол бол өнгөрсөн үед зарцуулсан хүч чармайлт ирээдүйд ач тусгаа өгдөг, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хийгээд хариу шагнал хоёрын хооронд холбоо байдаг гэдгийг харуулдаг зүйл мөн. Хүний капиталыг бүрдүүлэхэд зарцуулж байгаа хүч чармайлт, хөрөнгө оруулалтын үндсэн үүргийг боловсрол хүлээдэг.



Хяналтын асуултууд:

1. Нийгмийн институт гэж юу вэ? Тэрээр нийгэм оршин тогтнох, хөгжихөд ямар холбоо хамааралтай вэ?
2. Гэр бүл яагаад нийгмийн суурь институт болдог вэ?
3. Гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх үүргүүдийг тайлбарлана уу?
4. Орчин үеийн болон уламжлалт гэр бүлийн бүтэц, харилцаа, нийгэмд гүйцэтгэх үүргийн ялгаатай байдлыг хэрхэн тайлбарлах вэ?
5. Боловсрол яагаад нийгмийн институт болдог вэ? Түүний нийгмийн институт болох шинжүүдийг нь хэлнэ үү?
6. Боловсролын институт нийгмийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэх вэ?
7. Элит боловсрол задарч бүх нийтийн боловсрол түрэн гарч ирсэн үйл явцын талаар ямар тайлбар өгөх вэ?



Эх сурвалж:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Richard T. Shaefer, Robert P. Lamm (1995), Sociology, Chicago press
4. Осипов Г.В. (2002), Социология: Основы общей теории, Москва, Издательство
5. Кравченко, Добрянков, (2002), Социальные институты и процессы: Социология, 3 том, М
6. Бүрэнжаргал Т (2005), Гэр бүлийн социологи, УБ
7. Family life and family policies in Europe. (2002), Volume 2. Problems and issues in comparative perspective. Oxford university press
8. Anne Helene Gauthier. (1998), The State and Family. A comparative Ananalysis of Family Policies in Industrialized Countries. Clarendon press Oxford



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон

Сэдэв - 2: Монголын гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлтүүд: эрх зүйн зохицуулалт (сем-2 цаг)

Хичээлийн зорилго: Монголын гэр бүлийн харилцаан дахь уламжлал болон шинэчлэлийн харьцааг тодорхойлох үүднээс нийгмийн үндсэн нэгж болсон гэр бүлийн бүтэц, харилцаанд гарч буй хувьсал, өөрчлөлтийг социологийн үүднээс шинжлэн, улмаар түүнийг зохицуулах эрхзүйн зохицуулалтад бүтээлч, шүүмжлэлт байр сууринаас хандуулахад энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Гэр бүл ба гэрлэлт
- ❖ Гэр бүлийн харилцаа
- ❖ Орчин үеийн гэр бүл
- ❖ Уламжлалт гэр бүл
- ❖ Гэр бүлийн бүтэц ба засаглал
- ❖ Гэр бүлийн хөдөлмөрийн хуваарь
- ❖ Гэр бүл дэх гаж үзэгдэл
- ❖ Альтернатив гэр бүл
- ❖ Гэр бүлийн эрхзүй

Сэдвийн агуулга:

- ❖ Гэр бүл, гэрлэлт ба гэр бүлийн харилцаа
- ❖ Гэр бүлийн хэв маягууд, тэдгээрийн ялгаа
- ❖ Гэр бүлийн бүтэц, засаглал, чиг үүрэг
- ❖ Гэр бүл дэх гаж үзэгдлүүд
- ❖ Гэр бүлийн альтернатив хэлбэрүүд

Санал болгож байгаа арга:

1. Бүлгээр ажиллах
2. Мэтгэлцээн

• *Монгол гэр бүл хэрхэн өөрчлөгдөж байна вэ?*

Гэр бүлийн харилцааны өөрчлөлт нь зөвхөн аль нэг улс орны тусгаар үйл явц байхаас илүүтэй улам бүр даяаршиж буй ертөнцийн хүрээн дэх нийтлэг үйл явц болж байна.



Шигтгээ. Гэр бүлийн гишүүдийн цэргийн хуваарилалтад өөрчлөлт орж байгаа,

Гэр бүлийн харилцаанд цйлчилж ирсэн ураг төрлийн уламжлалт харилцаа улам бүр саармагжих, үе хоорондын холбоо хөндийрэх хандлагатай болж, Их гэр бүл төвт тогтолцооноос Бага гэр бүл төвт тогтолцоо руу, хувь хүн рүү шилжиж байгаа,

Төрөлтийн тоо буурч, өнөр гэр бүлээс бүл цөөтэй гэр бүл рүү шилжиж байгаа,

XX зууны сүүлээс Монгол гэр бүлд өрнөдийн соёл, үнэт зүйлс нэвтэрсэн, XXI зууны босгон дээр Азийн соёлын нөлөөлөл идэвхжсэн нь өнөөдөр гэр бүлийн уламжлалт болон орчин үеийн соёлууд нэг талын хосолмол, нөгөө талын зэрэгцэн орших болсон,

Өргөжсөн гэр бүлийн хэлбэрээр амьдрах үзэгдэл Монголчуудын хувьд нийтлэг үзэгдэл байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь дан гэр бүл орших эдийн засгийн боломж хязгаарлагдмал байгаагаар нөхцөлдсөн,

Өрөөсгөл гэр бүлийн тоо нэмэгдсэн, бэлбэсэн болон салсан гэр бүлд тулгамдаж буй нийтлэг бэрхшээл нь санхүүгийн хүндрэл, ганцаардал, сэтгэл санааны хямралд орох нөхцөл болсон,

Гэр бүлийн институтын хүрэн дэх зөрчил, хямрал илэрч, энэ нь гэр бүл салалт, хүчирхийлэл гэх мэт үзэгдэл ихээхэн тархсанаас харагдах бөгөөд үүнд өрхийн эдийн засгийн уналт, амьдралын хэв маягийн өөрчлөлт, архидалт зэрэг суурь хүчин зүйлс нөлөөлөх болов,

Гэр бүлийн гишүүд удаан хугацаагаар тусгаар аж төрөх бие даасан үзэгдэл бий болсон,

Нийгмийн тодорхой хэсэгт хамтран амьдрах үзэгдэл бий болсон, ижил хүйстэн гэр бүл, гэрээт гэр бүл зэрэг гэрлэлтийн альтернатив хэлбэрүүд бодитой орших болсон,

Эх сурвалжууд: Мөнхбат О, Ц.Болд, Гэр бүлийн харилцааны уламжлал шинэчлэл, Социологи сэтгүүл УБ. 2001 он, Бүрэнжаргал Т. Гэр бүлийн социологи, УБ. 2005 он, Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, НХХЯ, ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн Хүн амын Сан, УБ 2010 он, Нийгмийн ажил сэтгүүл, Монгол гэр бүлийн хөгжлийн шинэ үе хандлага, 2010 он

<p><i>Шигтгээ.</i> <i>Гэр бүлийн эрхзүйн зохицуулалт: тулгарч буй сорилтууд судалгааны дүнд</i></p>	<p><i>Гэр бүл салгах тухай «Гэр бүлийн тухай» хуулийн 14 дүгээр зүйлийн 1,4 дүгээр заалтуудад дараах байдлаар өөрчлөлт оруулах шаардлагатай юм. Үүнд, албан бусаар салаад хэдэн жил болсон, гэр бүл салгуулахгүй байгаа шалтгаан, ямар зорилгоор тусдаа амьдарч байгаа (гэр бүлийн амьдралын төлөө хувийн ажлаар уу, эсвэл албан ажлын шаардлагаар тусдаа амьдарч байна уу), дахин гэрлэсэн (албан бус байдлаар өөр хүнтэй амьдарч байгаа) эсэхийг нь харгалзан гэрлэгсдийн нэг талын нэхэмжлэлийг үндэслэн гэр бүл салгах асуудлыг шийдвэрлэнэ гэж нэмэлт байдлаар тусгаж болох юм...</i></p> <p><i>Судалгаанд хамрагдсан гэр бүлээсээ салсан эмэгтэйчүүдийн хувьд өмнөх гэр бүлтэйгээ амьдрах хугацаандаа гэр бүлийн хүчирхийлэлд удаа дараа өртдөг байсан ч хүчирхийлэлтэй тэмцэх хууль, хүчирхийллээс ангид байх арга замууд, хэнд хандахаа ч мэдэхгүй байх нь элбэг байна...</i></p> <p><i>Хууль эрх зүйн мэдлэг тааруу, гэр бүлийн тухай хуульд заасан арга хэмжээ иргэдэд тэр бүр хүрдэггүйн улмаас гэр бүлийн хүчирхийлэлд дахин, дахин өртсөөр байх явдал их, эцэстээ гэр бүл салахад хүрдэг. Зарим талаар эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт хангалтгүй байгаагаар холбоотой юм. Тухайлбал, «Гэр бүлийн тухай» хуулийн 14.2-т «Шүцх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна» гэж заасан байдаг ч хэн гүйцэтгэх вэ гэдэг нь тодорхойгүй аж...</i></p> <p><i>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг хамгаалах байр гэнэ гэж тодорхойлсон байдаг. Гэтэл энэ хамгаалах байр нь тэр бүр байдаггүй. Байлаа гэхэд хөрөнгө мөнгөний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан шаардлага хангахуйц түвшинд, тогтмол ажилладаггүй...</i></p> <p><i>Мөн хуулийн 14.11-т «Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэн гэрлэлтээ Монгол Улсад захиргааны ба шүцхийн журмаар цуцлуулж болно» гэж заасан нь бодит байдалд нэлээд учир дутагдалтай, хөшигч заалт болсон. Гэр бүл салгуулахын тулд Монгол Улсад ирэхгүйгээр энэ асуудлыг шийдвэрлэх боломжуудыг хайх нь зүйтэй юм. Тухайлбал, олон улсын гэрээ конвенцэд нэгдэн орсон улсуудад амьдарч буй иргэдийн асуудлыг тухайн улсад нь шийдвэрлэх, гэрлэгчид тусдаа улсад амьдарч байгаа бол нэхэмжлэл гаргагчийн зүгээс итгэмжлэгч томилж гэр бүлээ салгуулах г.м тэрхүү зохистой гарцуудыг хайж энэ асуудлыг шийдвэрлэж болох юм...</i></p>
---	--



Шигтгээ.
Гэр бүлийн
эрхзүйн
зохицуулалт:
тулгарч буй
сорилтууд
судалгааны дүнд

Гэр бүл салалтын дараа хүчхдээ авч үлдсэн талын нийгмийн асуудлыг онцгойлон анхаарч санхүүгийн болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, хүчхдийн хүмүүжилд анхаарах, асран хамгаалагч болон хүчхдийн сэтгэл зүйн өөрчлөлтийг засах тал дээр илүү анхаарч сургууль анги тэнхмийн багш, баг хороо, сургуулийн нийгмийн ажилтны оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй гэр бүлийн аль нэг гишүүн нь байнгын хүчирхийлэл, заналхийлэлд өртсөний улмаас бусдад мэдэгдэхгүй байх тохиолдол элбэг байдаг тул «Гэр бүлийн тухай» хуулийн 14.4-т хөндлөнгийн этгээдийн (эцэг, эх, найз нөхөд, айл хөрш, энэ чиглэлийн цйл ажиллагаа явуулдаг байгууллага г.м) мэдүүлснээр гэр бүл цуцлах асуудлыг шийдвэрлэнэ гэсэн байдлаар тусгах нь тохиромжтой юм.

Хамтран амьдрах хэлбэр нь эрх зүйн хувьд бүрэн чадамжгүй. Учир нь «Гэр бүлийн тухай» хуульд хамтран амьдрах хэлбэр, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй. Харин «Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай» хуулийн 3 дугаар зүйлд «энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс нэгэн адил хамаарна» гэж заасан нь хамтран амьдрагчдын талаар зохицуулсан цорын ганц эх сурвалж хэмээн дүгнэсэн байдаг.

2002-2007 онд эцэг, эх нь гэрлэлтээ төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй байхад нь буюу хамтран амьдарч байх хугацаанд нь 22924 хүчхэд шинээр мэндэлсэн байна гэсэн нь хамтран амьдрах хэлбэр нэлээд түгээмэл байгааг харуулж байна. Тооцоо, судалгаа нь гэрлэлт батлуулахаас өмнөх амьдралын хугацаанд хүсээгүй жирэмслэх магадлал өндөр байж болохыг харуулж байгаа бөгөөд хүсээгүй жирэмслэлтээс үүдэн хүчхэд өнчрөх, цаашлаад нэгэнт төрсөн хүчхдэд тэтгэмж төлөхөөс зайлсхийх, тухайн хүчхэд шоовдорлогдох зэрэг социаль сөрөг асуудлууд гарч болзошгүй. Эдгээр асуудлыг зохицуулах үүднээс эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага урган гарч байгаа бөгөөд «Гэр бүлийн тухай» хуульд хамтран амьдрагчдын талаар тодорхой заалт оруулах шаардлагатай байна.

Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулсан хүчин төгөлдөр эрх зүйн баримт юм. Монгол улсын Иргэний хуульд заасанчлан гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчдийн эд хөрөнгийн асуудлыг зохицуулдаг бөгөөд гэрээнд эд хөрөнгийн бус харилцаа (хайр сэтгэл, итгэлцэл, бие биенээ халамжлах, үр хүчхэд г.м), аль нэг талын эрх ашгийг хөндсөн үйл тусгахыг хориглодог.

Шигтгээ. *Гэрээт гэр бүлийн хувьд гэрээ байгуулагч талууд цаашид хамтран амьдрах хүсэл зориггүй байж болох бөгөөд гол нь бие биешинхээ аль нэг хэрэгцээг хангах үүднээс эрх бүхий байгууллагад бүртгүүлэхгүйгээр гэрээ байгуулж амьдардгаараа онцлогтой. Энэ удаагийн судалгааны дүнгээс дээр харахад гэрээт гэр бүлийн хэлбэр тцгээмэл тархаагцй ч (1.6%) нэгэнт ццсэн бий болсон нь тодорхой байна.*

Гэр бүлийн эрхзүйн зохицуулалт: тулгарч буй сорилтууд судалгааны дүнд *Ижил хцйсэрхэх зан цйл буюу хцний бэлгийн чиг хандлага нь заяагдмал зцйл, хцн бэлгийн чиг хандлагаар ялгаварлагдах ёсгцй гэсэн сэтгэлгээг нийгэмд бцрдцлэх, ялгаварлан гадуурхалгцй эрццл нийгмийн орчин нөхцөлийг бцрдцлэхэд бодлогын арга хэмжээг чиглцлэх нь зцйтэй юм.*

Эх сурвалж: Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. НХХЯ, ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн Хүн амын Сан, Улаанбаатар 2010 он, 32



Хяналтын асуултууд:

1. Гэр бүлийн харилцаа гэж юу вэ? Гэр бүлийн харилцааны ёс суртахууны болон эрхзүйн талыг ялган тайлбарлана вэ?
2. Өрхийн тэргүүний асуудал хэрхэн тавигдаж байна вэ?
3. Монгол гэр бүлийн доторх засаглал, шийдвэр гаргах үйл явцад гишүүдийн оролцоо ямар байна вэ?
4. Гэр бүлийн эдийн засаг, өмчлөлийн харилцаа хэрхэн өөрчлөгдөж байна вэ?
5. Гэр бүлийн хүчирхийлэл, салалтын асуудал өнөөгийн хуульд хэрхэн туссан бэ?
6. Дан болон нийлмэл гэр бүлийн хэлбэрүүд дэх харилцааны ялгаа, онцлог хэрхэн бүрэлдэх вэ?
7. Уламжлалт монгол гэр бүлийн харилцааны гол онцлогуудыг хэлнэ үү?
8. Монгол гэр бүлийн харилцаанд эдүүгээжиж, орчин үежиж байгаа талуудыг дурдана уу?
9. Гэр бүлийн альтернатив хэлбэрүүдийг эрхзүйн үүднээс хэрхэн зохицуулах вэ?
10. Гэр бүлийн социологи ба гэр бүлийн эрхзүй хоорондын харьцаа, харилцан хамаарлын талаар ямар бодолтой байна вэ?



Мэтгэлцээнд санал болгож буй шийдлүүд:

1. Хамтран амьдрах хэлбэрийг хуулиар зохицуулах ёстой.
2. Ижил хүйстний гэр бүлийг хуулиар зөвшөөрөх ёстой.



Эх сурвалж:

1. Бүрэнжаргал Т, (2005), Гэр бүлийн социологи, УБ
2. Мөнхбат О, Ц.Болд. (2001), Гэр бүлийн харилцаан дахь уламжлал ба шинэчлэл: Социологи-1, сэтгүүл, УБ, МУИС-ийн Хэвлэл
3. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. (2010), НХХЯ, ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн Хүн амын Сан, УБ
4. Тунгалаг Ч. (2010), Гэрлэлт, гэр бүлийн харилцааны философи, ёс зүйн асуудлууд, Улаанбаатар
5. Намжил Т (2009), Монгол гэр бүлийн хөгжлийн шинэ үе хандлага, Нийгмийн ажил сэтгүүл, Чех Каритас, МУИС-ийн хэвлэл



Унших материал:

1. Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. (2010), НХХЯ, ШУА-ийн ФСЭХ, НҮБ-ийн Хүн амын Сан, УБ
2. Тунгалаг Ч. (2010), Гэрлэлт, гэр бүлийн харилцааны философи, ёс зүйн асуудлууд, Улаанбаатар
3. Намжил Т (2009), Монгол гэр бүлийн хөгжлийн шинэ үе хандлага, Нийгмийн ажил сэтгүүл, Чех Каритас, МУИС-ийн хэвлэл

Сэдэв- 3: Нийгмийн институтууд: Эдийн засгийн болон шашны институтууд (лекц-4 цаг)

Хичээлийн зорилго: Эдийн засгийн болон шашны институтууд, засаглал болон улс төрийн институтуудын бүтэц, бүрэлдэхүүн, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар суурь мэдлэг олгох, нийгэм дэх баялаг бүтээх, сүсэглэх үйлдэл, үйл ажиллагааг социологийн хандлагын үүднээс тайлбарлах аргазүйг эзэмшихэд энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Эдийн засгийн институтууд
- ❖ Эдийн засгийн тогтолцооны хэв маяг
- ❖ Хөдөлмөрийн хуваарь ба эдийн засгийн секторууд
- ❖ Ажил, хөдөлмөр, ажилгүйдэл
- ❖ Чөлөөт цаг ба ажлын цаг
- ❖ Албан бус эдийн засаг
- ❖ Шашины институтууд, шашны байгууллагууд
- ❖ Иргэнлэгжихүй
- ❖ Шашны үүрэг

Сэдвийн агуулга:

- ❖ Эдийн засгийн институтууд ба түүний мөн чанар
- ❖ Эдийн засгийн тогтолцооны хэв маягууд
- ❖ Ажил хөдөлмөр ба нийгмийн хөдөлмөрийн хуваарь
- ❖ Ажилгүйдлийн үндсэн төрлүүд
- ❖ Орчин үеийн нийгэм дэх эдийн засгийн секторууд, тэдгээрийн харьцаа, хөгжил
- ❖ Шашин институтууд болох нь
- ❖ Шашны бүлэг, байгууллага, төрөл хэлбэр
- ❖ Иргэнлэгжихүй ба түүнд нөлөөлөх хүчин зүйлс
- ❖ Шашны институтуудын үүрэг

• *Эдийн засгийн институтууд ба мөн чанар*

Маркс «хүний амьдралын анхдагч нөхцөл болсон оршихуйн хэрэгцээний талаар, хүмүүс түүхийг бүтээх чадвартай байхын тулд амьдрах бололцоотой байвал зохих тэр урьдчилсан нөхцөлийг тэмдэглэх хэрэгтэй юм. Гэтэл амьдрахад юуны өмнө хоол, унд, орон сууц, хувцас хунар зэрэг бас бус зүйлс хэрэгтэй байдаг» хэмээн хэлжээ. (К.Маркс, Ф.Энгельс.1982,20) Үнэн хэрэгтээ хүмүүсийн оршихуй үйлдвэрлэлийн тогтолцооноос л хамаардаг. Түүхийн хөгжлийн явц дахь нийгмийн бүдүүлэг хэв маягуудад ч материаллаг нөөцөө зайлшгүй хуваарилах, олборлохтой холбоотой холбогдох дэс дараалалт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж амьдардаг байжээ. Мэдээж орчин үеийн хөгжингүй нийгэмд энэхүү үйл ажиллагаа нь ихээхэн нарийн төвөгтэй тогтолцоог бүрдүүлсэн нь ойлгомжтой. Нийгэмд баялгийг үйлдвэрлэх (бүтээх), хуваарилах, хэрэглэх бүхий л үйл явц нь



цогцоороо эдийн засгийн амьдралын хүрээг тодорхойлдог. Эдийн засгийн институт нь социологич Р.Миллсийн хэлснээр «нийгэмд аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах институциональ эмх журмыг бүтээж байдаг» бол харин бүтэц үүргийнхний тухайлбал, Т.Парсонсын системийн онол ёсоор «нийгмийн гишүүдийн материаллаг дасан зохицохуйн хэрэгцээг хангадаг» билээ.

- *Ажил, хөдөлмөр ба хөдөлмөрийн хуваарь*

Өмнөх зүйлд дурдсанчлан хүмүүсийн оршихуй үйлдвэрлэлийн тогтолцооноос хамаардаг бол аль ч нийгэмд ажил нь бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх, хуваарилах байгууллагуудаас бүрэлдэх эдийн засаг буюу эдийн засгийн тогтолцооны суурь нь **ажил** болж байдаг. Хүний хэрэгцээг хангах баялаг, үйлчилгээг бүтээх зорилго бүхий оюуны болон биеийн хүчин зарцуулахтай холбогдсон зорилтуудыг шийдвэрлэхийн **ажил хэмээн тодорхойлж болох** юм. (А.Гидденс, 2005, 400) Ан агнуур, түүн цуглуулалт, мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр зэрэг нь цөмөөрөө амьдрал залгуулах хэрэгсэлд хүрэх янз бүрийн аргууд бөгөөд хүмүүсийн амьдралд тулгуур нөлөө үзүүлдэг. Орчин үеийн эдийн засгийн тогтолцооны тодорхойлогч нэгэн шинж нь нарийн төвөгтэй, олон талт **хөдөлмөрийн хуваарь** юм. Хөдөлмөрийн хуваарийн онцлог шинж чанар нь **нэгдүгээрт**, ажил нь маш олон янзын төрөлтэй болсон явдал юм. Өөрөөр хэлбэл нь ажил нь, тус бүрдээ хүмүүс тухайлан мэргэшсэн маш олон тооны янз бүрийн төрөлд хуваагдана. **Хоёрдугаарт**, хөдөлмөрийн буюу баялаг бүтээх нэг үйл явц нь эхнээсээ дуусах хүртлээ өөртөө олон төрлийн ажил, мэргэжлүүдийг багтаах болсон. Уламжлалт нийгэмд ажиллагч нь үйлдвэрлэлийн үйл явцын бүхий л шатанд оролцдог байсан байна. Харин өдгөө аж үйлдвэрийн газар ажиллаж байгаа цахилгаанчин тодорхой төрлийн машины зарим эд ангийг задалж сэлбэн тохинуулдаг бол үлдсэн ажлуудыг бусад ажиллагчид хийдэг. **Гуравдугаарт**, хөдөлмөрийн хуваарь нь нийгмийн гишүүдийн нийгэм болон эдийн засгийн хамаарлыг улам бүр нэмэгдүүлж, биенээсээ илүү ихээр хамааралтай болгож байна. Орчин үеийн ба уламжлалт нийгмийн хөдөлмөрийн хуваарийн ялгаа үнэхээр их байгааг судлаачид тогтоожээ.

Шигтгээ. Томоохон уламжлалт нийгэмд ч голчлон худалдаачин, санваартан, цэрэг мэтийн хэдхэн төрөлжсөн ажилтай хамт хорь гучаас илцэгүй бүрэн гар урлал оршиж байжээ. Орчин үеийн үйлдвэржилтийн тогтолцоонд олон мянган мэргэжил оршдог. Нэгдсэн вант улсын тооллогоор Британий эдийн засгийг бүрдүцлдэг 20000 орчим янз бүрийн төрлийн ажлыг бүртгэжээ. Уламжлалт нийгэмд хүн амын ихэнх нь (хөдөө аж ахуйд ажиллагчид) өөрсдийгөө хүнс, хувцас хунар, бусад зүйлсээр хангахуйцаар эдийн засгийн хувьд өөрийн хангамжийг бий болгодог. Үүний эсрэгээр орчин үеийн нийгмийн нэгэн гол шинж нь эдийн засгийн харилцан хамаарал бүхий байдал улам бүр өсөж байна. Бид хотлоороо маш олон хүнээс хамааралтай төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шаарддаг. Зарим зүйлийг тооцвол орчин үеийн нийгмийн хүмүүсийн зонхи олонх нь идэж буй хүнсээ үйлдвэрлэдэггүй, амьдарч буй барилгаа барьдаггүй, хэрэглэж буй материаллаг баялгаа бүтээдэггүй байна.

Эх сурвалж: А.Гидденс. 2005, 401

Эдийн засгийн тогтолцооны хэв маягууд

Корпоратив капитализм. Хувийн өмчтэй байх эрхийг хүлээн зөвшөөрч, түүнийг аж үйлдвэрлэлд капитал хэлбэрээр хөрөнгө оруулан тэрхүү хөрөнгө оруулалтаасаа ашиг олдог эдийн засгийн тогтолцоог капитализм гэж нэрлэдэг. Энэ тогтолцооны талынхан өрсөлдөх чадвар болон идэвхт чанарыг үнэлдэг. Аж үйлдвэрийн хувьсгал нь орчин үеийн капитализмын хөдөлгөгч хүч байлаа. Үйлдвэрлэгчид бол капитализмын хөгжлийн гол үйлчлэгч хүч мөн. Тэд капиталыг эзэмшиж өөрийн болон хүнийхийг өсгөж байдаг. Үйлдвэрлэлд оруулсан мөнгө эргэж зардлаа нөхөөд дээр нь ашиг олно. Аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд үүссэн капиталист тогтолцоо эхэн үедээ Засгийн газраас харьцангуй хараат биш байсан гэж үздэг. Үйлдвэрлэгчдийн энэ эрх чөлөөг францууд *laissez faire*- буюу өөрөөр нь хийлгэх, хувийн үзэмжээрээ үйлдэх бололцоо гэж ойлгодог байв. Капитализм нь төрөөс гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөхийг хянах, хувийн өмчийг хамгаалах зэрэг цөөн зүйлийг л шаарддаг. Эдийн засгийн энэхүү хэв маягийг илэрхийлдэг жишиг орон нь АНУ билээ.



Ардчилсан социализм. Ардчилсан орнууд дахь социалист эдийн засаг нь марксизм мэтийн тодорхой үзэл суртлыг баримталдаггүй бөгөөд тийм орны Засгийн газар ямар нэг тодорхой том томъёологдсон загварыг үндэс болгон авдаггүй. Чухамдаа ардчилсан социализм бол үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх нийгмийн өмч (янз бүрийн шаттай), таваарын хуваарилалтад үндэслэсэн улс төрийн янз бүрийн онолуудын нийлбэр цогц мөн. Эдгээрт нийгмийн өмчийн хязгаарлагдмал хэлбэрийг (жишээ нь, зөвхөн томоохон үйлдвэрүүдэд) зөвшөөрөхөөс эхлээд эдийн засгийн төлөвлөлт, удирдлагын бүх хүрээнд төрийн бүх талын хяналтыг тогтоох хүртэл үзэл бүхий олон янзын онолууд багтдаг. Ардчилсан социализм XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үеийн аж үйлдвэрийн хувьсгалын эсрэг социалист болон марксч хүчний эсэргүүцэлд тулгуурлан үүссэн бөгөөд харин энэ зууны сүүлээр зарим социалистууд болон Марксын хооронд нийгмийн шинэтгэлийн асуудлаар тухайлбал, шинэтгэлийг аажим хэрэгжүүлэх үү, эсвэл хүчирхийлэлд үндэслэсэн хувьсгалч аргаар уу гэсэн маргаан дэгдэж гүнзгий хагарал гарчээ. ЗХУ-д хүчирхийллийн хувьсгалыг уриалсан большевикууд засгийн эрхэнд гарсан бол Британид орчин үеийн лейборист намын улс төрийн бодлогын үндэс болсон шинэчлэгч үзэл давамгайлжээ. Европт социалист намууд олноор байгуулагдсан байна. Умард болон баруун европын орнуудад ардчилсан социализм хэлбэрээр хөгжив.

Коммунизм. Улс төрийн эрхэмнэлийн хувьд бүх өмчийг нийгэм эзэмшсэн эдийн засаг, улс төр, нийгмийн тогтолцоо юм. Коммунизмын онол бий болоход ангигүй нийгэм бий болгохыг уриалдаг Марксын бүтээлүүд их хэмжээгээр нөлөөлсөн. Дарлал мөлжлөгөөс бүрэн чөлөөтэй, хөдөлмөрчин хүмүүс амьдардаг, биеийн болон оюуны хөдөлмөрт ялгаа арилсан тийм нийгмийг Маркс төсөөлж байсан боловч энэ нь коммунист эдийн засгийн практикт (хуучнаар Зөвлөлтийн г.м) чөлөөт зах зээл биш харин улс төрийн нэг намын хуваарьгүй ноёрхол, хатуу хяналт, шалгалт, урт хугацааны нарийвчилсан төлөвлөгөө л байв. Капиталист орнуудад зарим үнийг засгийн газрын байгууллага зохицуулдаг бол харин коммунист тогтолцоонд бараг бүх үнэ тэднээс хамаарч, эрэлт нийлүүлэлтийн хууль эдийн засагт тун ялихгүй нөлөөтэй байдаг. Зөвлөлт засгийн газар урт хугацааны туршид эдийн засгийн өсөлтийг хангаж чадсан боловч энэ нь коммунист эдийн засгийн тогтолцоо капиталист юмуу, социалист тогтолцоо шиг үр ашигтай, бүтэмжтэй байсан хэрэг огтхон ч биш юм.

Эдийн засгийн секторууд

Үйлдвэржсэн эдийн засагт ажлыг анхдагч, хоёрдогч, гуравдагч гэсэн гурван секторт хуваадаг. Энэхүү гурван секторт ажиллагсдын харьцаа нь тухайн улс орны аж үйлдвэржилтийн түвшингээс хамаарах ба үйлдвэржилтийн янз бүрийн шатанд ялгаатай. Байгалийн нөөцийг олборлох, цуглуулах үйл ажиллагаа нь **анхдагч сектор**т хамаарах агаад энд хөдөө аж ахуй, олборлох болон ойн үйлдвэрлэл, загас агнуур зэргийг багтаадаг. Аж үйлдвэржилтийн эхний шатанд ажилчдын дийлэнх хэсэг нь анхдагч секторт ажиллаж байжээ. Машин ашиглалт нэмэгдэхийн хирээр үйлдвэрийн тоо нэмэгдэж, ажиллах хүчний ихэнх хэсэг нь хоёрдогч секторт шилжжээ. **Хоёрдогч сектор** нь түүхий эдийг үйлдвэрийн бүтээгдэхүүн болгодог буюу боловсруулах салбар билээ. Харин **гурав дахь сектор** нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бөгөөд материаллаг баялгийг шууд үйлдвэрлэхгүйгээр үйл ажиллагаа эрхэлж, бусад хүмүүст ямар нэг үйлчилгээ үзүүлдэг. Эдийн засгийн салбаруудыг ийнхүү дэс дугаарлан авч үзэх нь болхидуу зүйл ч гэлээ ингэж ялгаж үзснээрээ нийгмийн хэв маягуудыг тодорхойлоход ач тустай байдаг ажээ. Тухайлбал гуравдагч ертөнцийн орнуудад ажиллах хүчний дөрөвний гурав нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг байхад үйлдвэржсэн капиталист орнуудад хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дээр тун ялихгүй хэсэг нь ажилладаг. Аж үйлдвэржилтийн явцад одоогийн хөгжингүй капиталист орнуудын ажиллагч хүн ам нь хөдөө аж ахуйгаас боловсруулах салбарт, улмаар үйлчилгээний салбар луу урсан орсон байдаг.

Ажил ба хүнийсэл

Хөдөлмөр зохион байгуулалт болон технологийн янз бүрийн хэв маяг ажилтад хэрхэн нөлөөлдгийг социологичид их сонирхдог юм. Боломжит үр дагавруудын нэг бол дараах гурван элемент бүхий хүнийсэх үйл явц мөн. **Нэгдүгээрт**, тусламж авах боломжгүй байдлын мэдрэхүй. Ажилтан хүнд түүний хэрэглэж байгаа багаж хэрэгсэл хамаарахгүй, тэдэнд зайлшгүй шаардлагатай нөөц байхгүй, тэд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ худалдаж чадахгүй. **Хоёрдугаарт**, өөрийн ажлын учир утгагүйн мэдрэмж, эцсийн бүтээгдэхүүн гаргахад ажилчин хүн ганц л үйлдлээр хувь нэмрээ оруулах (жишээлбэл, автомашин цэвэрлэхэд цахилгаан дамжуулагчийг залгах) ба бусад ажилчинтай үндсэндээ холбоогүй байна. **Гуравдугаарт**, залхаж, зайлсхийх мэдрэхүй. Олон мэргэжилд зөвхөн албан үүргийнхээ дагуу хөдлөх, ажлынхаа явцад нөхөдтэйгөө хамт байх боломжгүй болж, ажилчин хүн бүтээх үйл явцаасаа сэтгэлийн таашаал авч бахархах явдал үгүй болдог байна. Хүнийсэх үйл явцын онцлогийг Блаунер хөдөлмөрийн нөхцөлтэй бус, харин хөдөлмөрийн янз бүрийн нөхцөлд бүрэлдэн бий болдог нийгмийн бүтэцтэй холбон авч үзсэн ба хүнийсэлд технологийн хөгжлийн түвшин, хөдөлмөрийн хуваарийн шинж, бюрократын онцлогийг чухал ач холбогдолтой гэж үзжээ. (Смелзер Н. 2001, 476) Орчин



үеийн аж үйлдвэрийн хөгжил олон төрлийн ажлыг сонирхолгүй, нэгэн төрлийн даалгавар болгож орхидог гэдгийг анхлан Маркс олж харсан юм. Марксынхаар капитализмын хөдөлмөрийн хуваарь ажилчныг ажлаас нь хүнийсгэдэг гэж үздэг. Уламжлалт нийгэмд ажил залхмаар байх нь цөөнгүй, тухайлбал тариачин ургах нарнаас бүрий хүртэл тариан талбай дээрээ борви бохис хийлгүй хөдөлмөрлөж талбайгаа боловсруулдаг гэдгийг Маркс хүлээн зөвшөөрч байсан. Гэвч тэд ихээхэн мэдлэг, чадвар, дадал шаарддаг ажлаа өөрсдөө зохион байгуулж чаддаг байжээ. Харин аж үйлдвэрийн ажилчид гүйцэтгэж буй ажлынхаа шинж чанарт огтхон ч нөлөөлж чаддаггүй, бүхэл бүтээгдэхүүнийг бэлтгэх явцад зөвхөн хувь нэмрээ л оруулдаг, эцсийн эцэст түүнийг хэнд худалдах вэ? гэдэгт ердөө ч нөлөөлж чаддаггүйгээрээ бүр ч эсрэг. Тийм болохоор цалин авахын тулд ажилчин хүний гүйцэтгэх даалгавар нь, ямар нэгэн зүйлээр хүнийсч түүнийг мөн чанартаа ажилчин ердөө ч сонирхдоггүй байна.

Шигтгээ. *Хөдөлмөрийн хүнийсэл юугаар нөхцөлддөг вэ? Нэгдүгээрт, ажилчинд хамаарах харилцаагаараа ажил гадны болдог, түүний мөн чанарын хэсэг болдоггүй, үүнээс болоод тэр нь ажлаар өөрийгөө хөгжцүлдэггүй, гэвч дорд мэдрэмжид автагдан өөрийгөө үгүйсгэнэ. Тэр ажлаасаа ханамж авахгүй, оюуны ба бие бялдарын хүчээ хөгжцүлэхгүй, харин ч биеийн хүчээр сульдаж, оюун санаагаар хоосорно. Үүнээс болоод ажилчид зөвхөн завтай цагтаа өөртөө ханамжтайгаа мэдэрч, ажил дээрээ бол тэр өөрөө сүг болсноо мэдэрнэ. Түүний ажил сайн дурынх бус, харин өөрийн эрх мэдэлгүй, албадлагын ажил юм. Тэр нь түүний суурь хэрэгцээг хангадаггүй, харин зөвхөн бусад хэрэгцээг хангах хэрэгсэл болдог. Ажлаас хүнийссэн шинж чанар нь биеийн болон бусад албадлага арга болмогц шууд илрэх бөгөөд түүнээс тахал мэт зугатдаг. Хүн (ажилчин) идэх, уух, үржих мэтийн адгуусны явдалдаа л чөлөөтэйгөө мэдэрдэг, түүнчлэн өөрийн орон сууцандаа байж, өөрийгөө гоёж гоодож байхдаа эрх чөлөөтэйгөө мэдэрдэг, үүний хамт тэр хүний явдалдаа адгуус хүртлээ доошилдог. Адгуус хүн болж, хүн адгуус болон хувирч байна.*

А.Гидденс. 2005, 404

Марксын хувьд хүнийсэл нь ажилдаа зөвхөн дайсагнасан юмуу цэвдэг байх, мэдрэмжтэй төдийгүй харин капитализмын нөхцөл дэх аж үйлдвэрлэлийн бүхий л бүтэцтэй холбоотой юм. Ажилчин хүн хөдөлмөрийнхөө нөхцөлд жинхэнэ утгаараа хяналт тавьж чадахаа больсныг илэрхийлдэг билээ. Орчин үеийн нийгэмд ч хөдөлмөрийн хүнийсэл объектив нөхцөлөөс гадна, субъектив байдаар ч оршоор байдаг гэдгийг судлаачид авч үзэх нь бий. Ажлын байдал нь «бие даах, өөрийгөө илэрхийлэх боломжгүй болгож, нэг талын залхуутай, нэгэн хэвийн, утга

учиргүй даалгавар болж ирдэг» бөгөөд «бүхий л түвшний албан тушаалын ажилтнуудад сэтгэл ханамжгүй сэтгэгдэл төрүүлдэг» талаар судалгааны үр дүнгүүд бий.

Ажилгүйдэл

Ажилгүйдэл нь ихэнхдээ эдийн засгийн судлагдахууны хувьд тайлбарлагдаж байдаг бол социологичдын анхаарал хандуулдаг нэгэн чухал сэдвийн нэг мөн билээ. Социологийн байр сууринаас ажилгүйдлийг тодорхойлох нь бүр ч нарийн зүйл болох нь харагддаг. Ерөнхийдөө аль нэг секторт ажил эрхэлдэг бол ажилтай, эрхэлдэггүй бол ажилгүй хүн гэх ухагдахуунд хамруулах хандлага байдаг нь учир дутагдалтай юм. Ажил, хөдөлмөр эрхлэх гэдэг ойлголт нь социологийн утгаар харах аваас **нэгдүгээрт**, эдийн засгийн агуулгаас халин гарах ба цалин, ашиг, рент гэх зэрэг эдийн засгийн сонгодог ойлголтоос гадуур хэрэгжих явдал буй. Тухайлбал, хүмүүс цалин ч үгүй, албан тушаал ч үгүй мөртлөө нийгмийн тусын тулд хөдөлмөрлөх явдал байдаг. **Хоёрдугаарт**, бодит ажил хийхгүй боловч цалин авч суудаг үзэгдэл ч бюрократ тогтолцоо өсөн тэлсэн газруудад байдаг. Түүнчлэн бодит баялаг бүтээгээгүй боловч, нийгмээс унац, өртөг хайх, олох явдал ч (rent seeking) байдаг. **Гуравдугаарт**, хүн ажил хөдөлмөр хийх нь нийгмийн оршихуй болсон хүний хувьд олон сэдлийг агуулж байдаг. Хүн хамт олонтой байхын тулд, эсвэл өөр газар дамжихын тулд аль нэг ажлыг эрхэлж байх нь ч бий. **Дөрөвдүгээрт**, хүн ажил хөдөлмөр эрхлэх нь байнгын тогтвортой байхаас гадна, хагас цагаар, түр зуурын, хавсран ажиллагч, чөлөөт ажил, мэргэжлийнхэн гээд олон хувилбарыг бий болгодог. **Тавдугаарт**, ажилгүйдлийн төрөл хэлбэрүүдээс бүтцийн, мөчлөгийн, түр зуурын гэх мэтийн талаар эдийн засгийн бүтээлүүдэд өргөн хэмжээгээр хэлэлцдэг. Харин социологичдын хувьд мэдээж эдгээр хэлбэрүүдийг судлахаас гадна зарим нэг төрлүүдийг сонирхож байх нь бий.



Социологичдын анхаарал хандуулдаг ажилгүйдлийн зарим хэлбэрүүд

Үнэ хүндийн ажилгүйдэл. Ажлын байр байсаар байтал тэдгээрт хүн амын тодорхой хэсэг очиж ажиллахгүй байх явдал.

Орон нутгийн ажилгүйдэл. Тодорхой орон нутгуудад ажилгүйдлийн түвшин өндөр байх явдал ба үйлдвэрлэлийн хөгжил, соёл, болон бусад хүчин зүйлээс хамаардаг.

Хүн амзүйн ажилгүйдэл. Хүн амын өсөлт, төрөлт, хөдөлмөрийн насны хүн амын бүтцэд гарсан өөрчлөлтөөр нөхцөлдөн үүсэх ажилгүйдэл.

Нуугдмал ажилгүйдэл. Нэг данс бүртгэлээс гадуур гол төлөв засаг захиргаа завсардан, нэг орон нутгаас нөгөөд шилжин явагчид, хоёрт, нэг ажлын байрнаас нөгөөд шилжин явагчид, гуравт, ажлын байртай мөртөө зүгээр суугчид гэх мэт бүлгүүдэд хуваагддаг ажилгүйдлийн хэлбэр мөн.

Эх сурвалж: Гүндсамбуу Х.Ажилгүйдэл, асуудал, шийдэл, 1991, 28-30

Шашин институтц болох нь

Шашныг тодорхой системчлэгдсэн ертөнцийг үзэх үзэл, үзэл суртал, юм уу эсвэл тогтоосон хэм хэмжээ, зан үйл, нарийн дэг горим бүхий ёслол хүндэтгэлийн шинжтэй шүтлэгийн үйлдлийн цогц болох талаас нь судалж байх нь бий. Түүнээс гадна тусгай зохион байгуулалт, зэрэг дэвийн шатлал бүхий сүм хийд болон бусад сүсэг бишрэлийн байгууллагуудаас тогтох нийгмийн байгууллага болох талаас нь социологийн шинжлэх ухаан судалдаг билээ. Нийгмийн тогтвортой, суурь хэрэгцээг хангасаар ирсэн тийм багууллагуудын тогтолцоо өнөө бидний энэ үед ч оршсоор байна.

Шашны бцлэг, байгууллагууд

Бүхий л шашинд өөрийн сүсэгтнүүдийн бүл байх ба тэдний зохион байгуулагдах арга олон янз байдаг байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс сүсэг бишрэлийн үйлдэл, үйл ажиллагаагаа эрхлэн явуулахын тулд өөр хоорондоо нэгдэн тогтвортой орших хэрэгцээ гарах ба энэхүү хэрэгцээг нь шашны байгууллагууд гүйцэлдүүлдэг билээ. Шашны байгууллагуудыг ангилгах нэг хандлагыг Вебер болон түүний хамтрагч Эрнест Трельч нар дэвшүүлсэн байна. (А.Гидденс, 2006, 381) **Сүм хийд** бол шашны байгууллагын нийтээр зөвшөөрөгдсөн, сайтар бэхжсэн, илүү зохион байгуулагдсан, хэмжээний хувьд томоохон хэлбэр болно. Сүм хийдүүд нь ерөнхийдөө мяндаг тушаалтнуудын шатлал бүхий албан ёсоор хэлбэржсэн түшмэл ёсны бүтэцтэй байх бөгөөд нэг институтцийн хүрээнд нэгдэн үйл

ажиллагаа явуулдаг болохоор шашны консерватив хэсгийнхний ашиг сонирхлыг төлөөлөх хандлагатай байх нь олонтаа. Харин **бүлэглэл** буюу **сект** нь шашны байгууллагын хоёр дахь нийтлэг хэлбэр бөгөөд хэмжээний хувьд арай багавтар байх аж. Сект болохоор энд дурдсанчлан харьцангуй жижиг байхын зэрэгцээгээр албан ёсны сүм хийдийг эсэргүүцэн өөрсдийн сүсэгтнүүдийн бүлийг бий болгон тэдний хүрээнд үйл ажиллагаа явуулж байдаг. Тэд өөрсдийн «үнэн зам мөрийг» олж түүнийгээ баримтлахыг хичээх ба гишүүд нь сүм хийдийнхнийг худалдагдсан гэж үздэг байна. Тэдний дунд шашны алба үүрэгтэн бараг байхгүй бөгөөд гишүүдээ тэгш гэж үздэг. Вебер, Трельч, нарын шашны байгууллагын судалгааг цааш хөгжүүлсэн хүн Ховард Бекэр бөгөөд тэрээр дээрхээс гадна **деноминаци** болон культ гэсэн хоёр хэлбэрийг тодорхойлсон байна. Деноминаци нь аядаж намжсан сект бөгөөд идэвхтэй сөргөлдөгч хүч байхаа нэгэнт больж, нэлээд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгууллага билээ. Сектүүд нэлээд удаан хугацаагаар бүхэллэг байдлаа хадгалж үлдэж чадах аваас деноминаци хэлбэрт шилжин ордог. Сүм хийдээс их бага хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн деноминациуд нь сүм хийдтэй зэрэгцэн оршиж үйл ажиллагаа явуулж байдаг. Эцэст нь **культ** хэмээх хэлбэр байх ба секттэй төстэй боловч, өөрийн гэсэн онцлогтой бөгөөд бусад хэлбэрүүдээ бодвол илүү чөлөөтэй, хувьсамтгай, шилжимтгий зүйл болно. Культ нь сектийн нэгэн адил хүчтэй хошуучлагч, идэвхжүүлэгчийг тойрон хүрээлдэг байна. Нэгэн ижил сэтгэлгээтэй хүмүүс энэхүү байгууллагад нэгдэн ороход хувийн туршлага ихээхэн чухал байх ба гишүүдээ шашны өөр байгууллагад хамрагдах, алба үүргээр холбогдохыг үл хориглоно. Барууны нийгмүүдэд бясалгал, зурхай, сүнслэг үзэл (спиритизм) гэх мэт культийн хэлбэрүүд байдаг.

Шашны байгууллагын хэлбэрцүд ба тэдгээрийн шинж чанар

	Сүм хийд	Деноминаци	Сект	Культ
Хэмжээ	Үлэмж том	Том	Жижиг	Жижиг
Баялаг	Өргөн цартай	Өргөн цартай	Хязгаарлагдмал	Хувьсамтгай
Шашны үйлчилгээ	Албан ёсны, бага оролцоотой	Албан ёсны, бага оролцоотой	Албан бус, сэтгэл хөдлөлийн	Хувьсамтгай
Сургаал	Өвөрмөц, гэвч тайлбарлал нь хүлцэмтгий байж чадна	Өвөрмөц, гэвч тайлбарлал нь хүлцэмтгий байж чадна	Өвөрмөц, сургаалийн цэвэр ариун байдлыг онцлоно	Шинэчлэгч хийгээд урсгалыг эвдэгч
Санваартан	Сайн сургагдсан, бүтэн цагаар	Сайн сургагдсан, бүтэн цагаар	Зарим түвшинд сургагдсан	Тусгайлан бэлтгэгдээгүй



Гишүүнчлэл	Нийгмийн гишүүдийн ахуйн буянт үйлээр	Сургаалийг зөвшөөрснөөр	Сургаалийн зөвшөөрснөөр	Сэтгэл хөдлөл бүхий үүрэг, амлалтаар
Төртэй харилцах	Хүлээн зөвшөөрөх, эгнэн зэрэгцэх	Хүлцсэн	Сайшаан дэмжихгүй	Үл тоох

Эх сурвалж: Шифр, 1995, 406

Иргэнлэгжихүй

Судлаачдын дунд орчин үеийн нийгмийн хөгжилтэй холбоотойгоор шашин ноцтой уналтад орж байна гэлцээд, үүнийхээ баталгаа болгон ажиглагчдын нүдэнд өртсөнөөр шашин хоцрогдсон итгэл үнэмшил хийгээд заншлын салбар луу шахагдах болсон хэмээн тэмдэглэх нь бий. Гэвч өнөөгийн дэлхий дахины улс үндэстнүүдэд хүн амын дийлэнх нь өөр өөрсдийн шашны итгэл үнэмшлээ аль нэг түвшинд хадгалсаар байгаа нь дамжиггүй юм. Британичуудын 80 хувь нь ямар нэг тэнгэр бурхан оршин байдагт итгэдэг бол Америкийн сүсэг бишрэл бүхий хүний тоо бусад аж үйлдвэржсэн орнуудынхаас өндөр бөгөөд тэдний 94 хувь нь тэнгэр бурханд, харин 71 хувь нь хойд насны амьдралд итгэдэг байна. Бидний мэдэх өндөр хөгжсөн барууны эдгээр оронд байдал ийм атал барууны судлаачид иргэнлэгжихүй хэмээх ойлголтод ач холбогдол өгч, түүний доор юуны талаар ярих болов. Хүмүүс ямар нэг хэмжээгээр шашинд тал өгөхийг сүсэглэхүй хэмээн үздэг бол харин эсрэгээр тэд амьдрал ахуйдаа шашинлаг бус үзэл хандлагыг бий болгохыг, өөрөөр хэлбэл хүмүүсийн амьдралд шашинлаг бус амьдралын хэв маяг бий болж ирэхийг иргэнлэгжихүй хэмээн үздэг бололтой. Үүнийг социологич Шифр «нийгмийн бусад институтэд үзүүлэх шашны нөлөөг үгүйсгэх байдлыг буюу эл нөлөө буурах үзэгдлийг **иргэнлэгжих** (secularization) хэмээн» тодорхойлсон байна. (Шифр, 1995, 407) Мэдээж хэрэг шашин түүхийн тодорхой үе шатуудад нийгмийн бусад институтэд үлэмж нөлөөтэй байсаар ирсэн бөгөөд тухайлбал, европт дундад зуунд нийгмийн бүх хүрээнд сүм хийд ноёрхлоо тогтоосон гэж үздэг. Харин энэ үеэс хойш сэргэн мандал, соён гэгээрэл, аж үйлдвэрийн болон ардчилсан хувьсгал, шинжлэх ухааны боловсролын тэлэлт гээд томоохон үйл явдлуудаас эхлэн иргэнлэгжих үйл явцын үр хөврөлүүд барууны нийгэмд тавигдах болсон ажээ. Иргэнлэгжихүйд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаарх Британий болон Америкийн социологичдын дүгнэлтийг товч авч үзье.

Иргэнлэгжилтэд юу нөлөөлсөн бэ?

Смелзер орчин үеийн нийгэм дэх иргэнлэгжих үйл явцын хүчин зүйлд **шинжлэх ухааны хөгжлийг** юуны өмнө авч үзсэн байна. Түүнийхээр шинжлэх ухааны итгэл үнэмшил нь анхнаасаа шашны итгэл үнэмшилд

харш зүйлүүд байсан бөгөөд түүхэн зөрчил, тэмцлүүдийг жишээлсэн байна. Шинжлэх ухааны технологи бидний амьдралд ноёрхох болсноор бидний үнэн зөвийг нь гэрчилж боломгүй үзэл санаанд итгэх хүсэл сэтгэгдэл утга учраа улам бүр алдах болсон аж. Мөн тэрээр иргэнлэгжилтийг **төрийн хөгжилтэй** холбоотой авч үздэг билээ. Төр шашны тусгаарлалтын талаар доор өгүүлэх болно. Смелзер цаашлаад **капитализмын хөгжил** иргэнлэгжилтэд нөлөөлсөн гээд ийм нийгмийн тогтоц нь хөрөнгө зорь хуримтлуулах, баян тансаг амьдралд тэмүүлэх хүсэл өөд хүмүүсийг чиглүүлдгээрээ шашны институцийн хүсэл санааны эсрэг аж. Дөрөвдүгээрт, **шашны мөргөлдөөнийг зохицуулах туршлага** нь иргэнжилтэд хүргэж байгаа чухал хүчин зүйл мөн. Тухайлбал, аль нэг шашны ноёрхлыг халах, шашны мөргөлдөөнд хүргэхээс сэргийлэх, олон шашин зэрэгцэн орших боломжийг бүрдүүлэх, хүний эрхийг хангах үүднээс нийтийн боловсролын сургалтын хөтөлбөрт аль нэг шашны номлолыг оруулахгүй байх гэх мэт туршлага бий болжээ. (Смелзер Н, 2001, 453-454) А.Гидденс харин энэ асуудалд социологичийн байр сууринаас өвөрмөцөөр ханджээ. Тэрээр юуны **өмнө сүм хийд, шашны байгууллагын гишүүнчлэлтэй** холбон үзсэн байна. Түүний дүгнэснээр шашны байгууллагын үйл ажилагаанд хүмүүс хэр зэрэг хамрагдаж, ямар давтамжтайгаар зочилж байгаагаас нь үзэхэд Америкийг эс тооцвол иргэнлэгжих үйл явц барууны орнуудад нэгэнт илэрхий болсон гэнэ. Тэрээр иргэнлэгжилтийн асуудал нь итгэл үнэмшлээр тайлбарлагдана гээд сүмд заавал зочлох, нийтийг хамарсан үйл ажиллагаанд хамрагдах нь иргэдийн шашны сүсэг бишрэл, чин эрмэлзлийг дагаж мөрддөг эсэхийг тодорхойлох албагүй байна. Юутай ч шашинд сүсэг буурах хандлага нийтлэг тохиолдох болсон ажээ.

Европын үнэт зүйлсийн судалгааны хүрээнд улс орнуудын соёлын ялгааг тодорхойлох зорилгоор судлаачид иргэнжилтийн асуудлыг хөндсөн асуултуудыг олон нийтийн санал бодлыг судлах ажлынхаа хүрээнд байнга хөндөж байх нь бий.

Европ дахь шашинжилт ба иргэнлэгжилт (Сүмд очих давтамж)

Улс	Сард нэг болон түүнээс дээш	Сард нэг удаа явах нь ховор тохиолдоно.	Огт үгүй
Европын холбоо 15			
Ирланд	74.6	17.6	7.7
Итали	53.6	32.5	13.9
Португал	53.2	31.0	15.8
Австри	42.9	40.6	16.5
Испани	36.0	32.5	31.5
Грек	33.6	61.7	4.6
Финлянд	12.5	59.4	28.2
Дани	11.9	45.4	42.7
Баруун Герман	34.7	41.5	23.7
Люксембург	30.4	36.3	33.3



Улс	Сард нэг болон түүнээс дээш	Сард нэг удаа явах нь ховор тохиолдоно.	Огт үгүй
Франц	12.3	27.2	60.4
Зүүн Герман	13.4	29.4	57.2
Их Британи	18.7	26.2	55.1
Нидерланд	25.1	26.9	48.1
Белги	27.8	25.9	46.3
Швед	9.1	45.2	45.7
I гишүүнчлэл			
Малта	87.2	8.9	3.9
Польш	78.1	16.0	5.9
Словак	49.8	27.1	23.1
Литва (Litauen)	28.9	53.5	17.5
Эстони	10.8	50.9	38.3
Латви (Lettland)	15.1	50.4	34.6
Слав	30.7	39.2	30.1
Чех	12.7	31.1	56.1
Унгар	17.9	38.1	44.0
II гишүүнчлэл			
Румын	46.4	46.1	7.5
Болгар	21.9	52.3	25.8

Эх сурвалж: Jurgen Gerhards. Unter Mitarbeit von Michael Hoelscher. Kulturelle Unterschiede in der Europaeischen Union. 2., durchgesehene Auflage. 2005, VS Verlag fuer Sozialwissenschaften, Seite-68

Төрөөс шашинтай харилцах асуудал

Шашны байгууллагын хэв маягуудын талаарх социологич Шифрийн хүснэгтэд шашнаас төртэй харилцах талаар үзүүлсэн билээ. Харин энд төрөөс шашинд хандах талаар бага зэрэг хөндөх болно. Орчин үеийн нийгмийн бусад инситуцүүд шашнаас тусгаарлагдах болсныг дээр авч үзсэнчлэн иргэнлэгжилтийн нэг илрэл нь төр шашны тусгаарлал билээ. Смелзерийн хэлснээр орчин үеийн төрүүд өдгөө шашнаас нэгэнт тусгаар зүйлс болсон ба иргэдийнхээ оюун санааг бүтээхэд анхаарал тавихаасаа илүү биет хэрэгцээг нь бүтээхэд чиглэж ажилладаг гэнэ. Төр нь орчин үеийн нийгэмд иргэддээ оюун санааны хайр халамж үзүүлэх бус түүний оронд тэдний бодит амьдралын нөхцөлд анхаарах болсон гэсэн үг. Төрөөс шашинтай харилцах чиглэлд аль нэг шашныг тусгайлан төрийн статустай болгохоос эхлээд төрийн бодлогод шашны үзэл санааг нийгмийн харилцаанд хадгалж үлдэх зорилго бүхий зрхицуулалтыг хийх асуудлыг ч багтаадаг. Мэдээж өнөөгийн ардчилсан ертөнцөд төрөөс аль нэг шашинд тусгайлсан статус олгох нь боломжгүй зүйл бөгөөд харин тийм дэглэм бүхий улс орнуудын төрийн бодлого нь ноёлох шашныхаа үзэл санааг агуулж байгаа нь дамжиггүй юм. Гэхдээ өдгөө төр шашин хоёр нь хамгийн

нягт хамааралтай улс орнуудад ч тусгаарлагдах болсон бөгөөд тухайлбал, католик шашинтан европын орнуудад Ирландаас бусад нь, тухайлбал уг шашны гүнзгий нөлөө бүхий Франц, Италид ч эмэгтэйчүүд үр хөндүүлэх эрхээр бүрнээ хангагдсан байдгийг бид гэр бүлийн институцийн жишээгээр үзсэн билээ.

Шигтгээ. *Шашны талаар төрөөс баримтлах бодлого нь Монгол улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлалаас урган гарсан байх ёстой. Монгол соёл иргэншлийн хувь заяа өрнөдийн соёл иргэншилд хандах хандлагаас ихээхэн шалтгаалах нь тодорхой юм. Бидэнд гурван зам буй. Эхнийх нь өрнөдийн шашныг хаах явдал. Гэвч мухардмал зам. Хоёр дахь нь баруунтай нэгдэн нийлж, ёс заншил, шашны суртахууныг нь хүлээн авах буюу нээлттэй зам. Өнөөдөр цйл явц улам бүр баруунжих хандлагатай байгаа боловч, үндэсний өв соёл, түүхэн уламжлал үүнээс өөр байхыг шаардаж байна. Үүнээс улбаалан гуравдах замыг сонгох шаардлагатай байна. Энэ бол барууны соёлтой эн зэрэгцэн соёлоо хадгалж үлдэх зам юм. Өрнөдөөс авна, өрнөдөөс суралцана, гэвч баруунжихгүй гэсэн үг. Төрөөс Монголын уламжлалт шашинтай хийгээд түүний байгууллагатай хэрхэн харилцах вэ? гэдэг нь зүй ёсоор урган гарч ирдэг асуудал юм.*

Энэ талаар олон нийтийн дунд эсрэг тэсрэг саналууд бий. Үүний нэг илрэл нь «Монгол улсын Үндсэн хууль» болон «Монгол улсын төр ба сүм хийдийн харилцааны тухай» хуулийг хэлэлцэн баталж байх нэлээд хүчтэй тавигдаж байсан бурхны шашныг төрийн шашин болгох буюу төрөөс давуу эрх олгох тухай асуудал болно. Шашин шүтлэг аливаа улс орны түүх соёл, зан заншилд нэвчин шингэж, түүний салшгүй хэсэг нь болж байдаг талаас нь авч үзвэл бид уламжлалт бурхны шашиндаа илүү хүндэтгэлтэй хандах учиртай. Гэвч өнөөгийн манай нөхцөлд төрийн шашинтай байх нь шашны асуудлыг улам бүр хүндрүүлэх юм. 1/ Бидний сонгосон зам нэгэнт олон шашин орж ирэх, зэрэгцэн байх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тул аль нэгийг нь онцлон үзэх эрхзүйн үндэс байхгүй, 2/ Монголын бурхны шашны тэргүүн Богд Жавзандамбыг тодруулах, түүний эрх мэдэл болон статусын асуудал тавигдана.



Шигтгээ. *Үүнийг дэмжих, эс дэмжих нийгмийн бүлгүүд буйн дээр Богд болон төрийн тэргүүн, түүнчлэн бусад шашны тэргүүн хоорондын харилцаанд байр суурь, ашиг сонирхол, үзлийн ялгаа гарч, даамжрахгүй гэх баталгаагүй, 3/ Төрийн шашны байгууллагууд бусад шашны байгууллагаас давуу эрх эдлэхтэй холбоотой үүсэх асуудлууд нь олон үр дагаварт хүргэнэ, 4/ Төрийн шашны хувьд тэр шашны байгууллага нь төрийн зарц байх ёстой, тиймээс төр өөрийн ашиг сонирхлыг тулган хүлээлгэх, буруу ч бай өөрийн бодлого шийдвэрийг шашнаар дэмжүүлэх болно, 5/ төр өөрийгөө хамгаалуулах, өөртөө үйлчлүүлэхийн тулд сүм хийдийг бүх талаар тэтгэх хэрэгтэй болно. Бусад шашныг бодвол төрийн эрх ямба, хангамжийг эдлэх болно. Ингэснээр нийгэмд нэгэн онцгой давхраа бүрэлдэнэ, энэ давхрааны ашиг сонирхол нь бусадтайгаа зөрчилдөхгүй гэх баталгаа үгүй, 6/ Шашны байгууллагаар дамжин улс төрийн ашиг сонирхлын өрсөлдөөн бий болох талтай. Энэ нь хүн амын сүсэгтэй болон шүтлэггүй хэсгийн болоод өөр шүтлэгтнүүдийн хоорондын харилцаанд ямар нэг хэмжээгээр нөлөөлнө, 7/ Шашин нь төрөөс ивээл дэмжлэг авсныхаа оронд төрийг ямар ч халдлагаас хамгаалах чадвартай байх ёстой.*

Эх сурвалж: Цэдэндамба С, Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг), УБ 2004 он, 134-135

Шашны институцийн чиг үүргүүд

Америкийн социологич, бүтэц чиг үүргийн онолын төлөөлөгч Т.Диа «Шашны социологи» бүтээлдээ шашны институцийн нийгмийн чиг үүргийг тоочин тайлбарласан байдаг. Тэдгээр нь нэгдүгээрт, зовлон зүдгүүр амсаж, амьдралын бэрхшээлтэй учирч байгаа хүмүүсийг тайвшруулан дэмжиж, гайтгаруулах, хоёрдугаарт, ид шид ба хүн хоёрын хооронд холбоо тогтоох, зуучлах ариун гэгээнтний, гуравдугаарт, нийгмийн тодорхой тогтолцооны үнэт зүйлс, хэм хэмжээг бататган ариутгах, тэдгээрийг зөрчихөөс хамгаалан бэхжүүлэх буюу нийгмийн хяналтын, дөрөвдүгээрт, шашны үзэл санааг нийгмийн бодит дэг журамтай жишиж үзээд түүнд өөрийн үзэл санаа, номлолын зүгээс шүүмжлэлтэй хандах, тавдугаарт, шашны бүлгийн шүтлэгтэй гишүүдийн ухамсарт илрэх адилтган тэнцүүлэх үүрэг, зургаадугаарт, ямар нэг хувь хүний хөгжлийн өсөлтөд шашны зүгээс нөлөөлөл үзүүлэхтэй холбоотой үүрэг гэгээрүүлэх зэрэг болно.

Нийгмийн чиг үүргүүд	Сэтгэгч, эрдэмтэд
Ертөнцийг үзэх үзлийн буюу үзэл суртал, ёс зүйн үүрэг	О.Конт, К.Маркс, М.Вебер
Шашин бол аливаа нийгэмд, нийгэм хамт олныг нэгтгэгч, эв нэгдлийг хангагч үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, хамтын ухамсрын буюу хамтын шүтлэгийн үйлдлийн хэлбэрийн үр дүнд нийгмийг нягтруулдаг.	Э.Дюркхайм
Шашин нийгмийн харилцаа, хүмүүсийн зан байдлыг хянан зохицуулагч болох ба нийгэм хамт олны харилцаанд дагаж мөрдвөл зохих хэм хэмжээ, дүрэм журам, заавар, хорио цээрийг тогтоож байдаг.	О.Диа, Т.Парсонс, З.Фрейд
Шашин хүмүүсийн хоорондын харилцааны үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээр хүмүүс тогтвортой харилцаанд орж нийгмийн институтийг бүрдүүлдэг.	Т.Парсонс, П.Бергер
Шашин хүний сэтгэл санааг нөхөн тайтгаруулах, тайвшруулах үүрэгтэй. Энэ үүрэг нь ихэнхдээ хуурмаг тайвшруулалт, сэтгэл засалт, өөрийгөө албадан үнэмшүүлэх шинжтэй, гэхдээ тухайн тохиолдолд зайлшгүй хэрэгтэй гэж үздэг.	К.Маркс, З.Фрейд
Хүн бол ирээдүйд хандах, маргаашдаа тэмүүлэх тэмүүлэл бүхий амьтан бөгөөд ингэхдээ итгэл найдвар, айдас түгшүүрийн аль алинаар нь ханддаг. Ирээдүй ямар байхыг шашин тайлбарлахыг эрмэлздэг.	О.Диа
Шашин соёлын үзэгдэл, түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохынхоо хувьд соёлыг үеэс үед уламжлан дамжуулах үүргийг гүйцэтгэдэг.	П.Сорокин, Б.Малиновский

Эх сурвалж: Цэдэндамба С, Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг), УБ 2004 он, 39



Хяналтын асуултууд:

1. Эдийн засгийн тогтолцооны хэв маягууд, тэдгээрийн мөн чанар юу вэ?
2. Нийгмийн хөдөлмөрийн хуваарийн хөгжил нийгмийн харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ ?
3. Орчин үеийн нийгэм дэх эдийн засгийн секторууд ба тэдгээрийн ялгааг заана уу?
4. Ажилгүйдлийн үндсэн хэлбэрүүд хийгээд тэдгээрийн шалтгааныг хэлнэ үү?
5. Шашны байгууллагуудын хэв маягуудыг авч үзэн, тэдгээрийн хоорондын ялгааг тайлбарлана уу?
6. Иргэнлэгжихүй гэж юу вэ? түүнд нөлөөлөх хүчин зүйлс юу вэ?
7. Шашны институцийн нийгэмд гүйцэтгэх чухал үүргүүдийг тайлбарлана уу?



Эх сурвалж:

1. Смелзер Н (2002), Социологи, УБ
2. Гидденс А, (2006), Социологи, УБ Адмон
3. К. Маркс, Ф.Энгельс. (1982), Түүвэр зохиол. I боть, УБ
4. Richard T.Shaefer, Robert P.Lamm, (1995), Sociology, Chicago Press
5. Осипов Г.В, (2002), Социология: Основы общей теории, Москва, Издательство
6. Кравченко, Добрьенков, (2002), Социальные институты ин процессы: Социология, 3 том
7. Гүндсамбуу Х, (1991), Ажилгүйдэл, асуудал, шийдэл
8. Цэдэндамба С, (2004), Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг)
9. Jurgen Gerhards. (2005), Unter Mitarbeit von Michael Hoelscher. Kulturelle Unterschiede in der Europaeischen Union. 2., durchgesehene Auflage, VS Verlag fuer Sozialwissenschaften



Унших материал:

1. Смелзер Н (2002), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ Адмон
3. Цэдэндамба С, (2004), Монгол улс дахь шашны нөхцөл байдал, УБ (XX-XXI зууны зааг)

Сэдэв- 4: Нийгмийн институтууд: Засаглал ба улс төрийн институт (лекц-4 цаг)

Хичээлийн зорилго: Засаглал болон улс төрийн институтийн бүтэц, бүрэлдэхүүн, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар суурь мэдлэг олгох, нийгэм дэх засаглалын үйл ажиллагааг социологийн хандлагын үүднээс тайлбарлах аргазүйг эзэмшихэд энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Засаглал
- ❖ Төрийн иснтитуц,
- ❖ Төрийн хэлбэрүүд
- ❖ Улс төрийн нам
- ❖ Улс төр нам
- ❖ Улс төрийн социаль үндэс
- ❖ Сонгууль
- ❖ Улс төрийн оролцоо

Сэдвийн агуулга:

- ❖ Засаглал улс төрийн үндэс хийгээд социаль үзэгдэл болох нь
- ❖ Төр нийгмийн институт болох нь
- ❖ Төрийн институтийн нийгэмд гүйцэтгэх үүрэг
- ❖ Улс төрийн намын социаль бааз суурь
- ❖ Сонгуулийн оролцоо ба абсентейзм


Эрх мэдэл улс төрийн засаглалын үндэс болох нь

Эрх мэдэл (power) бол улс төрийн засагалын үндэс хэмээн хэлж болох юм. Социологийн сонгодог төлөөлөгч Вебер эрх мэдэл бол «тухайлсан нийгмийн нөхцөл байдалд хэн нэгэн тоглогч жинхэнэ өөрийн хүсэл зоригийг хэрэгжүүлэх боломж» гэсэн бол бүтэц үүргийн онолын эцэг Т.Парсонс «дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд нөөцийг дайчлах нийгмийн чадвар» хэмээн тодорхойлжээ. Социологич Смелзер «эрх мэдлийн тухай тодорхойлолт нь ямар нэг хэмжээгээр тодорхой биш үлдэж байдаг. Энэ нь хэн нэгэнтэй харилцахад хүч хэрэглэх утгыг илэрхийлж болно; тэрчлэн нэг хүний болон бүлгийн бусдыг ноёрхох байдлыг хэлж болно; бид эрх мэдлийг өөрийн хүсэл зоригийг үүрэг болгон хүлээлгэх чадвар болохынх нь хувьд, нийгмийн нөөцийг дайчлах шид болохынх нь хувьд ч нэгэн зэрэг авч үзэж болно» хэмээн түүнд агуулагддаг утга санаануудыг тэмдэглэсэн байна. Эрх мэдэл нь зөвхөн улс төрийн гэлтгүй нийгмийн амьдралын бүхий л хүрээнд тархсан байдаг үзэгдэл юм. Харилцан үйлдэлд орж буй нэг тал нь шийдвэр гарган нөгөө талаар хэрэгжүүлэх чадамж бөгөөд энэ тодорхойлолтыг давын өмнө улс төрийн харилцааны хувьд авч үзэх боломжтой. Мэдээж хэрэг энд аль нэг нь (давын өмнө улс төрийн хувьд) нөгөөгөө засаглах учиртай. Засаглагч хүч болох эрх мэдэлтэй холбоотой **хүч** (force) хэмээх ойлголт



логик байдлаар урган гарч ирдэг. Социологич Смелзерийн тэмдэглэснээр хүч бол засаглал оршин байх нэг үндэс боловч засаглалаас явцуу утгатай зүйл болох ба учир нь засалал болгон хүч хэрэглэх албагүй ажээ. Тэгэхээр хүч хэрэглэхгүй засаглагч эрх мэдэл оршин байх бололцоотой бөгөөд түүний цааш нь бичсэнчлэн харин эндээс яагаад тодорхой тохиолдолд хүч хэрэглэдэг, яагаад хүч хэрэглэдэггүй вэ? Яагаад засаглагч эрх мэдлийг хэрэгжүүлэх нь удирдлагын нарийн төвөгтэй хэлбэрээс хамаардаг, яагаад жирийн хүч хэрэглэхээс хамаардаггүй вэ? гэсэн асуултууд урган гарах бөлгөө. Социологич Шифр аливаа улс төрийн системийн дотоодод эрх мэдлийн гурван эх үүсвэр байдаг гээд **хүч** (force), **нөлөө** (influence), **ноёрхол** (authority-бас эрх мэдэл гэж орчуулагддаг) зэргийг дурдсан юм. Харин эндээс эрх мэдэл оршин байхын тулд хүч, нөлөөлөл, ноёрхол зэрэг зүйл засаглагч этгээдэд хэрэгцээтэй болох нь харагдаж байна. Хүч гэдэг нь засаглалыг хэрэгжүүлэхийн тулд нэг талын хүсэл зоригийн төлөө бусдад албадлагыг хэрэглэх явдал бол харин нөлөөлөл нь ятгалгын үйл явцаар дамжуулж засаглалыг хэрэгжүүлэх байдлыг ойлгодог. Харин ноёрхол бол энэ хоёрыг бодвол илүү тогтвортой, найдвартай засаглах үндэс бөгөөд институтчилэгдсэн хийгээд засаглагч тал нь бусад хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн, тийм засаглалыг хэлэх ажээ. (Шифр, 1995, 426) Ноёрхол буюу эрх мэдлийн хэв маягуудын талаар дараагийн сэдэвт авч үзэх болно.

Бүдцвч: Засаглал ба түүний гурван эх үүсвэр (Шифр)



Төр нийгмийн институт болох нь

Төр бол орчин үеийн нийгмийн улс төрийн хүрээний хамгийн өргөн тархацтай, улс төрийн бусад институтийг бодвол өмнө дурдсан бүхэл нийгмийг засаглах гурван эх булаг болсон хүч, нөлөө, ноёрхлын аль алиныг өөртөө агуулсан институт бол төр юм. Энэ бүлгийн эхэнд социологийн эцэг О.Конт нийгмийн тогтвортой байдлыг хангагч гурван гол институтийн нэг нь төр хэмээн тодорхойлсныг өгүүлсэн билээ. Британий социологич Гидденс төр нь улс төрийн аппарат, газар нутаг, хууль ба хүч хэрэглэх гэсэн үндсэн шинж чанаруудтай болохыг заажээ. Өөрөөр хэлбэл төр нь засгийн газар, түүний бүрэлдэхүүн хэсгүүд гээд өөрийн төрийн байгууллагуудыг бүрдүүлэх ба газар нутгийн тодорхой хил хязгаарын дотор хэм хэмжээ тогтоон түүнийгээ хэрэгжүүлэх (мөрдүүлэх) үйл ажиллагааг зохион байгуулдаг билээ. Төр нь гэр бүл, шашин зэрэгтэй харьцуулахад хожуу боловч мэдээж түүхийн удаан хугацааны туршид оршиж байсан

үндсэн институт бөгөөд судлаачдын дунд төрийн түүхэн хувьслаас хамаарч уламжлалт болон орчин үеийн төр гэсэн ойлголтуудыг бий болгосон байна. Орчин үеийн төр нь үндэсний төр (nation state) бөгөөд хэд, хэдэн онцлог шинжтэй юм.

Хүснэгт. Төрийн түүхэн хэв маягууд, тэдгээрийн ялгаа

Уламжлалт төр	Орчин үеийн буюу үндэсний төр (nation state)
Уламжлалт төрийн үед удирддаг газар нутаг нь ямагт тодорхой байдаггүй. Төв засаг нь тэдгээрийг ихээхэн сул хянадаг байв.	Засгийн газар нь нарийн тодорхой хил хязгаар бүхий нутаг дэвсгэрийг удирдаж, түүнийхээ хүрээнд дээд засаглал нь болж байдаг буюу бүрэн эрхт (тусгаар тогтнол) шинжтэй байдаг.
Хаад болон эзэн хаан удирддаг уламжлалт төрд хүн амын дийлэнх хэсэг нь өөрсдийг нь хэн удирдаж байгааг мэддэггүй буюу мэдэхийг хичээдэггүй. Ноёрхох анги буюу баян хүмүүсийн бүлэг л хэн нэг хүний удирдаж буй нийгэмд хамаатай гэдгээ мэдэрдэг байв.	Улс төрийн системийн зааг хязгаарын дотор амьдарч байгаа олонх хүн нийтлэг, эрх, үүрэг бүхий иргэд болж, үндэстэнд хамаарч байгаагаа мэдэрдэг. Бараг хүн болгон өөрийгөө аль нэг үндэстэн, үндэстний улс төрийн байгууламжийн төлөөлөгч мэтээр үздэг.
Уламжлалт төрийн үед үндэсний үзэл жинхэнэ утгаараа тухайн улсын хүн амын нийтлэгийг зангидсан нэгдмэл ойлголт, мэдрэмж, бахархал зэргийг бүрдүүлж өгч байгаагүй.	Үндэсний үзлийн өсөлттэй холбогдож байдаг. Үндэсний үзэл нь хүмүүст өөрсөд нь аль нэг үндэстний нийтлэгт хамаатай гэсэн мэдрэмжийг нөхцөлдүүлж өгдөг бэлэгдэл, итгэл үнэмшлийн нийлбэр хэмээн хэлж болно. Үндэсний үзэл нь тодорхой бие даасан нийтлэгтэй, эв нэгдэлтэйн мэдрэхүйгээ илэрхийлэх арга болж ирсэн.

Эх сурвалж: Гидденс, Социологи, УБ 2006 он, 248

Улс төрийн нам ба социаль анги, давхаргууд

Улс төрийн нам бол улс төрийн нөлөөний гол эх сурвалжийн нэг мөн. Аливаа нам нь иргэн болон засгийн газрыг холбогч болж үйлчилдэг. Улс төрийн нам засгийн газар болон түүний бодлогын талаар мэдээлэл цуглуулах, түүнийгээ хялбаршуулсан байдлаар иргэдэд хүргэх, улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх, сонгуулийн кампанид тэдгээрийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Намын байгууллагыг ихэнхдээ байгууллага буюу эсвэл зүгээр л аппарат гэж нэрлэх ба үүнд намын албан ёсны удирдлагууд, эсвэл зарим нөлөө бүхий бие хүн, улсын болон орон нутгийн түвшний намын олон тооны удирдах ажилтнууд ба намын түшмэдүүд багтах нь нийтлэг зүйл юм. Улс төрийн нам гэдгийг сонгуулиар дамжин засгийн газарт тавих хууль ёсны хяналтыг олж



авахаар эрмэлзэж буй байгууллага гэж тодорхойлох явдал улс төр судлаач болон социологичдын дунд элбэг тааралдана. Харин засгийн эрх авахаар эрмэлзэж байгаа боловч үүнийгээ хууль ёсны хэрэгслээр хангах боломжгүй байгууллагууд байх ба тэдгээрийг улс төрийн сект буюу бүлэглэлүүд гэвэл зохилтой. Намын оршин тогтнох гол үндсүүдээс юуны өмнө тодорхой үзэл баримтлалыг хэлж болно. Баруун европын ихэнх оронд улс төрийн үндсэн ашиг сонирхлыг илэрхийлэгч гэж социалист, коммунист, консерватив болон либерал намуудыг томоохон намуудад тооцдог. Социологичдын анхаарлыг татдаг нэг зүйл бол намуудын хүрээнд санал хураалтын дүн ба социаль ангиудын хуваагдлын хооронд тод илэрсэн зүйл бий. Либерал болон зүүний чиглэлийн намууд нь доод ангийнхны ихэнхийн саналыг авахыг эрмэлздэг бол харин консерватив болон барууны чиглэлийн намууд нь сонгогчдоо чинээлэг хэсгээс хайдаг. Ерөнхийдөө намыг зүүний болон барууны гэх нь хамгийн ерөнхий ангиллууд бөгөөд энэ нь аж үйлдвэрийн хувьсгал, тэр дундаа францын хувьсгалаас хойш барууны орнуудад бий болсон нийгэм улс төрийн сэтгэлгээний хуваагдлаас үүдэлтэй бөгөөд либерализм нь Шотландын философич А.Смитийн байж болох хамгийн бага оролцоот төр бүхий чөлөөт зах зээлийн тогтолцоо үндэстэн чинээлэг байдалд хүрэх гол арга зам болох талаар, харин социализм нь германий философич К.Марксын капитализмын мөн чанар нь цөөнхийн гарт баялгийг хуримтлуулж, олонх ажилчид хүнийсч, мөлжигдөн улмаар үгүйрлийн эгнээ рүү орох ба нийгмийн баялгийн тэнцвэргүй хуваарь нь үл эвлэрэх зөрчлийг буй болгох тул нийгэмд радикал өөрчлөлт хийж капитализмыг халах болно гэсэн сургаалаас үүдэлтэй билээ. Намууд зүүний, барууны гэх энэ ангилал нь ардаа нийгмийн ангийн байр суурийг илэрхийлдэг ба зүүнийхэн нь ерөнхийдөө ажилчин анги, дундаас доогуур болон доод давхаргынхан, ядуусын гэх мэт социаль өргөн бүрэлдэхүүний ашиг сонирхлыг агуулах тул эдгээр намуудын хөтөлбөр нь нийгмийн баялгийг дахин хуваарилах, нийгмийн суурь үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх, эд баялгийн элдэв авираас хүмүүсийг хамгаалах, бүлгүүдийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах гэх мэтээр тодорхойлогддог. Харин барууны чиглэл нь чинээлэг хэсэг, зах зээлийн шидийг амсагчид, аж ахуйтнууд, бизнесийнхэн, өмчтөнүүдийн ашиг сонирхлыг агуулах талтай. Европоос Америкийн намын системийн ялгарах онцлог нь тэнд зүүний чиглэлийн томоохон гэх нам өсч бойжиж ирээгүйд оршино. Энд Бүгд найрамдах нам болон Ардчилсан намууд нь нийгмийн социаль асуудлыг шийдвэрлэх талаараа ялгаатай. Эхнийх нь нийгмийн илүү чинээлэг хэсэгт тулгуурлаж, харин удаах нь ядуу давхрааг татдаг. Гэвч 1993 онд Америкт хийсэн үндэсний судалгааны үр дүнд дээрх хоёр намыг дэмжигчид хүн амын дунд харьцангуй тэнцвэртэй хуваарилагддаг бололтой.

Хүснэгт. АНУ дахь Улс төрийн намуудыг чухалчлах байдал, 1993 он

Намуудтай адилсахуй	Хүн амын хувь
Ардчилсан намын хүчтэй дэмжигч	15
Хүчтэй биш ч, Ардчилсан намын дэмжигч	20
Аль ч намыг дэмжигч биш ч, ардчилсан намд ойр	12
Бие даасан	13
Аль ч намыг дэмжигч биш ч, бүгд найрамдахчуудад ойр	10
Хүчтэй биш ч, Бүгд найрамдахчуудын дэмжигч	19
Бүгд найрамдахчуудын хүчтэй дэмжигч	11

(Эх сурвалж: Шифр. Социологи, 278)

Харин европт, барууны гэгдэх европын хөгжилтэй орнуудад ч зүүний намууд хүч нөлөөтэй билээ. Үзэл суртлын ийм баримжаанаас гадна баруун европын орнуудад намын байгууллагын олон хэв маягууд байдаг, тухайлбаас үндэсний болон хэлний онцгой бүлгийг төлөөлсөн намууд (тухайлбал Их Британи дахь Шотландын үндэсний нам, Финлянд дахь Шведийн ардын нам), түүнчлэн хөдөөгийн хүн амын ашиг сонирхлыг илэрхийлсэн хөдөөгийн намууд (Швед дэх төвийн нам, Швейцар дах Швейцарын Ардын нам), мөн хүрээлэн буй орчны асуудлыг баримжаалсан намууд (Германы Ногоон нам) байдаг.

Сонгуулийн систем ба сонгуулийн оролцоо

Улс төрийн намууд нь сонгуулийн журмаар засгийн эрхийг авахын төлөө үйл ажиллагаа явуулдаг бол улс орнууд сонгуулийн харилцан адилгүй тогтолцоотой байх нь бий. Зарим оронд пропорциональ буюу авсан саналын хувь харгалзан төлөөлөх зарчмаар эрх барих хурлаа байгуулдаг байхад зарим нь «ялагч бүхнийг авна» гэх буюу илүү санал авсан нэр дэвшигч ард түмнийг төлөөлөх зарчмаар явдаг байна. Мөн холимог системийн орнууд ч буй. Жишээ нь Германд Бундестагийн суудлын тавь тавин хувийг дээрх хоёр системээр бүрдүүлдэг байна. Улс орнуудын төрийн дээд эрх мэдэлтнийг сонгох нь засаглалын хэлбэрээс хамаарна. Зарим оронд сонгуулиар олонх болсон болон эсвэл олонхын эвсэлд орсон намын манлайлагч улс төрч улс орны дээд албан тушаалыг эзлэн шууд ерөнхий сайд болдог бол зарим нь (жишээ нь Америкт) төлөөллийн гол байгууллага дахь намын сонгуулийн үр дүнгээс үл хамааран сонгодог байна. Өнөө цагт иргэдийн улс төрийн оролцооны хамгийн анхдагч, бас нийтлэг хэлбэр нь сонгуульд санал өгөлт билээ. Сонгуулийн оролцооны түвшин ба агуулгад юу нөлөөлдөг вэ? гэсэн асуултад хариулт өгөх нэгдсэн загвар байхгүй боловч (соёл, улс төрийн тогтолцоо, социаль бүтэц гээд олон хүчин зүйлээр нөхцөлдөнө) ерөнхийдөө тоймлон гаргах бололцоотой. Юуны өмнө сонгуулийн оролцоо болон сонгогчдын нийгмийн болон хүн амзүйн



шинж чанараас хамаарах хамаарлыг социологичид анхааран судалдаг юм. Өөрөөр хэлбэл тэдний улс төрийн сонгуульд санал өгөлтөд боловсролын түвшин, нас, хүйс, мэргэжил, ажил эрхлэлтийн байдал, нутагшилт, угсаатны хамаарал гээд хүчин зүйлүүдийн хамаарлыг тодорхойлохыг оролддог. Тухайлбал сонгуулийн оролцоо нь сонгогчдын нийгэм, эдийн засгийн байдал, боловсролын түвшинтэй нэлээд хэмжээгээр холбоотой байдаг. Хүний нийгмийн байдал хэдий дээгүүр байна, түүний улс төрийн амьдралд оролцох бэлтгэл төдий дээгүүр байх аж. Түүнчлэн сонгуулийн санал хураалтад ахимаг насны хүмүүс залуучуудыг бодвол илүү бэлтгэлтэй оролцох нь хаана ч байдаг ба энэ хандлага нь боловсролын түвшнээс үл хамааран хадгалагддаг. Түүнчлэн сонгуулийн оролцоо нь хүйсийн байдлаас хамаарах нь соёлын онцлогоор нөхцөлдөн зарим орнуудад эмэгтэйчүүдийнх харьцангуй бага байх боловч зарим орнуудад тэдний оролцоо өндөр байлаа гээд улс төрийн дээд албанд эмэгтэйчүүдийн төлөөлөл өндөр байх явдлыг дагуулдаггүй байна. (Смелзер, 2001, 508) Сонгуулийн оролцоо нь мөн нутагшилаас хамаарах нь бий. Улс орнуудад хөдөөгийн сонгогчдын оролцоо, томоохон хотуудын сонгогчдыг бодвол харьцангуй дээгүүр байх нь ажиглагддаг байна. Түүнчлэн үндэстэн, угсаатны бүтэц, арьсны өнгө сонгогчдын оролцоонд ялгаатай дүр зургийг бий болгох талтай. Америк нь сонгогчдын оролцоо тун багатай орнуудын нэг боловч тэндхийн бага оролцооны түвшин нь дотроо үндэстний болон арьс өнгөний ялгаатай түвшинг бий болгодог. Үүнийг хоёр удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн дүнгээс харж болох юм.

Хүснэгт. Улс төрийн сонгуулийн оролцооны хувь: арьсны өнгөөр

Бүлгүүд	Никсон болон Мак Говерн		Клинтон, Буш болон Перот	
	Бүртгэгдсэн хувь	Санал өгсөн хувь	Бүртгэгдсэн хувь	Санал өгсөн хувь
Нийт хүн амын	72.3	63.0	68.2	61.3
Цагаан	73.4	64.5	70.1	63.6
Хар	65.5	52.1	63.9	54.0
Испани	44.4	37.4	35.0	28.9

Эх сурвалж: (Шифр, 1995, 432)

Сонгуульд санал өгөхөөс дайжих явдал байх ба үүнийг абсентэйзм гэж нэрлэдэг. Сонгуулийн оролцоо ер нь дээгүүр юм уу, эсвэл доогуур байх явдал нь хэд хэдэн хүчин зүйлээр нөхцөлддөг талаар судлаачид тэмдэглэсэн байна. Тухайлбал энэ нь сонгуулийн тогтолцооноос хамаардаг гэх нь бий. Доорх хүснэгтээс харахад сонгуулийн оролцоо Америкт ийм байгаа нь энэ орон ардчилалд тийм их ач холбогдол өгдөг юм уу гэмээр сэтгэгдэл төрдөг байна. Харин олон нийтийн санал бодлыг судлах томоохон төвүүдийн судалгаагаар сонгуульд оролцохыг хүсдэггүй Америкчууд тийм ч их өндөр хувьтай байдаггүй ажээ. Энэ нь судлаачдыг сонгуулийн системтэй

холбон үзэхэд хүргэсэн байна. Заавал санал өгдөг орнуудад сонгуульд оролцогсдын тоо, хэмжээ сонгуульд оролцох эсэх нь чөлөөтэй байдаг орнуудтай харьцуулахад илүү байгааг анзаарчээ. Түүнээс гадна сонгогчдын бүртгэлийг засгийн газрын хяналтын доор автоматаар хийдэг орнуудад сонгуульд оролцогчдын тоо иргэн бүр бие даан бүртгүүлдэг орнуудынхаас өндөр байгааг Гласс болон бусад судлаачид тогтоожээ. Мөн абсентэйзмийн хэмжээ хэр их байх нь улс орнуудын хүн амын амьжиргааны түвшингээс хамаардаг байж болох ба чинээлэгдүү дунд ангийнхан зонхилсон нийгэмд сонгуулийн оролцоо багасах магадлал байж болох юм. Гэхдээ үүнийг нийгмийн бүтэц, давхраажил ромбо хэлбэртэй үед хүн амын зонхийн амьдрал тогтворжсон, улс төрөөс харьцангуй үл хамаарсан байх талаарх онолын төсөөлөл гэж үзэх нь ч бас буй.

Хүснэгт. Янз бүрийн орны төрийн засаглалын сонгууль дахь сонгогчдын оролцоо

Усын нэр	Сонгуулийн эрх бүхий насны хүн амын дунд сонгогчдын эзлэх хувь хэмжээ
Итали	94.0
Австри	89.3
Белги	88.7
Швед	86.8
Португал	85.9
Грек	84.9
Нидерланд	84.7
Австрали	83.1
Дани	82.1
Норвеги	81.8
Герман	81.1
Франц	78.0
Их Британи	76.0
Япон	74.4
Испани	73.0
Канад	67.4
Финлянд	63.0
Ирланд	62.0
АНУ	52.6
Швейцарь	39.4

Эх сурвалж: Смелзер Н. Социологи, 2001. 209



Хяналтын асуултууд:

1. Засаглалыг социаль үзэгдэл болох хувьд нь тайлбарлана уу?
2. Засаглал улс төрийн амьдралын үндэс болохын учир шалтгааныг хэрхэн үндэслэх вэ?
3. Улс төрийн засаглалын онцлог шинж юунд байна вэ?
4. Төрийн институцийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, онцлог юу вэ?
5. Улс төрийн нам болон сонгуулийн тогтолцоог судлах социологийн хандлагын онцлог хэрхэн илрэх вэ?



Эх сурвалж:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Осипов Г.В, (2002), Социология: Основы общей теории, Москва, Издательство
4. Кравченко, Добрьенков, (2002), Социальные институты и процессы: Социология, 3 том, М
5. Richard T.Shaefer, Robert P.Lamm (1995), Sociology, NY, Mc Graw Hill



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон

Сэдэв- 5: Нийгмийн институтууд: Засаглал, эрх мэдлийн (authority) хэв маягууд М.Веберийн социологийн шинжилгээнд тулгуурлан хэлэлцэх (сем-2 цаг)

Хичээлийн зорилго: Нийгэм дэх засаглалын нэг үндэс болсон ноёрхлын (эрх мэдлийн) мөн чанар, түүний үндсэн хэв маягуудыг М.Веберийн социологийн идеаль хэв шинжийн хандлагын үүднээс тайлбарлах аргагүйг эзэмшүүлэхэд энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Ноёрхол
- ❖ Ноёрхлын хэв маяг
- ❖ Хууль ёсны ноёрхол
- ❖ Уламжлалт ноёрхол
- ❖ Харизматик ноёрхол

Сэдвийн агуулга

- ❖ Нийгмийн ноёрхол гэж юу вэ? Түүнийг тодорхойлох шинж чанарууд: Ноёрхлын мөн чанар, ноёрхол хэрэгжих социаль үндэслэл
- ❖ Ноёрхлын хэв маяг тус бүрийн илрэх хэлбэр, ноёрхлын социаль амьдралд гүйцэтгэх үүрэг
- ❖ Ноёрхлын хэв маягууд хоорондын ялгаа

Ноёрхол (эрх мэдэл)¹ ба тццний хэв маягууд

Веберийн 1922 онд хэвлэгдсэн «Эдийн засаг ба нийгэм» эмхтгэлд ноёрхлын (эрх мэдлийн) гурван хэлбэр байгааг тоочин тодорхойлжээ. Тэрээр ноёрхлын хүлээн зөвшөөрөгдсөн гурван хэлбэр нийгэмд оршин байгааг заагаад тэдгээр тус бүрийн хүлээн зөвшөөрөгдөх тал, шинж чанарыг 1/ Рациональ шинжүүд: Энэ тохиолдолд хуулиар тогтоосон дэг ёсны эрхзүйд хийгээд ноёрхлыг хэрэгжүүлэхэд шаардагдах шийдвэр гаргах эрхэд тулгуурлах болно (хууль ёсны ноёрхол), 2/ Уламжлалын шинжүүд: Энэ үед аль нэг уламжлалын ариун нандин зүйл болох талаарх өдөр тутмын итгэл үнэмшилд тулгуурлана (уламжлалт ноёрхол), 3/ Харизмлаг шинжүүд: Харин энд хэн нэг бие хүний ариун дээд юмуу эсвэл баатарлаг хүчинд, эсвэл үлгэр жишээ байдлын талаар шимтэн бишрэх байдалд тулгуурлана (харизмлаг ноёрхол) гэж тодорхойлсон байна. (Max Weber, 1922,218) Энд дурдсан шинж чанаруудаар нөхцөлдөн ноёрхлын хэв маягууд бий болох ба тэдгээрийн шинж чанарын талаар тус бүрд нь авч үзэх болно.

1. М.Веберийн эх зохиолд Герман хэлний Herrschaft гэсэн үгээр, харин англи хэл дээрх социологийн ном зохиолуудад authority гэсэн үгээр илэрхийлсэн байдаг.



Хууль ёсны ноёрхол

Хууль ёсны ноёрхол нь дотроо янз бүрийн хэлбэртэй байх боловч, эзэн хаан, ноён гэх зэрэг хэн нэгэн бие хүнд бус харин гагцхүү хуульд захирагдаж, бюрократ тогтолцоогоор дамжин хэрэгждэг. Энэхүү ноёрхлын үед удирдлагын аппарат нь тусгай бэлтгэгдсэн түшмэдээс бүрдэх ба тэдгээр нь зөвхөн хууль дүрмэнд захирагдаж өөрийн үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй. Хууль ёсны ноёрхлын хүрээнд ихээхэн холбогдож ирдэг удирдлага, зохион байгуулалтын хэлбэр бол бюрократ идеаль хэв шинж билээ. Харин хууль ёсны ноёрхол нь бюрократ тогтолцоогоор дамжин хэрэгжих ба ийм нөхцөлд засаглалын үр өгөөжтэй рациональ хэлбэр орших боломжтой болдог байна. Ноёрхогчийн үйлдэл, үйл ажиллагааг урьдчилан хэлэх боломжтой болох ба бүлгийн тогтвортой байдал, дэг журмыг бүрдүүлж чадах ажээ.

Хүснэгт. Веберийн «Бюрократ идеаль хэв шинжийн хүрээн дэх ноёрхогчийн онцлог»

- ❖ Ноёрхогчийн үйл хөдлөл нь тусгай дүрэм журмаар зохицуулагдсан тодорхой эрх, үүргийн тогтолцоонд оршино.
- ❖ Ноёрхогчийн эрх мэдэл хязгаарлагдах ба энэ нь түүний гүйцэтгэх үүргээр нөхцөлдөнө.
- ❖ Ноёрхогч нь захирах ба захирагдах ёсны шатлал дотор оршин байна.
- ❖ Ноёрхогч нь тухайн түвшинд ноёрхол тогтооход шаардагдах мэргэжил, дадалтай байна.

Эх сурвалж: Мөнхбат О, 2009.

Уламжлалт ноёрхол

Вебер уламжлалт засаглалын хамгийн эртний хэлбэр бол ахмад настны эрх мэдлийг эрхэмлэх ахмад настны болон эцгийн эрхт ёсны ноёрхол бөгөөд харин түүний арай хожуугийн хэлбэр нь феодализм мөн гэжээ. Энэхүү ноёрхлын хувьд удирдлагын тогтолцоо нь хувь хүний мэргэжлийн ур чадвар, дадал гэхээсээ илүүтэйгээр удирдагчдаа үнэнч байх явдал агаад хууль цаазат засаглалын үед байдаг албан тушаалд томилогдох, дэвших тогтвортой систем байдаггүй. Уламжлалт ноёрхолд дулдуйдсан засаглал нь хууль ёсны засаглалыг сөрөн зогсож байдгаараа нийгэм дэх рациональ байдлын хөгжилд саад тотгор болж, рациональ эдийн засаг төдийгүй капитализмыг урагшлан дэвшихэд хор хөнөөл учруулдаг аж. (Мөнхбат О, 2009)

Харизм ноёрхол

Веберийн үзснээр хэн нэг бие хүний ариун дээд юмуу эсвэл, баатарлаг хүчинд, эсвэл үлгэр жишээ байдлын талаар бусад хүмүүсийн шимтэн бишрэх байдалд харизмлаг засаглал биелэлээ олдог байна. Энд хувь хүнээс үл хамаарсан хууль дүрэм юмуу, эсвэл уламжлалт зан заншлын

хэм хэмжээний тухай бус, харин бие хүний шинж чанарын тухай товчоор харизмлаг хүний тухай яригдана.

Бүдцүвч: Харизмлаг хүмүүсийн нийтлэг жишээ



Харизмлаг хүн гэдэг нь туйлын өргөн утгаар хэрэглэгддэг ойлголт агаад түүний хүрээнд бид салбар, салбарын домогт хүмүүсийн тухай эргэцүүлэхэд хүрдэг. Харин Веберийн хувьд хүний оюун санаанд нөлөөлж, өөрчилж чадахуйц хувьсгалч, өөрчлөгч, удирдан жолоодогч талаас нь илүү чухалчлан авч үзсэн билээ. Энэхүү ноёрхлын үед удирдлагын аппарат гэхээсээ тойрон хүрээлэгсэд, дагалдагсад, бараа бологсдын бүтэц байх ба энэ нь харизмлаг удирдагч нь үгүй болсон тохиолдолд, шинээр удирдагч тодруулах зэргээр өөрийн орших хугацааг сунгах чадвартай байдаг ажээ. Гэхдээ шинээр төрсөн удирдагч нь өөрийн ноёрхлыг өмнөх удирдагчийнхаа үлдээсэн дэг ёс, зарчим, журамд тулгуурлах замаар хэрэгжүүлдэг тул энэ нь аажимдаа уламжлалт засаглал болон хувирах талтай. (Мөнхбат О, 2009) Монголчуудын хувьд анхдугаар Богд Жавзандамба буюу халхын өндөр гэгээн Занабазар нь улс төр, шашин, шинжлэх ухаан, урлалд гүнзгий нэвтэрсэн нэгэн байсан тул төр, шашны язгууртнуудын хүрээнд харизмлаг ноёрхогч мөн байв. Харин түүнээс хойших Богдын залгамжлагч хойт дүрүүдийн хувьд монголчуудын хувьд төр шашныг хослогч харизмлаг лидерүүд гэхээсээ илүүтэй уламжлалт ноёрхогчид байсан гэж хэлж болох юм. Үүнтэй холбоотойгоор харизмлаг бүлэг гэсэн ойлголт социологит байх бөгөөд энэ нь харизм шинжээрээ тодорсон удирдагчийг тойрон хүрээлсэн бүлгийг хэлдэг байна. Ийм бүлгийн жишээнд Христос болон түүний шавь нарыг хэлж болох ажээ. Харизмлаг бүлгийн шинж чанар нь зохион байгуулалтын хувьсамтгай бүтэц, удирдагчаасаа хамаарч байдагт орших ба эдгээр бүлгүүд нь шатлан захирах



ёс байдаггүй юм. Гишүүдийн үүрэг нь удирдагчтайгаа харилцах харилцаанаас хамаардаг байна. (Смелзер. 2001. 156)

Ноёрхлын хэв маягийн хоорондын ялгаа

Америкийн социологич Смелзерийн хэлсэнчлэн «Хэрвээ бид дараах гурван асуултад хариулбал Веберийн санал болгосон ноёрхлын дээрх гурван хэв маягийн хоорондын ялгаа илэрхий болох» юм.

1. Бид хэнд захирагддаг болон юуны өмнө захирагдах цэрэгтэй вэ?

- ❖ Харизмлаг ноёрхлын үед бол хүчирхэг, бишрэм хошуучлагчид ямар ч яриагүйгээр захирагддаг.
- ❖ Уламжлалт ноёрхлын үед бид зан заншил, уламжлалаас заяагдсан удирдагчид чин үнэнч байдлаа илэрхийлдэг.
- ❖ Рациональ легитим ноёрхлын үед бид ямар нэг эзэнгүй дүрэм журмыг мөрддөг бөгөөд тиймээс хууль ёсны засаглалд хэн байна, түүнд л захирагддаг.

2. Улс төрийн тогтолцоо яаж зохион байгуулагдсан байдаг вэ?

- ❖ Харизмлаг ноёрхлын үед бол энэ тогтолцоо зөвхөн хошуучлагч ба түүнд үнэнч бүлэг хүмүүсийн хоорондын харилцаа л байдаг. Хошуучлагчийн тушаал дур зоргын байж болно.
- ❖ Уламжлалт ноёрхлын үед удирдагчид итгэх итгэл ба түүнийг залгамжлагчдын зүгээс үзүүлэх дэмжлэг нэг үеэс нөгөө үед дамжин ноён ба түүний албатуудын хоорондын харилцааг илэрхийлэгч зан үйлд уламжлагдан бэхждэг.
- ❖ Рациональ легитим ноёрхлын үед бол бүх түшмэдүүдэд зуршмал байдаг ерөнхий зарчмууд, хүний хувийн онцлогоос үл хамааран боловсон хүчнийг шилж сонгох, энд гол нь тэдний гавьяа байх, төрийн албыг албан тушаал, карер хөөцөлдөх явдал гэж үзэх нь улс төрийн тогтолцоонд зуршмал зүйл байдаг.

3. Ноёрхлын хэв маяг ба эдийн засгийн тогтолцооны хооронд ямар харилцаа холбоо үйлчилдэг вэ?

- ❖ Харизмлаг ноёрхлын үед бол хошуучлагч нь ихэнхдээ эдийн засгийн үйл хэрэг бол бүхэлдээ заваан, нийгмийг завхруулагч зүйл гэж үздэг. Энгийн бүдүүлэг нийгэмд бэлэг өгөх, эсвэл дээрэмдсэн зүйлсийг (баячуудын булхай хөрөнгөнөөс гэх мэт) хүлээн зөвшөөрнө. Орчин үеийн ардчилсан нийгмүүдэд харизмлаг улс төрчдийн ноёрхол нь түүнийг болон үзэл баримтлалыг дагагч, бишрэгч, дэмжигчдийн санхүүгийн дэмжлэг, хандиваар өөрийн үйл ажиллагааг явуулдаг.
- ❖ Уламжлалт ноёрхлын үед удирдагч өөрийн талын хүмүүст мэдлийнхээ хөрөнгөнөөс бэлэглэж тэднийг дэмждэг. Ноёрхогчийн сан хөмрөг уламжлал, зан заншлаар тэтгэгдэн түүнийг тойрогчдын хамжлага үйлчилгээгээр арвижих ба өвлөгдөн дамжина.
- ❖ Рациональ легитим ноёрхлын үед бол бүх албан хаагч нь хэлбэржиж баталгаажсан тусгай эрх, ямба, хөнгөлөлт эдэлдэг. Татварын системээр дамжин дэмжигдэх ба төсөвлөсөн хөрөнгөнөөс удирдлагад байгаа хүмүүстээ санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Бюрократ тогтолцооны түшмэдүүд албан үүргийнхээ төлөө цалин хүлээн авдаг.



Хяналтын асуултууд:

1. Ноёрхлын хэв маягуудыг Вебер ямар шинж чанарт тулгуурлан дэвшүүлэн тавьсан бэ?
2. Орчин үеийн нийгэмд ноёрхлын хэлбэрүүд ямар харьцаатай, хэрхэн оршин тогтнодог вэ?
3. Ноёрхлын хэлбэр тус бүрт оноогдох улс төрийн удирдагчдыг хилийн чанадаас болон өөрийн орноос хэрхэн нэрлэж чадах вэ?



Эх сурвалж:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Richard T. Shaefer, Robert P. Lamm (1995), Sociology, Chicago press
4. Кравченко А.И, Добрыенков В.И, (2002), Социальные институты ин процессы: Социология, 3 том, М
5. Max Weber (1922). Wirtschaft und Gesellschaft. Voltmedia, GmbH, Paderborn



Унших материал:

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон



БҮЛЭГ-ҮИИ. Социаль дэг ёс хийгээд гаж үзэгдэл

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Социаль дэг ёс хийгээд гаж үзэгдэл	Нийгмийн дэг ёс (хэм хэмжээ, үнэт зүйл) гаж үзэгдэл, түүний хэлбэрүүд	2	Лекц
	Гэмт хэрэг ба ял шийтгэл, гавьяа ба шагнал (П.Сорокинний социологийн шинжилгээнд тулгуурлан хэлэлцэх)	2	Семинар

Сэдэв - 1: Нийгмийн дэг ёс (хэм хэмжээ, үнэт зүйл) ба гаж үзэгдэл, түүний хэлбэрүүд

Хичээлийн зорилго: Нийгмийн дэг ёс хэмээх ойлголтын талаар социологийн үүднээс ул суурьтай авч үзэж, улмаар нийгмийн гажуудал, гаж үзэгдлийг нийгэм соёлын тогтолцоо, үнэт зүйлс, хэм хэмжээ гэх мэт социаль амьдралын үндсэн нөхцөлүүдтэй холбон авч үзэх, гажуудлын хэлбэрүүд, түүний талаарх социологийн онолын үндсэн тайлбаруудтай танилцах нь энэ хичээлийн гол зорилго болно.

Гол ойлголтууд:

- ❖ Нийгмийн дэг ёс
- ❖ Нийгмийн үнэт зүйл ба хэм хэмжээ
- ❖ Нийгмийн гаж үзэгдэл
- ❖ Эерэг гаж үзэгдэл
- ❖ Сөрөг гаж үзэгдэл
- ❖ Нийгмийн хяналт ба хориг арга хэмжээ
- ❖ Нийгмийн сөрөг гаж зан үйл
- ❖ Гэмт хэрэг

Сэдвийн агуулга:

- ❖ Нийгмийн дэг ёсны тухай ойлголт
- ❖ Нийгмийн үнэт зүйлс, хэм хэмжээ нийгмийн дэг ёсны тулгуур ойлголтууд болох нь
- ❖ Нийгмийн хяналтын тогтолцоо бүрэлдэх нь
- ❖ Нийгмийн хариу арга хэмжээ, түүний хэлбэрүүд
- ❖ Нийгмийн гаж үзэгдлийн тухай ойлголт, гаж зан үйл ба гаж үзэгдэл
- ❖ Нийгмийн сөрөг гаж зан үйл, түүний хэлбэрүүд

Нийгэм хэрхэн орших боломжтой болдог вэ?

Социологийн сонгодог сэтгэгч Г.Зиммел «Нийгэм хэрхэн орших боломжтой болдог вэ?» (Wie ist die Gesellschaft moeglich?) хэмээх асуултын талаар алдарт «Социологи» бүтээлийнхээ социологийн асуудлуудын тухай бичлэгтээ эргэцүүлсэн байдаг. Тэрээр Гегелийн «Байгаль хэрхэн боломжтой вэ?» гэсэн асуулт дэвшүүлэн түүний хүрээнд хийсэн философи эргэцүүлээс нь үлгэрлэн хүний нийгмийн тухай цэвэр социаль шинжлэх ухаан болох социологийн хүрээнд нийгэм хэрхэн оршин тогтнож байдаг талаар эргэцүүлжээ. Нийгмийн дэг ёсны асуудлыг ерөөс нийгэм хэрхэн оршин байдаг вэ? гэсэн асуултад хариулахгүйгээр огтоос танин мэдэх боломжгүй зүйл билээ. Нийгмийн сэтгэлгээний түүхэнд «Нийгмийн хэрхэн боломжтой болдог» талаар сэтгэгчид өөр өөрсдийн хариултыг өгсөн байх юм. Германы судлаач Х.Абел нийгмийн дэг ёс хэрхэн бүрэлддэг талаар буюу нэгэн дор хүмүүс хэрхэн хамтран аж төрж, нийгмийг бүтээж байгаа талаар нийгмийн сэтгэгчдийн үзлийг авч үзсэн байна.

Хүснэгт. Нийгмийн дэг ёс буюу нийгэм хэрхэн оршин тогтнох боломжтой болдог тухай цэлцүд

Руссо	Хүн төрөлхөөсөө бие даасан, бусдад тусархаг, ёс суртахуунт, эрх чөлөөт нэгэн бөгөөд тэрээр хүний анхдагч заяагдмал энэ дүрийг жам ёсны хүн (natural man) хэмээжээ. Харин хүн нийгмийн хөгжлийн явцад хувийн өмч, эрх мэдэл, улмаар төр бий болсноор жам ёсны хүн нь заяагдмал төрхөө гээн, эрх мэдэлд дурлагч, эд хөрөнгөд шунагч болж эвдэрсэн ба дарлал, мөлжлөг, дарангуйлал тэргүүтэн асуудлууд буй болжээ. Тиймээс хүмүүсийн жам ёсны дүр төрхийг сэргээхийн тулд нийгмийн гэрээний зарчим чухал байна. Нийгмийн гэрээ бол бие биенийхээ эрх чөлөөнд хохирол учруулахгүйгээр, басхүү өөрийн эрх чөлөөг бусдын эрх чөлөөнд саад учруулахгүй байхуйцаар эдлэх боломжийг тусгана. Нийгмийн дэг ёсыг хангахын тулд энэхүү гэрээ бий болж нийгмийн гишүүдээр мөрдөгдөх учиртай.
Смит	Хүмүүс бие биентэйгээ хамтран аж төрөхдөө хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх нөхцөл бүрддэг. Хүний хувийн сонирхлыг хангах үндсэн нөхцөл нь чөлөөт солилцоо бөгөөд чөлөөт солилцооны үр дүнд зах зээл цогцолж, хөдөлмөрийн хуваарь гүнзгийрэн нийгмийг тор мэт хэрэх болно. Хүмүүс зэрэгцэн зүй ёсоор оршин тогтнох үндэс нь аяараа үүсэх дэг ёс бөгөөд чөлөөт өрсөлдөөний үед хүний өөрийнхөө төлөө явуулах үйл ажиллагааны үр дүн нь явсаар нийгмийн тусын тулд болж үйлчлэх бөгөөд томоохон нийгмүүд оршин тогтнох материаллаг хэрэгцээгээ хангаж, чинээлэг байдал аз жаргал цогцлоно.
Г.Зиммел	Нийгэм нь хүмүүсийн харилцан үйлдлийн тогтвортой хэлбэрүүдийг өөртөө агуулж байдаг. Хүмүүс өөр хоорондоо харилцан үйлдэлд оролцох явцад тэдгээр нь тодорхой хэлбэрүүдийг бүтээх ба нийгмийн харилцааны ийм тогтсон, тогвортой хэлбэрүүд бий болох үйл явцыг «нийгэмжих» (vergesellschaftung ²) хэмээн нэрлэсэн байна.



Мид	Социаль бэлэг тэмдгүүд нь нийгмийн гишүүдийн үйлдлийн чиг баримжаа, харилцан үйлдлийн загвар, үйл ажиллагааны өдөөлт болдог талаар авч үздэг. Тухайлбал, хэл яриа ч гэсэн бэлэг тэмдгийн нарийн солилцоо ба үнэт зүйлс, хэм хэмжээний учир холбогдлыг агуулна. Мид «дохио зангаанаас бэлэг тэмдэг өөд» хэмээх өгүүлэлдээ хэл яриа ч гэсэн үг ойлголтын ердийн мөргөлдөөн төдий биш агаад түүний мөн чанар болсон социаль өгөгдөхүүнийг орхигдуулж болохгүй гэжээ. Биднийг хүрээлэн байгаа бэлэг тэмдгийн ертөнцөд бидний зүгээс өгч байгаа утга холбогдлууд нь бидний хамтын үйлдэл, амьдралыг боломжтой болгодог байна.
Парсонс	Нийгмийн систем нь өөрийн эмх журам, интеграцийг хангахын тулд өөрийн гишүүдээс биелүүлж үл чадах зүйлийг нь шаардаж, мөн хэрэгжүүлж үл болох үйлдлийг нь зөвшөөрч болохгүй. Тийнхүү шаардсан юм уу, зөвшөөрсөн соёлын загварыг баримталдаггүй. Чухамдаа нийгмийн системийн эмх журам, нэгдмэл байдлыг үйлдвэрлэж байдаг дэд систем бол соёлын дэд систем бөгөөд тэрээр нийгмийн гишүүдэд норматив хандлагыг төлөвшүүлж байдаг ажээ.
Лукманн, Бергер	Бодит байдал нийгмийн хувьд хэрхэн байгуулагддаг вэ? гэсэн асуулт тавиад хариулт өгсөн. Объектив бодит байдал нь бидний өөрсдийн ахуйд хүлээн авч буй зүйлүүддээ өгч байгаа субъектив утга учраас салангид оршин тогтнодоггүй. Хүмүүс өөрсдөө л хамтдаа нийгэм, соёл, сэтгэлзүйн иж бүрдэл бүхий хүний орчноо үйлдвэрлэдэг. Хүмүүсийн туршлага болох өдөр тутмын амьдрал нь тэдний зүгээс ердөө аль нэг баримт болон объектой нүүр тулгарч байгаа жирийн нэг үзэгдэл бус, гагцхүү өдөр тутмын амьдрал нь нийгмийн (хүмүүсийн) харилцаагаар байгуулагддаг (socially constructed) зүйл билээ. Хүний бүхий л мэдлэг нийгмийн тодорхой нөхцөлд хөгжиж, дамжуулагдаж, хадгалагдаж байдаг ба конструктивизм нь ийнхүү хөгжиж, дамжуулагдаж, хадгалагдсан мэдлэг нь ямар замаар бодит байдал болж буй үйл явцын үндэслэлийг хайх ёстой юм.

Эх сурвалж: H.Abel. Eine Einfuehung in die Soziologie. Blick auf die Gesellschaft.

Нийгэмд дэг ёс оршин тогтнохын тулд хамтын тулгуур үнэт зүйлс (value) болон хүмүүсийн үйлдлийг зохицуулах хэм хэмжээний (norm) тогтолцоо бүрэлдэн бий болж байх шаардлагатай болно. Учир нь нийгэм оршин тогтнохын тулд товчоор *хүн сүрэг байхгүйн тулд өөртөө ямар оршихуйг бүтээдэг вэ?* гэсэн асуулт гарч ирнэ. Нийгэм өөрийн эмх журмыг хадгалах, цогц байдлыг хангахын тулд хүмүүсийн зан үйл, үйл ажиллагааг тодорхой дэг горимонд оруулах ёстой гэсэн үг. Үнэт зүйлс болоод хэм хэмжээний тогтолцоо нь нийгмийн дэг ёс бүрэлдэн тогтоход ямар учир холбогдолтой талаар доорх байдлаар авч үзэж болох юм.

- ❖ Нийгэмд хамтын амьдрал боломжтой болоход үнэт зүйлс, хэм хэмжээ хоёр хамгийн чухал үүрэгтэй.
- ❖ Үнэт зүйлс хүмүүс бусдын дунд оршин байх утгыг илэрхийлэх ба бүх нийтэд хамаатай харьцангуй бүхэллэг төсөөллийн ийм тогтолцоо байгаагүй бол хүмүүс хамтаараа байх өөр төгс шалтгаан олдохгүй.

- ❖ Хэм хэмжээ үгүйсэн бол хамтын амьдрал хүн сүргээс ялгарахгүй бөгөөд үнэт зүйлсийг олж авах, хадгалах, байршуулахын төлөөх байгалийн хууль үйлчлэх болно.
- ❖ Үнэт зүйлс хүмүүсийн амьдралдаа утга учир өгч ямар нэг зүйлийг эрмэлзэх эрмэлзлэлийг бий болгодог бол хэм хэмжээ нь энэхүү эрмэлзлээ хэрхэн хангах арга, нөхцөлийг нь зааж өгдөг.
- ❖ Соёл бол хүмүүсийн амьдралын хэв маягыг бүхэлд нь илэрхийлдэг ойлголт байдаг бол үнэт зүйл, хэм хэмжээ нь хүмүүсийн амьдралын хэв маягыг тодорхойлогч соёлын тогтолцооны цөм нь болдог.

Нийгэмд оршин буй үнэт зүйлсийг байршуулах, хадгалах, өвлүүлэх, хэм хэмжээний тогтолцоог мөрдүүлэхийн тулд социаль хяналтын тогтолцоо бүрэлдэн бий болдог. Смелзер «социаль хяналт гэдэг бол гаж зан үйл бүхий хүнийг шийтгэх, залруулахад чиглэсэн орчин тойрных нь хүчлэл юм» (Смелзер Н, 227) хэмээсэн бол Кендал өргөн утгаар нь «социаль хяналтын систем нь хөгжлийн үйл явцад конформизмыг (хэм хэмжээг аялдан дагах байдлыг) байнга сайшаан урамшуулж байхын зэрэгцээ, мөн хэм хэмжээний аливаа гажуудлыг буруушаан шийтгэж байдаг» (D. Kendall, 232-233) гэжээ. Нийгмийн хяналтын чиг үүргийн доор зөвхөн шүүх эрх мэдлийн байгууллагууд, тухайлбал цагдаа, прокурор, шүүх зэргийг ойлгох нь социологийн шинжлэх ухааны талбарыг хумисан хэрэг болох ба социаль хяналтын тогтолцоонд юуны өмнө нийгэмшлийн анхдагч, цаашилбал хоёрдогч агентуудыг авч үздэг. Гэр бүл, хөрш, найз нөхөд, сургууль, сүм хийд гээд цааш хөврөх нийгэмшилд чухал агентууд нь хяналтын маш чухал чиг үүргийг хүлээх ба хүнд үнэт зүйл, хэм хэмжээг төлөвшүүлэх хамгийн анхдагч орчнууд байдаг.

Хүснэгт. Нийгмийн хяналтын систем ба хариу үйлчлэл

Хяналтын хэлбэрүүд	Албан бус хяналт	Албан ёсны хяналт	Өөрийн хяналт
Санкцийн хэлбэрүүд			
Эерэг (+)	Сайшаал дэмжлэг	Зэмлэлт буруушаалт	Өөрийгөө сайшаах, өөртөө дурлах
Сөрөг (-)	Шагнал урамшуулал	Шийтгэл	Өөрийгөө зэмлэхээс эхлээд хүнд хэлбэр ч буй (амиа егүүтгэх)

Эх сурвалж: Кравченко, Добрьенков, (2002), Социальные институты и процессы: Социология, 3 том, М



Гажуудлын (гаж зан үйлийн) хэлбэрцүд

Нийгмийн гаж үзэгдэл хэмээх ойлголт нь социологийн хүрээнд маш өргөн агуулгатай ойлголт юм. Энэхүү ойлголтын дор дийлэнхдээ хамтын амьдралд тохиолдож байдаг сөрөг зан үйлийн хэлблэрүүдийг багтаан ойлгох хандлага байдаг бол харин эерэг хэлбэрүүдийг ч агуулах болно. Социологийн үүднээс авч үзвэл хэм хэмжээ сахигдах хийгээд хэм хэмжээ зөрчигдөх хоёр нь нэг зоосны хоёр тал мөн бөгөөд нийгмийн гишүүдийн дундаж хандлагаас эерэг утгаар болон сөрөг утгаар гажуудаж байгаа бүхий л хэлбэрүүд үүнд багтах учиртай. Эерэг утгаар ёс суртахууны хувьд сайшаал дэмжлэг хүлээсэн эгэл үйлдлээс эхлээд алдар гавьяат үйл хүртэл, харин сөрөг утгаар ёс суртахууны хувьд зэмлэн буруушаагдсан ердийн үйлдлээс эхлээд аймшигт гэмт хэрэг хүртэлх үйлдлийн хэлбэрүүд нь үнэндээ нийгмийн гаж үзэгдэл гэдэг энэ ойлголтод багтдаг.

Бүдцүвч: Нийгмийн гажуудлыг тусгасан ойлголтууд



Гажуудал, гэмт хэргийн талаарх социологийн онолын үзэл баримтлалууд

Нийгмийн зохион байгуулалт (үнэлэмж, хэм хэмжээ уналтад орох) алдагдах болоод гажуудал (гэмт хэрэг) хоёрын хамаарал юу вэ?

Дюркхаймийн аноми байдлын сургаалд нийгмийн гажуудлын талаарх үзэл баримтлал бий болох бөгөөд аноми байдал нь нийгмийн гишүүдийн дийлэнх нь хэм хэмжээг сахихгүй юм уу, түүнийг зөрчих, эсвэл түүнд хайхрамжгүй хандах байдлаар илэрнэ. Хүмүүсийн бодит харилцаа холбоо болон оршин буй үнэт зүйл, хэм хэмжээ хоёр таарч тохирохоо болиод ирэх нь гэмт хэргийн социаль нөхцөл болдог аж. (Смелзер Н, 207) Нийгмийн

бусад гаж үзэгдлийн нэгэн адил гэмт хэрэг нь эдийн засгийн хямрал, улс төрийн засаглалын хямрал, тогтворгүй байдал, гэр бүлийн болон шашны итгэл үнэмшлийн зөрчилтэй байдал гэх мэт социаль хүчин зүйлүүдээр хязгаарлагддаг. Нийгмийн аномн байдлыг тэрээр аж үйлдвэржсэн болон уламжлалт нийгмийн бүтцийг харьцуулах замаар тодорхойлсон бөгөөд энэ нь хүмүүс механик эв нэгдлээс органик эв нэгдэл рүү, ёс суртахуунд тулгуурладаг хамтын ухамсрыг бодвол илүү хурдан дэвшилд хүрдэг хөдөлмөрийн хуваарьт нийгэмд шилжих завсрын үеийн бүтээгдэхүүн болой. Гэмт хэрэг бол механик эв нэгдлийг зөрчиж буй зүйл агаад түүний мөн чанарыг танин мэдэхийн тулд хамтын амьдралын механик эв нэгдлийн мөн чанарыг ухаж ойлгох хэрэгтэй болдог. (Дюркхайм Э. 1995, 77) Дюркхаймын судалгаанд гэмт хэрэг бол нийгэмд зайлшгүй үзэгдэл төдийгүй хамтын амьдралд эерэг үүрэг гүйцэтгэдэг гэх үзэл бий болдог. Тэрээр «үнэн хэрэгтээ гэмт хэрэг хэлбэрийн хувьд энд тэнд өөр хэлбэрээр тааралдах боловч, хүмүүс хэзээ ямагт тийм үйлдлүүдийг өдөөж, эрүүгийн ял шийтгэлийг хүлээсээр ирсэн» хэмээн бичсэн нь бий. (Дюркхайм Э. 1995, 86, 87) Социологич Кендалл, сэтгэгч Дюркхайм гэмт хэрэг нийгэмд зайлшгүй байсаар ирсэн зүйл болохыг мөн, түүний эерэг үүрэг гүйцэтгэдэг болохыг тодорхойлсныг дараах байдлаар авч үзэж болно гэжээ. Түүний дүгнэснээр гэмт хэрэг болон гажуудал нь нэгдүгээрт, хэм хэмжээ, дүрэм журмыг төгөлдөршүүлэх, тунгалагшуулах (хуулийг өөрчлөх, шинэчлэн батлах), гэмт хэрэг нь тиймээс нийгмийг үлбэгэр, нойрмог систем байхаас сэргийлдэг аж, хоёрдугаарт, бүлгийг эв нэгдэлтэй болгох (хүмүүс гэмт хэргийг үзэн ядах, зэвүүцэх мэдрэмжээр нэгдэн нягтрах), гуравдугаарт, харилцан үйлдэл, солилцооны хяналтыг дээшлүүлэх (хүмүүс сонор соргог болох) зэрэг үүргийг гүйцэтгэдэг байна. (D. Kendall, 235)

Хүмүүс амьдарч буй нийгмээсээ зөвшөөрөгдсөн амьдарлын зорилго болон түүнд хүрэх арга замд хэрхэн ханддаг вэ?

Нийгмийн гажуудын тухай Мертоны онол нь Дюркхаймын үзлээс үүдэлтэй бөгөөд социологийн функционализмын үүднээс гүнзгийрүүлэн судалсан билээ. Тэрээр социологи амжилттай хөгжихийн тулд дунд түвшний онолуудыг боловсруулах хэрэгтэй гээд түүний жишээ болгон өөрийн гажуудлын онолыг авч үзсэн байдаг. Хүмүүсийн нийгмийн зорилго болон үйл ажиллагааны хоорондын зөрүүтэй байдлаас зан үйлийн хэв маягуудыг тодорхойлсон юм.



Хүснэгт. Нийгмийн зан үйлийн хэв маягууд

Хүмүүсийн нийгэмд дасан зохицох аргууд	Соёлоор хүлээн зөвшөөрөгдсөн зорилгыг эрмэлзэх (үнэт зүйл)	Соёлоор хүлээн зөвшөөрөгдсөн арга хэрэгслийг баримтлах (хэм хэмжээ)	Жишээ зан үйлүүд
Хэм хэмжээг аялдан дагагчид	+	+	
Шинэчлэгчид	+	-	Хөрөнгөжихийн тулд авлига, хээл хахууль авагсад, албан тушаалын хэрэг үйлдэгчид, энгийн жишээ бол өвчтэй ээждээ санаа тавихын тулд аптекаас эм хулгайлсан хүү.
Хуурмаг жаяг сахигчид	-	+	Хүнд сурталтнууд, албан тушаалын бөглөөсүүд, сохроор аялдан дагагчид, эрмэлзэл, зорилгогүйгээр дүрэм, журмыг эрхэмлэгчид
Гээгсэд	-	-	Архаг архичид, мансууруулах донтнууд, биеэ үнэлэгчид, тэнэмлүүд
Эсэргүүцэгсэд	- (эрс)	- (эрс)	Террористууд, аллага үйлдэгчид, маф, гэмт бүлэглэлүүд, Герман, Орос, Италийн нацистууд, Английн мулзан толгойтнууд

Нийгмийн тодорхой хэсгийнхэнд хуулийн хүрээнд ажиллаж, амьдрах боломжоос илцү хуулиас гадуур амьдрах боломж олддог нь үнэн үү?

Боломж бүрэлдэхүйн онол бөгөөд хүмүүс хэм хэмжээ, үнэт зүйлсийн хүрээнд амьдралын зорилго, арга хэрэгслээ уялдуулж чадахаа больсон үед гэмт хэрэг үүсдэг гэж үздэг. Хүмүүс бусдын адил сайхан амьдрах хүсэлтэй боловч түүнийг хууль ёсны хүрээнд гүйцэлдүүлэх боломж байдаггүй. Энэхүү онолын хувьд Р.Мертоны үзэлд тулгуурлан үндэслэгдсэн боловч Клауорд ба Оулин нар хөгжүүлсэн байна. Залуучууд хар тамхи татах, гэмт хэрэгт өртөх, гэмт бүлэглэлд орох зэрэг нь тэд хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд боловсрол эзэмшиж, ажил төрөл эрхлэх боломжгүй байдагтай

холбоотой ажээ. Ийнхүү ялангуяа эмзэг болон маргиналь бүлгийн залуучуудын хүрээнд хуулиас гадуур амьдралын боломж бүрэлдэх үйл явцыг тайлбарлажээ.

Хүмүүс гаж зан үйлд суралцдаг уу?

Э.Сазерландын бүтээсэн онол бөгөөд гол үзэл баримтлал нь хүмүүс гэмт зан үйл бүхий хүмүүстэй байнга агаад удтал харилцаанд оролцсоны үндсэн дээр түүнд амжилттай суралцдаг. (D. Kendall, 209) Гэмт ертөнцийн хэм хэмжээ, үнэт зүйл, биеэ авч явах байдалд ялгаа бүхий харилцааны хүрээнд суралцдаг. Нэн ялангуяа өсвөр үе, залуучуудын хүрээнд энэ үйл явц маш хурц явагддаг. (Martin Marcus, Alan Daclin. 230)

- ❖ Хүмүүс гаж зан үйлд суралцдаг, түүнийг бусадтай харилцах явцад сурдаг.
- ❖ Гэмт зан үйлийг ихэвчлэн ойр дотно бүлгийн хүрээнд суралцдаг.
- ❖ Суралцана гэдгийн доор үйлдлийг гүйцэтгэх техник болон шууд үйлдэх сэдэл, залуурыг багтаадаг.
- ❖ Сэдэл ба залуур нь хуулийн кодекссыг тайлах байдлаар явагдах буюу суралцагч бие хүн шалтгааныг нь хүчирхийлэгчийн байр сууринаас хардаг.
- ❖ Гэмт хэргийн үргэлжлэх байдал, үр дагавар, дараалал, эрчмийн талаар ойлголттой болно. (фантаз)
- ❖ Гэмт хэрэгт суралцах үйл явц нь гэмт зан үйлийн болон хэвийн зан үйлийн харилцааны харьцуулалтан дээр явагддаг.

Судлаачдын дунд шорон бол нийгмийн бусад орчинтой харьцуулах аваас хүмүүс гэмт зан үйлд тасралтгүй бөгөөд эрчимтэй суралцдаг гол орчин гэх нь бий. Түүнчлэн гэмт хэрэгтнүүд болон гангстерүүд ихтэй ядуу дүүргийн хорооллууд, түүнчлэн ийм хүмүүс олноор ажиллаж амьдардаг худалдааны төв, захууд зэргийг онцолдог.

<i>Шигтгээ.</i>	<ul style="list-style-type: none">❖ <i>Нийгмээс бүрэн хийгээд хагас тусгаарлагдсан</i>❖ <i>Нийгмийн хяналтын (хууль ба ОНСБ) зүгээс өвөрмөц санхүүгийн хэргээс (ихэнх үндэстний хувьд хүндэтгэр болон хүнд зөрчилд цэцгүлдэг ба олон нийтийн буруушаалт)</i>❖ <i>Нийгэм сэтгэлзүйн хувьд эмзэг ба хөндцөр</i>❖ <i>Соёлын өвөрмөц загвар бүхий бүлэг (үнэт зүйлс, хэллэг, эталон)</i>❖ <i>Дотоод далд засаглал ба бүтэц хүчтэй</i>❖ <i>Сөрөг нийгэмшил (десоциализаци)</i>❖ <i>Аюулгүй байдлын баталгаа буюу хувь хүний хандлага хүчтэй</i>
-----------------	--

Эх сурвалж: Gefaengniss als Menschliches Umwelt, Hinweise fuer Sozial beruf. 2007



Гэмт хэрэг, гаж зан цйл нь ойр хүрээллийн хүмүүсийн бие биендээ тавих хяналт суларсны үр дүн мөн үү?

В.Реклесс болон Т.Кирси нарын онолоор гэмт хэрэг бол хүмүүсийн нийгэмшлийн үйл явц доголдсоны үр дүн бөгөөд нийгэмшлийн чухал агентуудын хяналт алдагдсаны өр төлөөс гэж үздэг. Тухайлбал гэр бүл, сүм хийд, хөрш, сургууль зэрэг агентуудын хяналт алдардаг. Ялангуяа гэмт хэрэгт өртөх шалтгаан нь гэр бүл, сургууль зэрэг анхдагч агентуудын хяналтын алдагдлын өр төлөөс болж илэрнэ. Нийгэмшлийн анхдагч агентуудын зүгээс тавих хяналтын чиг үүргүүд нь нийгэмшлийн ерөнхий жимийг зааж, тохируулдаг, хувь хүнийг бүлэг, нийгэмд нэгтгэдэг, гаж зан үйлд хяналт тавьдаг, зан үйлийн эталон, хэв загварыг бүтээдэг ажээ. Хүмүүс хоорондын хэлхээ холбоо хэдий бат бөх байна, гажуудал гарах магадлал төдий чинээ бага байна гэсэн үндэслэлийг бий болгодог. Хяналтын онол ёсоор хүн гэмт хэрэгт татагдан орох буюу гэмт хэрэгтэн болох үйл явц нь хэд хэдэн шат дамжина.

- ❖ Зан үйлийн гажуудлын энгийн үе шат (албан бус эерэг ба сөрөг санкци үгүй байх)
- ❖ Зан үйлийн хоёр дахь гажуудал (анхдагч агентын хяналтаас бүрэн гарах)
- ❖ Гажуудлын гүнзгийрэл буюу гэмт хэрэгтэн бие хүний зан үйл (албан ёсны хяналтын сөрөг үйлчлэл ба нөлөө)
- ❖ Төгс гэмт хэрэгтнүүд (*Beauty Criminals*)

Энэхүү онолын үүднээс хүмүүс гаж болон гэмт зан үйлд орохгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам нь анхдагч болон хоёрдогч бүлгүүдийн хүрээнд бий болдог. Энэ нь нэгдүгээрт, хүмүүс зөвшилцөлд орох, хоёрдугаарт, хамтын зөвшилцлөөс үүдэлтэй идэвхт байдлыг эрхэмлэх, гуравдугаарт, аливаад зөвшилцөх нь байнгын зуршил болох, дөрөвдүгээрт, хамтын зөвшилцлөөр бий болсон үнэт зүйл болон дүрэм горимонд итгэх зэрэг болно. (D. Kendall, 212)

Гэмт хийгээд гаж зан цйл нь хэн нэгэнд эргэн тойрны хүмүүсийнх нь зүгээс зүцсэн хаяг, шошгийн үр дүн мөн үү?

Энэ онолын гол төлөөлөгчдийн хувьд Н.Беккер, Э.Лемерт, Р.Кемпблесс Э.Гоффман болон Л. Розенхэн нарыг авч үзэж болно. Нийгэм орчны зүгээс хэн нэгэнд энэ бол гаж зан үйлтэн, эсвэл гэмт хэрэгтэн гэж хаяг наах үйл явц нь анхдагч, хоёрдогч гажуудлыг бий болгодог. Улмаар гэмт хэрэгтнүүд болон гаж зан үйлтнүүд төрөн гардаг гэж үздэг шүүмжлэлт социологийн онол юм. Гэмт хэрэгтэн болоход түлхэж буй гол хүчин зүйл нь «гэмт хэрэг үйлдэгчийн өөрийн итгэл үнэмшил» бөгөөд ийм итгэл үнэмшил хаяг наах явцад бий болдог. Нийгэмд ийнхүү бусдыг гэмтэн гэсэн хаяг наах үйл явц нь мэдээж хэрэг социаль хүчин зүйлүүдээр нөхцөлддөг байна. Арьс өнгө, угсаа, нийгмийн байр суурь, шашин шүтлэг, цаашилбал хүйс, нас, зэрэг нь хүмүүс бие биенээ гэмт хэрэгтэн болгож төлөвшүүлэх, гэмтэн гэж хаяг наах үндэс нь болдог ажээ. Социологичдын дунд олон сонирхолтой судалгаа

байдаг бөгөөд тухайлбал Р.Кемпблессийн дунд сургуулийн хөвгүүдийн Роутнекс болон Сэйнтс гэсэн хоёр бүлэг дээр явуулсан ба багш нар, сургуулийн удирдлагын зүгээс Роутнексүүдэд болохгүй, хэцүү хүүхдүүд гэсэн хаягийг байнга зүүж байсан бол хэрэг дээрээ Сэйнтсүүд нь хичээл таслах, архи уух, тамхи татах, хулгай хийх зэргээр хэцүү хүүхдүүдийн авирыг гаргадаг байжээ. Гэтэл Сэйнтсүүдийн эцэг, эхчүүд нь сургууль дээр илүү нэр хүнд бүхий хүмүүс болохыг ажиглалтын явцад тогтоосон байна. Мөн Лемертийн судалгаагаар гудманд хүү архи, тамхи хэрэглэх бөгөөд эхний удаад түүнийг хэн ч гаж зантан гэж анзаардаггүй бөгөөд хүү ч өөрийгөө тэгж үздэггүй байна. Энэ нь анхдагч гажуудал ба харин дараагийн удаа тийм зан үйлийг хүмүүс мэдсний үндсэн дээр хүүтэй хэцүү хүүхэд гэж хаяглан харьцах ба хүү аажмаар девиант буюу гаж зан үйлтэн гэдэгтээ итгэлтэй болдог байна. Үүнийг хоёрдогч гажуудал хэмээжээ. (D. Kendall, 241)

Гэмт хэрэг, гажуудал нь нийгмийн чинээлэг хэсгийнхэн болон ядуусын хоорондын зөрчилтэй холбоотой юу?

Энэхүү онол нь К.Марксын ангийн зөрчил, капиталист тогтолцооны мөлжигч мөн чанарын тухай онолын үзэл баримтлалаас үүдэлтэй болно. Хүн амын цөөнх нь нийгмийн баялгийг хуримтлуулж, харин олонх нь ядуурал, гуйланчлалд нэрвэгдэх нь гэмт хэрэг, гажуудлын нийгмийн үндсэн учир шалтгаан гээд ийм үед гэмт хэргийн тоо хэмжээ нь хүн амын тооноос ч үлэмж илүү байдлаар өсөн тэлэх болно хэмээн Маркс тэмдэглэж байв. Харин энэ үзэл санаа нь социологит гэмт хэрэг болон гажуудлыг тайлбарлах зөрчлийн онолын урсгалыг буй болгосон билээ. Ерөнхийдөө баян чинээлэг болон эрх мэдэлтэй хүмүүс өөрт тааламжтай дүрмийг зохиох хандлага байх бөгөөд тэгэхээр гэмт хэрэг болон бусад төрлийн гажуудал нь зөвхөн статус болон хөрөнгө чинээ доогуур давхраа, ангийнханд хамаатай зүйл гэж үздэг. Товчхондоо гэмт хэрэг бол чинээлэг хэсгийнхнээс доодчуулд наасан хаяг, шошиг мөн хэмээдэг. Марксаас угшилтай орчин үеийн энэхүү шүүмжлэлт онолын хүрээнд зарим тодорхой чиглэлүүд буй болсон бөгөөд тухайлбал Британий реализм болон радикал онолыг нэрлэж болох юм. Британий реализмын хувьд гэмт хэрэгт өртөх хамгийн их магадлалтай хүмүүс бол ажилчин ангийнхан бөгөөд ажилчин ангийн болон ядуу ажилчдын гэр бүл, хүүхдүүд бол нийгмийн ажилтны ажиллах гол талбар мөн. Нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн дунд ерөнхийдөө ажилчин ангийн туршлага ноёрхож байдаг ажээ. Харин радикал онолын хувьд гэмт хэрэг бол баян чинээлэг хийгээд ядуу хүмүүсийн хоорондын зөрчлөөс үүдэлтэй. Ядуу хүмүүс болон баян чинээлэг хүмүүс нь өөрийн байр суурьтай холбоотойгоор гэмт хэрэгт холбогддог. Ядуучууд амьдралын боломж хомс тул суурь хэрэгцээгээ хангахын тулд гэмт хэрэгт өртдөг бол чинээлэг хэсгийнхэн статусаа хадгалан үлдэхийн тулд гэмт хэрэг хийдэг байна.



? **Хяналтын асуултууд:**

1. Нийгмийн дэг ёс (social order) гэж юу вэ? Ойлголтын гол агуулга нь юу вэ?
2. Нийгмийн гаж үзэгдэл гэж юу вэ?
3. Нийгэмд байгаа үзэгдлүүдийг гаж юмуу хэвийн гэж үзэх социаль үндэслэл нь юу вэ?
4. Нийгмүүдэд соёлын онцлогоос нь хамааран дэг ёс ялгаатай төлөвшдөг талаар тайлбар өгнө үү?
5. Нийгмийн хяналтын тогтолцоог социологичид ямар хүрээнд авч үздэг вэ?
6. Нийгмийн хориг арга хэмжээ (санкци) ял шийтгэлээр хязгаарлагдах уу? Үгүй бол социологид ямар хүрээнд авч үздэг вэ?
7. Гэмт хэрэг нийгмийн гаж үзэгдлийн бусад хэлбэрүүдээс ямар онцлог шинээр ялгарах вэ?
8. Гаж зан үйлд хүний ямар зан авир, араншингууд багтах вэ? Яагаад?
9. Нийгмийн гаж үзэгдлүүдэд нийгэм ямар хариу үйлчлэл үзүүлдэг вэ?
10. Гэмт хэргийг социологи ямар дурангаар хардаг вэ? Түүний гол ялгарах онцлогыг заана уу?
11. Гэмт хэрэг төрөн гарах нийгмийн социаль шалтгаануудыг бусдаас (сэтгэцийн, биологийн, газар нутгийн) ялган тайлбарлана уу?

📖 **Эх сурвалж:**

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон
3. Хууль зүйн социологи. (2003), Ред. В.А.Глазырин, УБ
4. Richard T.Shaefer, Robert P.Lamm, (1995), Sociology, Chicago Press
5. Kendall D. (1997), Sociology in our times
6. Martin Marcus, Alan Daclin. (2000), Success in sociology. London, Bath Press
7. Дюркхайм Э. (1995), Социология, Предмет, её значение
8. Дюркхайм Э. (1991), Разделение общественного труда
9. Түмэннаст Г. (2006), Шилжилтийн үеийн Монголын нийгэм дэх гэмт хэргийн өсөлт, цэцэглэлтийн нийгмийн хүчин зүйлс, социологийн эрэл хайгуул. Шинэ Толь сэтгүүл

📖 **Унших материал:**

1. Смелзер Н (2001), Социологи, УБ
2. Гидденс А (2006), Социологи, УБ, Адмон

Сэдэв-2: Гэмт хэрэг ба ял шийтгэл, гавьяа ба шагнал (П.Сорокиний² социологийн шинжилгээнд тулгуурлан хэлэлцэх) (сем-2 цаг)

Хичээлийн зорилго: Социологийн ухаанд нийгмийн гаж үзэгдлийг тайлбарлах хүрээг тодорхойлж, нийгмийн гаж үзэгдэлд хандах социологийн аргазүйн үндсийг эзэмшихэд энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Хүний зан үйл, үйлдэл (акт)
- ❖ Гадаад араншин
- ❖ Сэтгэцийн үйл хөдлөл
- ❖ Гэмт хэрэг
- ❖ Алдар гавьяа
- ❖ Ял шийтгэл
- ❖ Шагнал
- ❖ Гэмт хэргийн болон гавьяат үйлийн элемент
- ❖ Ял шийтгэл ба шагналын шаблончлол
- ❖ Ял шийтгэл, шагналын нийгмийн үүрэг

Сэдвийн агуулга:

- ❖ Нийгмийн дундаж хандлага, эталон
- ❖ Хүний зан үйл хоёр чиглэлд ялгарах ба туйлчлах
- ❖ Хэвийн үйлдэл бидний ухамсарт тусах буюу бид хариу үйлдэл үзүүлэх нь
- ❖ Гэмт хэрэг ба алдар гавьяа зэрэгцсэн ойлголт болох нь
- ❖ Ял шийтгэл, гавьяа шагналыг нийгмийн зүгээс шаблончлох нь
- ❖ Ял шийтгэл ба шагнал хүний зан үйлд нөлөөлөх нь
- ❖ Ял шийтгэл ба шагналын нийгмийн үүрэг (сурган хүмүүжүүлэх болон бусад)
- ❖ Нийгмийн хориг арга хэмжээний (санкцын) социаль бүлэг хооронд гүйцэтгэх үүрэг

Санал болгож байгаа арга:

1. Мэтгэлцээн
2. Тохиолдол шинжлэх

2. Орос, Америкийн нэрт социологич, болшевик хувьсгалын дараа Америкт цагаачлан гарсан бөгөөд Америкийн болон барууны социологийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан юм. Харвардын их суругуулийн социологийн салбарын тэргүүлэгч, Америкийн Социологийн Холбооны дэд ерөнхийлөгч байлаа.



Харилцан үйлдэл социологийн судлагдахуун болох нь

Сорокин социологийн сонгодог сэтгэгчийн хувьд уг шинжлэх ухааны институтчилалд томоохон хувь нэмэр оруулсан хүн юм. Юуны өмнө социологийн судлах зүйлийн асуудалд гүнзгий шинжилгээ хийж, хүний үйлдэл, үйл ажиллагааг социологийн чухал судлагдахууны хувьд сайтар эргэцүүлжээ. Тэрээр сэтгэцийн үйл хөдлөл хийгээд гадаад араншин гэсэн ойлголтуудыг ашигласан бөгөөд эдгээр нь хүний зан үйлийн элементүүд болдог. Нэг хүний сэтгэцийн үйл хөдлөл хийгээд гадаад араншин нь нөгөө хүний социаль үйлдлийн учир шалтгаан, харилцан үйлдэл оршин байх үндэс болдог талаар, тэгээд энэ нь социологийн судлах зүйлийн цөм болох тухай «Социологийн тогтолцоо» бүтээлийн I ботьдоо эргэцүүлжээ. Түүнчлэн социологи нь социаль хийгээд организмын дээрх үзэгдлийн ухаан бөгөөд түүний судалгааны цөмд нийгмийн харилцан үйлдэл байхыг онцолсон байна.

Шигтгээ. Харилцан үйлдлийн тодорхой хэлбэрцүд болвоос цлэмж олон. Насанд хүрэгчид болон хцүхдийн, хохирогч болон гэмт хэрэгтний, эхлэгч болон цргэлжлцүлэгчийн, эрэгтэй ба эмэгтэйн, цүлдвэрлэгч ба ажилчны гээд... Нийгмийн бодит амьдрал дээр тэдгээр хэлбэрцүд нь тоо томшгцү олон. Эдгээр хэлбэрцүдийг тоочин бичиглэх боломжгцү. Эндээс нэг зцү ёсны асуудал гарч ирэх ба энэ нь «Эдгээр тодорхой агаад хязгааргцү олон хэлбэрийг, цөөн тооны хангалттай ухагдахуунд захируулан тайлбарлах хэрэгтэй юм биш цү?» Хэрвээ цүгдийг нь биш юм бол ядаж харилцан үйлдлийн цндсэн хэлбэрцүдийг ийнхцү авч цзэх хэрэгтэй байна.

Эх сурвалж: Сорокин П.А. Система социологий. Том I, II, Пер. с англ. М.: Политиздат, 1995

Харилцан үйлдлийн үндсэн элементүүд нь 1/ хувь хүмүүс, 2/ тэдгээрийн үйлдлүүд, 3/ харилцан үйлдлийн дамжуулагч бөгөөд тэдгээрт тулгуурлан харилцан үйлдлийн мөн чанарт шинжилгээ хийх боломжтой. Тухайлбал, нийгмийн харилцан үйлдлийг түүнд оролцож байгаа хүний тоо, чанар, хувь хүмүүсийн гүйцэтгэж байгаа үйлдлийн шинж чанараас, дамжуулагчийн шинж чанараас хамааруулан ангилсан байна. Хүний нийгмийн үйлдэл, үйл ажиллагаанд хийсэн түүний дүн шинжилгээнд нийгмийн гажуудлын тухай хайгуул томоохон байрыг эзэлнэ. Нийгмийн гаж үзэгдлийн талаар «Хүн, иргэншил, нийгэм» хэмээх бүтээлдээ эргэцүүлсэн ба түүнийг нийгмийн үйлдэл болохын хувьд, гэхдээ нийгмийн харилцан үйлдлийн хүрээнд шинжилсэн байна. Гэмт хэрэг бол зүгээр нэг талын үйлдэл бус, харин нийгмийн харилцан үйлдэл, энэ утгаараа социологи гэмт хэргийг нэг талын үйлдэл болон түүнд нийгмийн бусад гишүүдийн (нийгмийн) зүгээс үзүүлж байгаа хариу үйлдлийн хувьд цогцоор нь тайлбарладаг. Үүгээр зогсохгүй гэмт хэргийн социаль мөн

чанарыг илүү тодорхой болгохын тулд эерэг гажуудал болсон ариун журамтай харьцуулан, тэдгээрт нийгмийн зүгээс үзүүлэх хариу үйлдлийг тайлбарласан байна. Сорокин нийгмийн гажуудлын хоёр хэлбэр болсон ариун журам, сайн үйлс болон гэмт хэрэг, тэдгээрт нийгмийн зүгээс өгөх хариу үйлдлүүдийг буюу шагнал болон шийтгэлийг социологийн хандлагаар тайлбарласан байна. Социологийн шинжлэх ухааныг нэгдүгээрт, нийгмийн тухай ерөнхий сургаал, хоёрдугаарт, нийгмийн механик, гуравдугаарт, нийгмийн генетик, дөрөвдүгээрт, нийгмийн бодлого гэсэн дөрвөн үндсэн түвшинд хуваасан агаад түүнийхээр нийгмийн механик нь нийгмийн үйлдэл, харилцан үйлдлийг (тухайлбал, гэмт хэрэг ба шийтгэл, гавьяа ба шагналыг) органик болон органик бус ертөнцийн бусад үйлдэл, харилцан үйлдлийн хэлбэрүүдээс ялган тодорхойлоход чиглэх бол нийгмийн генетик нь гол социаль институтүүдийн (тухайлбал эрхзүйн) хөгжил, чиг үүргийг тайлбарлах учиртай. Харин нийгмийн бодлого нь социологийн мэдлэгт тулгуурлан хүний аз жаргал, сайн сайхны төлөө шийдлүүдийг боловсруулахад чиглэх болно. (Сорокин П.А, 1992,29)

Хүмүүсийн үйлдэл бидний сэтгэлийн цйл хөдлөлд хэрхэн тусч байдаг бэ?

Сорокин бусдын үйлдэл бидэнд гурван янзын байдлаар тусах буюу бид тэдгээрийг харилцан адилгүй байдлаар тусган ойлгож байдаг гэсэн байна.

Байвал зохих зүйл гэсэн байдлаар бидэнд тусч байдаг үйлдэл. Бусдын ийм үйлдлүүд бидний сэтгэлзүйн үйл хөдлөлд жигшин зэвүүцэх, эсвэл хайр хүндлэл төрөхийн аль ч байдлыг үүсгэхгүй. Зүгээр л байх ёстой зүйл л гэхээс өөрөөр хэлэхэд хэцүү тийм байдлаар буудаг. Тиймээс байх ёстой, хэвийн л зүйл болж байдаг.

Бусдын зүгээс онцлон дэмжүүштэй зүйлүүдийг үйлдэж байх нь бий. Бидний сэтгэлзүйн үйл хөдлөл нь бусдын тийм үйлдэлд талархалтай хандаж байдаг. Тэдгээрийг бид хүсэмжлэх, талархалтай хандах, түүнийг дэмжин сайшаамаар мэдрэмж бий болдог.

Хориглон үгүйсгэм үйлдлүүд хийгээд зан үйлийг хүмүүс гаргаж байдаг. Тийм үйлдлүүд, тэдний гадаад араншинд бид дургүйцэх, зэвүүцэн буруушаамаар мэдрэмж буй болдог.

Сорокин бусдын үйлдэл бидний ухамсарт хэрхэн тусдаг талаар авч үзсний дараа дээрх гурван хэв маягт харгалзах жишиг ойлголтуудыг дурдсан байна. Тэрээр дээр дурдсан сэтгэлийн үйл хөдлөлүүдэд социологийн шинжилгээ хийхийн тулд нийгмийн үйлдэл болон хариу



үйлдлийн жишээнүүдийг өөрийн судалгаандаа ашигласан байдаг. Эхний тохиолдолд бусдаар хүлээн зөвшөөрөгдсөн үйлдлийг авч үзэж болох ба харин түүнд хүмүүсийн зүгээс өгөх хариу үйлдлүүдийн хувьд байвал зохих хариу үйлдлийг судлах боломжтой ажээ. Харин онцлон дэмжүүштэй мэдрэмжийг төрүүлж байгаа үйлдлийн жишээгээр гавьяа буюу сайн үйлсийг, түүнд хүмүүсийн зүгээс үзүүлэх хариу үйлдлийн хувьд шагналыг авч үзсэн байна. Эцэст нь хориглон үгүйсгэм сэтгэлийн үйл хөдлөлийг буй болгож байгаа нийгмийн үйлдлийн жишээнд гэмт хэргийг, харин түүнд үзүүлж байгаа хариу үйлдлийн жишгээр шийтгэлийг тус бүр авч шинжилсэн байдаг.

Тэрээр юуны өмнө гэмт хэрэг хэмээх ойлголтыг өмнө нь авч үзсэн судлаачдын үзэл баримтлал тодорхойлолтод шүүмжлэл өгөх замаар социологийн үүднээс эргэцүүлжээ.

Шигтгээ. *Гэмт хэргийг уламжлалт ойлголтоор эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, тухайлбал эрцүгийн кодексийг зөрчсөн явдал гээд хялбархан тодорхойлж байдаг. Энэ нь Сорокиний хувьд эрх зүйн энэхүү тодорхойлолт нь догматик хийгээд шаблончлолын үүднээс хандах байдлыг бий болгож байгаа хэрэг бөгөөд гэмт хэрэг бол түүнээс ч илүү нарийн төвөгтэй социаль үзэгдэл билээ. Олонх судлаачид дээрхийн адил хялбархан тодорхойлолт бий болгоод цаашилбал гэмт хэргийг эрхзүйн хэм хэмжээний бусад төрлүүдээс ялгах оролдлого хийж байдгийг тус бүрийн хувьд Сорокин няцаажээ.*

а/ Нэлээд хэсэг эрдэмтэд эрцүгийн хэм хэмжээг зөрчих хувьдаа гэмт хэргийн үйлдэл нь юуны түрүүнд хүний хэрэгцээг ядууруулж байна хэмээн мэтгэж байна. Энэ утгаараа гэмт хэрэг хэмээн үзэж байгаа аль ч үйлдэл нь бүхий л эрцүгийн кодуудад гэмт хэрэг хэмээн үзэгдэж чадах уу? Ийм үйлдлийн жишээгээр хүний амь хөнөөхийг авч үзэж болох уу? Эрцүгийн янз бүрийн кодуудад гэмт хэрэг хэмээн нэрлэж байгаа бүхий л үйлдлүүд нь хэзээд, хаана ч гэмт гэж нэрлэгдэж чадахгүй. Тэр бүү хэл аллага ч тэгж чаддаггүй. Хэрэв соёлуудын дунд аль нэг үйлдэл нь агуулгаараа нэгэн адил гэмт хэрэг гэж үзэгддэг бол тэр ялгаатай байдал байхгүй байх байсан. Аллага ч өөрийн агуулгаар хэзээд, хаана ч гэмт хэрэг л байхсан. Ерөнхийд нь хэлэхэд хүнийг хөнөөх хийгээд аврах, үнэн ба худал ярих, өршөөх хийгээд цээрлүүлэх, үзэн ядах болоод дурлах, бэлгийн хүсэлд албадах болоод тэвчих зэрэг бүхий л үйлдлүүд нь тэднийг хэн үйлдсэн, хэний эсрэг үйлдсэн, ямар нөхцөлд гүйцэлдүүлсэн зэргээсээ хамаараад янз бүрийн эрхзүйн кодуудад гэмт хэрэг болоод гэмт үйл биш гэхчлэн адилгүй байсаар ирсэн бөгөөд байсаар байна.

б/ Эрцүгийн хэм хэмжээг зөрчих үзэгдлийг олон эрдэмтэд бусад зөрчлөөс ялгахын тулд хувь хүний юм уу, эсвэл бүлгийн ашиг сонирхлыг үлэмж ихээр зөрчих явдал буюу тэдгээрт үлэмж хор хөнөөлтэй, аюултай байх шинж чанарыг нь дэвшүүлдэг. Энд бас л учир дутагдал буй болох ба үнэн хэрэгтээ үлэмж аюултай, хор хөнөөлтэй, эсвэл эрх ашгийг нь ноцтой зөрчих гэдэг хэрхэн батлагдаж байгаа вэ? Брахман хүн сүү худалдаж авахад аюултай шинж чанар хаана нь агуулагдаж байна вэ? Ямар ч аюултай шинж үгүй. Гэвч энэ нь гэмт хэрэгт тооцогдох бөгөөд тэгсэн нэгнийг эгнээнээс хөөж шутрагийн түвшинд түлхэн унагах ба хамгийн хүнд шийтгэлийн нэгийг ноогдуулна.



Шигтгээ. Энэ тохиолдолд брахман хүн бусад кастын хүний амийг хөнөөхөөс илүү аюултай гэж үзэх ба харин сүцлийн тохиолдолд ямар нэг шийтгэлгүй бөгөөд гэмтэнд тооцохгүй. Тэгэхээр гэмт хэргийн хор хөнөөл, аюулын шинж нь соёлуудын хувьд харилцан адилгүй.

Гэмт хэргийн талаарх Сорокиний эргэцүүллийг авч үзэх нь

в/ Эрхзүйн хэм хэмжээ зөрчих үзэгдлийн мөн чанарыг тодорхойлохдоо бас нэг хэсэг нь гэмт хэрэг үйлдэгчийн дотоод төлөв байдал гэсэн ухагдахуунд найддаг. Гэмт хэрэг үйлдэгчид сэтгэлзүйн дотоод ямар үйл явц болж өнгөрдөг вэ? Тэр нь бүхий л гэмт хэргүүдийн хувьд тодорхойлох чанар байж чадах уу? Тухайбал профессор Прусторослевийн хэлсэн «гэмт хэргийн дотоод төлөв байдал бол гэмт хэрэгтний хувьд буруушаан үзэм, оюун санаа, мэдрэмж, хүсэл зоригийн тийм хүний мөс муутай дотоод төлөв» гэснийг Сорокин жишээ болгон аваад гэмт этгээдийн толгойд ямар процесс болж өнгөрсөн бэ? Нэгэнтээ тэр бурхан тэнгэрийн зөршөөрлөөр үйлдсэн үү? гэсэн асуултыг тавьжээ. Хэм хэмжээг тогтоогч нь гэмт хэрэгтний сэтгэлзүйн дотоодод болж өнгөрсөн зүйлсийг, бас гэмт үйлдэл бүрийн хувьд гэмтний оюун санаа, утга холбогдлыг эргэцүүлж чадахгүй билээ. Тиймээс хүний яс чанар гэсэн хэмжүүр гэмт хэргийн төгс шалгуур байх боломжгүй ажээ.

г/ Эрхзүйн зөрчлийг илэрхийлэх нэг мөн чанар нь нийгмийн шинжлэх ухаантнуудын хувьд үндэслэгээ болгодог тухайн үзэгдлийн ялгарах шинж чанар (*differentia specifica*) юм. Энэ нь эрцүгийн гэмийн хувьд шийтгэл байдаг талаар хэлцгээж байна. Харин үүнд хоёр чиглэлд хариу өгөх ёстой. Нэгдүгээрт, гэмт хэрэг нь зөвхөн шийтгэлтэй байхын хувьд иргэнийхээс ялгарах гэнэ. Олон судлаачдын хувьд иргэний эрхийн зөрчигдөл нь өөртөө шийтгэлийг агуулах нь түүний гол шинж чанар бус, харин өмч хөрөнгийн хорхирлоор илэрнэ. Тиймээс өмч хөрөнгийн хохирол бол шийтгэлийг урин дуудахгүй гэнэ. Эд хөрөнгийн шийтгэл нь шийтгэл бус гэж үү? Тэдгээр нь нэлэнхүйдээ ядахад баривчлах юмуу, эсвэл богино хугацаагаар хорихыг бодвол, илүүтэй энэрэнгүй ханддаг явдал биш үү?

Энэ тохиолдолд. Тиймээс иргэний болон эрцүгийн хэм хэмжээний зөрчигдөлд сүцлийнх нь шийтгэлд чиглэдэг гэдгээр гол ялгаа гарч ирэхгүй байна. Хоёрдугаарт, гэм хийсэн нэгэнд шийтгэлийг ноогдуулахдаа албадлага хэрэглэдэг ба боломж, эрхийг нь хасах, өршөөх, буруушаах, ер нь бүхий л хор хохирол амсуулах байдлаар цээрлүүлдэг.

Шигтгээ. *Гэвч шийтгэл нь амьдрал дээр эдгээр үйлдлүүдийн бүхий л хэлбэр байж чадахгүй. Хэн нэгэн, хэн нэгэнд ямар нэг шалтгаангүйгээр хор хохирол амсуулж байдаг ба хараан зүхэж, зодож занчиж байх нь бий. Тиймээс албадан хор хөнөөл учруулж байгаа бүхэн гэмтэнд үзүүлж буй зэм биш.*

Гэмт хэргийн талаарх Сорокиний эргэцүүллийг авч үзэх нь

Гэмт хэрэг бол шийтгэл гэдэг ойлголтоос хамааралтайгаар бүрэлдэж буй ойлголт, харин шийтгэл нь эхний ээлжинд гэмт хэргээс хамааран тодорхойлогдоно. Гэхдээ хамгийн гол нь бидний дээр үзсэнчлэн гагцхүү бидэнд учруулсан хэн нэгний үйлдлийн хариуд бидэнд энэ байж болохгүй, хоригловол зохино гэсэн сэтгэлийн үйл хөдлөл буй болж, түүний дагуу хариу үйлдэл болсон шийтгэлийг үзүүлж байгаа, тийм социаль харилцан үйлдэл болохын хувьд тодорхойлогдоно.

Эх сурвалж: Сорокин П.А. Человек, цивилизация, общество, Общ. ред. сост. и предисл. А. Ю. Согомонов: Пер. с англ. М.: Политиздат, 1992

Шигтгээ. *«Гэмт хэргийн талаар эргэцүүлэх явцад шийтгэлийн талаар эргэцүүлэхэд хүрнэ, харин шийтгэл нь зүй ёсоор шагналтай хамааралтай байх бөгөөд шагналын тухай социологийн эргэцүүлэл нь улмаар гэмт хэрэгтэй зэрэгцэн орших гавьяа буюу ариун журамт үйлс рүү хүрч очно» хэмээн Сорокин тэмдэглэжээ. Тэрээр цааш нь өнөөг хүртэл нийгэм судлаачид болон эрхзүйчдийн хувьд «Гэмт хэрэг ба шийтгэл» хэмээх нийгмийн амьдралын хос тулгуур ойлголт нь ихээхэн судлагдаж ирсэн боловч, харин түүнтэй эрх тэгш яривал зохих нийгмийн амьдралын нөгөө талын хос ойлголт болсон «Гавьяа ба шагнал» нь олонх социологич, эрхзүйчдийн хувьд танил бус гэсэн байгаа нь учир дутагдалтайг заасан байна. Түүний үзснээр шийтгэлийн эрхзүй чухал байдгийн адил шагналын эрхзүй чухалд байх ёстой гэсэн үзлийг дэвшүүлсэн юм.*

Сорокиний үзлээр гавьяа буюу ариун журам нь дараах онцлог шинжцүдээр тодорхойлогдоно.

а/ Байвал зохих зүйл гэсэн бидний сэтгэлийн үйл хөдлөл, мэдрэмжтэй зөрчилдөхгүй. Үүний ачаар тэрхүү үйлдлүүд нь байнга л ёс суртахууны хувьд үнэ цэнтэй байж чаддаг. Ёс суртахууны хувьд тухайн соёлын дотор үгүйсгэгдэж байдаг, гэмт хэрэгтэй эсрэгцэх хүчийг олж авдаг.



Шигтгээ. *Тэрээр зан үйлийн шаблончлолд байвал зохих зүйл гэсэн ерөнхий утгаар ангилалд багтах ба шударга ёсны хэм хэмжээ болон хэр хэмжээг агуулж байдаг. Байвал зохих зүйл гэдэг нь шударга ёсонд утга дүйнэ. Тэгэхдээ гавьяа нь шударга ёсны хэвийн хэм хэмжээнээс дээгүүр түвшинг илэрхийлэх болно.*

Гавьяа болон ариун журамт үйлийн талаарх Сорокиний эргэцүүцлийг авч үзэх нь

б/ Гавьяат үйлсүүд нь сайн үйлийн хэвийн хэмжээнээс халин гарсан, түүнээс дээгүүр түвшинг илэрхийлнэ. Энэ мөн чанар нь иймэрхүү үйлдлүүдийг хийхээр эрмэлзэх, хичээн зүтгэх байдал болон хүмүүст зайлшгүй үйлдэх зүйл мэт тооцож болохгүй байдлаар илэрнэ.

в/ Гуравдах мөн чанар нь түүний сайн дурын шинжтэйд байдаг буюу ийм байдлаар гүйцэлддэгт оршино.

Гавьяа буюу ариун журмын үйлсүүдийн жишээг эртний нийгмүүдээс аваад олонтаа олж болох бөгөөд басхүү нийгмийн соёлын тодорхой орчин, бас түүхэн цаг үеийн байдлаар нөхцөлдөн түүнийг нэг мөр тодорхойлох шаблон, кодчиллол байгаагүйг ойлгох хэрэгтэй ажээ.

Гэмт хэргийг субъектээр нь, объектоор нь (төрийн, гэр бүлийн, шашны болон бусад), үйлдлийн шинжээр нь, хамрах түвшингээр нь (хувийн болон нийгмийн) гэх мэтээр ангилдаг бол харин гавьяат үйлийг дэмжигч-идэвхтэй үйлдэл (хэн нэгний хэрэгцээг хангах буюу жишээ нь асрамжийн газраас хүчхэд өргөж авах, хүмүүнлэгийн хандив өргөх), үгүйсгэгч-идэвхгүй (ямар нэг зүйлээс татгалзах, жишээ нь гэрлэлтээс татгалзах нь шашны зарим урсгалд хэдийнээс ариун журам байсан), идэвхтэй-тэвчигч (ямар нэг үл тэвчим зүйлд тэвчээр заан гарах үйлдэл) гэсэн гурван чиглэлд ангилж болох ажээ.

Эх сурвалж: Сорокин П.А. Человек, цивилизация, общество, Общ. ред. сост. и предисл. А. Ю. Согомонов: Пер. с англ. М.: Политиздат, 1992

Шийтгэл ба шагналын тухай

«Энгийнээр хэлэхэд шийтгэл бол үйлдэл бөгөөд бидний сэтгэлийн үйл хөдлөлд хориглом мэдрэмжийг төрүүлж байгаа гэмт үйлдлүүдэд нийгмийн зүгээс хариу барьж байгаа тийм үйлдэл, яг үүний нэгэн адил шагнал бол үйлдэл, гэхдээ бидэнд бахдан сайшаам сэтгэлийг өдөөж байдаг ариун журам, алдар гавьяанд өгч буй нийгмийн хариу үйлдэл мөн» хэмээн Сорокин тэмдэглэсэн байна. (Сорокин П.А, 91) Бүхий л шагнал болон шийтгэлийн хэлбэрүүд нь өөртөө ямар нэг биет болон сэтгэлзүйн үйлдлүүдийг багтааж байдаг ажээ. Түүний үзснээр шийтгэл нь гэмт хэрэгтэнд зовлон нажид,

гачигдлыг бий болгоход чиглэдэг бол харин шагнал нь сэтгэл ханамж, баяр бахдлыг бий болгоход чиглэдэг байна. Гэмтэнд учруулах шийтгэлийн зовлон нажид нь янз бүрийн түвшинд (зүгээр үл ойшоох, зэмлэх, донгодох, үгээр доромжлох, өмчийн эрхийг хасах, баривчлах, жанчих, гэмтээх, амь насыг нь хөнөөх) байж болох бөгөөд энэ нь уг хэргийн бузар, жигшүүрт байдлын хэр хэмжээнээс хамаарна, ийм байдлаар шагналын баяр бахдал нь янз бүрийн түвшинд (ердийнөөр онцлон үзэх, үгээр магтах, эд өлгийн зүйлээр урамшуулах, магтан гайхах, хүндэтгэл үзүүлэх, бишрэн хүндлэх, мэхийх) байх ба энэ нь ариун журмын өндрөөс хамаардаг байна. (Сорокин П.А, 1995, 95)

Шийтгэл ба шагналыг социаль үйлдэл болохынх нь хувьд тэдгээрийн субъект, объект, дээрх үйлдлийг өөртөө хаяглан хүртэгч (адресат), мөн дестинатор буюу тэдгээрийг хэрэглэж байгаа (тухайлбал, ариун журмын төлөө болон гэмт хэргийн эсрэг) гол утга учир гэсэн гурван элементийг авч үзсэн байдаг.

Социаль үйлдэл болох шийтгэл болон шагнал нь ямар элементүүдийг агуулдаг вэ?

- а) Нийгмийн үйлдэл болох шийтгэл болон шагналын субъектүүдийн доор тэдгээрийг үйлдэж байгаа янз бүрийн үйлдэгчдийг ойлгох ба гэхдээ эдгээр нь 1/ ер бусын буюу биднээс дээгүүр оршихуй (бурхан, чанагуух, оюун, уг удам, дээдсийн оюун санаа, сахиусууд, албин чөтгөр), 2/ бидний оршихуйд хамаарах зүйлс (хүмүүс, амьтад, ургамал, амьгүй зүйлс) болон тодорхой нэгдмэл хийгээд хийсвэр бүлгүүд багтах ажээ.
- б) Нийгмийн үйлдэл болох шийтгэл болон шагналын объектод харин сэтгэгч маань янз бүрийн зан авир, гадаад илрэл, эс үйлдэл, үйлдлүүдийг багтааж байгаа зан үйлийг ойлгосон билээ. Товчхондоо, дээр дурдсан субъектүүдийн зүгээс гадаад үйл байдлаар нь илэрч байгаа тэр зүйлийг объект гэж ойлгож байна.
- в) Шийтгэл ба шагналын үйлдлийг өөртөө хаяглан хүртэгч гэдэг нь шийтгүүлэгч болон шагнуулагч билээ. Өөрөөр хэлбэл гэм үйлдсэн, юмуу эсвэл гавьяа байгуулсан хүмүүс юм.
- г) Шийтгэл болон шагналыг чухам юуны тулд үйлддэг вэ? гэсэн асуултад, мөн тэдгээр нь ямар мөн чанартай болох талаар энд эргэцүүлэх ёстой ба үйлдлийн мөн чанарын асуудал орно.

Шийтгэл ба шагналууд нийгэмд ямар цэрэг гүйцэтгэдэг вэ?

Шийтгэлийн хүний зан үйлд үзүүлэх нөлөөллийн талаар дээрээс судлаачид анхаарч ирсэн бөгөөд харин шагналын асуудал судалгааны түвшинд тийм ч их хэлцэгдэж байгаагүй талаар Сорокин тэмдэглэсэн юм. Ерөнхийдөө шийтгэл болон шагналын социаль амьдралд гүйцэтгэх хамгийн эхний чиг үүрэг бол мэдээж хүний зан үйлд үзүүлэх нөлөө билээ. Тэгэхдээ зан үйлд үзүүлэх сэдэлжилтийн нөлөөг тодорхойлох хэрэгтэй ажээ. Тэрээр өөрийн шинжилгээндээ эл асуудлыг нарийвчлан гаргахын тулд дараах гурван асуудлыг тайлбарлах шаардлагатай хэмээн үзэж байв.



1) Ямар нэгэн хүнд аль нэг шагнал болон шийтгэл нь ялгаатай байдлаар нөлөөлж байгаа нь юугаар нөхцөлдөж байгааг, 2) Янз бүрийн хүмүүст аль нэг шагнал болон шийтгэл нь ялгаатай байдлаар нөлөөлж байгаа нь юугаар нөхцөлдөж байгааг, 3) Ямар нэгэн хүнд янз бүрийн шагнал болон шийтгэлүүд ялгаатай нөлөөлж байгаа нь юугаар нөхцөлдөж байгааг тус тус тайлбарлах нь социологийн ухааны үндсэн асуудал юм.

Бүлгийн дотоод дахь үүрэг. Хүн бол нийгмийн амьтан, бусадтай харилцаанд орохгүйгээр, тусгаар хувь хүн орших боломжгүй. Шагнал болон шийтгэл нь социаль бүлгүүдийн дотоод харилцаанд үүрэг гүйцэтгэдэг байна. Сорокиний бичсэнээр «Шагнал болон шийтгэлгүйгээр зөрчил тэмцэл нь үе үе тохиолдох зүйл бус, харин байнгын зүйл байх байсан. Хүмүүсийн хоорондын харилцан үйлдэл нь үнэн хэрэгтээ бүхний эсрэг бүхний дайн (bellum omnium contra omnes) байх байсан ажээ». Бүлэг дотор байвал зохих зан үйлийн стандартыг бий болгосон байх ба түүнээс гажих тохиолдол нь шагнал болон шийтгэлийг дагуулах ба тэдгээр нь бүлгийн эрхэмнэлийг хадгалахад үүрэг гүйцэтгэнэ. Сорокин «Бүлэгт зөрчилтэй төлөв байдал үүсч, гишүүд түүнд бэлэн байх үед байвал зохих зан үйлийн хэм хэмжээ нь тэдгээрийн бие биедээ энхийн болон зөрчилгүй байдлаар харилцах боломжийг хэрхэн бүрдүүлэх вэ? гэсэн асуулт тавиад шагнал болон шийтгэлийн бүлгийн гишүүдийн зан үйл дэх сэдэлжүүлэх хийгээд шахалтын нөлөөллийн үр дүнд боломжтой» гэсэн хариултыг гаргаж ирсэн байна.

Бүлгийн гадаад дахь үүрэг. Шагнал болон шийтгэл нь нийгмийг бүрдүүлж байгаа томоохон бүлгүүдийн хүрээнд социаль нэгдмэл байдлыг өргөжүүлэх, бэхжүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг. Нийгмийн энх тайван бол нийгмийн томоохон ангиуд болон нийгмүүд хоорондын мөргөлдөөнийг шийдэрлэснээр цогцлох зүйл байдаг. Гэтэл дайн бол шийтгэл бөгөөд нөгөө талын гэмт үйлдлийн хариу ч байж болно. Тэгэхээр томоохон социаль нийтлэгүүдийн хувьд байвал зохих зан үйлийн шаблон бүтээх, түүнд зөвшилцөлд хүрэх арга зам чухал юм.

1) Хэрвээ бүлгийн дотор болон гадна социаль тэмцлээс өөр юу ч оршихгүй байгаа бол бүлгийн янз бүрийн гишүүдэд болон янз бүрийн *бүлгүүдэд байвал зохих, хоргилол зохих, эсвэл бахдан дэмжвэл зохих* зан үйлийн хэлбэрүүд нэгдмэл утгаар ойлгогдож чадахгүй агаад итгэл үнэмшлийн энэхүү зөрчилдөөний өсөлт хийгээд хэтийдлийн аль нэг тохиолдол нь нийгмийн зүгээс үзүүлэх хариу арга хэмжээний (шийтгэлийн) хатуу чангарах болон (шагналын) аугаа болох байдалд илрэлээ олдог.

2) Бүлгийн үл эвлэрэгч хэсгүүд болон үл эвлэрэгч бүлгүүдийн зан үйлийн шаблон нь хэр зэрэг тогтвортой байна, тэдгээрийн хоорондын зөрчлийг намжаахын тулд шийтгэл нь *төдий чинээ зохимжтой, шагнал нь төдий чинээ цр дүнтэй* байна. Эдгээр шаблонууд хэдий чинээ тогтворгүй байна, нийгмийн болон бүлгийн зүгээс үзүүлэх хариу арга хэмжээ нь (санкция) төдий чинээ оновчгүй байна.



Хяналтын асуултууд:

1. Гэмт хэргийг тайлбарлах социологи ба эрхзүйн хандлагын ялгаа юу вэ?
2. Гэмт хэрэг ба алдар гавьяа хэмээх ойлголтуудыг яагаад социологийн шинжлэх ухаанд зэрэгцүүлэн авч үзэх ёстой вэ?
3. Ял шийтгэл ба шагнал нь хүний зан үйлд хэрхэн нөлөөлдөг вэ?
4. Өнөөгийн Монголд ял шийтгэл нийгмийн үүргээ хэрхэн гүйцэтгэж байна вэ? Ямар асуудал байна вэ?
5. Монголын нийгэмд шагнал ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?
6. Ял шийтгэл ба гавьяа шагнал нь нийгмийн дэг ёсыг хадгалах, дундаж хандлага төлөвшихөд ямар үүрэгтэй вэ?
7. Хорих ял Монголын нийгэмд ямар үр дагавар авч ирж байгаа вэ?



Эх сурвалж:

1. Сорокин П.А. (1995), Система социологий. Том I, II, Пер. с англ. М.: Политиздат
2. Сорокин П.А. (1992), Человек, цивилизация, общество, Общ. ред. сост. и предисл. А. Ю. Согомонов: Пер. с англ. М.: Политиздат
3. Түмэннаст Г. (2009) Гэмт хэрэг ба шийтгэл, гавьяа ба шагнал, Социологийн шүүмжлэлт бодрол, эргэцүүлэл. www.monkey.mn



Унших материал:

1. Сорокин П.А. (1992), Человек, цивилизация, общество, Общ. ред. сост. и предисл. А. Ю. Согомонов: Пер. с англ. М.: Политиздат



БҮЛЭГ-IX. Социологийн судалгаа: Хөтөлбөр ба аргууд

Хичээлийн нэр	Сэдвийн нэр	Цаг	Хичээлийн хэлбэр
Социологийн судалгаа	Социологийн судалгааны хөтөлбөр	2	Лекц
	Тоон судалгааны аргууд	2	Лекц
	Чанарын судалгааны аргууд	2	Лекц

Сэдэв - 1: Социологийн судалгааны хөтөлбөр

Хичээлийн зорилго: Социологийн судалгааны хөтөлбөрийг боловсруулах үйл явц нь судалгааг үр дүнтэй хийх урьдач нөхцөл юм. Энэ хичээлээр судалгааны хөтөлбөрийн агуулга, бүтэц, хэлбэр, бүрэлдэхүүн хэсгүүдтэй танилцахын зэрэгцээ хөтөлбөрийг хэрхэн боловсруулах мэдлэг, ур чадварт суралцана.

Гол ойлголтууд:

- ❖ Судалгааны хөтөлбөр
- ❖ Судалгааны арга зүй
- ❖ Судалгааны аргачлал
- ❖ Ном зохиолын тойм
- ❖ Судлах зүйл, объект
- ❖ Судалгааны зорилго, зорилт
- ❖ Үндсэн ойлголтын тайлбарлал
- ❖ Таамаглал
- ❖ Хувьсагчууд
- ❖ Судлах зүйлийн шинжилгээ

Сэдвийн агуулга:

- ❖ Судалгааны хөтөлбөр бол аливаа судалгааны чухал хэсэг, бэлтгэл шат мөн.
- ❖ Судалгааны хөтөлбөрийн бүтэц, бүрэлдэхүүн

Санал болгож байгаа арга:

- ❖ Лекц
- ❖ Харилцан ярилцах
- ❖ Асуулт тавих


А. Судалгааны хөтөлбөр бол аливаа судалгааны чухал хэсэг, бэлтгэл шат мөн.

Социологичид болон социологийн судалгаа хийж буй аливаа судлаачид судалгааг тодорхой хөтөлбөрийн дагуу хийдэг. Судалгааны хөтөлбөр нь дараах хэсгүүдийг өөртөө агуулна. Үүнд: асуудлыг тодорхойлох, зохиол бүтээлийн тойм хийх, таамаглалаа томъёолох, судалгааны төлөвлөгөө гаргах, өгөгдлөө цуглуулах, өгөгдлөө шинжлэх, үр дүнг нэгтгэж дүгнэлт гаргах зэрэг болно.

Судалгааны хөтөлбөр гэж юу вэ?

Тулгамдсан, тодорхой нийгмийн үзэгдэл үйл явцыг судлах арга зүйн хандлага, онол үзэл баримтлал, аргачлалын бүх талын үндэслэгээг агуулсан цогц шинжтэй стратегийн баримт бичиг бол судалгааны хөтөлбөр юм. Үүнийг зарим ном зохиолд судалгааны дизайн хэмээх нэр томъёогоор тэмдэглэсэн ба «дизайн боловсруулна гэдэг бол судалгааны асуултыг төсөл болгон хувиргана гэсэн үг» (Робсон, 2006, 40) гэжээ.

Практикт хийгдэж буй ихэнх судалгаанууд судалгааны хөтөлбөрийн дагуу хийгдэнэ. Судалгааны хөтөлбөрийг арга зүйн болон аргачлалын гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваадаг.



Судалгаагаар шийдвэрлэх асуудал

Амьдралаар дэвшигдэн гарч ирж буй зөрчилт байдлыг нийгмийн асуудал хэмээн нэрлэдэг. Асуудал шийдэх нөхцөл нь бодит байдлаас дэвшигдсэн эрэлт хэрэгцээг хангахад зайлшгүй шаардагдах мэдлэгтэй холбоотой үүснэ. Хэрэгцээ, түүнийг хангахад шаардагдах мэдлэг хоёрын зөрчил нь объектив ба субъектив аль ч хэлбэртэй байж болно.

- ❖ Объектив зөрчил бол шинжлэх ухааны судалгаагаар шийдвэрлэвэл зохих зөрчил юм.



- ❖ Харин субъектив зөрчил бол шинжлэх ухаанаар нотлогдсон боловч хүмүүс тухайн асуудлыг мэдэхгүй явдалтай холбогдон гардаг.

Судлах зүйл, объект

Социологийн судалгааны объект нь өргөн утгаараа нийгмийн асуудлыг агуулагч хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагаа байдаг. Судалгааны объектыг зөрчил бүхий (шийдвэрлэх асуудлыг агуулсан) нийгмийн үзэгдэл үйл явц мөн гэж үзэх нь бий. Судалгааны объектоо яв цав тодорхойлох нь судлах зүйлээ зөв тогтооход чухал ач холбогдолтой. Судлах зүйл нь судалгааны объектын судалгаанд шууд хамаарагдах тодорхой шинж чанар (Осипов Г.В, 1977,131) элементүүд юм. Иймд судлах зүйл нь дэвшүүлсэн асуудлын дотоод зөрчлийг бүрэн дүүрэн нээн харуулах шинж чанар, талыг агуулж байдаг.

Судалгааны зорилго, зорилт

Нийгмийн тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх зорилгоор социологийн судалгаа хийгддэг. Судалгааны зорилго бол товчхондоо судалгаагаар хүрэх үр дүн мөн. Судалгааны зорилгыг онолын ба практикийн, үндсэн ба үндсэн бус, гол ба гол бус гэж ангилдаг. Судалгааны зорилгыг тодорхой алхамуудаар дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөдөг ба үүнийг судалгааны зорилт гэж үзнэ.

Үндсэн ойлголтод хийх тайлбарлал

Социологийн судалгаа явуулахдаа судлах зүйл, объектын гол шинж, харилцааг тодорхойлох зорилгоор онолын тайлбарлал хийдэг. Ойлголтод хийх тайлбарлал гэдэг нь уг үзэгдлийн талаарх бусад ойлголтуудтай харьцуулах, судалгааны объектын гол, гол талыг тэмдэглэсэн ойлголтын агуулгад хийх тодорхойлолт юм. Дараах нөхцөлд үндсэн ойлголтод тайлбарлал хийх шаардлагатай. Үүнд:

1. Зарим ойлголтууд нэг утгаар бүрэн гүйцэд тодорхойлогдоогүй үед тайлбарлал хийнэ.
2. Судалгааны объект болон судлах зүйлийн өвөрмөц тал шинжийг онолын үүднээс үндэслэх болон тайлбарлах шаардлагатай.
3. Нийгмийн тодорхой үзэгдлийг тусгасан олон янзын нэр томъёоноос уг үзэгдлийг тэмдэглэсэн шинжлэх ухааны ойлголтыг зааглах үед тайлбарлал хийнэ.

Таамаглал дэвшүүлэхүй

Таамаглал бол ямар нэг баримт мэдээ, үзэгдэл, үйл явцыг тайлбарлахын тулд урьдчилан дэвшүүлсэн нэг бол батлагдах, эс бөгөөс няцаагдах төсөөлөл юм. Үндэслэл сайтай таамаглал дараах шаардлагыг хангасан байна (В.Отгоннасан, 2003, 36). Үүнд:


1. Таамаглалын гол санааг илэрхийлсэн ойлголтуудын агуулга бодитой,

- тодорхой баримтаар шалгаж болохоор байх
2. Таамаглал шинжлэх ухаанаар нотлогдсон баримттай харшлахгүй байх
 3. Таамаглал объектыг бүхэлд нь тайлбарлаж чаддаг байх
 4. Таамаглал нь судалгаагаар шийдвэрлэх асуудалтай холбоотой байх
 5. Судалгаанд дэвшүүлсэн таамаглалууд өөр хоорондоо уялдаатай байх

Судлах зүйлд шинжилгээ хийх нь

Судалгааны судлах зүйл болон объектод шинжилгээ хийх нь өмнө хуримтлагдсан мэдлэгийг нэгтгэхийн зэрэгцээ судалж буй нийгмийн үзэгдэл хоорондын хамаарлыг урьдчилан тогтооно гэсэн үг юм. Объектын чухам ямар шинжийг тухайлан судлах шаардлагатай нь судалгаагаар шийдвэрлэх асуудал болон түүний зорилгоос шалтгаалдаг/3.32/ байна. Нийгмийн аливаа үзэгдлийг тодорхойлдог ерөнхий ба өвөрмөц, объектив ба субъектив, шууд ба шууд бус хүчин зүйлс нь хоорондоо олон тооны холбоосоор холбогдоно. Эдгээр нь эерэг, сөрөг харилцан адилгүй хамааралтай байж болох юм.

Зураг 1. Судлах зүйлийн шинжилгээ (Отгоннасан, 2003, 34)



- А - Нийгмийн харилцааны ерөнхий хүчин зүйлс
Б - Өрх гэр, хамт олон гм харилцааны өвөрмөц хүчин зүйлс
В - Бие хүний хувийн онцлог
V1 - Нас, боловсрол, мэргэжил
V2 - Хүмүүжлийн түвшин, үзэл санаа
Г - Бие хүний бодит үйл ажиллагаа
Д - Анкетын асуултад өгсөн хариулт

Аргачлалын бүрэлдэхүцн хэсэг

Түцвэрлэлт хийх тухай

Эх олонлогийн тодорхой дэд олонлогт судалгаа хийж, гарсан үр дүнг эх олонлогт дэлгэрүүлэн хэрэглэх аргыг түүвэр судалгаа гэдэг. Түүвэр судалгааг анх 1763 онд Францын судлаач Лаплас хүн амын тооллогод хэрэглэж байжээ. (В.Отгоннасан, 2003, 50) Түүвэр судалгаа нилэнхүй судалгааг бодвол судалгааны зардлыг багасгадаг, эцсийн үр дүн хурдан гардаг, судалгааг эрхлэн явуулах цөөн хүн шаарддаг зэрэг давуу талтай. Түүвэрлэлтийг дотор нь магадлалт ба магадлалт биш түүвэрлэлт гэж хувааж үздэг (Nachmias Ch.F, 1996, 183).



Мэдээлэл цуглуулах аргуудыг сонгох нь

Мэдээлэл цуглуулахад тоон ба чанарын судалгааны аргуудыг өргөнөөр ашигладаг бөгөөд нийгмийн ямар асуудлыг хэрхэн судлахаас хамааран тоон, чанарын аргын аль нэгийг нь, эсвэл эдгээрийг хамтад нь хослуулан хэрэглэнэ. (Судалгааны хөтөлбөрийн бүтэц, бүрэлдэхүүн хэсгээс тодруулж харна уу.)

Мэдээллийг боловсруулах аргачлал

Мэдээлэл боловсруулах нь социологийн судалгааны чухал үе шат мөн. Учир нь мэдээлэл боловсруулалтын түвшингээс судалгааны үр дүн үлэмж хамаардаг. Иймд мэдээлэл боловсруулах аргачлалыг нарийвчлан төлөвлөж, судалгааны программд оруулж өгдөг. Тоон судалгааны мэдээллийг SPSS, CsPro, SAS, STATA зэрэг программууд ашиглан, чанарын судалгааны мэдээллийг NVIVO, QDA miner, NUDIST зэрэг программууд ашиглан боловсруулж байна. Социологийн судалгааны мэдээллийг боловсруулахдаа дараах 5 үе шаттайгаар гүйцэтгэдэг.

1. Мэдээллийг шинжлэх логик схем зохиох
2. Мэдээллийг компьютерт оруулахад бэлтгэх
3. Мэдээллийг компьютерт оруулах, өгөгдлийн сан байгуулах
4. Боловсруулах
5. Гарсан үр дүнг шинжлэх

Мэдээллийг тайлбарлах, тайлан бичих нь


Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэх, тайлагнах явдал бол аргачлалын аль ч үе шатнаас дутуугүй судлаачаас ихээхэн хүч хөдөлмөр, чармайлт шаарддаг.

Тайлан гэдэг нь уг судалгаагаар шийдвэрлэх асуудал, зорилт, таамаглал, судалгааны онол арга зүй, аргачлалын үндэс, судалгаанаас гарсан баримт, түүнд хийсэн дүгнэлт, тайлбарлал, практик зөвлөмж, саналыг нэгтгэж, судалгааны онол практикийн ач холбогдол, үр дүнг иж бүрнээр нь илтгэсэн эрдэм шинжилгээний өвөрмөц бүтээл мөн (Отгоннасан, 2001,185).

Аливаа судалгааны тайлан эрдэм шинжилгээний ба практикийн хоёр үндсэн зориулалтаар бичигдэх ба дараах үүргүүдийг гүйцэтгэдэг байна.

- ❖ Нэгд, тайлан бол социологийн судалгааны онол, судалгааны цаашдын үйл ажиллагааны эх сурвалж, үндэс болно.
- ❖ Хоёрт, тайлан нь хууль зүйн учир холбогдолтой бичиг баримт тул судлаачийн бие даасан эрдмийн бүтээл, зохиогчийн эрхийг тогтоох баримт юм.
- ❖ Гуравт, тайлан бол социологийн судалгааны онолын үр дүн, гаргасан зөвлөмж саналыг практикт нэвтрүүлэх алхам, түүний үндэс байдаг.

Б. Судалгааны хөтөлбөрийн бүтэц, бүрэлдэхүүн



R.T.Scheaper (2005), *Sociology*, NY



? **Хяналтын асуултууд:**

1. Объектив ба субъектив зөрчил гэж юу вэ? ялгааг дурдана уу.
2. Судалгааны хөтөлбөрт үндсэн ойлголтыг тайлбарлах нь яагаад чухал байдаг вэ?
3. Судалгааны хөтөлбөрийг арга зүйн болон аргачлалын хэсгүүдэд хуваан үзэхийн учир?
4. Таамаглал дэвшүүлэхгүйгээр судалгаа хийж болох уу? яагаад?
5. Судалгааны мэдээллийг ямар үе шаттайгаар боловсруулдаг вэ?

Даалгавар:
Хууль эрхийн тодорхой асуудлыг сонгон авч судалгааны хөтөлбөр зохиогоорой.

📖 **Эх сурвалж:**

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Дашдаваа С нар (1989) Социологийн судалгааг хэрхэн явуулдаг вэ?., УБ, Улсын хэвлэл
3. Отгоннасан В (2003) Социологийн судалгааны үндсэн аргууд УБ., МУИС-ийн хэвлэл
4. Робсон К (2006) Бодит ертөнцийг судлахуй УБ., Монсудар
5. Руденко Р.И (2006) Социологийн ажилбар УБ., PRO-LINE
6. Уртнасан Ц, Пүрэв.Ц (2008) Социологийн судалгааны арга зүй аргачлал. УБ., Sansudai
7. Nachmias Ch.F, Nachmias.D (1996) Research Methods in the Social Sciences. NY, St.Martin's press, Inc

📖 **Унших материал:**

1. Отгоннасан В (2003) Социологийн судалгааны үндсэн аргууд УБ.,
2. Робсон К (2006) Бодит ертөнцийг судлахуй: Нийгмийн ухааны судлаач болон мэргэжилтэн судлаачдад зориулсан гарын авлага УБ., Монсудар
3. Уртнасан Ц, Пүрэв.Ц (2008) Социологийн судалгааны арга зүй аргачлал. УБ.,

Сэдэв - 2: Тоон судалгааны аргууд

Хичээлийн зорилго: Тоон судалгааны мөн чанар, онолын эх сурвалж, үндсэн ойлголтууд, мэдээлэл цуглуулах аргууд, тэдгээрийг хэрэглэх онцлог, ур чадварт суралцана.

Гол ойлголтууд:

- ❖ Шинжилгээний нэгж
- ❖ Хувьсах хэмжигдэхүүн
- ❖ Хамаарах ба үл хамаарах хувьсагч
- ❖ Хөндлөнгийн хувьсагч
- ❖ Таамаглал
- ❖ Асуух арга
- ❖ Санал асуулга-анкет
- ❖ Стандарт сурвалжлага
- ❖ Контент анализ
- ❖ Туршилт

Сэдвийн агуулга:

- ❖ Тоон ба чанарын судалгааны үндсэн ойлголт, онцлог
- ❖ Мэдээлэл цуглуулах тоон аргууд

Санал болгож байгаа арга:

- ❖ Асуулт тавих
- ❖ Харилцан ярилцах

Тоон ба чанарын судалгааны онцлог

Тоон судалгааны онцлог	Чанарын судалгааны онцлог
<ul style="list-style-type: none"> • Хэд хичнээн гэсэн асуултад хариулагдана; • Тоо, хувиар илэрхийлэгдэнэ; • Объектив хандлагаар судална; • Судалгааны хэв загварт оруулсан арга хэлбэрийг ашиглана; • Урьдчилан төлөвлөсөн; таамаглал дэвшүүлээд түүнийгээ шалгах хэлбэрээр хийгдэнэ. • Олон тооны жишээ баримт судлана; • Шинжилгээний логик нь дедуктив хэлбэртэй. Ерөнхий суурь, мэдээллийг бий болгодог. 	<ul style="list-style-type: none"> • Юу, яагаад гэсэн асуултад хариулагдана; • Үг өгүүлэмжээр илэрхийлэгдэнэ; • Субъектив хандлагаар судалдаг (хүмүүсийн санал бодол, юу гэж бодож байна); • Судалгаа нь нээлттэй, хэв загварт оруулаагүй арга хэлбэрийг ашиглана; • Уян хатан чанартай; урьдчилан таамаглал, төсөөлөлд захирагдахгүй бөгөөд асуудлыг олон талаас нь тайлбарлана. • Цөөн тооны мэдээлэл хүргэгч эсхүл баримт (тохиолдол) судлана; • Шинжилгээний логик нь индуктив хэлбэртэй. Нэгж юмс үзэгдлийн талаарх мэдээллийг бий болгодог.



Тоон хийгээд чанарын судалгааны аргын аль нь илүү болох талаар судлаачид маргах нь олонтаа. Энэ тохиолдолд судлаачид дэвшигдсэн асуудлын судлах зүйлийн онцлог, хамрах хүрээ, түүвэр зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч судалгааны арга, хэлбэрийг сонгодог. Олон нийтийн төсөөлөл хандлага, санал бодлыг тоон судалгааны аргуудаар (санал асуулга, стандарт сурвалжлага) судлах ба олон нийтийн төсөөллөөс нуугдмал, иргэдийн санал бодлоор илрүүлэхэд төвөгтэй нийгмийн асуудлыг илрүүлэхэд чанарын судалгааны аргуудыг (ажиглалт, гүнзгийрүүлсэн ярилцлага гм) ашиглах буюу эдгээр аргуудыг хослуулан хэрэглэж байна.

Тоон судалгааны цндсэн ойлголтууд

- ❖ Хувьсах хэмжигдэхүүн: Тоон судалгааны гол ойлголт. Хоёр буюу түүнээс олон утга буюу категори агуулж, хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголтууд. (нас, хүйс, боловсрол гм)
- ❖ Шинжилгээний нэгж: Судлаач хувьсах хэмжигдэхүүнийг хэмжихдээ ямар төрлийн нэгж хэрэглэж буйг үүгээр илэрхийлдэг. (жишээ нь, нийгмийн институт гэсэн хэмжигдэхүүний хувьд шашин, боловсрол, гэр бүл зэрэг нь шинжилгээний нэгж болно)
- ❖ Үл хамаарах хувьсах хэмжигдэхүүн: Сонгож авсан үзүүлэлт буюу хэмжигдэхүүн үзэгдэл юмсын өөрчлөлтийн шалтгаан болж байвал independent variable буюу үл хамаарах хувьсах хэмжигдэхүүн гэж нэрлэнэ.
- ❖ Хамаарах хувьсах хэмжигдэхүүн: Сонгож авсан үзүүлэлт буюу хэмжигдэхүүн үзэгдэл юмсын өөрчлөлтийг даган хувирч өөрчлөгдөж байвал dependent variable буюу хамаарах хувьсах хэмжигдэхүүн гэж нэрлэнэ.
- ❖ Хөндлөнгийн/завсрын хувьсах хэмжигдэхүүн: Хоёроос дээш олон хүчин зүйлийн шалтгаант хамааралд илэрдэг. Энэ хувьсагч нь үл хамаарах хувьсах хэмжигдэхүүнтэй харьцуулахад хамаарах хувьсах хэмжигдэхүүний үүрэг гүйцэтгэдэг байхад, хамаарах хувьсах хэмжигдэхүүнтэй харьцуулахад үл хамаарах хувьсах хэмжигдэхүүний үүрэг гүйцэтгэдэг.
- ❖ Таамаглал: Хоёр буюу түүнээс дээш хувьсах хэмжигдэхүүн хоорондын шалтгаан үр дагаврын хамаарлыг илэрхийлсэн, туршигдвал зохих бодомжийг илтгэдэг.
- ❖ Тэг таамаглал: Батлах буюу үгүйсгэх байдлаар өмнө дэвшүүлсэн таамаглалд хандаж буйг илэрхийлнэ. Энгийнээр хэлэхэд энэхүү таамаглал бол таамаглалыг шалгах урвуу арга хэлбэр болно.

Тоон судалгааны онцлог

- ❖ Тоон судалгаа нь позитивист хандлагын ойлголт, үндэслэлүүдэд голчлон тулгуурлана.
- ❖ Ихэнх тоон судалгаа нь бүтэцчилэгдсэн бөгөөд ерөнхий онолд

тулгуурласан, урьдчилан бий болгосон таамаглалыг батлахад чиглэдэг.

- ❖ Тоон судалгаа нь «Хэд?», «Хичнээн?», «Хэдэн хувь, ямар хамааралтай?» зэрэг асуултад тулгуурлан хийгддэг.
- ❖ Тоон судалгаа нь нийгмийн бодит байдлыг маш сайн дүрслэн үзүүлэх ба хүмүүсийн хэв маяг, социаль үйл ажиллагааны талаарх үнэлэмжээс ангид дүр зургийг (тоо, хувь, шалтгаант холбоо гм) бий болгоно.
- ❖ Судалгааны ихээхэн хувийг тоон судалгаа эзлэнэ. Тоон судалгаа нь мэдээлэл цуглуулахдаа санал асуулга, стандарт сурвалжлага, контент-анализ, туршилтын аргуудыг өргөнөөр ашиглана.

Мэдээлэл цуглуулах тоон аргууд

Мэдээлэл цуглуулах тоон аргуудыг ихэнх тохиолдолд хослуулан хэрэглэдэг бөгөөд жишээ болгон дараах аргуудыг нэр, төрөл, давуу болон сул тал, хэрэглэх онцлогийн хувьд авч үзье.

Санал асуулга	
Тодорхойлолт	Санал асуулга бол судалгааны гол зорилготой уялдуулан зохиосон тодорхой агуулга, зохион байгуулалт, бүтэц дараалал бүхий мэдээлэл цуглуулах зорилгоор тусгайлан боловсруулсан асуулт хариултын цогц юм.
Давуу тал	Эл төрлийн судалгааг явуулах, мэдээллийг шалгах, боловсруулахад харьцангуй хялбар бөгөөд зардал багатай. Орчин бэлтгэх шаардлагагүй.
Сул тал	Судалгааны асуултыг эхнээс нь сайн шалгаагүй тохиолдолд алдаа үүссэн бол засварлаж болдоггүй. Аноним буюу нэргүй авдаг тул мэдээллийг лавшруулах бололцоо тааруу.
Хэрэглэх онцлог	Асуултыг бичгээр тавина. Судалгаанд оролцогч асуултад байж болох өгөгдсөн хариултаас сонголт хийх, нэмж дэлгэрүүлэх замаар хариулдаг. Нэгдсэн нэг хэв загварын асуултууд тавина. Бусад аргууд, ялангуяа ярилцлагатай хослуулж хэрэглэнэ.
Стандарт сурвалжлага	
Тодорхойлолт	Судлаач судалгаанд оролцогчтой урьдчилан бэлтгэсэн асуултуудад тодорхой дарааллын дагуу ярилцах замаар хариулт авах хэлбэрийг стандарт сурвалжлага гэж нэрлэдэг.
Давуу тал	Судлаач мэдээллийг тухайн нөхцөл, цагт шалгах лавшруулах бүрэн боломжтой.
Сул тал	Ярилцагчаас эв дүй, ур чадвар шаардана. Орчин бэлтгэх, техник тоног төхөөрөмж (диктафон, дуу хураагуур гм) зайлшгүй шаардагдана. Судалгаанд харьцангуй их зардал гарахын хамт мэдээллийг нягтлан боловсруулахад цаг хугацаа их шаардагдана.



Хэрэглэх онцлог	Урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу шууд асууна. Судалгаанд оролцогчийн онцлогт тохируулан асуултаа тавьж болно. Бусад аргууд болох ажиглалт, санал асуулгатай хослуулж хэрэглэнэ.
Контент анализ-Баримт бичигт хийх тоон шинжилгээ	
Тодорхойлолт	Гараар бичсэн болон хэвлэмэл бичиг, гэрэл зураг, соронзон бичлэг, кино хальсанд бичигдэж тэмдэглэсэн янз бүрийн мэдээллийн шинж тэмдгүүдийг агуулгын хувьд олон талаас нь цэгцтэй судлах боломж олгодог тоон арга бол контент анализ юм.
Давуу тал	Их хэмжээний материалыг судалгааны зорилгод тулгуурлан системчлэн таамаглалын хэлбэрт оруулж унших бололцоо олгоно. Судалгаагаар дэвшигдэж буй асуудлын талаарх өмнөх нөхцөл байдлын тухай тоймыг харуулна.
Сул тал	Өргөн хүрээтэй боловсруулалт хийх боломжгүй, материал хангалтгүй, төлөөлөх чадваргүй хэмээн үзэж байгаа тохиолдолд тоон шинжилгээ хийх боломжгүй. Баримт материалыг тодорхой шалгуураар (улс төрийн нөлөө, хувийн үзэл бодол гм) авч хэрэглээгүй тохиолдолд алдаа үүсч болно.
Хэрэглэх онцлог	A) Шинжилгээний нэгжийг тогтооно. B) Шинжилгээний нэгжийн шинж тэмдгийг тогтооно. B) Статистик боловсруулалт хийнэ. Судалгааны бусад аргуудтай нягт хослуулж хэрэглэнэ.
Туршилт	
Тодорхойлолт	Хүмүүст сонирхогдож байгаа нийгмийн өвөрмөц үзэгдлийн холбоог илрүүлэн тогтооход зайлшгүй шаардагдах хангалттай орчин, нөхцөлийг бий болгох замаар судалгаа явуулах арга юм.
Давуу тал	Практик дахь үнэнийг танин мэдэхэд туршилт чухал үүрэгтэй.
Сул тал	Туршилтын зайлшгүй нөхцөлийг судлаач нийгмийн бодит амьдралд бүрдүүлж судалгааг хийнэ. Өөрөөр хэлбэл, судлаачаас ихээхэн зардал, хүч, хөдөлмөр шаардана. Нийгмийн үзэгдэл олон талтай, хувьсамтгай тул туршилт хийхэд өвөрмөц арга ажиллагаа шаардаж байдаг.
Хэрэглэх онцлог	Туршилтыг харьцангуй нэг төрлийн ижил нөхцөлд, цөөн хэдэн бүлэгт хийнэ. Туршилтын бүлгийг тодорхой шалгуурын дагуу сонгон авч судлаад, хяналтын бүлэг дэх үзүүлэлттэй харьцуулж, үр дүнг шинжилнэ.



Хяналтын асуултууд:

1. Судалгааны сэдэв, асуудал, таамаглал нь хоорондоо ямар холбоотой вэ?
2. Тоон ба чанарын судалгааны онцлогийг жишээн дээр тулгуурлан тайлбарла?
3. Үл хамаарах, хамаарах, хөндлөнгийн хувьсах хэмжигдэхүүнүүдийн ялгааг дурдана уу?
4. «Явсан замын км-ийн хэмжээ нь тухайн жолооч бензин түгээгүүрийн газар хэдэн удаа очих давтамжид нөлөөлнө» гэсэн таамаглал дахь үл хамаарах ба хамаарах хувьсах хэмжигдэхүүнүүдийг нэрлэ?
5. Мэдээлэл цуглуулах тоон аргуудаас практикт алиныг нь түлхүү хэрэглэх хандлагатай байдаг вэ?
6. Мэдээлэл цуглуулах тоон арга тус бүрийг дангаар нь болон хослуулан хийсэн судалгааны тайлантай танилцаж, үр дүнг хэлэлцээрэй.



Эх сурвалж:

1. Гидденс А (2006) Социологи. УБ., Адмон
2. Отгоннасан В (2003) Социологийн судалгааны үндсэн аргууд УБ
3. Колин Робсон. (2006), Бодит ертөнцийг судлахуй. Нийгмийн ухааны судлаач болон мэргэжилтэн судлаачдад зориулсан гарын авлага
4. Уртнасан Ц, Пүрэв Ц (2008) Социологийн судалгааны арга зүй аргачлал. УБ., Sansudai
5. Nachmias Ch.F, Nachmias.D (1996) Research Methods in the Social Sciences. NY, St.Martin's press, Inc
6. Bailey K.D (1994) Methods of Social Research. NY, The free press, A division of Macmillian Inc



Унших материал:

1. Отгоннасан В (2003) Социологийн судалгааны үндсэн аргууд УБ
2. Уртнасан Ц, Пүрэв Ц (2008) Социологийн судалгааны арга зүй, аргачлал. УБ., Sansudai
3. Колин Робсон. (2006), Бодит ертөнцийг судлахуй. Нийгмийн ухааны судлаач болон мэргэжилтэн судлаачдад зориулсан гарын авлага. УБ., Монсудар



Сэдэв - 3: Чанарын судалгааны аргууд

Хичээлийн зорилго: Социологийн судалгааны үндсэн хэв маяг болсон чанарын судалгаа, түүний мөн чанарын талаар тайлбарлаж, чанарын судалгааны үндсэн аргуудын онцлог, хэрэглэх аргачлалын талаар суурь мэдлэг эзэмшихэд энэ хичээлийн зорилго оршино.

Гол ойлголтууд:

- ❖ Судалгааны арга
- ❖ Чанарын судалгааны арга
- ❖ Микро социологи
- ❖ Судалгааны онол аргазүй
- ❖ Оролцсон ажиглалт
- ❖ Гүнзгийрүүлсэн ярилцлага
- ❖ Хүүрнэл ярилцлага
- ❖ Фокус бүлгийн хэлэлцүүлэг
- ❖ Баримт бичгийн шинжилгээ

Сэдвийн агуулга:

- ❖ Судалгааны арга ба түүний үндсэн хэв маяг
- ❖ Чанарын судалгааны аргазүйн онцлог, стратеги
- ❖ Микро социологийн онол аргазүй ба чанарын судалгаа
- ❖ Судалгааны онол аргазүйн үндэслэл ба чанарын судалгааны онолын үндэс
- ❖ Чанарын судалгааны өргөн хэрэглэгддэг аргууд: Оролцсон ажиглалт, Гүнзгийрүүлсэн ярилцлага, Хүүрнэл ярилцлага, Фокус бүлгийн хэлэлцүүлэг, Баримт бичгийн шинжилгээ

Санал болгож байгаа арга:

1. Бүлгээр ажиллах арга
2. Тохиолдол шинжлэх

Чанарын судалгаа, тцүний мөн чанар

Нийгмийн судалгаа бол хүмүүсийн өөрсдийн зохиосон ертөнц болох социаль ертөнцийн талаар шинжлэх ухааны аргын тусламжтайгаар мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийх, түүндээ тулгуурлан хүний болон нийгмийн сайн сайхан байдлыг хангахад ач холбогдол бүхий мэдлэгийг бүтээх үйл ажиллагаа мөн. Байгаль, сэтгэхүй, техникийн ертөнцийн нэгэн адил хүний нийгэм нь өөртөө тоон хийгээд чанарын гэсэн хоёр шинж чанарыг агуулж байдаг бөгөөд тоон тал, шинж тэмдэг түүний хөгжил, хувьслыг тоон судалгааны аргуудын хүрээнд судалдаг бол харин одоо чанарын шинж тэмдэг, түүний хөгжил, хувьслыг ямар аргуудаар хэрхэн судалдаг талаар өгүүлэх болно.

Чанарын судалгаа нь социологийн онол аргазүйд хэрхэн үндэслэгдэг вэ?

Хэт онолдох нь буруу зүйл, онол нь практикаас (судалгаанаас) хэт хөндийрчихлөө гэх мэт яриаг сургалтын явцад онол хийгээд практикын (судалгаа) тэнцвэртэй байдалд санаа зовниж буй зүйл гэж хүлээн авахаас бус, ерөөс онолын учир холбогдлыг үгүйсгэж, бүр цаашлаад онолгүй эмпирик судалгааг илүүд үзэх аваас судалгаа өөрөө сохрох аюултай. Нийгмийн судалгааг хийж байгаа хүмүүс нь тэр бүр мэдрээд байдаггүй ч, судалгаа бүхэн онолын тодорхой мэдлэгт үндэслэж байдаг юм. Судалгааны хамрах хүрээ, хандлага, түлхүүр ойлголт, асуулт, шинжилгээ хийх стратеги энэ бүхэн уг судалгаа нь ямар онол аргазүйг баримжаалж, түүнд үндэслэж байгааг илэрхийлэх болно. Тоон судалгаа нь позитивист онол аргазүйд илүү суурилдаг талаар өмнөх бүлэгт үзсэн билээ. Энэ утгаараа нийгмийн үзэгдлийг дүрслэн үзүүлэх, биднээс харьцангуй үл хамааран явагдаж байгаа ихэвчлэн макро хүрээний үйл явцууд болон тэдгээрийн хоорон дахь хамаарлыг харуулахад оршино. О.Конт социологи бол байгалийн шинжлэлийн судалгааны аргуудыг хэрэглэх ёстой бөгөөд нийгмийн үзэгдлийн зүйл тогтлыг тоочлох хандлагыг аргазүйн системтэй дэвшүүлсэн юм. Тухайлбал, өмнө бидний өгүүлсэн Дюркхаймын шинжилгээнд амиа хорлолтын талаарх улс орнуудын статистик үзүүлэлтүүд, ерөнхий дүр зургыг, бас тэдгээр нь хувь хүн жижиг бүлгийн сэтгэхүй, санаа бодлоос үл хамаарсан ерөнхий зүй тогтлыг харуулж байгаа талаар үзүүлдэг. Тэрээр нийгмийн бидний сэтгэхүйгээс ангид боловч бидний амьдралд албадлагын нөлөө үзүүлдэг баримт сэлтүүдийг (гэмт хэрэг, шашны болон эрхзүйн систем, хөдөлмөрийн хуваарь, амио буюу гажуудал) судалж байснаараа позитивизмын хөгжилд том хувь нэмэр оруулжээ.

Харин чанарын судалгаа нь социологийн ойлгохуй, тайлбарлахуйн онолуудад илүү түшиглэдэг. Тэр утгаараа чанарын судалгааны онолын үндсийг М.Вебер тавьсан гэж хэлж болно. Тэрээр өөрийнхөө хөгжүүлсэн социологийг «Ойлгож буй социологи» (Verstehende Soziologie) хэмээн нэрлэсэн байна. Эдгээр онолууд нь гэмт хэргийн хэмжээг улс орнуудын эдийн засгийн бүтэц, ядуурлын түвшин, боловсролын хүртээмжтэй нь бус, харин хувь хүн, жижиг бүлгийн амьдралын туршлага, социаль мэдлэг, сэтгэлзүйн үйл хөдлөл, утга учир, ач холбогдолтой нь холбон авч үздэг.

Хүснэгт. Чанарын судалгааны онолын үндэс ба стратеги

Онолын чиглэлүүд	Чанарын судалгааны стратегиуд бий болох нь
Этнографи (Г.Гарфинкель)	Жижиг бүлгийн хөгжил, дотоод харилцаа, ойлголцол, Хувь хүний болон жижиг бүлгийн амьдралын түүх.



Феноменологи (А.Шюц, Э.Гуссерль)	Хувь хүний өдөр тутмын амьдралын туршлага, ач холбогдлын ертөнц буюу социаль орчныхоо болон амьдралын зүйлст өгч буй учир холбогдол.
Конструктивизм (Т.Лукманн, П.Бергер)	Хүний социаль мэдлэг, туршлага, энэхүү мэдлэг туршлагууд нь нийгмийн харилцааг хэрхэн бүтээж буй арга хэлбэр.
Бэлэг тэмдгийн харилцан үйлдэл (Ж.Мид, Ч.Кули)	Нийгмийн гишүүд бэлэг тэмдгийн тогтолцоог бүтээж, түүндээ орших ба энэ нь хувь хүмүүсийн зүгээс социаль амьдралыг зохицуулах үндэс болно.

Чанарын судалгааны доорх аргазүйн хандлага буй болох болно:

- ❖ Нийгмийн бодит байдал нь түүнийг бүрдүүлэгч гишүүдээс үл хамаарах объектив зүйл бус, харин хүний ухамсрын бүтээгдэхүүн ба оролцогч, үйлдэгчдийн ухамсрын байдлаас хамааран өөрчлөгддөг. Тиймээс хүмүүсийн аливаа зүйлсийг хэрхэн тусгаж, ойлгож, ухамсарлаж байгаа нь маш чухал зүйл мөн.
- ❖ Нийгмийн бодит байдал бол өдөр тутмын амьдралын бодит байдал (харилцаа, харилцан үйлдэл) мөн. Тиймээс хүмүүсийн өдөр тутмын амьдралын туршлага болон тэд өдөр тутамд юунд ач холбогдол өгч буй нь чухал.
- ❖ Нийгмийн бодит байдал нь хувь хүмүүсийн болон жижиг бүлгийн амьдралын түүхээр нөхцөлддөг. Тиймээс хувь хүн, бүлгийн намтар, амьдралын түүхэнд түшиглэвэл үнэнийг олж мэднэ.
- ❖ Нийгмийн бодит байдал нь социаль харилцааны явцад хүний мэдлэг, туршлагаар дамжин байгуулагдаж байдаг. Тиймээс бодит байдал нийгмийн харилцаагаар дамжин хэрхэн бүтээгдэж байгаа нь чухал.
- ❖ Тэгэхээр нийгмийн судалгаа нь хүний амьдралын олон асуудлуудыг бодит өрнөл, амьд түүхэнд нь, сэтгэл хөдлөл, үйл байдалд нь, хүмүүсийн зүгээс ойлгох ойлголт, утга учирт нь, амьдралын ердийн орчин, жам ёсны явцад нь тулгуурлах ёстой.

Чанарын судалгааны онцлог юу вэ?

Судлаач Ян Дей өөрийн «Чанарлаг өгөгдлийн шинжилгээ» бүтээлдээ чанарын судалгаа нь утга учир, туршлага, сэтгэл хөдлөл, ойлгохуй гэсэн мөн чанаруудтай болох талаар илэрхийлсэн байна. Чанарын судалгаа нь тооноос илүүтэйгээр үг өгүүлбэр, бичвэр мэдээлэлд, холбоо хамаарлаас илүүтэй үйлдлийн субъектив учир утга, учир холбогдолд, таамаглал шалгахад бус судалгааны эцэст таамаглал дэвшүүлэхэд, хэн юу гэж хэлсэн, хэд нь ийнхүү хариулсан гэдэгт бус яагаад ингэж хариулав гэдэгт гол анхаарлаа хандуулдаг. Чанарын судалгааны үед гол хэрэглэгдэхүүн нь судлаач өөрөө байдаг ба өдрийн тэмдэглэл, захидал, сонин сэтгүүл, ном, видео бичлэг, кино, фото зураг зэрэг мэдээллийн төрөл бүрийн туслах болон үндсэн эх үүсвэрийг судалгааны онцлогоос хамааран ашиглаж болно.

Чанарын судалгааны аргууд нь нөхцөл байдал, үйл явцыг амьдралын олон янзын төлөв байдалд нь цогц байдлаар шинжлэхийг эрмэлздэг. Түүнчлэн судалгааны үр дүнг тайлбарлахдаа тодорхой хувь хүний үнэн

бодитой үг яриаг өргөн ашиглана. Иймээс чанарын судалгаа нь амьдралын жирийн нөхцөл байдалд хүмүүстэй байнга холбоотой байж, тэдний харилцан үйлдлийг мэдэрч судалгаа хийхийг шаардана.

-
- Шигтгээ.* 1) *Урьдчилан тааварлахад бэрхтэй, нарийн төвөгтэй, далд, эсвэл шинэ үзэгдэл, хандлагын хувьсал өөрчлөлт, цйл ажиллагааны нийтлэг бус хэлбэрийг судлахад чанарын хандлага цр нөлөөтэй. Тухайлбал нийгмийн гажуудлын болон сөрөг үзэгдлийн хүрээнд биеэ үнэлэгчдийн, гэр бүл салалт, гар аргаар алт олборлогчид буюу нинжа нарын амьдрал, хар тамхи хэрэглэгчдийн, хууль бус наймааны, авлигын судалгаанд чанарын аргууд илцү боломж олгож болох юм.*
- 2) *Чанарын судалгаа тусгай буюу нэгж, онцгой тохиолдлыг судалж, түүнтэй төсөөтэй тохиолдлын явцуу хүрээнд цр дүнг дэлгэрцүлэн хэрэглэнэ. Нэг объектын хүрээнд хийсэн судалгааны цр дүн, ойлгохуй өөр газар хэрэглэхэд зөрцүтэй байж болох бөгөөд тоон судалгааг бодвол аль нэг цр дүнг нэлэнхүйд нялзаан тайлбарлах боломж бага. Жишээ нь өсвөр үеийнхний гэмт хэргийн бүлэгт хийсэн ажиглалын цр дүнг шууд насанд хүрэгчдийн гэмт бүлгийн судалгаанд тайлбарлах боломжгүй гэсэн цг юм.*
- 3) *Чанарын судалгааны үед тусгай бөгөөд тодорхой онолын үүднээс хийгдэж байгаа анализтек нэгтгэн дүгнэлт нь тоон судалгааны үе дэх статистик дүгнэлтээс эрс ялгаатай. Тиймээс чанарын судалгааны дүгнэлтээ бататгах юм уу, няцаах үед ижил объект дээр хийсэн судалгааны дүнтэй харьцуулан үзнэ. Дүгнэлт нь үнэн зөв болох нь бусад объект дээр энэ холбоо давтагдах байдлаар илэрнэ. Гэмт хэргийн талаар ерөнхий хэр хэмжээ, тархалтын талаар дүгнэлт бус, харин түүний нийгмийн тодорхой хүрээнд илрэх хэлбэр, үйлдэгдэж буй туршилага, учир шалтгаанд нэвтрэх болно.*
- 4) *Чанарын судалгааны үед судлаач, судалгааны бүхий л үе шатанд оролцдог тул түүний хувийн үнэлэлт дүгнэлт, үнэт зүйлсийн тогтолцооноос олон зүйл хамаарна. Иймээс субъективизм тухайн судалгаанд илэрч болохыг үгцүсгэх аргагүй. Тухайлбал гэмт хэрэг, гажуудлын асуудлыг судлахдаа судлаач хувийн ёс суртахуун, үнэт зүйлс, сэтгэл хөдлөлийн элементүүдийг хязгаарлах, судлагдахуунтай хольж хутгахгүй байх нь чухал байдаг.*
-



5) Чанарын судалгааны үед мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглан объектыг тал талаас нь шинжлэхийг чухалчлана. Гэмт хэргийн болон эрхзүйн зөрчлийн нэг тохиолдлыг олон талаас нь харах боломжийг олгоно. Харин тоон судалгаа нь ганцхан статистик хандлагыг гол болгоно.

Чанарын судалгааны мэдээлэл цуглуулах түгээмэл аргууд

Чанарын судалгаа нь мэдээлэл цуглуулах олон төрлийн аргуудыг хэрэглэдэг байна. Гэхдээ нийгмийн судлаачдын хувьд хамгийн өргөн хэрэглээтэй зарим аргууд буй. Тэдгээр нь оролцсон ажиглалт, гүнзгийрүүлсэн ярилцлага, хүүрнэл ярилцлага, фокус бүлгийн хэлэлцүүлэг, баримт бичгийн шинжилгээ зэрэг болно.

Оролцсон ажиглалт

Судлаач судлаж буй зүйлийнхээ бүрэлдэхүүнд өөрөө оролцож, тэдэнд итгэгдсэн бүрэн эрхт гишүүн болж, аль нэг үйл ажиллагааны хүрээнд, эсвэл шууд дотор нь орж ажиглахыг хэлнэ. Оролцсон ажиглалтын (participant observation) аргаар судалгаа хийж, нийгмийн судалгааны аргазүйн түүхэнд үлдсэн тохиолдлууд бий. Влиям Уайт ХХ зууны гучаад оны сүүл үед Бостоны ядуу дүүрэгт амьдран тэнд Итали цагаачдын дасан зохицохуйд ажиглалт хийсэн ба 1943 онд «Гудамны корнер нийгэм» бүтээлээ гаргасан бол Эрвин Гоффман сэтгэцийн эмнэлэгт тэдний ажилтны дүрээр оролцож ажиглалт хийсэн ба 1968 онд «Шошго» зохиолоо гаргажээ. Судлаач ийм ажиглалтыг хийхдээ судалгаанд хэрхэн оролцож байгаа байдлаар нь «бүрэн оролцсон», «бүрэн бус оролцсон» гэж ангилж болно. Бүрэн оролцсон гэдэг нь судлаач ажиглаж буй зүйлийнхээ үйл явц, өрнөлд бүрэн оролцож, хамт олны нэг гишүүн болох явдлыг хэлдэг бол харин бүрэн бус оролцсон нь судлаачийн ажил гүйцэтгэж байгааг нь оролцогчид мэдэх боловч, тэдний амьдрал, үйл ажиллагаанд оролцоод явахыг хэлдэг.

Гүнзгийрүүлсэн ярилцлага

Гүнзгийрүүлсэн сурвалжлага (in depth interview) бол чанарын судалгааны үед түгээмэл хэрэглэгддэг сурвалжлагын хэлбэр билээ. Гүнзгийрүүлсэн сурвалжлага нь хувь хүний сэтгэлгээ, үзэл бодол, зан үйлийн ертөнц рүү төвлөрөх үйл явц мөн. Уг аргын онцлог тал нь энэхүү судалгааг явуулахын тулд юуны өмнө төлөвлөлтийн ажлыг гүйцэтгэх ёстой ба үүнд: 1/ Хэнийг хамруулахаа шийдвэрлэх, 2/ Ямар мэдээлэл авах талаар тодорхойлох, аль мэдээллийг хэнээс авах талаар тогтох, 3/ Оролцогчдын жагсаалтыг гаргах, 4/ Судалгааны ёс зүйн зарчмуудыг тогтоох, зохицуулах зэрэг багтана. Дараагийн шатанд судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулах ажилд ордог. Энэ нь ярилцагын протоколыг хэрхэн хөтлөх, тэмдэглэх заавар, мөн ярилцагыг хэрхэн эхлүүлэх, респондентод ёсзүйн асуудлыг

хэрхэн танилцуулах, судалгааны явцад юу асуух, явцыг хэрхэн хянах, өрнөл үед хэрхэн юу асуух, хэрхэн ярилцах, мэдээж ярилцлагыг хэрхэн төгсгөх гээд бүхий үе шатны асуулт, арга техникүдийг бэлтгэдэг. Гүнзгийрүүлсэн ярилцлагын үед асуултыг хэрхэн тавих талаар анхаарвал зохих зааварчилгаа гэж буй.

-
- | | |
|--|--|
| <i>Шигтгээ.</i> | 1) <i>Асуултыг хаалттай байдлаар төгсгөх бус, харин нээлттэй байдлаар төгсгөнө.</i> |
| <i>Гүнзгийрцүлсэн сурвалжлагын цед асуулт тавих зарим зааврууд</i> | 2) <i>Жишээлбэл, «Та өмгөөллийн цйлчилгээний талаар юу мэдэх вэ?» гэж асуухын оронд «Та өмгөөллийн цйлчилгээг тайлбарлаж өгнө үү?»</i> |
| | 3) <i>Асуултын хувилбарыг тавихынхаа өмнө ямар нэг баримт сэлтийн талаарх асуулт тавих хэрэгтэй. Жишээлбэл, «Явагдсан цйл ажиллагаануудын талаар юу гэж бодож байна вэ?» гэхийн өмнө «Ямар цйл ажиллагаанууд явагдсан бэ?»</i> |
| | 4) <i>Хэрэгтэй шалгах, турших асуултуудыг хэрэглэ. Жишээлбэл:</i> |
| | - <i>Та надад жишээ хэлж өгөөч?</i> |
| | - <i>Энэ санааг та сайжруулж чадах уу? Хэрхэн сайжруулах вэ?</i> |
| | - <i>Та цаашид хэрхэх талаар тайлбар өгч чадах уу?</i> |
| | - <i>Уучлаарай, Таны санааг би баттай тодорхой ойлгож чадсангүй?</i> |
| | - <i>Та бидний дурдаагүй, өөр ямар нэг зүйл байна уу?</i> |
-

Эх сурвалж: Carolin Boys and Palena Neale. Conducting in depth interviews. 2006, 5

Хүчрнэл ярилцлага

Хүчрнэл ярилцлага нь (narrative interview) чанарын судалгааны нэгэн чухал чиглэл бөгөөд хүний амьдралын туршлага, түүхийн талаар мэдээлэл цуглуулахад хэрэглэх болжээ. Анх намтар судлах судалгаанд зориулж Ф.Шюц хүүрнэх ярилцлагын үзэл санааг дэвшүүлсэн байдаг. Хууч яриа, хүүрнэл, намтар, хуучлан ярилцах нь зэрэг нь бидний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэдэг харилцааны хэрэгсэл билээ. Ийм харилцааг хүний харилцааны эгэл институт, өдөр тутмын туршлага, дадал гэж ойлгож болно хэмээн тэрээр хэлсэн байдаг. Хүүрнэл ярилцлагын аргыг судалгааны практикт нэвтрүүлэхэд Чикагогийн сургуулийнхан томоохон хувь нэмэр оруулсан гэдэг. Билефелдийн их сургуулийн социологийн төслийн хүрээнд анхлан Ф.Шюц засаг захиргааны нэгж өөрчлөгдсөний дараа засаглалын бүтцийн уялдаа холбоо, чиг үүргийн байдалд шинжилгээ хийхдээ энэхүү ярилцлагын аргыг ашигласан гэдэг. Хожмоо академик ертөнцөд, тухайлбал 1980-аад оноос аргагүйн хандлагын тухай бүтээлүүд орноор гаржээ. Банк (1882), Белл (1988), Броди (1987), Хэллбрүн (1988) гэх зэрэг бусад нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэд хүний нарратив мөн чанарын талаарх



аргазүйн шинэ хандлагыг дэвшүүлэн тавьсан байна.

Хүүрнэл ярилцлага амжилттай явагдах нь тодорхой урьдач нөхцөл хангагдсан эсэхээс хамаардаг. Энэ талаар Ф.Шюцийн хэлснээс тодорхой байх ба судалгаа амжилттай явагдах эхний урьдач нөхцөл нь яриа өрнүүлэгч буюу судлаач нь хүүрнэл яриа өрнүүлэх дүрмийн талаар сайн мэдлэгтэй байх ёстой, харин удаах нөхцөл нь хүүрнэн өгүүлэгч буюу судалгаанд оролцогч нь болж өнгөрсөн үйл явдлыг урьд өмнө хэрхэн болж өнгөрсөн яг тэр байдлаар нь сэргээн санах явдал юм. Хүүрнэн яригчийн танин мэдэх чадвараас хамааран амьдралын туршлага хуулбарлагдана. Ярианд дурдаж буй зүйл нь түүхэн бодит үзэгдэлтэй биш, харин хүүрнэгчийн хувийн амьдралын туршлагын бүтэцтэй тохирч байх ёстой. Үүний тулд нэгдүгээрт, хариулагч нь зөвхөн өөрийн амьдралд тохиолдсон үзэгдэл, үйл явдлуудын талаар хүүрнэх, хоёрдугаарт, урьдчилан хэрхэн ярилцахаа төлөвлөх бололцоог өгүүлэгчид олгохгүй байх хэрэгтэй гэжээ. Хүүрнэл ярилцлага нь Ф.Шюцийн дэвшүүлсэн гурван зарчмыг баримтлах ёстой болдог.

Шигтгээ. а/ *Бүхэллэг хийгээд гүйцэд байх. Хариулагч өөрийн амьдралд тохиолдсон зарим нэг цйл явдал, бодол санааны талаар эхэлсэн хүчрнэлээ дуусгах шаардлагатайн дээр өгцүлэгчийн амьдралын туршилагад чухал, гол зүйл болох тэрхүү үзэгдэл, цйл явдлыг бүхэлд нь, хэлхээ холбоонд нь шалиггүй тохиолдол бүрийг ч гүйцэд, дууссан байдлаар өгцүлэх ёстой.*

**Хүчрнэл
ярилцлагаар
мэдээлэл
цуглуулахад
баримтлах
зарчмууд**

б/ *Товч тодорхой байх. Өгцүлэгч ярилцах цаг хугацаа хязгаарлагдмал гэдгийг ойлгож, өөрийн үзэж буйгаар хамгийн учир утгатай, шийдвэрлэх ач холбогдолтой гэж үзэж байгаа тэрхүү нөхцөл байдал, цйл явдалд анхаарлаа хандуулах ёстой. Мэдээллийг ийнхүү шилж, сонгох шаардлага хүчрнэгчээс өөрийн амьдралын туршилагын хувьд хамгийн гол байх үзэгдлүүд, тэдгээрийн холбоо уялдаа, гарсан цр дагаврын талаарх мэдээллийг сонсогчид өгөх гэсэн хандлагаар илэрч байдаг.*

в/ *Нарийвчлах. Өгцүлэгч шинэ сэдэвт орох юмуу, эсвэл ямар нэг юмны талаар ярихдаа уг үзэгдлээс дагалдан гарч ирж байгаа тодорхой байдлыг (цаг хугацаа, орон зай, шалтгаан) гүнзгийрцүлж тайлбарлахын чухлыг ойлгох ёстой.*

Эх сурвалж: Социологийн судалгааны аргазүй, аргачлал, 2008 УБ, 59

Фокус бүлгийн хэлэлцүүлэг

Төвлөрсөн бүлгийн ярилцлага гэж хэлж болох ба аль нэг асуудлаар оролцогчид санал бодлоо илэрхийлэх, тодорхой утга гаргаж авах үйл явц юм. Судлаач Морганы бичсэнчлэн фокус бүлгийн арга нь (focus group discussion) хөгжлийн гурван үе шатыг туулсан ажээ. ХХ зууны хориод оны үеэс Э.Богардус, У.Терстоун зэрэг социологичид бүлгийн төрөл

бүрийн ярилцлагыг зохион байгуулж байсан түүхтэй боловч, төрөл бүрээр хэрэглэж байсан туршилтууд нь судалгааны тусгай, бие даасан арга гэж үзэгддэггүй байжээ. Харин үүнээс хожуухан Лазерсфелд цэрэг дайны сэдвээр бүлгийн ярилцлага явуулж байсан бөгөөд Мертонтой холбоо тогтоосноор фокуст шинэ түүх эхэлжээ. Мертон нэг удаа радиогийн нэвтрүүлэг сонссон хүмүүсийн сэтгэгдлийг тандах бүлгийн ярилцлагыг харж суугаад оролцогчдын идэвхийг өрнүүлэх санаа төрөн, Лазерсфелдтэй зөвлөж, улмаар Мертоныг хөтлөгч болгосон байна. Дэлхийн II дайны үеэс 1970-аад он хүртэл фокус бүлгийн ярилцлагыг зөвхөн маркетингийн судалгаанд хэрэглэсэн байдаг. 1956 онд Мертон өөрийн хоёр шавийн хамт «Фокус ярилцлага» номоо хэвлүүлжээ. Фокус бүлгийн судалгааг явуулахад судлаачдын баг ажиллах шаардлагатай болдог ба эдгээр шууд оролцогчид нь чиглүүлэгч, тэмдэглэл хөтлөгч, зарим тохиолдолд хянан туслагч гэдэг. Чиглүүлэгч нь бүлгийн хэлэлцүүлгийг удирдан оролцогч нартай яриа өрнүүлж байгаа, асуулт тавьж буй хүнийг хэлдэг. Харин тэмдэглэл хөтлөгч нь бүлгийн хэлэлцүүлгийн явц болон түүний үе шатуудад оролцогчдын илэрхийлсэн санал бодол, сэтгэл хөдлөл, үйл байдлыг тэмдэглэн авах үүрэг хүлээж буй хүнийг хэлнэ. Бүлгийн ярилцагын явцад орчны нөхцөл байдлыг хянах, саад төвөггүйгээр ярилцах боломжийг хангах, мөн техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хариуцах хүнийг хянан туслагч гэж хэлнэ. Бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоог уламжлалт байдлаар 8-12 хүнтэй байхаар зохион байгуулдаг бол харин сүүлийн үед оролцогчдын тоог 5-7-оор хязгаарлах буюу тохиромжтой гэж үзэх болжээ. Энэ нь оролцогчдын санал бодлоо хэлэх боломжийг нэмэгдүүлэх, асуудал дээрээ илүү их төвлөрөх, чиглүүлэгч бүлэгт тавих хяналтыг дээшлүүлэх, нүүр тулж ажиллах нөхцөл бүрдүүлэх зэрэг учир шалтгаантай юм. Практик дээр бүлгийн хэлэлцүүлэг дээд тал нь хоёр цаг үргэлжлэх тал бий. Гэхдээ дөчин минутаас нэг цаг орчим үргэлжлэх нь тохиромжтой.

Бүдцэвч: Фокус бүлгийн судалгааны үе шатууд

Сэдвийг тодорхойлох	Бүлгийн хэлэлцүүлгээр судлах асуудлын мөн чанар, агуулга, хамрах хүрээг тодорхойлох буюу асуудлаа нарийн фокуслах
Хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч болон багийн хүмүүсийг сонгох	Судалгаа хийх багийг бүрдүүлэх, хэлэлцүүлгийг хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч нарыг сонгоно, судалгааны туршлагыг харгалзан сонгох ба ер нь бүлгийн хэлэлцүүлгийн судалгаанд оролцох судлаачдыг тухай бүрд нь сургалтаар бэлтгэх хэрэгтэй.
Оролцогчдын байдлыг тодорхойлох	Судалгаанд хэлэлцэх асуудлын онцлогтой холбогдуулан оролцогчдын нийгэм, хүн амзүйн байдал, амьдралын туршлага, асуудлын талаарх мэдлэг зэрэг олон хүчин зүйлийг харгалзан ямар байхыг тодорхойлно.



Бүлгийн хэлэлцүүлгийн удирдамж, асуултын чиглэлүүдийг боловсруулах	Бүлгийн хэлэлцүүлгийн удирдамж, асуултын чиглэлүүд, задаргааг нарийвчлан тодорхойлно. Бүлгийн хэлэлцүүлгийн мэдээллийг хэрхэн буулгах, тэмдэглэлийг хэрхэн хийх талаар, мөн үр дүнг хэрхэн нэгтгэх гээд бүхий л шатны заавар гаргана.
Газраа сонгох, бэлтгэх	Хэлэлцүүлгийн газар нь тохьтой, төвийг сахисан, тайван байдлыг хангасан байхуйцаар урьдчилан бэлтгэдэг.
Оролцогчдыг бүрдүүлэх	Хэлэлцүүлэгт оролцогчдыг урьдчилан зар өгч, цаг товлон, бас хэлэлцүүлэг явуулах газар зайтай бол унаагаар авч ирэх гэх зэргээр бүрэн ирцтэй байх талаар сайтар төлөвлөх хэрэгтэй.
Бүлгийн хэлэлцүүлэг	Бүлгийн хэлэлцүүлэг явуулна. Чиглүүлэгч нь бүлгийг удирдана, мөн тэмдэглэл хөтлөгч нь мэдээлэл болон ажиглалтаа бичнэ. Хянан туслагч нь фото зураг авч баримтжуулна.
Бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлийг сайжруулах	Бүлгийн хэлэлцүүлэг дууссаны дараа тухайн өдөртөө хэлэлцүүлгийн явцад хийсэн тэмдэглэлээ сэргээх хэрэгтэй. Учир нь хугацаа удалгүй сэргээх явцад хэлэлцүүлгийн явцад гарсан мэдээллүүдийг мартаагүй байдаг. Түүнчлэн дуу хураасан бичлэгийг сонсоод бүлгийн хэлэлцүүлгийн мэдээллээ бүрэн дүүрэн болгоно. Тэмдэглэл хөтлөгч нь зөвхөн санал бодол ярьсан зүйлүүдийг бус, харин үйл байдал, сэтгэл хөдлөлийг тусгана.
Үр дүнд шинжилгээ хийх	Мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.

Баримт бичгийн шинжилгээ

Баримт бичгийн судалгаа нь социологийн судалгааны аргын хувьд тоон аргад хамардаг. Гэвч баримт бичигт шинжилгээ хийх тохиолдол бүр нь тоон утга, үр дүн гаргаж авах ажил байдаггүй. Өөрөөр хэлбэл баримт бичигт шинжилгээ хийн чанарын үр дүн гаргаж авдаг. Нийгмийн тодорхой үзэгдэл, үйл явцын хүрээнд орших хүмүүсийн амьдралын туршлага, утга учир, учир шалтгаан, сэтгэлзүйн дотоод ертөнцийг нээн илрүүлэхийн тулд ажиллавал зохих баримт бичгүүд буй. Тухайлбал захидал харилцаа, өдрийн тэмдэглэл, шүлэг, шүүхт хандсан өргөдөл, сэтгэл хөдлөлийн бусад уран сайхны илэрхийллүүд гэх мэтийг юуны өмнө нэрлэж болно.



Хяналтын асуултууд:

1. Чанарын судалгаа нь социологийн онол аргазүйд хэрхэн үндэслэгддэг вэ?
2. Чанарын судалгааны онцлог, шинж чанарууд юу вэ?
3. Чанарын судалгааны ямар нийтлэг хэлбэрүүд байдаг вэ?
4. Мэдээлэл цуглуулах аргуудыг хэрхэн хэрэглэдэг вэ?
5. Хүүрнэл ярилцлагын онцлог юу вэ?
6. Гүнзгийрүүлсэн ярилцлагын онцлог юу вэ?
7. Фокус бүлгийн аргын онцлог юу вэ?
8. Чанарын судалгааны хүрээнд баримт бичигт шинжилгээ хийх аргын онцлог юу вэ?



Эх сурвалж:

1. Колин Робсон. (2006), Бодит ертөнцийг судлахуй. Нийгмийн ухааны судлаач болон мэргэжилтэн судлаачдад зориулсан гарын авлага
2. Уртнасан Ц, Пүрэв Ц. (2006) ШУА Социологийн судалгааны аргазүй, аргачлал., ФСЭХ, УБ, Sansudai
3. Carolin Boys and Palena Neale. (2006), Conducting in depth interviews. Pathfinder International Tool Series



Унших материал:

1. Пүрэв Ц. (2012), Чанарын судалгаа, УБ
2. Уртнасан Ц, Пүрэв Ц. (2006) ШУА Социологийн судалгааны аргазүй, аргачлал., ФСЭХ, УБ, Sansudai
3. Колин Робсон. (2006), Бодит ертөнцийг судлахуй. Нийгмийн ухааны судлаач болон мэргэжилтэн судлаачдад зориулсан гарын авлага